

Монгол Солонгосын олон улсын эрдэм шинжилгээний хурал
한-몽 국제학술대회

| 결과 보고서 |

Солонгос - Монгол улсын эрх зүйн өөрчлөлт шинэчлэл, түүний үнэлэлт дүгнэлт, цаашдын чиг хандлага

한국과 몽골의 법제개혁, 평가와 전망

Хугацаа: 2016.07.27(лхагва) 10:00-18:30

Газар: Монголын хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хурлын танхим

Зохион байгуулагч: Солонгосын хууль зүйн үндэсний хүрээлэн,
Монголын хууль зүйн үндэсний хүрээлэн,
Солонгосын Күүкмин их сургуулийн хууль зүйн сургууль (КИС, ХЗС),
МУИС-ийн хууль зүйн сургууль (МУИС, ХЗС)

일 시: 2016년 7월 27일 (수요일) 10:00-18:30

장 소: 몽골법제연구원 강당

주 최: KLRI





- 일시: 2016. 7. 27.(수) 10:00~18:30
- 장소: 몽골법제연구원 강당



개회사 E.Batbayar 박사(몽골법제연구원 원장)



환영사 이원 원장(한국법제연구원)



환영사 J.Erdenebulgan 교수(몽골국립대 법대 학장)



축사 Ts.Mandakh 박사(몽골법원평의회)



축사 몽골법무부 대표



[제1세션-발표1] 김대희 상임위원(한국 국민권익위원회)



[제1세션-발표2] Ts. Tsogt 판사(몽골 행정 고등법원)



[제2세션-발표1] 김성배 교수(한국국민대)



[제2세션-발표2] P. Odgerel 교수(몽골 국립대)



[제3세션-발표1] 소정수 검사(한국 법무부)



[제3세션-발표2] M. Uyanga 교수(몽골국립대)



[제4세션-발표1] E. Batbayar 박사(몽골법제연구원)



[제4세션-발표2] 박광동 박사(한국법제연구원)



[제5세션-특별강연-발표1] 박정원 교수(한국 국민대)



[제5세션-특별강연-발표2] Sh. Unentugs 박사(몽골법무부 상급 전문가)



[제6세션-종합토론] 지성수 부장연구관(한국 헌법재판소)



[제6세션-종합토론] 김충구 교수(한국 국민대)

Солонгос - Монгол улсын эрх зүйн өөрчлөлт шинэчлэл,
түүний үнэлэлт дүгнэлт, цаашдын чиг хандлага

한국과 몽골의 법제개혁, 평가와 전망





Солонгос - Монгол улсын эрх зүйн өөрчлөлт шинэчлэл,
түүний үнэлэлт дүгнэлт, цаашдын чиг хандлага

한국과 몽골의 법제개혁, 평가와 전망





Программ

-10:00	Бүртгэл
10:00-10:20	Нээлт
	Нээлт: Чиглүүлэгч : Проф. Ан Гёнг Бунг(КИС) Нээлтийн үг: ХЗҮХ-ийн дарга Э.Батбаяр(Монголын ХЗҮХ) Мэндчилгээ: ХЗҮХ-ийн дарга И Вон(Солонгосын ХЗҮХ) МУИС-ХЗС-ийн захирал Ж.Эрдэнэбулган(МУИС-ХЗС) Доктор Ц.Мандах(Монголын ШЕЗ-ийн ШСМСХ-ийн) Монголын хууль зүйн яамны төлөөлөгч
10:20-10:30	Хүндэтгэлийн зураг авалт
10:30-11:30	[Нэгдүгээр хуралдаан] Захиргааны шүүхийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
	Чиглүүлэгч: Шүүгч Ким Жонхён(Солонгосын хууль зүйн үндэсний хүрээлэн)
	1. БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО БА ТУЛГАМДСАН АСУУДАЛ Илтгэгч: Ким Тэхи(Солонгосын хүний эрхийн комиссийн Байнгын хорооны гишүүн) Хэлэлцүүлэгч: Дэд проф. Г.Банзрагч(МУИС-ийн ХЗС)
	2. Монгол улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ Илтгэгч: Шүүгч Ц.Цогт(Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх) Хэлэлцүүлэгч: Шүүгч У Сёюун(Солонгосын шүүхийн бодлого төлөвлөлтийн судалгааны хүрээлэн)
11:30-12:30	[Хоёрдугаар хуралдаан] Захиргааны эрх зүйн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
	Чиглүүлэгч : Проф. Бак Жонвон(КИС)
	3. БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ БА ҮНЭЛЭЛТ Илтгэгч: Проф. Ким Сонбэ(КИС) Хэлэлцүүлэгч: Шүүгч Ц.Цогт(Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх)
	4. Монголын Захиргааны эрх зүйн төлөвшлийн асуудал Илтгэгч: Дэд проф. П.Одгэрэл(МУИС ХЗС) Хэлэлцүүлэгч: Доктор. И Санюун (Солонгосын хууль зүйн үндэсний хүрээлэн)
12:30-14:00	Үдийн зоог
14:00-15:00	[Гуравдугаар хуралдаан] Олон улсын салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
	Чиглүүлэгч : Доктор Пак Гуандун(Солонгосын ХЗҮХ)
	5. ЭЦЭГ ЭХ БОЛОН ГЭР БҮЛИЙН АЛЬ НЭГ ГИШҮҮН ХҮҮХДИЙГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР ХИЛИЙН ЧАНД РҮУ АВЧ ЯВАХ ТОХИОЛДОЛД ХҮҮХДИЙГ ОРШИН СУУГАА УЛСАД НЬ ШУУРХАЙ БУЦААН АВЧРАХТАЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ БНСУ-ын Хууль зүйн яамны санаачилгаар Илтгэгч: Прокурор Су Жонсү(Солонгосын ХЗЯ) Хэлэлцүүлэгч: Доктор Ц.Мандах(Монголын ШЕЗ-ийн ШСМСХ-ийн дарга)
	6. Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтын онцлог, цаашдын хөгжлийн чиг хандлага Илтгэгч: Ахлах багш М.Уянга(МУИС ХЗС) Хэлэлцүүлэгч: Доктор И Санмү(Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэн)
15:00-16:00	[Гуравдугаар хуралдаан] Хууль эрх зүйн шинэчлэл ба нийгмийн хөгжлийн зорилт
	Чиглүүлэгч: Проф. Ким Дунхүн(КИС)
	7. Монгол Улсын эрх зүйн шинэтгэл: шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал Илтгэгч: Доктор Э.Батбаяр(Монголын ХЗҮХ-ийн захирал) Хэлэлцүүлэгч: Су Жонсү прокурор(Солонгосын хууль зүйн яам)
	8. Солонгосын нийгмийн хөгжил болон эрх зүйн тогтолцооны хөгжил Илтгэгч: Пак Гуандун доктор(Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэн) Хэлэлцүүлэгч: Доктор (Sc.D) Ш.Үнэнтөгс(ХЗЯ-ны ахлах мэргэжилтэн)
16:00-16:30	Цайны завсарлага
16:30-17:30	[Тавдугаар хуралдаан] Тусгай илтгэл
	Чиглүүлэгч : Доктор. И Санюун(Солонгосын ХЗҮХ)
	9. Хойд Солонгосын хүний эрхийн эрх зүйн тогтолцооны тулгамдсан асуудал, дүн шинжилгээ Илтгэгч: Проф. Пак Жонвон(КИС) Хэлэлцүүлэгч: МУИС-ХЗС-ийн захирал Ж.Эрдэнэбулган(МУИС-ХЗС)
	10. МОНГОЛ, СОЛОНГОСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА Илтгэгч: Доктор (Sc.D) Ш.Үнэнтөгс(ХЗЯ-ны ахлах мэргэжилтэн) Хэлэлцүүлэгч: Доктор Ким Жонхён(Солонгосын ХЗҮХ)
17:30-18:20	[Зургадугаар хуралдаан] Нэгдсэн хэлэлцүүлэг
	Чиглүүлэгч : Доктор. И Санюун(Солонгосын ХЗҮХ)
	Жи Сонсү(Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн судалгааны хүрээлэнгийн салбарын дарга) Проф. Ким Чүнгү(КИС)
18:20-18:30	Хаалт
	Хаалтын үг : Проф. Кан Гүчол(КИС, МУИС-ХЗС СЭЗБТ)



PROGRAM

-10:00	등 록
10:00-10:20	개 회 식
	<p>사 회: 안경봉 교수(한국 국민대) 개회사: E.Batbayar 박사(몽골법제연구원 원장) 환영사: 이 원 원장(한국법제연구원) J.Erdenebulgan 교수(몽골국립대 법대 학장) 축 사: Ts.Mandakh 박사(몽골법원평의회) 몽골법무부 대표</p>
10:20-10:30	기념촬영
10:30-11:30	[제1세션] 행정재판의 개혁과 과제
	<p>사 회: 김정현 박사(한국법제연구원)</p> <p>1. 한국 행정심판제도의 현황과 과제 발표: 김대희 상임위원(한국 국민권익위원회) 토론: G. Banzragch 교수(몽골국립대)</p> <p>2. 몽골 행정재판의 평가와 전망 발표: Ts. Tsogt 판사(몽골 행정 고등법원) 토론: 오세용 판사(한국 사법정책연구원)</p>
11:30-12:30	[제2세션] 행정법의 개혁과 과제
	<p>사 회: 박정원 교수(한국 국민대)</p> <p>3. 한국 행정소송법 개정과정 및 평가 발표: 김성배 교수(한국국민대) 토론: Ts. Tsogt 판사(몽골 행정 고등법원)</p> <p>4. 몽골 행정법 법형성 발표: P. Odgerel 교수(몽골 국립대) 토론: 이상윤 박사(한국법제연구원)</p>
12:30-14:00	오 찬
14:00-15:00	[제3세션] 국제법 분야의 개혁과 과제
	<p>사 회: 박광동 박사(한국법제연구원)</p> <p>5. 국제적 아동탈취의 민사적 측면에 관한 협약 - 대한민국 법무부의 역할을 중심으로 발표: 소정수 검사(한국 법무부) 토론: Ts.Mandakh 박사(몽골법원평의회 의장)</p> <p>6. 몽골 국제 무역법의 법적 조정의 특징과 발전 경향 발표: M. Uyanga 교수(몽골국립대) 토론: 이상모 박사(한국법제연구원)</p>
15:00-16:00	[제4세션] 법제개혁과 사회발전의 과제
	<p>사 회: 김동훈 교수(한국 국민대)</p> <p>7. 몽골의 법제개혁 - 사법개혁의 실행, 성과와 과제 발표: E.Batbayar 박사(몽골법제연구원장) 토론: 소정수 검사(한국 법무부)</p> <p>8. 한국사회의 발전과 법제발전 발표: 박광동 박사(한국법제연구원) 토론: Sh.Vnentugs 박사(몽골법무부 상급 전문가)</p>
16:00-16:30	Coffee Break
16:30-17:30	[제5세션] 특별강연
	<p>사 회: 이상윤 박사(한국법제연구원)</p> <p>9. 북한 인권법제의 문제점과 전망 발표: 박정원 교수(한국 국민대) 토론: J.Erdenebulgan(몽골국립대 법대 학장)</p> <p>10. 해외투자의 상태와 과제: 몽골에 대한 한국투자 발표: Sh.Unentugs 박사(몽골법무부 상급 전문가) 토론: 김정현 박사(한국법제연구원)</p>
17:30-18:20	[제6세션] 종합토론
	<p>사 회: 이상윤 박사(한국법제연구원)</p> <p>지성수 부장연구원(한국 헌법재판소) 김충구 교수(한국 국민대)</p>
18:20-18:30	폐 회 식
	<p>폐회사: 강구철 교수(국민대 법대, 몽골한국법교육센터)</p>



CONTENTS

Нээлтийн үг: 개회사 1
 ХЗҮХ-ийн дарга Э.Батбаяр(Монголын ХЗҮХ)
 E.Batbayar 박사(몽골법제연구원 원장)

Мэндчилгээ 환영사 5
 ХЗҮХ-ийн дарга И Вон(Солонгосын ХЗҮХ)
 이 원 원장(한국법제연구원)

Мэндчилгээ 환영사 9
 МУИС-ХЗС-ийн захирал Ж.Эрдэнэбулган(МУИС-ХЗС)
 J.Erdenebulgan 교수(몽골국립대 법대 학장)

Мэндчилгээ 축사 13
 Доктор Ц.Мандах(Монголын ШЕЗ-ийн ШСМСХ-ийн захирал)
 Ts.Mandakh 박사(몽골법원평의회 의장)

Session 1_ Захиргааны шүүхийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага 행정재판의 개혁과 과제

**БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО БА
ТУЛГАМДСАН АСУУДАЛ** 21
 한국 행정심판제도의 현황과 과제
 Илтгэгч: Ким Тэхи (Солонгосын хүний эрхийн комиссийн Байнгын хорооны гишүүн)
 발표: 김대희 상임위원(한국 국민권익위원회)
 Хэлэлцүүлэгч: Дэд проф. Г.Банзрагч (МУИС-ийн ХЗС)
 토론: G. Banzragch 교수(몽골국립대)

Монгол улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ 47
 몽골 행정재판의 평가와 전망
 Илтгэгч: Шүүгч Ц.Цогт (Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх)
 발표: Ts. Tsogt 판사(몽골 행정 고등법원)
 Хэлэлцүүлэгч: Шүүгч У Сэун (Солонгосын шүүхийн бодлого төлөвлөлтийн су-далгааны хүрээлэн)
 토론: 오세용 판사(한국 사법정책연구원)



Session 2_ Захиргааны эрх зүйн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
행정법의 개혁과 과제

БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ БА ҮНЭЛЭЛТ 87

한국 행정소송법 개정과정 및 평가

Илтгэгч: Проф. Ким Сонбэ (КИС)

발표: 김성배 교수(한국국민대)

Хэлэлцүүлэгч: Шүүгч Ц.Цогт (Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх)

토론: Ts. Tsogt 판사(몽골 행정 고등법원)

Монгол улсын захиргааны эрх зүйн төлөвшлийн асуудал 147

몽골행정법의 발전

Илтгэгч: Дэд проф. П.Одгэрэл (МУИС ХЗС)

발표: P. Odgerel 교수(몽골 국립대)

Хэлэлцүүлэгч: Доктор. И Санюүн (Солонгосын хууль зүйн үндэсний хүрээлэн)

토론: 이상윤 박사(한국법제연구원)

Session 3_ Олон улсын салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
국제법 분야의 개혁과 과제

ЭЦЭГ ЭХ БОЛОН ГЭР БҮЛИЙН АЛЬ НЭГ ГИШҮҮН ХҮҮХДИЙГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВШӨӨРӨЛ ГҮЙГЭЭР ХИЛИЙН ЧАНД РУУ АВЧ ЯВАХ ТОХИОЛДОЛД ХҮҮХДИЙГ ОРШИН СУУГАА УЛСА Д НЬ ШУУРХАЙ БУЦААН АВЧРАХТАЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ БНСУ -ын Хууль зүйн яамны санаачилгаар 169

국제적 아동탈취의 민사적 측면에 관한 협약 -대한민국 법무부의 역할을 중심으로

Илтгэгч: Прокурор Су Жонсү (Солонгосын ХЗЯ)

발표: 소정수 검사(한국 법무부)

Хэлэлцүүлэгч: Доктор Ц.Мандах (Монголын ШЕЗ-ийн ШСМСХ-ийн захирал)

토론: Ts.Mandakh 박사(몽골법원평의회 의장)



Session 5_ Тусгай илтгэл

특별강연

Хойд Солонгосын хүнийн эрхийн эрх зүйн тогтолцооны тулгамдсан асуудал, дүн шинжилгээ	273
북한 인권법제의 문제점과 전망	
Илтгэгч: Проф. Пак Жонвон (КИС)	
발표: 박정원 교수(한국 국민대)	
Хэлэлцүүлэгч: МУИС-ХЗС-ийн захирал Ж.Эрдэнэбулган (МУИС-ХЗС)	
토론: J.Erdenebulgan(몽골국립대 법대 학장)	

гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага :

Монгол дахь Солонгосын хөрөнгө оруулалт	325
해외투자의 상태와 과제: 몽골에 대한 한국투자	
Илтгэгч: Доктор (Sc.D) Ш.Үнэнтөгс (ХЗЯ-ны ахлах мэргэжилтэн)	
발표: Sh.Vnentugs 박사(몽골법무부 상급 전문가)	
Хэлэлцүүлэгч: Доктор Ким Жонхён (Солонгосын ХЗҮХ)	
토론: 김정현 박사(한국법제연구원)	

Session 6_ Нэгдсэн хэлэлцүүлэг

종합토론

Проф. Ким Чүнгү(КИС)	401
김충구 교수(한국 국민대)	
Хаалтын үг 폐회사	405
Проф. Кан Гүчол(КИС, МУИС-ХЗС СЭЗБТ)	
강구철 교수(국민대 법대, 몽골한국법교육센터)	
Тусгай илтгэл 특별강연	407

НЭЭЛТИЙН ҮГ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
доктор, дэд професср Э.Батбаяр

Хүндэт зочид, төлөөлөгчид, эрхэм судлаачид аа!

Монгол-Солонгос хоёр улсын нөхөрсөг хамтын ажиллагаа нь олон тулгууртай билээ. Бид улс төр, эдийн засаг, хууль зүйн гэх мэт салбарт харилцан итгэлцэж нягт хамтран ажилладаг. Бидний хамтын ажиллагаа нь эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, мөн хууль дээдлэх ёсыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон төлөвшүүлэх гэсэн нэгэн үзүүрт зорилготой билээ.

Монгол Улсын Хууль зүйн үндэснийн хүрээлэн нь БНСУ-ын Хууль зүйн үндэсний хүрээлэн, БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургууль, МУИС-ын Хууль зүйн сургуультай олон жилийн хамтын ажиллагаатай ажиллаж ирсэн. Энэ дашрамд хэлэхэд “Солонгос-Монгол Улсын эрх зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахад идэвхитэй дэмжлэг үзүүлсэн БНСУ-ын ХЗҮХ-ийн дарга, профессор И Вон, МУИС-ын ХЗС-ийн захирал профессор Ж.Эрдэнэбулган, ШЕЗ-ийн ШСМСХ /Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн/-ийн захирал, доктор Ц.Мандах, Монгол Улсын Хууль зүйн яамны Эрх зүйн шинэтгэлийн газрын дарга Т.Бат-Өлзий нарт талархал илэрхийлье.

Монгол Улс 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагын үүднээс хөгжингүй орнуудын эрх зүйн тогтолцооны шинэлэг зохицуулалтуудыг өөрийн оронд нутагшуулах, рецепци хийх талаар олон ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж ирсэн. Энэ хүрээнд Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг 1990-1992 он, 1992-1998 он, 1998-2016 онуудад шат дараатай хийж хэрэгжүүлсэн бөгөөд одоогоор 2016 оноос хойш хууль тогтоомжийг боловсронгуй болгох гэсэн чиглэлээр бодлогын баримт бичиг гаргахаар судалгааны ажил хийгдэж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ХЗЯ-ы захиалгад тулгуурлан “Эрх зүйн шинэтгэл:

Хүрсэн үр дүн /2008-2016/, цаашдын зорилт, чиглэл” сэдвээр судалгаа гүйцэтгэж, тайлан боловсруулах шатандаа ажиллаж байна. Энэхүү эрдэм шинжилгээний хуралд тавигдах судлаачдын илтгэл, хурлаас гарах зөвлөмж нь бидний судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Төгсгөлд нь энэхүү бага хурлын бэлтгэл ажилд оролцсон бүх хүнд баярласан талархсанаа дахин илэрхийлье. Энэхүү эрдэм шинжилгээний хурал шинэлэг мэдлэг, мэдээллээр дүүрэн байж амжилттай явагдана гэдэгт эргэлзэхгүй байна.

“Солонгос-Монгол Улсын эрх зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” эрдэм шинжилгээний хурал нээснийг мэдэгдье.

Та бүхэнд баярлалаа.

개회사

몽골 법제연구원 원장 박사E.Batbayar

존경하는 참석자 여러분 안녕하십니까 !

한-몽 양국은 여러 분야에서 우호 협력하고 있습니다. 우리는 정치, 경제, 법률 적으로 상호 협조해 왔습니다. 우리 협력의 목적은 자유, 민주주의와 시장 경제를 발전시키고, 국가의 최고 원리로서 법을 준수하는 것입니다.

몽골 법제연구원은 한국 법제연구원, 국민 대학교 법과대, 몽골 국립대학 법과대와 몇 년 전 부터 협력해 왔습니다. “한국과 몽골의 법제개혁, 평가와 전망”이라는 주제로 한-몽 국제학술 대회를 개최할 때 지원하는 한국 법제연구원 이 원 원장님, 몽골 국립대학 법과대 학장 에르덴 불강 교수님 몽골 법원평의회 대표 만다흐 박사님, 몽골 법무부 대표 바트울지 님에게 감사 말씀 드립시다.

몽골은 1992년에 몽골의 민주헌법의 채택 이후 세계 경제의 일반적인 방법, 법적 프레임 워크의 개선을 위해 개발도상국의 법제에 새로운 규제를 연수하여 다양한 활동을 해 왔었습니다. 몽골은 법제 개혁을 1990-1992년, 1992-1998년, 1998-2016 년에 순서대로 적용했다가 2016년 이후 법을 개선하기 위한 정책문서연구작업이 집행되었습니다.

몽골 법제연구원은 몽골 법무부의 베이스를 주문하여 “몽골의 법제개혁: 사법개혁의 실행, 성과와 과제”라는 주제로 연구하여 보고서를 제출하였습니다. 이번 국제학술대회에서 나온 우리 연구에 크게 기여하기를 바랍니다.

마지막으로 이번 국제학술대회의 준비에 참여한 모든 분에게 다시 한 번 감사 말씀을 드리 겠습니다.

“한국과 몽골의 법제개혁, 평가와 전망” 세미나의 개최를 선언합니다.

감사합니다.

Мэндчилгээ

Солонгосын Хууль зүйн үндэсний
хүрээлэнгийн дарга И Вон

Эрхэм хүндэт зочид оо ! Та бүхэнтэй уулзах болсондоо таатай байна.

Намайг Солонгос Монгол олон улсын эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулж буй Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дарга И Вон гэдэг.

Юуны өмнө энэхүү эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулж буй Монголын Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дарга Э.Батбаяр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал Ж.Эрдэнэбулган, Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор Кан Гү Чол болон бидэнд мэндчилгээ дэвшүүлэхээр хүрэлцэн ирсэн Монголын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн төлөөлөгч Ц.Мандах, Монгол Улсын Хууль зүйн яамны Эрх зүйн шинэтгэлийн газрын дарга Т.Бат-Өлзий нарт баярласнаа илэрхийлье. Түүнчлэн өнөөдрийн эрдэм шинжилгээний хуралд илтгэгч болон хэлэлцүүлэгчээр оролцож байгаа Монгол, Солонгосын мэргэжилтнүүдэд болон өнөөдрийн энэхүү үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн та бүхэндээ дахин баярласан талархсанаа илэрхийлье.

Монгол нь манай Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрх зүйн судалгааны байгууллагын хооронд бизнесийн эрх зүйн чиглэлээр хамтран ажиллаж эхэлсэн улсын нэг юм. Өнгөрсөн 2008 онд Солонгос Монгол мэргэжилтнүүдийн форум болж өнгөрсөн бөгөөд 2009 онд ч гэсэн урилгаар ирж сургалт явуулж байсан. Мөн энэ оны 4 сард Сөүл хотноо “Солонгос Монголын Иргэний процессын эрх зүйн тулгамдсан асуудлууд” сэдэвтэй МУИС-ХЗС-ийн профессорууд оролцсон олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан бөгөөд хэдэн өдрийн өмнө 7 сарын 7-8-ны хооронд МУИС-ХЗС-ийн оюутнууд Солонгос улсад зуны сургалтаар очиж Солонгосын эрх зүйн талаарх лекцийг сонссон.

Ялангуяа өнгөрсөн 7сарын 17-ны өдөр ерөнхийлөгч Пак Гын Хэ болон ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж нар Солонгос Монголын Чөлөөт худалдааг дэмжих гэрээ/FTA/-д гарын үсэг зурсан. Цаашдаа Солонгос Монголын Чөлөөт худалдааг дэмжих гэрээ /FTA/-г байгуулвал Солонгос Монголын хооронд эдийн засаг, соёл зэрэг олон салбарт харилцаа улам өргөжин тэлнэ гэдэгт итгэж байнга. Үүнтэй зэргэцэн хуулийн салбар ч гэсэн илүү хөгжин

тэлнэ гэдэгт найдаж байна.

Энэ үед зохион байгуулагдах олон улсын эрдэм шинжилгээний хурал нь илүү өргөн хүрээнд болно гэж бодож байна. Өнөөдөр хоёр улсын эрх зүйн шинэтгэлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцэх гэж байна. “Захиргааны эрх зүйн орчин, дүн шинжилгээ”-ээр эхлэн захиргааны хэргийн шүүх, Олон улсын эрх зүй, эрх зүйн шинэтгэл болон нийгмийн хөгжил өнөөгийн байдал зэрэг олон салбарын хоёр улсын мэргэжилтнүүд хоёр орны эрх зүйн шинэтгэлийн талаар тус тусын туршлага болон мэдээлэл солилцон тус тусын орны эрх зүйн өнөөгийн байдал болон хөгжүүлэх аргын талаар хэлэлцэнэ гэдэгт найдаж байна. Түүнчлэн өнөөдрийн хэлэлцсэн агуулгыг цаашдаа хэрэгжих Солонгос Монголын Чөлөөт худалдааг дэмжих гэрээ/FTA/-д тусгана гэж бодож байна.

Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Солонгосын цорын ганц хуулийн мэргэжлийн судалгааны байгууллага учраас эрх зүйн тогтолцоог мэргэжлийн түвшинд судалгаа хийх, судлах бөгөөд эрх зүйн мэдээллийг системтэйгээр цуглуулах, удирддаг учир үндэсний хууль тогтоомж бодлогод дэмжлэг үзүүлэх болон эрх зүйн соёлыг сайжруулах зорилгоор байгуулагдсан засгийн газраас санхүүждэг үндэсний судалгааны байгууллага юм. Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэн нь өнөөдрийн хэлэлцүүлэгт суурилан Солонгос Монголын хоорондын эрх зүйн харилцаа болон судалгааг үргэлжлүүлэн цаашдаа Солонгос Монголын эрх зүйн харилцааны төв нь болохын тулд хичээнгүйлэн ажиллах болно.

Төгсгөлд нь энэхүү эрдэм шинжилгээний хурлын бэлтгэлийг хийхэд хичээнгүйлэн ажилласан бүх хүмүүстээ баярласнаа илэрхийлье.

환영사

한국법제연구원장 이 원

존경하는 내외 귀빈 여러분! 만나 뵙게 되어 반갑습니다.

저는 이번 한몽 국제학술대회를 공동으로 주최하는 한국법제연구원의 원장 이원입니다.

먼저 이번 학술행사를 함께 개최해 주신 몽골 법제연구원의 E.Batbayar 원장님, 몽골국립대학의 J.Erdenebulgan 학장님, 한국의 국민대학교 법과대학 강구철 교수님과 축사를 해주시는 Ts.Mandakh 몽골법원평의회 의장님, 000 법무부 차관님께 깊은 감사의 말씀을 드립니다. 그리고 오늘 주제 발표와 토론을 맡아 주신 몽골과 한국의 전문가 여러분들과 그 외에 자리를 함께 해주신 모든 분들께도 진심으로 감사와 환영의 말씀을 드립니다.

몽골은 저희 한국법제연구원이 법제연구 관련기관들과의 국제 네트워크 사업을 시작한 초창기부터 가장 활발히 연구교류를 해온 나라의 하나입니다. 이미 2008년에 한몽 전문가 포럼을 개최하였고, 2009년에도 초청연수와 교육 등을 진행하였습니다. 그리고 금년에는 4월에 “한몽 민사법의 쟁점”이라는 주제로 몽골 국립대학 교수님들을 모시고 서울에서 국제학술대회를 개최하였으며, 얼마 전인 7월 7일과 8일에는 몽골 국립대 학생들을 한국으로 초청하여 한국법에 대한 특강을 진행한 바가 있습니다.

특히 지난 7월 17일에는 박근혜 대통령과 차히야 엘벡도르지 몽골 대통령이 한·몽 FTA(자유무역협정) 체결 추진에 합의하였습니다. 향후 FTA가 정식으로 체결되면 한몽간에 경제, 문화 등 각 분야에서의 교류는 더욱 활기를 띠게 될 것입니다. 그와 동시에 법제분야에서도 더욱 왕성한 교류가 이루어질 것으로 기대됩니다.

이러한 시점에서 개최되는 오늘의 한몽 국제학술회의는 더욱 의미가 있다고 생각됩니다. 오늘 이 자리는 양국의 법제 개혁과 이에 대한 평가, 전망에 대해 심도 있는 토론을 위한 장입니다. ‘행정법의 개혁과 과제’를 시작으로 ‘행정재판’, ‘국제법’, ‘법제개혁과 사회발전의 과제’ 등 다양한 분야에서 양국의 전문가들이 양국의 법제개혁에 관한 각국의 경험과 정보를 교환하고,

각국의 법제의 현황 및 개선 방안에 관해 충분히 논의해주실 것으로 기대합니다. 그리고 오늘 논의된 내용은 향후 진행될 한몽 FTA 체결에 있어서도 좋은 참고자료가 될 수 있을 것으로 생각합니다.

한국법제연구원은 한국 유일의 법제전문 국책연구기관으로서, 법제를 전문적으로 조사·연구하고 법령정보를 체계적으로 수집·관리함으로써 국가입법정책의 지원과 법률문화의 향상을 목적으로 설립된 정부출연 국책연구기관입니다. 한국법제연구원은 오늘 논의된 내용을 기반으로 해서 한몽간 법제교류와 연구를 지속적으로 진행하여 향후 한몽간 법제교류의 증추가 될 수 있도록 노력하겠습니다.

끝으로 이 학술행사를 준비하느라 수고해주신 모든 분들께 감사의 말씀을 드립니다.

МЭНДЧИЛГЭЭ

МУИС-ийн ХЗС-ийн захирал

проф.Ж.Эрдэнэбулган

БНСУ-ын Хууль зүйн үндэсний хүрээлэн, БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургууль, Монгол улсын Хууль зүйн яам, Шүүхийн Ерөнхий зөвлөл Монголын улсын Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хамтран зохион байгуулж буй “Солонгос-Монгол улсын эрх зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт ноёд, хатагтай, профессор, багш нар бусад оролцогч та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Юуны өмнө энэхүү хурлыг зохион байгуулахад хамтран ажилласан байгууллага, хүмүүс тэр дундаа БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургууль дахь Солонгосын эрх зүйн боловсролын төвийн захирал, профессор Кан Гүчол болон тус төвийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Өнөөдрийн энэхүү хурал нэлээд өргөн сэдвийн хүрээнд маш чухал асуудлуудыг авч үзэж байгаа бөгөөд ийм ч учраас хоёр улсын эрх зүйн салбарын судалгааны гол төв байгууллагууд оролцож байна. Мөн үүнээс гадна тус хуралд Солонгос болон Монголын судлаач, эрдэмтэд төдийгүй Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн судалгааны хүрээлэн, хүний эрхийн комиссийн Байнгын хорооны гишүүн, шүүгч, прокурор, хууль зүйн яамны төлөөллүүд оролцож өөр өөрсдийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар илтгэл хэлэлцүүлж байгаа нь энэхүү хурлын ач холбогдлыг өндөрсгөж байгаа юм.

Бидний хийж байгаа энэхүү хурал нь хоёр улсын эрх зүйн боловсрол, хуулийн салбарын хамтын ажиллагааны нэгээхэн хэсэг болох бөгөөд бидний хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлнэ гэдэгт миний бие эргэлзэхгүй байна. Цаашид бид эрх зүйн салбарын тодорхой асуудлуудаар хамтарсан судалгааг нарийвчлан хийх хэрэгтэй байна.

Энэхүү ажлыг хэрэгжүүлэхэд БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургууль дахь Солонгосын эрх зүйн боловсролын төвийн анхны төгсөгч оюутнууд маань гол боловсон

хүчин болох бөгөөд тэд солонгосын эрх зүйн боловсролыг өөрийн орондоо эзэмшсэн ахны мэргэжилтнүүд гэдгээрээ бахархаж байх ёстой.

Солонгос-Монгол улсын судлаачдын тавих илтгэл маш сонирхолтой, өнөө үед Монгол улсад эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй чухал асуудлуудыг хөндсөн байна.

Ингээд хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч нийт оролцогч та бүхэнд эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Баярлалаа.

환영사

몽골 국립대학 법과대 학장

교수 E.Erdenebulgan

한국 법제연구원, 국민대학교 법대, 몽골 법무부, 법제연구원, 법원평의회, 몽골 국립대학교 법대가 공동 개최한 “한국과 몽골의 법제개혁, 평가와 전망” 한-몽 국제학술대회에 참석하신 친애하는 참석자 여러분 안녕하십니까?

우선 이번 학술대회를 개최할 때 많은 도움을 해주신 조직과 사람들 그 중에서 몽골한국법교육센터 강구철 교수님과 몽골한국법교육센터 직원들에게 감사 말씀을 드립니다.

이번 학술대회는 매우 광범위한 주제 내에서 매우 중요한 문제로 토의하기 위해 양국 법률분야 연구기관들이 참여하고 있습니다. 또한, 이번 학술대회에 한국과 몽골의 교수님들뿐만 아니라 한국헌법재판소 연구관, 한국 국민권익위원회 상임위원, 판사, 검사, 법무부 대표님들 참여하여 자신의 분야에 대한 평가와 전망에 대해 토론하는 것이 이번 학술대회의 중요성을 의미하는 것입니다.

우리가 개최하는 이번 학술대회는 양국의 법률 교육, 법적 협력의 일환으로 우리의 협력을 확대한다고 믿습니다. 앞으로 우리는 사법분야의 특정분야에 대한 깊은 세부적 공동 연구를 할 필요가 있습니다. 이와 같은 일을 수행할 때 몽골한국법교육센터의 졸업 학생이 주요한 인물 될 것입니다.

이번 한-몽 연구자들의 발표는 몽골의 법제 개혁의 중요한 문제를 제기하고 있다고 생각합니다.

오늘 참석하신 여러분에게 건강과 행운을 기원합니다.

감사합니다.

Мэндчилгээ

Монгол улсын ШЕЗ-ийн ШСМСХ-ийн захирал Доктор Ц.Мандах

Эрхэмсэг зочид оо,

Хатагтай, ноёд оо,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Эрхэм хүндэт хурал зохион байгуулагчийн зүгээс энэхүү эрдэм шинжилгээний хуралд намайг урьж, үг хэлэх завшаан олгосон явдалд чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. Монгол, Солонгос хоёр улсын эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, эрдэмтэн эрхэмсэг та бүхэнтэй энэхүү эрдэм шинжилгээний хурал дээр уулзаж байгаагаа нэр төрийн хэрэг хэмээн үзэж байна.

Монгол, Солонгос хоёр улс нь ахан дүүсийн орнууд гэж дуудагдах хэмжээнд он удаан жилийн түүхэн хугацаанд гарал угсаа, соёл заншил, оюун сэтгэлийн нарийн харилцаа холбоотой явж ирсэн билээ. Энэхүү найрамдалт харилцаандаа суурилан хоёр улс 1990 онд дипломат харилцаа тогтоосноос хойш улс төр, эдийн засаг, худалдаа, нийгэм, соёл, хөгжлийн хамтын ажиллагааны олон салбар дахь харилцаа, хамтын ажиллагаагаа хурдацтай хөгжүүлсээр ирсэн юм.

Хоёр улсын найрсаг хамтын ажиллагааны хүрээнд хууль, шүүхийн салбар дахь хамтын ажиллагаа мөн эрчимтэй хөгжиж ирсэн юм. Хууль, шүүхийн салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд хоёр орны хууль, шүүхийн салбарын эрдэм шинжилгээний байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа чухал байр суурийг эзлэх бөгөөд энэхүү зохион байгуулагдаж байгаа хурал нь манай хоёр улсын хууль, шүүхийн салбарын хамтын ажиллагаанд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

“Солонгос-Монгол Улсын эрх зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт энэхүү эрдэм шинжилгээний хурал нь өнөөдөр 2 улсын захиргааны эрх зүйн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, захиргааны шүүхийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, олон улсын салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, хууль эрх зүйн шинэчлэл ба нийгмийн хөгжлийн зорилт зэрэг 2 улсын хууль шүүхийн салбарын өнөөгийн

байдал, цаашдын чиг хандлага зэрэг өргөн хүрээний хамтын ажиллагаа, чиг хандлагыг хэлэлцэх хариуцлагатай индэр болоод зогсохгүй харилцан ойлголцох, нийтлэг үнэт зүйлсээ хамгаалах тухай ярилцах таатай нөхцөл бүрдсэнийг онцолмоор байна.

Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэнээр хүний эрх, эрх зүйт ёс, төрийн эрх мэдлийн хяналт, тэнцвэрийн зарчимд суурилсан шинэ шүүх засаглалтай болохоор шинэтгэлийн томоохон алхмуудыг авч хэрэгжүүлж ирсэн. Одоогоос 5 жилийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга дор шүүхийн шинэтгэлийг эхлүүлж, шүүхийн багц хуулиудыг баталсан.

Энэ хүрээнд Шүүхийн захиргааны төв байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлийг шүүхээс бие даалгаж тусдаа байгуулсан. Улмаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бүх шатны шүүхийг мэдээлэл, судалгаагаар хангах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих, хууль зүйн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэйгээр Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнг 2014 онд байгуулсан. Энэхүү академик байгууллага нь Монгол Улсын шүүхийг мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллахын зэрэгцээ шүүхийн судалгааг хийдэг, сургалтыг зохион байгуулдаг байгууллагын хувьд гадаадын адил төстэй сургалт, судалгааны байгууллагатай хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай болно. Хэдийгээр тус хүрээлэн нь байгуулагдаад удаагүй боловч бие даан гадаад харилцааг өргөтгөх хүрээнд хоёр хөрш зэргэлдээ орны судалгаа, шинжилгээ, сургалтын байгууллагатай хамтын ажиллагааг тогтоон ажиллаж байгаа бөгөөд цаашид найрамдалт харилцаатай улс болох БНСУ-ын хууль, шүүхийн хүрээний судалгаа, шинжилгээ, сургалтын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллах зорилготой байна. Шүүхийн ерөнхий зөвлөл нь МУИС-ийн БНСУ-ын эрх зүйн боловсролын төвтэй найрсаг хамтын ажиллагаатай бөгөөд 2014 онд БНСУ-ын ХЗЯ-ны дэмжлэгтэйгээр нийт Монгол Улсын 33 иргэний хэргийн шүүгчид зориулж “Тэр бүлийн маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэх нь” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан юм. Мөн 2014 онд БНСУ-ын Күүкмины их сургуулийн Хуулийн сургуулийн 20 оюутанд Монгол Улсын шүүхийн тогтолцоо түүний өөрчлөлт, Шүүхийн тухай багц хууль, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны талаар танилцуулах зэрэг хүрээнд хамтын ажиллагааг эхлүүлсэн юм.

Хамтын ажиллагааны хүрээнд маргааш буюу 7-р сарын 28-ны өдөр БНСУ-ын Хууль зүйн

ям, Шүүхийн захиргааны газраас Монгол Улсын иргэний хэргийн шүүгчид зориулж “Хүүхдийн асрамжлагчийг тогтоох, эд хөрөнгийн маргааныг хянан шийдвэрлэх практик, эрх зүйн зохицуулалт” сэдвээр сургалтыг зохион байгуулах бөгөөд сургагч багшаар тус хуралд оролцож байгаа эрхэм хүндэт шүүгч У Сэюун хичээлийг заах болсныг энэхүү завшааныг далимдуулан онцолж, талархалаа илэрхийлж байна.

Тус хүрээлэн нь гадаад хамтын ажиллагааг чухалчлахын зэрэгцээ дотоодын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай нягт холбоотой ажилладаг бөгөөд манай судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагаанд хурал зохион байгуулагч талууд болох ХЗҮХ, МУИС-ийн ХЗС-тай тогтмол амжилттай хамтран ажилладгийг энэхүү завшааныг далимдуулан онцолж, талархлаа илэрхийлье.

Иймд өнөөдрийн энэхүү эрдэм шинжилгээний хурал нь Монгол Улс, БНСУ-ын хууль, шүүхийн байгууллагууд хоорондын найрсаг хамтын ажиллагаанд онцгой чухал үүрэгтэй болохыг онцлон тэмдэглэж байна.

Энэхүү хуралд манай Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаачид идэвхтэй оролцож байгааг дуулгахад таатай байгаа бөгөөд тус хурлаар миний бие эрхэм хүндэт прокурор Су Жонсү (Солонгосын ХЗЯ)-ын илтгэлийг хэлэлцүүлэхээр уригдсанд талархлаа илэрхийлж байна.

Ингээд энэ хурлыг зохион байгуулахад бие хүч, сэтгэл санаа, оюун ухаанаа дайчлан оролцож хичээл зүтгэл гаргасан бүх хүнд Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархлаа илэрхийлж, хурал амжилттай явагдаж Монгол Улс, БНСУ-ын хууль, шүүхийн салбар дахь харилцаа, хамтын ажиллагаа улам бүр гүнзгийрэхийг хүсэн ерөөж та бүхэнд амжилт хүсье.

Баярлалаа.

축사

몽골 법원평의회 박사 Ts.Mandakh

존경하는 조직자들에게 이번 회의 추대해주시고 축사할 기회 주셔서 진심으로 감사드립니다. 양국 학자님들, 연구자님들 만나 뵙게 돼서 아주 영광스럽습니다.

한국과 몽골은 형제의 나라로 볼릴 만큼 오랜 역사를 공유하면서 인종적, 문화적, 정서적으로 특별한 유대관계를 이어왔습니다. 이러한 배경을 바탕으로 양국은 1990년 수교 이래 정치, 경제·통상, 사회, 문화, 개발협력 등 다양한 분야에서 교류와 협력을 빠른 속도로 발전시켜 왔습니다.

양국 강화를 바탕으로 법률, 법정 분야의 협력을 고도성장 시켜왔습니다. 이번 학술회의도 중요한 지위를 소유하고 있으며 큰 도움이 되기를 기대하고 있습니다.

“한국과 몽골의 법제개혁, 전망”이란 학술회의는 행정법제개혁 전망, 행정재판개혁 전망, 국제개혁 전망, 법제변경과 사회개발 목적 등 양국 법률 법정 분야 개혁, 전망 등 광범한 협력과 경향을 논의하는 중요한계기가 될 겁니다.

몽골은 민주주의 제도 이동하고 인권, 균형의 원칙에 근거한 사법을 제정하러 노력 해왔습니다. 5년 전 몽골 대통령 발의 의하여 법원 변경을 실시했으며 법정 조직법을 제정했습니다.

그래서 법원평의회를 법원에서 따로 발생시켰습니다. 따라서 법원평의회는 각급법원 정보, 조사를 제공하고, 판사와 법원행정관들을 전문개발 지원하고, 지속적인 법률교육을 조직할 기본적인 목적으로 2014 년에 법원조사 정보 교육원이 설치되었습니다. 이러한 목적에 따라 같은 기능을 담고 있는 기관들과 교류와 협력하는 것이 필요성이 높습니다. 비록 설치는 늦었지만 법원평의회 목적에 대한 독립적으로 행동하고 있으며 이번 회의를 통해서 많이 참고 할 것 이라고 생각합니다. 법원평의원과 몽골국립대학교 법과대학은 2014년에 대한민국 법무부 지원을 받고 몽골 민사사건 판사 (모두 33명) 들에게 “가정사건의 재판” 제목에 따라 세미나, 법과 대학 20명 학생들에게 몽골의 법정제도, 법원 조직법, 법원평의회 절차에 대해 소개시키는 등으로 교류 실시되었습니다.

내일 (07.28)에 대한민국 법무부와 법정행정처에서 조직한 세미나에 오늘 회의에 참가하고 있는 오세용 판사님께 감사합니다.

몽골법원평의회는 국제 협력을 강조할 뿐만 아니라 국내 대학교, 학술관들과 몽골법제연구

원, 몽골국립대학교 법과대학과 밀접한 관계가 있다는 것을 이번 기회를 통해서 말씀드리겠습니다.

이러한 이유로 이번 회의의 중요성이 많다고 강조하고 싶습니다.

그리고 몽골법원평의회 많은 연구자들 참가하고 있으며, 제가 한국 법무부의 소정수 검사님의 발표에 토론 맡게 되서 감사함을 표현합니다.

마지막으로 오늘 참가해주신 모든 분들 특히 조직자 여러분들에게 몽골법원평의회 대표하여 다시 한 번 감사드리겠습니다.

Session 1

**Захиргааны шүүхийн өнөөгийн байдал,
цаашдын чиг хандлага
행정재판의 개혁과 과제**

**БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ УРЬДЧИЛАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО БА
ТУЛГАМДСАН АСУУДАЛ
한국 행정심판제도의 현황과 과제**

Илтгэгч: **Ким Тэхи** (Солонгосын хүний эрхийн комиссийн Байнгын хорооны гишүүн)

бэлтгэл: **김대희** 상임위원(한국 국민권익위원회)

Хэлэлцүүлэгч: **Дэд проф. Г.Банзрагч** (МУИС-ийн ХЗС)

Толгой: **G. Banzragch** 교수(몽골국립대)

БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО БА ТУЛГАМДСАН АСУУДАЛ

2016. 7.



1

**Захиргааны урьдчилан шийдвэрлэх
ажиллагааны ойлголт**



Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны ойлголт






- ◆ **Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зорилго**
 - Захиргааны байгууллагын хууль бус буюу зүй бус шийдвэр, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх ба үүнээс татгалзах зэргээс шалтгаалж зөрчигдсөн иргэний эрх болон ашиг сонирхлыг сэргээж, захиргааны хэвийн үйл ажиллагааг хангахад оршино.
- ◆ **Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулах нь**

Харьцуулалт		Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа
Нийтлэг тал		- Захиргааны процессын ажиллагаа, хуулийн хэрэгжилтийг хангах - Хэргийн оролцогчдын хоёр талыг шүүх хуралдаанд оролцуулж тэгш байдлыг хангах зарчим - Хууль зүйн хувьд ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд нэхэмжлэл гаргах - Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны болон шүүхийн шийдвэрийг биелүүлэх	
Ялгаатай тал	Гол зорилго	Захиргааны хяналт ба зөрчигдсөн эрх ашгийг сэргээх үүрэгтэй	Зөрчигдсөн эрх ашгийг сэргээх үүрэгтэй
	Захиргааны процессын ажиллагааны хүрээ	Хууль ёсны болон зорилгод нийцсэн эсэхийг шалгана	Зарчмын хувьд хууль ёс эсэхийг л шалгана
	Захиргааны процессын ажиллагааны хүрээ	Процессын хялбаршуулсан ажиллагаа	Процессын үндсэн ажиллагаа
	Захиргааны процессын ажиллагааны төрөл	Даалгах нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн	Даалгах нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөөгүй

3

Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны объект



Захиргааны акт

- ◆ Тодорхой хууль зүйн фактын дагуу захиргааны байгууллагын хууль хэрэгжүүлэх буюу төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эсхүл үүнээс татгалзах зэргийн үйлдэл

Эс үйлдэхүй

- ◆ Захиргааны байгууллагаас оролцогчийн хүсэлтээр тодорхой хугацааны дотор тодорхой захиргааны акт гаргах ёстой байтал шийдвэрлэхгүй орхигдуулах

4

Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны төрөл

국민권익위원회
Anti-Corruption & Civil Rights Commission

Хүчингүй болгох	◆ Захиргааны байгууллагын хууль бус буюу зүй бус захиргааны актыг хүчингүй болгох эсхүл өөрчлөх ажиллагаа
Хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх	◆ Захиргааны байгууллагаас захиргааны акт гаргасан эсэх, хүчин төгөлдөр эсэхийг шалгах ажиллагаа
Даалгах	◆ Оролцогчийн хүсэлтийн дагуу захиргааны байгууллагын хууль бус буюу зүй бус татгалзал эсхүл эс үйлдэхүйд тодорхой захиргааны акт гаргуулахаар даалгах ажиллагаа

5

Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны холбогдох хууль тогтоомж

국민권익위원회
Anti-Corruption & Civil Rights Commission

Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хууль	◆ “Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тухай ерөнхий хууль” (Нийт 8 бүлэг, 61 зүйл)
Бусад онцгой хууль	◆ “Төрийн албан хаагчийн тухай хууль”(Төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлийн талаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа), “Төрийн татварын ерөнхий хууль”(Татварын маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа) гэх мэт


※ БНСУ-ын Үндсэн хуулийн 107 дугаар зүйлийн 107.3 дахь хэсэг : Шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагааны өмнөх шатаар захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж болно. Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны процессыг хуулиар тогтоох боловч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг баримтална.

6





Төв захиргааны урьдчилан шийдвэрлэх хороо



국민권익위원회
Anti-Corruption & Civil Rights Commission

Үүсэл хөгжил


- ◆ **Холбогдох хууль тогтоомж** : Үндсэн хуулийн 107 дугаар зүйлийн 107.3 дахь хэсэг, Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль
- ◆ **Байгуулагдсан огноо** : 1985.10. Ерөнхий сайдын захиргааны урьдчилан шийдвэрлэх хороо
- ◆ **Хорооны нэр өөрчилсөн огноо** : 2010. 7. Төв захиргааны урьдчилан шийдвэрлэх хороо

Хорооны чиг үүрэг

- ◆ Дараах захиргааны байгууллагын акт буюу эс үйлдэхүйд холбогдуулан гаргасан гомдлын дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэн шийдвэрлэнэ.
 - Ерөнхийлөгчийн харьяа байгууллагын дарга, Ерөнхий сайд болон бусад сайд, яамдын харьяа байгууллага
 - Дээд шатны Засаг дарга нар, дээд шатны засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн боловсрол хариуцсан Засаг дарга
 - Төрийн бүтэц, зохион байгуулалтын тухай хууль буюу бусад ердийн хуулийн дагуу байгуулсан орон нутгийн тусгай төв захиргааны байгууллага

10

Төв захиргааны урьдчилан шийдвэрлэх хорооны мөн чанар



Хянан шийдвэрлэх байгууллага	◆ Урьдчилан шийдвэрлэх захиргааны хэргийг хянан шийдвэрлэж бүх нийтэд үйлчлэх хүчин чадал бүхий шийдвэрийг гаргаг байгууллага
Хамтын хариуцлагын байгууллага	◆ Хуралд ололцсон гишүүдийн олонхийн саналаар урьдчилан шийдвэрлэж журмаар гаргасан гомдлыг шийдвэрлэдэг хамтын хариуцлагын байгууллага (Гишүүдийн дийлэнх нь төрийн бус олон нийтийн гишүүн)
Шүүх эрх мэдлийг шилжүүлэн авч хэрэгжүүлэх байгууллага	◆ Процессын ажиллагааг хэрэгжүүлж, бие даан хянан шийдвэрлэх эрх мэдэл бүхий байгууллага

11

Хороо болон хурлын бүрэлдэхүүн



Гишүүний бүрэлдэхүүн : нийт 50 гишүүн

- ◆ Хорооны дарга 1 хүн (Иргэний эрх ашгийг хамгаалах хорооны дэд дарга)
- ◆ Байнгын гишүүн 3 хүн, байнгын бус гишүүн 46 хүн 2016. 5-р сары байдлаар



Хурлын бүрэлдэхүүнт гишүүн : 9 хүн

- ◆ Хорооны дарга, байнгын 2 гишүүн, байнгын бус 6 гишүүн нийт 9 гишүүн оролцдог.
- ◆ Хуралд байнгын бус гишүүний дийлэнх оролцоно.

12

Хорооны гишүүний шалгуур ба бүрэн эрхт хугацаа

국민권익위원회
Anti-Corruption & Civil Rights Commission

Гишүүний шалгуур

- ◆ Өмгөөлөх эрхтэй байх (практикт 5 жилээс дээш ажилласан байх)
- ◆ Их сургуулийн багш(дэд багшаас дээш зэрэгтэй байх)
- ◆ 4 дүгээр зэргээс дээш эсхүл дээд албан тушаал бүхий төрийн албан хаагчаар ажиллаж байгаа эсхүл ажиллаж байсан
- ◆ Докторын зэрэг хамгаалсан (тухайн салбарт 5 жилээс дээш ажилласан байх)
- ◆ Үүнээс гадна захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдлэг, туршлагатай хүн

Бүрэн эрхт хугацаа

- ◆ Байнгын гишүүн : 3 жил
(1 удаа улируулан ажилуулж болно, нийт 6 жил)
- ◆ Байнгын бус гишүүн : 2 жил
(2 удаа улируулан ажилуулж болно, нийт 6 жил)

13

Хурлын төрөл

국민권익위원회
Anti-Corruption & Civil Rights Commission

Үндсэн хорооны хурал

- ◆ Долоо хоног бүр мягмар гарагт, сард 4 удаа (жилд 46 удаа хуралдана.)
- ◆ Хорооны дарга, байнгын 2 гишүүн, байнгын бус 6 гишүүн нийт 9 гишүүн оролцдог.

Бага хорооны хурал

- ◆ Үндсэн хорооны хурал болох өдрийн өглөө хуралдана.
- ◆ Жолооны үнэмлэхтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэнэ.
- ◆ Байнгын 2 гишүүн, байнгын бус 2 гишүүн нийт 4 гишүүн оролцдог.

Мэргэжлийн хорооны хурал

- ◆ Тодорхой салбар(мэдээлэл технологи, цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалал, анагаах ухаан) –ын хэргийг хянан шийдвэрлэнэ.
- ◆ Салбар бүрийн мэргэжилтнээр бүрэлдсэн мэргэжлийн хорооноос сар болгон нэгээс дээш удаа хуралдана.
- ◆ Байнгын гишүүн, байнгын бус гишүүн зэргээр нийт 4-5 гишүүн оролцдог.

14



3

Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны одоогийн байдал

Урьдчилан шийдвэрлэсэн хэргүүд



Жилд 25 мянга гаруй хэргийг хянан шийдвэрлэдэг ('15жил 24,425 хэрэг)

Ангилал Жил	Хүлээн авсан хэрэг	Хянан шийдвэрлэсэн хэрэг				Хангаж шийдвэрлэсэн хувь (%)	Гомдлоо буцаасан шилжүүлсэн
		Нийт	Хангаж шийдвэрлэсэн	Хангаагүй	Буцаасан		
2011	28,058	28,923	4,840	23,084	999	16.7	1,063
2012	25,317	24,987	3,983	19,974	1,030	15.9	1,015
2013	25,570	24,405	4,227	18,820	1,358	17.3	1,088
2014	25,301	25,270	4,131	19,164	1,975	16.3	1,068
2015	24,425	24,947	3,933	18,627	2,387	17.4	1,433

2016 оны 7-р сарын дунд үеэр

- Одоогийн байдлаар 14,298 хэргийг хүлээн авч, 12,742 хэргийг хянан шийдвэрлэсэн.





БНСУ-ын захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал (1)



Улсын төлөөлөгчийн тогтолцоо

◆ Тогтолцоог нэвтрүүлэх болсон шалтгаан

Хэргийн бодит байдал ба хууль зүйн ашиг сонирхлын зөрчил бүхий ээдрээтэй хэрэг нэмэгдэж захиргааны урьдчилан шийдвэрлэх гомдлыг төлөөлөгчөөр дамжуулж гаргах нь элбэг болсон.

→ Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг хамгаалах улсын төлөөлөгчийн тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай.

◆ Хамаарах этгээд ба хүрээ

Гомдол гаргагчийн эдийн засгийн байдал, өндөр нас, хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг бүхэлд нь шалгаж тус тогтолцоонд хамрах этгээдийг сонгоно.

◆ Үйл ажиллагааны хүрээ

Хэргийн тухай зөвлөх, гомдол, хариу тайлбар гаргах, бичих, хянан шийдвэрлэх ажиллагаанд аман тайлбар гаргах гэх мэтийн төлөөллийн үйл ажиллагаа

БНСУ-ын захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал (2)



Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны гомдлыг хангаж шийдвэрлэсэн шийдвэрийг биелүүлэх

- ◆ Захиргааны байгууллагаас гомдлыг хангаж шийдвэрлэсэн боловч зохих захиргааны актыг гаргах байвал уг шийдвэрийг биелүүлэх хүртэл тодорхой хэмжээний нөхөн төлбөр гаргуулах тогтолцоо
- ◆ Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэж гаргасан шийдвэр үүр нөлөө нэмэгдэнэ

21

БНСУ-ын захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал (3)



Захиргааны урьдчилан шийдвэрлэх тусгай ажиллагааны нэгдсэн байдлыг хангах

- ◆ **Одоогийн байдал ба тулгамдсан асуудал**
Захиргааны урьдчилан шийдвэрлэх тусгай ажиллагаагаар
① улсын татвар, орон нутгийн татварын маргаан, ② патентын маргаан, ③ төрийн албан хаагч, багшийн гаргасан гомдолтой холбоотой маргаан, ④ шударга өрсөлдөөнтэй холбоотой маргаан гэх мэт олон маргаан байдаг.

→ Тус бүр өөр процессоор явагддаг бөгөөд холбогдох байгууллагын бие даасан болон объектив байдал сул.

22

БНСУ-ын захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал (3)



Захиргааны урьдчилан шийдвэрлэх тусгай ажиллагааны нэгдсэн байдлыг хангах

◆ Асуудлыг шийдвэрлэх арга

Захиргааны урьдчилан шийдвэрлэх тусгай ажиллагааг ерөнхий ажиллагаатай нэгтгэж, (сорилт нэр)“захиргааны урьдчилан шийдвэрлэх хороо” гэдэг хянан шийдвэрлэх нэгдсэн байгууллагыг шинээр байгуулах

-Патентын маргаан гэх мэт өндөр мэргэжлийн мэдлэг шаардсан маргааны хувьд урьдчилан шийдвэрлэх ерөнхий ажиллагаанд нэгтгэхгүй байх.

- Нэгтгэх маргааныг салбар бүрээр хариуцсан хянан шийдвэрлэх газрыг байгуулах

23

БАЯРЛАЛАА



한국 행정심판제도의 현황과 과제

2016. 7.



1

행정심판 제도의 개관



행정심판 제도

◆ 행정심판의 목적

- 행정청의 위법하거나 부당한 처분 그 밖에 공권력의 행사·불행사 등으로 인한 국민의 권리 또는 이익의 침해를 구제하고, 행정의 적정한 운영을 기하는데 있음

◆ 행정소송과의 비교

구분		행정심판	행정소송
같은 점		<ul style="list-style-type: none"> - 쟁송절차, 사법적 성질의 작용 - 대심구조 - 법률상 이익이 있는 자가 제기 - 재결 또는 판결에 기속력 	
다른 점	주된 목적	행정감독적 및 권리구제 기능	권리구제 기능
	쟁송 범위	적법성 및 합목적성	원칙적으로 적법성만 판단
	쟁송의 성격	약식쟁송	정식쟁송
	쟁송종류	의무이행심판 인정	의무이행소송 불인정

3

행정심판의 대상

처분

- ◆ 행정청이 행하는 구체적 사실에 관한 법집행으로서의 공권력의 행사 또는 그 거부, 그 밖에 이에 준하는 행정작용

부작위

- ◆ 행정청이 당사자의 신청에 대하여 상당한 기간 내에 일정한 처분을 하여야 할 법률상 의무가 있는데도 처분을 하지 아니하는 것

4

행정심판의 종류

취소심판

- ◆ 행정청의 위법·부당한 처분을 취소 또는 변경하는 심판

무효등 확인심판

- ◆ 행정청의 행정청의 처분의 효력 유무 또는 존재 여부를 확인하는 심판

의무이행 심판

- ◆ 당사자의 신청에 대한 행정청의 위법 또는 부당한 거부처분이나 부작위에 대하여 일정한 처분을 하도록 하는 행정심판

5

행정심판 관계법령

행정 심판법

- ◆ 행정심판에 관한 기본법(총 8장 61조)

기타 특별법

- ◆ 국가공무원법(국가공무원의 징계에 관한 심판), 국세기본법(조세심판) 등


※ 대한민국 헌법 제107조제3항 : 재판의 전심절차로서 행정심판을 할 수 있다. 행정심판의 절차는 법률로 정하되, 사법절차가 준용되어야 한다.

6






중앙행정심판위원회



국민권익위원회
Anti-Corruption & Civil Rights Commission

설치근거 및 연혁

- ◆ 관련법령 : 헌법 제107조제3항, 행정심판법
- ◆ 설치일자 : 1985.10. 국무총리행정심판위원회
- ◆ 명칭변경 : 2010. 7. 중앙행정심판위원회




위원회의 기능

- ◆ 다음 행정청의 처분이나 부작위에 대한 심판청구사건의 심리·재결
 - 대통령 소속기관의 장, 국무총리 및 행정 각 부 장관 및 그 소속기관
 - 특별시장·광역시장·도지사·제주특별자치도지사 및 교육감
 - 정부조직법이나 다른 법률에 따라 설치된 국가특별지방행정기관

10

위원회의 성격



심리·재결기관	<ul style="list-style-type: none"> ◆ 심판청구사건을 판단하고 대외적인 기속력을 가지는 재결을 하는 기관
합의제 행정기관	<ul style="list-style-type: none"> ◆ 출석위원 과반수의 찬성으로 재결하는 합의제기관 (과반수 이상은 민간위원)
준사법적 행정기관	<ul style="list-style-type: none"> ◆ 소송법적 절차를 적용하며 독립적으로 판단·재결하는 권한을 가진 기관

11

위원 및 회의 구성



위원의 구성 : 총 50인

- ◆ 위원장 1인(국민권익위원회 부위원장)
- ◆ 상임위원 3인 및 비상임위원 46인

2016. 5. 현재

임명직 : 4인

변호사 : 23인

법대 교수 : 16인

의사 : 5인

사회대 교수 : 2인

※ 여성위원 : 16인

회의구성 위원수 : 9인

- ◆ 위원장, 상임위원 2인 및 비상임위원 6인 등 총 9인 참석
- ◆ 비상임위원이 과반수 이상 참석

12

위원의 자격 및 임기

위원의 자격

- ◆ 변호사 자격 소지자(실무경험 5년 이상)
- ◆ 대학 교수(조교수 이상)
- ◆ 4급 이상 공무원 또는 고위 공무원단이었던 자
- ◆ 박사학위 취득자(해당분야 5년 이상 근무경험자)
- ◆ 그 밖에 행정심판에 관한 지식과 경험이 있는 자

위원의 임기

- ◆ 상임위원 : 3년
(1회 연임 가능, 총 6년)
- ◆ 비상임위원 : 2년
(2회 연임 가능, 총 6년)

13

회의운영

본위원회 회의

- ◆ 매주 화요일, 월 4회 개최 (통상 연간 46회 개최)
- ◆ 위원장, 상임위원 2인 및 비상임위원 6인 등 총 9인 참석

소위원회 회의

- ◆ 본 회의 개최일 당일 오전에 개최
- ◆ 운전면허사건의 심리·재결
- ◆ 상임위원 2인, 비상임위원 2인 등 총 4인 참석

전문위원회 회의

- ◆ 특정분야(정보공개분야 및 보훈·의료) 사건의 전문심리
- ◆ 분야별 전문가로 구성된 전문위원회를 각 월 1회 이상 개최
- ◆ 상임위원, 비상임위원 등 4~5인으로 구성

14



사건 처리




국민권익위원회
Anti-Corruption & Civil Rights Commission

연간 2만5천건 내외의 사건을 처리('15년 24,425건)

구분 연도	접수 (건)	심리·의결(건)				인용률 (%)	취하· 이승
		계	인용	기각	각하		
2011	28,058	28,923	4,840	23,084	999	16.7	1,063
2012	25,317	24,987	3,983	19,974	1,030	15.9	1,015
2013	25,570	24,405	4,227	18,820	1,358	17.3	1,088
2014	25,301	25,270	4,131	19,164	1,975	16.3	1,068
2015	24,425	24,947	3,933	18,627	2,387	17.4	1,433

**2016년
7월 중순**

- 현재 14,298건 접수, 12,742건 처리



4

한국 행정심판의 과제



한국 행정심판의 과제 (1)



행정심판 국선대리인제도

- ◆ 도입배경
사실관계 및 법리가 복잡한 사건의 증가로 행정심판
청구시 대리인 선임 비율이 지속적 증가
→ 사회적 약자에 대한 권리구제 확대를 위한
국선대리인 제도 도입 필요
- ◆ 지원대상 및 범위
청구인의 경제적 여건, 고령, 장애상황 등을
종합적으로 고려하여 제도 지원 대상 선정
- ◆ 업무 범위
사건 상담, 청구서 및 보충서면 작성·제출, 구술
심리 참석 진술 등 심판 대리업무 수행

한국 행정심판의 과제 (2)

행정심판 인용재결에 대한 간접강제 도입

- ◆ 행정청이 인용재결에 따른 처분을 하지 않는 경우, 이행시까지 행정청에게 일정 금액의 배상을 명하는 제도
- ◆ 행정심판 인용재결의 실효성 제고 기대

21

한국 행정심판의 과제 (3)

특별행정심판의 일원화

- ◆ 현황 및 문제점

특별행정심판으로 ① 국세 및 지방세 심판,
② 특허심판, ③ 공무원 및 교원의 소청심사,
④ 공정거래사건에 대한 심판 등이 다수 존재

→ 절차가 다양하고 담당 기관의 독립성 및 객관성이 높지 않음

22

한국 행정심판의 과제 (3)

특별행정심판의 일원화

◆ 개선방안

특별행정심판을 일반행정심판으로 편입하고,
(가칭)행정심판원이라는 통합 심판기관 신설

- 특허심판 등 고도의 전문성이 인정되는 특별심판은 통합대상에서 제외
- 통합되는 특별심판의 분야별로 전담조직(심판부)을 둬

23

감사합니다



Монгол улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ 몽골 행정재판의 평가와 전망

Илтгэгч: **Шүүгч Ц.Цогт** (Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх)

발표: **Ts. Tsogt** 판사(몽골 행정 고등법원)

Хэлэлцүүлэгч: **Шүүгч У Сэюун** (Солонгосын шүүхийн бодлого төлөвлөлтийн судалгааны хүрээлэн)

토론: **오세용** 판사(한국 사법정책연구원)

Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ¹⁾

Ц.Цогт

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

Товч агуулга

Энэхүү илтгэлд Монгол Улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдсан эрх зүйн үндэслэл, шүүхийн тогтолцоонд захиргааны хэргийн шүүхийн эзлэх байр суурь, шүүхийн үйл ажиллагааны төлөвшил, дагнасан шүүхийн тогтолцооны онцлог, хэргийн харьяалал, маргааны төрөл, ачаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, тулгамдсан асуудал зэрэг асуудлыг хөндсөн болно. Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны үр дүн нь (1) дагнасан хэрэг маргааны онцлогт тохирсон өвөрмөц хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон (2) мэргэшсэн шүүгч, хуульчдын чадвараар илэрхийлэгдэн хэмжигдэх учирэдгээр чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг цаашид боловсронгуй болгох шаардлага байгаа. Нөгөө талаар, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн бодит гүйцэтгэл, хэрэгжилт нь энэхүү дагнасан шүүх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгыг гүйцэлдүүлэх эцсийн хэмжүүр болохынхоо хувьд тулгамдсан асуудлын нэгэн болоод байгаа талаар эцэст нь танилцуулах юм.

Түлхүүр үг

Захиргааны хэргийн шүүх, захиргааны хэрэг, дагнасан шүүх, мэргэшсэн шүүгч, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо, захиргааны шүүхийн төлөвшил.

1) “Солонгос-Монгол Улсын эрх зүйн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд зориулсан илтгэл.

Шүүхийн тогтолцоонд захиргааны хэргийн шүүхийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг

Монголын улс төрчид, хуульч-мэргэжилтнүүд Үндсэн хуулийн төсөл боловсруулж эхлэхээс өмнө ч, явцад ч бусад орны шүүхийн, түүний дотор Захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг судалж байсан бөгөөд түүний үр дүнд Захиргааны хэргийн шүүхийн тухай шинэ Үндсэн хуульд анхлан тусгаж чадсан болов уу²⁾. Ардчилсан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудын хэрэгжилт, ялангуяа хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад шүүх байгууллагын тогтолцоо оновчтой, эрх мэдэл хүрэлцэхүйц байх ёстой³⁾. Шинэ үндсэн хууль шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан шүүх байгуулж болохоор заасны дагуу УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 27 дугаар заалт, 2000 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний Стратеги зорилт, арга хэмжээний 1.2.1 –д захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулах талаар шаардлагатай алхмуудыг тодорхойлж ирсэн байна. Улмаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт⁴⁾ тухайлан заасан анхны шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх болох Захиргааны хэргийн шүүх байгуулах зорилго 2002 оны 12 дугаар сарын 26 –ны өдөр батлагдсан Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль батлагдсанаар бодит ажил⁵⁾ болсон юм. Төр засаг “дур зоргоороо аашлах” боломжийг бууруулахад засгийн газар нь дүрэм журмыг мөрддөг, шүүх нь төвийг сахисан байдлаар хуулийг сахиулах нөхцлийг хангадаг хууль дээдлэх ёс чухал үүрэгтэй⁶⁾.

2) Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн мөн чанар, нийгэм – эрх зүйн ач холбогдол. Б.Чимид. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 44 дэх талд. 2004 он.

3) Захиргааны хэргийн шүүх – Хүний эрх. Ц.Цогт. Хүний эрх сэтгүүл 2005 оны №4.

4) Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” –ны 314 дүгээр зүйлийн 6.4.6 дугаар хэсгийн 1072 –д Дагнасан шүүхийн эрх зүйн үндэсийг бүрдүүлж, захиргааны хэргийн шүүхийг байгуулан ажиллуулна хэмээн тодорхойлон төлөвлөж байсан байдаг.

5) “Хэдийгээр Монгол Улсад 1998 онд “Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн тухай” төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан ч өнөөдрийг хүртэл уг хуулийг батлаагүй байна. Захиргааны хэргийн шүүхийг алгуурлахгүй байгуулах нь төр, иргэн хоёр хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг хангах, Монгол Улсын иргэн үндсэн эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдлэх, ингэснээр бидний сонгож авсан ардчилсан нийгмийг төлөвшүүлэх үйл явцын урагшилсан давшингүй нэг алхам болохсон” хэмээн захиргааны эрх зүй судлаач, доктор Д.Сүнжид 2002 онд бичиж байжээ. Захиргааны шүүх байгуулснаар хүний эрхийг хамгаалахад том алхам хийнэ. Д.Сүнжид. Эрх зүйн шинэтгэл сонин. 2002 оны 12 дугаар сар №3.

6) Монгол Улсад Ардчилалын бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ. 2015 он. 13 дах

Шүүхийн тогтолцоон дахь захиргааны хэргийн шүүхийн байр суурь нь анхны хэрэг маргааны төрлөөр дагнасан шүүх гэдгээр тодорхойлогдох бөгөөд дагнасан шүүхээ дагаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан хууль тогтоомж шинээр боловсруулах, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх зэрэг дагалдах онцлог, шаардлагууд тавигддаг, бас хөгждөг болох нь тодорхой болсон юм. Ийм учраас дагнасан шүүх бол шүүхийн тогтолцооны зүгээр л нэг хэсэг нь биш, харин шүүх тогтолцооны цаашдын чиг хандлага, хөгжлийн ирээдүй юм⁷⁾. Орчин үеийн захиргааны эрх зүйн харилцааны чиг хандлага иргэндээ ойр, үйл ажиллагаа нь хүртээмжтэй захиргаа бий болгохын төлөө өөрчлөгдөж байгаа боловч захиргааны эрх зүйн уламжлалт нэг талын давамгайлсан харилцаа, иргэдийн эрх ашиг сонирхлын дээгүүр захиргааны (нийтийн биш тухайн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны) санаа зоригийг тулган хүлээлгэх⁸⁾ эрмэлзэл, хуучин байр суурь харьцангуй хадгалагдсан хэвээр байна. Тиймээс захиргааны үйл ажиллагаан дахь иргэний эрхийн зөрчлийг сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын тогтолцоог зөвхөн захиргааны өөрийн бүтэц, дотоод хяналтад найдаж хариуцуулах боломжгүйд хүрсэн тул захиргааны үйл ажиллагаанд дагнасан шүүхийн хяналтыг бий болгох, улмаар түүгээр дамжуулан иргэний эрхийн зөрчлөөс хязгаарлах, хамгаалах, нээлттэй бас хариуцлагатай захиргааг төлөвшүүлэхэд зорьсон болно. “Захиргааны хэргийн шүүхийн гол зорилго нь иргэний нийтийн эрх зүйн субъектив эрхийг хамгаалах, түүгээр дамжуулан захиргааны үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавихад оршино”⁹⁾ гэж захиргааны эрх зүйн тэргүүлэх эрдэмтэн П.Одгэрэл дүгнэсэн байна. 2010 онд хийгдсэн, “Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн төлөвшил, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт” цогц шинжтэй судалгааны тайланд дурьдсанчлан¹⁰⁾, захиргааны

ь талд.

7) Монгол Улс дахь дагнасан шүүхийн тогтолцоо: үр нөлөө, анхаарах зарим асуудал. М.Батсуурь. Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2013 оны №4(44) 49 дэх талд.

8) “Ард иргэдийн сэтгэлгээнд өөрчлөлт оруулах /даргыг тахин шүтдэг, дарга албан тушаалтнууд буруу зүйл хий дэггүй гэсэн хатуу байр суурьтай байдаг/ хүний салшгүй бүрэн эрхийг хэн дуртай үедээ хөндөж, хууль зөрчих ёсгүй гэдгийг дахин дахин сурталчилж таниулах нь хамгаас чухал гэж үзэж байна” хэмээн захиргааны хэргийн нэгэн шүүгч иргэдэд захиргааны үйл ажиллагаанд өртөгдсөн эрхээ хамгаалуулах боломжтой гэдгийг мэдүүлэх ийн чухлын талаар саналаа бичиж байжээ. Захиргааны процессын хуулийг хэрэглэхэд гарч байгаа хүндрэлүүд, түүнийг шийдвэрлэх арга замууд. У.Бадамсүрэн. Шүүхээс хууль тайлбарлан хэрэглэх онол практикийн тулгамдсан асуудал. 199 дэх талд 2008 он. Улсын дээд шүүх.

9) Захиргааны эрх зүйн ерөнхий анги. П.Одгэрэл. 57 дахь талд. 2016 он. 3.Хэвлэлт.

10) “Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн төлөвшил, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэг

хэргийн шүүх өнгөрсөн хугацаанд иргэд, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлийн дагуу тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан ажиллаж, харьцангуй хурдан хугацаанд төлөвшсөн байна.

Нөгөө талаар, 1992 оны Үндсэн хуулиар тунхагласан төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмын хэрэгжилт, гүйцэтгэх ба шүүх эрх мэдлийн хороонд анх удаа бодит байдлаар бүрдэж тогтох үндэслэл нь захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулсан явдал билээ. Гэхдээ энэ нь төрийн байгууллагын эрх мэдэл хоорондын хуваарилалт, хяналт тэнцэл гэхээс илүүтэйгээр захиргааны үйл ажиллагаанд өртсөн иргэний эрхэд хамгаалалт бий болгох нөхцөл бүрдсэн гэдэг утгаараа ач холбогдол илүү. Аливаа улсад захиргааны эрх зүйн хөгжил нь тодорхой нэг институци, үйл явдал, хууль дагаж үүсч хөгжсөн байдаг, тухайлбал Францад 18 дугаар зууны төгсгөлд хувьсгалын дараахнаас үүссэн Төрийн Зөвлөл (*Conseild'Etat*)-ийн үйл ажиллагаа¹¹), АНУ-д 19 дүгээр зууны сүүлчээр холбооны улсын агентлагууд (*Regulatory Agencies and Commissions*) байгуулагдаж, түүний шийдвэр үйл ажиллагааг дагажтус тус захиргааны эрх зүй хурдацтайхөгжлийн замд орсон гэж үзэж болно. Харин Монгол Улсын орчин цагийн захиргааны эрх зүй нь Захиргааны хэргийн шүүх байгуулагдсан, ажиллаж эхэлсэн цагаас цоо шинэ хөгжил, төвшинд хүрч хөгжиж байгаа, өөрөөр хэлбэл дан ганц захиргааны процессын хууль тогтоомжийн тогтолцоо бус захиргааны эрх зүй бүхэлдээ Захиргааны хэргийн шүүхээ дагаж хөгжиж байна гээд хэлчихээд алд дэлэм алдсан хэрэг болохгүй биз ээ.

Тогтолцооны асуудал

2002 оны Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулиар зөвхөн аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх буюу анхан шатны шүүхүүдийг байгуулсан бөгөөд ингэхдээ аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгчийг тухайн аймгийн давж заалдах шатны (ерөнхий харьяалалын шүүх) шүүхийн ерөнхий шүүгч хавсран ажиллахаар зохицуулсан¹²) байдаг. Түүнчлэн, үүнтэй зэрэгцүүлэн Шүүхийн тухай (2002)

жилт”судалгаанытайлан. 70 дахь талд. 2010 он. Ханнс-Зайделийн сан. 2010 оны байдлаарх захиргааны хэргийн шүүх, түүний үйл ажиллагаанд хийгдсэн энэхүү судалгаанаас холбогдох бусад асуудлыг дэлгэрүүлэн үзэх боломжтой.

11) French Administrative Law and Common-Law World. Bernard Schwartz. 1954 (1923) pp23.

12) 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар Шүүхийн тухай хуульд 32дугаар зүйлд “32.10. Аймгийн захи

оны хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр¹³⁾ аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүх болох талаарх зохицуулалтыг нэмсэн байдаг.

Аймгийн захиргааны хэргийн шүүхийн энэхүү тухайн аймгийн давж заалдах шатны шүүхийн “хавсарга” мэт зохион байгуулалт нь захиргааны шүүхийн үйл ажиллагаа болон зохион байгуулалтад сөрөг үр дагаваруудыг дагуулсаар ирсэн юм. Гагцхүү Улаанбаатар хотод байрлах Нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь хэрэг дээрээ өөрийн тамгын газартай, ерөнхий шүүгчтэйгээр байгуулагдан ажилласан цорын ганц бие даасан, дагнасан шүүх болж байгуулагдсан байлаа.

Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо¹⁴⁾ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай харгалзсан шинжтэй байдаг өөрөөр хэлбэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхны нэгж болох сум, дүүрэгт сум эсхүл сум дундын, дүүргийн шүүх харин аймаг, нийслэлд аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх байх мэтээр. Харин захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулахдаа энэ зүй тогтлоос өөрөөр буюу аймаг, нийслэлийн төвшинд анхан шатны шүүх байгуулсан юм. Энэ нь ч тухайн үеийн улс төр, эдийн засгийн хүчин зүйлс болоод эрх зүйн сэтгэлгээний төлөвшилтэй хамааралтайгаар нэг дор бүрэн төгс захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо бүрдүүлэх боломжгүй байсан, түүнчлэн хэрэг маргааны гаралт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практик, төлөвлөөс хамааран цаашид хэрхэхийг тодорхойлох зорилготой байсантай холбоотой бизээ.

Давж заалдах, хяналтын шатны журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг Шүүхийн тухай (2002) оны хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т оруулсан нэмэлт өөрчлөлт, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д зааснаар¹⁵⁾ Улсын дээд шүүхэд олгосон байдаг. Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны тухайлсан шүүх байгуулалгүйгээр Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим нь нэгэн зэрэг давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үүргийг гүйцэтгэх болсон юм.

ргааных эргийн шүүхийн Ерөнхий шүүгч нь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч байна.” гэсэн хэсэг нэмсэн.

13) 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар Шүүхийн тухай хуульд 161 дугаар зүйл нэмсэн.

14) Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар шүүхийн нийт тогтолцоог Үндсэн ба Дагнасан гэсэн хоёр хэсгээс бүрдэхээр, гэхдээ хяналтын шатны шүүхийн төвшинд нэг шүүхтэй байхаар хуульчилсан.

15) Нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө буюу 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн анх батлагдсан байдлаараа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 –д “*аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны журмаар*” Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим хянан шийдвэрлэнэ гэж заасан байсан.

Захиргааны хэргийг хяналтын шатанд шийдэхдээ “тухайн асуудлаар мэргэшээгүй” 2 шүүгч орж байгаа нь захиргааны хэргийн танхимын нэг шүүгчийг “өөртөө татаж чадвал” олонхоороо шийдвэр гаргах боломжтой болно гэсэн үг¹⁶⁾.

Хэдий тогтолцооны хувьд бүрэн биш¹⁷⁾, анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн зохион байгуулалт асуудалтай байсан ч захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулж ажлыг нь эхлүүлсэн явдал нь “*нийтийн захиргааны үйл ажиллагаанд тавих ерөнхий шүүхийн хяналтыг чанарын хувьд өөрчлөх*”¹⁸⁾ зорилгод нийцсэн хэрэг байлаа.

Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаа эхлүүлснээс хойш 6 жил гаруйн дараа захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг¹⁹⁾ тусд нь байгуулж ажиллуулахаар шийдвэрлэсэнээр 2011 оны 4 дүгээр сарын 01-ны өдрөөс захиргааны хэргийн шүүх тогтолцооны хувьд бүрэн бүрдсэн юм. Ингэснээр Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хэргийг шийдвэрлэдэгтэй холбоотойгоор тухайн хэргийг хяналтын журмаар хэлэлцэхэд захиргааны хэргийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй²⁰⁾ байх, улмаар өөр бусад танхимын шүүгч нарын оролцоотойгоор шийдвэрлэсэн²¹⁾ хэрэгт хуульчид, мэргэжилтнүүдийн зүгээс шүүхийн шийдвэрийн мэргэшсэн байдалд эргэлзэхэд хүргэх зэргээр үүсээд байсан маргаантай асуудлыг

16) “Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн төлөвшил, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэг жилт” судалгааны тайлан. 11 дэх талд. 2010 он. Ханнс-Зайделийн сан.

17) Давж заалдах боон хяналтын шатны шүүхийн үүргийг нэг бүтэц буюу Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим гүйцэтгэж байгаа учир дагнасан шүүхийн хяналтын тогтолцоо төгөлдөр биш байна. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил [судалгааны тайлан-2006]. 9 дэх талд. Б.Чимид нарын судалгааны баг. Хууль зүйн үндэсний төв. Дэлхийн банк “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл. 2008 он.

18) Захиргааны хэргийн шүүхийн өмнөх үеийн шүүхийн хяналт, шинэ тогтолцооны үндэс, Б.Чимид. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 38 дахь талд. 2004 он. Ханнс-Зайделийн сан. Б.Чимид багш энд “ерөнхий шүүхийн хяналт” хэмээсэн нь дагнасан бус шүүхээс захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд учирч байсан доголдолыг илэрхийлэхэд зорьсон бизээ. Ц.Ц

19) 2010 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хууль.

20) Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим тухайн үед 6 шүүгчийн орон тоотой байсан бөгөөд давж заалдах журмаар хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнд тэдгээрийн 3 шүүгч нь томилогдож орсон тохиолдолд хяналтын шатны журмаар тухайн хэргийг хэлэлцэхэд оролцох боломжгүй тул эрүү, иргэний хэргийн танхимаас доод тал нь 2, түүнээс дээш тооны шүүгч нарын бүрэлдэхүүнтэйгээр захиргааны хэргийг хяналтын журмаар хэлэлцэн шийдвэрлэж байсан юм. Ц.Ц

21) “Харин хяналтын шатны тухайд хэрэг, маргааныг ихэнхдээ бусад танхимын шүүгчид шийдвэрлэсэн байна. Хяналтын шатны шүүх хуралдаанд хамгийн олон оролцсон гэх захиргааны хэргийн шүүгч П.Цэцгээд 5 хэрэг ногдож байхад өөр бусад танхимын шүүгч С.Нямжавт-18 хэрэг, Б.Доржготовт-14 хэрэг, Д.Батсайханд-14 хэрэг ногдож байгаа нь захиргааны хэргийн шүүх энэ шатандаа дагнан мэргэшсэн байх зарчим биелэхгүй байна.” Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил [судалгааны тайлан-2006]. 10 дахь талд.

шийдвэрлэсэн. Нөгөө талаар, давж заалдах шатны шүүх байгуулагдаж ажиллан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасан гомдлыг хянан хэлэлцэх болсоноор анхан шатны шүүхүүдийн процессын хуулийн хэрэглээний зөрүүтэй байдлууд жигдрэхэд эерэгээр нөлөөлсөн байдаг.

2016 оны 7 дугаар сарын 01-нээс мөрдөгдөж эхлэх процессын хуульд давж заалдах журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх зарчим, харьяалал зэрэгт нилээдгүй өөрчлөлт орсон хэдий ч цаашид давж заалдах шатны шүүхийн чиг үүргийг дараах асуудлаар илүү тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна. Үүнд, хэрэг маргааны төрөл олширч, шинэ төрлийн захиргааны эрх зүйн харилцаа маргаанууд шийдвэрлэгдэх болсонтой холбогдуулан улсын хэмжээний давж заалдах шатны шүүхийн хувьд танхимын²²⁾ зохион байгуулалтайгаар ажиллах шаардлага байна. Юуны түрүүнд, гааль, татвар, концесс зэрэг эдийн засгийн хэргийн танхим байгуулах. Түүнчлэн, давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гарсан гомдол бүрийг хяналтын журмаар заавал хэлэлцэж буй нь хоёр дахь шатны шүүхийн үйл ажиллагааг үргүйдүйлж, зүгээр нэг үр дагаваргүй “шат дамжлага” болгоход хүргэж болзошгүйг анхаарах.

Анх “53 шүүгч аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд шүүгчээр томилогдож, захиргааны хэргийн шүүхүүд ажиллаж эхэлснээс хойш 4 сарын хугацаанд 162 нэхэмжлэл хүлээж авснаас, 100 гаруйг нь Нийслэлийн захиргааны хэргийн шүүх дангаараа”²³⁾ хүлээж авч байсан ажээ. Одоо хэрнээ энэ харилцан тэнцвэргүй ачаалалтай байдал хэвээр байгаа бөгөөд анхан шатны шүүхүүд харилцан адилгүй ачаалалтай²⁴⁾ байгаа нь тухайн аймаг орон нутгийн хувьд захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй байх байхгүйн тухай ярих биш харин хэрхэн яаж боловсон хүчний хуваарилалт болон шүүхийн зохион байгуулалтыг зөв зохистой хийх, ингэхдээ иргэд өөрийн оршин суугаа газартаа захиргааны шүүхэд хандах

22) Монгол Улсын шүүхийн тухай хуульд 2015 оны 6 дугаар 19-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулахдаа давж заалдах шатны шүүхэд танхим байгуулах боломжийг зөвхөн “Аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалд ахшатны шүүхээр” хязгаарласан шинжтэй өөрчлөлт оруулсаныг эргэж харах шаардлагатай. Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-г харах.

23) Монгол Улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдаж буй үйл явц, түүний онцлог. Ч.Ганбат. Монголын төр, эрх зүй сэтгүүл. 2004 оны №4.

24) 2006 онд хийсэн судалгааны тайланд “Орон нутаг дахь захиргааны хэргийн шүүхийн ачаалал жигдрэхгүй нэлээд “сул зогсож” байна” хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил [судалгааны тайлан-2006]. 9 дэх талд. Б.Чимид нарын судалгааны баг. Хууль зүйн үндэсний төв. Дэлхийн банк “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл. 2008 он.

боломжтой байдлаар зохицуулах талаар анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн багц хууль батлагдсантай холбогдуулан шүүхүүдийг шинэчлэн байгуулах хуулийн төсөлд анхан шатны захиргааны хэргийн шүүхүүдийг бүсчилэн, тойргийн загвараар байгуулахаар УИХ-д санал хүргүүлснийг тухайн үед шат шатны шүүхээс санал гаргасны дүнд анхан шатны шүүх иргэдэд ойр, хүртээмжтэй байх, иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг орон зай, цаг хугацааны хүчин зүйлээс хамааралтай болгох улмаар хязгаарлах нөхцөлд хүргэж болохгүй гэдэг үүднээс аймаг, орон нутаг бүрт нь хэвээр байгуулахаар шийдвэрлэж байсан. Түүнчлэн 2013 оны 1 дүгээр сарын 24 -ны өдрийн Шүүх байгуулах тухай хуулиар Сэлэнгэ, Булган аймгуудад захиргааны хэргийн анхан шатны шүүхгүй, тухайн аймгуудын иргэдийн нэхэмжлэлийг Дархан-Уул, Орхон аймаг дахь захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх болсон нь хожим засагдсан²⁵⁾ ч тухайн үедээ иргэдэд нилээдгүй чирэгдэлтэй байдлыг үүсгэсэн төдийгүй, энэхүү хүндрэлээс²⁶⁾ шалтгаалан шүүхэд хандах эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн тохиолдол байсныг ч үгүйсгэхгүй юм.

Нөгөө талаар, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүхийн хяналтын объект нэмэгдэж²⁷⁾ дан ганц захиргааны актаар хязгаарлагдахгүйгээр захиргааны гэрээ, захиргааны төлөвлөлт зэрэг²⁸⁾ бүхий л захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас үүдсэн хэрэг маргаан шийдвэрлэгдэх болсон тул цаашид орон нутаг дахь захиргааны хэргийн ачаалал “сул зогсолтын хэмжээнд” байхгүй болов уу.

25) Энэ хууль 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн хуулиар хүчингүй болсон.

26) “Зарим шүүгчдээс дэвшүүлдэг дагнасан шүүхийг бүсчилэх саналыг Монгол шиг тархай бутархай байршилтай, хүн ам цөөнтэй улсын хувьд хэрэглэх нь иргэдээс шүүхийг улам холдуулах муу үр дагавартай” Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил [судалгааны тайлан-2006]. 9 дэх талд.

27) Монгол Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухайд. Г.Банзрагч. Шүүх эрх мэдэл сэтгүүл 2016 оны №1.

28) “Захиргааны хууль зөрчсөн бүхий л үйл ажиллагааг засч, залруулаад явж чадах тийм хяналтын хүрээ нь байна уу? ... Гэрээ, төлөвлөлт төлөвлөгөө гээд бусад юмнууд нь хуулиас гадуур ... маргаан гарлаа гэхэд Захиргааны шүүх үүнийг хүлээж авахгүй, өнөөдрийн манай Монголын орчинд бол.” П.Одгэрэл. “Захиргааны шинэтгэл: Асуудал ба Шийдэл” сэдэвт бага хурлын үндсэн илтгэлүүдтэй холбогдуулж дэвшүүлсэн асуудал, саналууд. Төрийн захиргаа сэтгүүлийн 2011/Тусгай дугаар (18) 56 дахь талд.

Боловсон хүчин (мэргэшсэн байдал, тогтвортой хараат бусаар ажиллах боломж)

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд анхан шатны захиргааныхэргийнхорин хоёршүүхэд 22 ерөнхийшүүгч, 82 шүүгч²⁹⁾, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 11 шүүгч³⁰⁾, хяналтын шатны шүүхэд 8 шүүгчийн орон тоотойгоор ажиллаж байна. Нэг үеэ бодвол, анхан шатны шүүхүүд бүтцийн хувьд бүгд бие даасан болж хөгжиж байна. Дагнасан шүүхийн утга учир нь өөрийн гэсэн процессын зарчмуудыг удирдлага болгон мэргэшсэн шүүгчтэйгээр ажилладагт оршдог. 2004 онд захиргааны хэргийн шүүх анх ажиллаж эхлэх үед бэлтгэгдсэн боловсон хүчин байгаагүй боловч түүнтэй харьцуулбал 10 гаруй жилийн шүүхийн практик, хууль тогтоомжийн хэрэгжилттэй болсон өнөө үед харьцангуй сонгон шалгаруулалт хийх боломжтой болсон. 2013 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн шүүхийн багц хуулийн дагуу шинээр шүүгчээр ажиллахаар нэр дэвшигч болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд ажиллах хүмүүст “*тухайн дагнасан шүүхийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байх*” шаардлага тавьж буй хэдий ч, энэхүү шалгуур, үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох, улмаар чадлан хэрэгжүүлэх ажил төдийлөн хангалттай биш байгаад анхаарах шаардлагатай.

Түүнчлэн, хуулиар шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил шилжүүлэхийг тухайлан зааж хориглосон зохицуулалтыг үл хэрэгсэн “*Улсын Их Хурлаас батлагдсан орон тооны хүрээнд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь Ерөнхий шүүгч 1, шүүгч 12, нийт 13 шүүгчийн орон тоотой ажиллах ёстой байсан ба тухайн үед тус шүүх нь орон тоо дутуу буюу нийт 6 шүүгчтэйгээр ажиллаж байсан, УИХ-аас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн тоог цөөрүүлсэн шийдвэр гараагүй байхад шүүхийг татан буулгаж шинээр байгуулсан гэдэг үндэслэлээр Ерөнхий зөвлөл тус шүүхийн нэр бүхий шүүгчдийг орон нутагт байрлах эрүүгийн болон иргэний хэргийн шүүхэд шилжүүлэх санал*” гаргаж томилуулсан явдал³¹⁾ гарсан нь захиргааны хэргийн шүүхээр

29) 2016 оны 05 дугаарсарын 13-нд Шүүхбайгуулахтухайхуульдөөрчлөлторуулахтухайхууль, "Шүүгчийноронтоо гшинэчлэнбатлахтухай" УИХ-ынтогтоолоор батлагдсан орон тоо нь энэ бөгөөд үүнээс дутуу ажиллаж байгаа.

30) Дээрх тогтоолоор батлагдсан орон тоо нь захиргааныхэргийндавжзаалдахшатнышүүхэд 1 ерөнхийшүүгч, 15 шүүгч.

31) Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо сэдэвт бодлогын судалгаа ны тайлан. 105 талд. Нээлттэй Нийгэм Форум, 2015 он.

шийдвэрлэгддэг хэрэг маргааны онцлог буюу төрийн улс төрийн болон захиргааны байгууллага, эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын шийдвэр үйл ажиллагааг хянаж шийдвэрлэдэгтэй холбогдуулан энэхүү шүүх, шүүгчийг “чих зөөлөн”-тэй байлгах сонирхол ихээхэн байгааг³²⁾ харуулж байна.

Тиймээс цаашид захиргааны хэргийн дагнасан шүүхийн боловсон хүчний бодлогын хувьд шат шатанд нь мэргэшсэн шүүгч сонгож ажиллуулах, шүүгч нар тогтвортой, мэргэшиж, хараат бусаар³³⁾ажиллах нөхцлийг *de facto* байдлаар хангах нь зайлшгүй шаардлагатай, захиргааны хэргийн шүүх “*засаг захиргааг өмгөөлөн хамгаалагч, түүний хавсарга бус харин тэдгээрийн үйл ажиллагаанд хүч нөлөөтэй хяналт тавьж, эрх зүйт төрийн дээд зарчим болсон хууль дээдлэх ёсыг хангах механизм байх ... шүүгчид яаж өсөж, хэр шударга ажиллахаас хамаг зүйл шалтгаалах*”³⁴⁾ учир тэргүүлэх ач холбогдолтой тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Захиргааны хэргийн шүүхийн чиг үүрэг, зорилго (“хуулийн” зөрчил үү эсхүл иргэний “эрхийн” зөрчил үү)

1990 оноос өмнөх тогтолцоонд эрүү, иргэний журмаар хэрэг маргааныг шийдвэрлэх явцдаа *ЭНГИЙН МАГАДЛАЛ* гаргах гэх мэтээрзөвхөн хязгаарлагдмал хүрээнд зарим нэг захиргааны үйл ажиллагаанд шүүхуувь хүний эрх, ашиг сонирхлыг шууд бус, дам байдлаархамгаалах (хяналт тавих) төдий зохицуулалттай байсан. Монгол Улсын захиргааны процессын эрх зүйн хөгжилд 2002 оны Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдан 2004 оноос хэрэгжиж эхэлсэнээс хойш эрс өөрчлөлт хийгдэж, захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго³⁵⁾нь хууль эрх зүйн хувьд цоо шинэ гэж хэлж болохуйц үзэл баримтлал буюу

32) “ЗХШ-д ийм хандлага гарах аюул бусад шүүхээс илүүтэй нүүрлэж таарна” гэж 2004 онд энэ шүүх дөнгөж байгуулагдаж байх үед судлаачид бичиж байсан нь одоо нотлогдоод байна. Дэлгэрэнгүйг Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг номны IV бүлгээс үзнэ үү.

33) “Гэрээ засаад төрөө зас” гэдэг шүүгч өөрөө хамгаалагдсан байж дараа нь өөр бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах тухай ярих боломжтой. Шүүх-Хүний эрхийн баталгаа. Ц.Цогт. Хүний эрх сэтгүүл. 2009 оны №2.

34) Шүүхийн шинэ тогтолцооны үндэс – Захиргааны хэргийн шүүх байгуулахад тулж ирсэн нь. Б.Чимид. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 41 дэх талд. 2004 он. Ханнс-Зайделийн сан.

35) Шүүхийн чиг үүрэг шинэчлэгдсэн нь. Дарангуйлалын зэвсгээс шударга ёсны манаанд, Б.Чимид. Захиргааны х

“захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаасхүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээн, тогтоох” зорилготой болсон билээ.

Гэвч энэхүү үзэл баримтлал нь шүүхийн практикт буюу хуулийн бодит хэрэгжилтэнд бүрэн төгс ойлгогдож, хэрэглэгдэж чадахгүй байсаар 10 гаруй жил өнгөрсөн байна. Захиргааны эрх зүйн онолын хувьд 1992 оны Үндсэн хуулийн “*төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх*” үүргийг иргэнийхээ өмнө хариуцах зохицуулалт болон 2002 оны процессын хуульд тусгаж өгсөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь иргэн, хуулийн этгээдээс эрхээ хамгаалуулах баталгаа байх зарчмыг боловсронгуй болгож, хөгжүүлэх, нарийвчлан тодорхойлох шаардлага гарч байна. “Үндсэн хуулийн зохицуулалтаас үзвэл шүүхийн тэр дотроо захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь “захиргааг хянах” биш харин иргэний “эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” сэргээн тогтоох явдал гэж тодорхойлж болно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоос хамаарч тухайн нэхэмжлэлийг шийдвэрлэх процессын зарчим, хэргийн оролцогч байх шалгуур, нөхцөл, оролцогчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, шүүхээс гаргаж болох шийдвэрийн төрлүүд зэрэг нь өөр өөр байх учиртай болно”³⁶⁾.

Захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь “зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бус харин маргаан бүхий захиргааны акт хууль ёсны дагуу гарсан эсэхийг тодорхойлоход оршиж байсан энэхүү загвараас бүрэн татгалзаж, захиргааны хэргийн шүүхийн процессын зорилго нь “маргаан бүхий акт нь хувь этгээдийн эрхийг зөрчсөн эсэхийг тогтоон шийдвэрлэх явдалд чиглэдэг загвар”³⁷⁾ руу онол, хууль, хэрэглээний төвшинд бүрэн шилжихэд зорьж байна.

эргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 2004 он. Ханнс-Зайделийн сан. Энэ номын х эсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

36) Захиргааны эрх зүйн өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл. Ц.Цогт. 2016 он. 34 дэх талд.

37) Захиргааны эрх зүйн онол дахь гол үзэл баримтлалын өөрчлөлт, түүний урьдач болсон Оросын холбооны улс ын захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн эмхтгэл. Зеленцов Александр Борисович. Захиргаан ы эрх зүй ба процесс сэтгүүл 2015 оны №11.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журам: онцлог, тулгамдсан асуудал

А. Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуультай хамт нэг өдөр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдаж, улмаар 2004 оны 6 дугаар сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнээр 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн “Монгол Улсын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хууль” хүчингүй болсон юм. Үндсэн хуулийн шилжилтийн хугацаанд “иргэний шүүн таслахын хүрээнд захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын талаар тухайлсан хууль гаргасан нь цагтаа чухал алхам болсон юм”³⁸⁾. Улс төр, нийгмийн өөрчлөлтийн өрнөлт байдал, цаг үетэй давхцсан байдлаас шалтгаалан уг хуулийн зорилго, зохицуулалт “цааснаасаа халилгүйгээр” шахуу 2002 оны дагнасан шүүх байгуулах хуультай золгосон билээ. Энэ оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхлэн *Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль* халаагаа өгөх хүртэл нийт 10 удаа нэмэлт, өөрчлөлт орж байснаас 2010 оных нь хамгийн дорвитой өөрчлөлт байсан юм. Харин 2016 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс шинэ шүүхийн процессын хууль дөнгөж хэрэгжиж эхлээд байна.

2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн онцлог, шинэчлэх шаардлагын талаар тойм асуудлыг судлаач доктор Г.Банзрагчийн өгүүлэлээс³⁹⁾ дэлгэрүүлэн үзэж болох тул энд нуршихыг зорьсонгүй. Түүнчлэн, энэ өгүүлэлд захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны асуудлыг бүхэлд нь авч үзэхийг зориогүй учир зөвхөн суурь, ерөнхий зарчмын шинжтэй зарим нэг асуудлыг өмнө гарсан өгүүлэлээс⁴⁰⁾ (зөвхөн энэ хэсэгт) сийрүүлэн хөндье.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны суурь асуудлын нэг нь “захиргааны үйл ажиллагааны ямар хэлбэр нь шүүхийн журмаар хянагдах боломжтой”-гоор

38) Хуучин шинийн зааг дахь шүүхийн хяналт, ялгуурхан шинэтгэл (1990 оны III сараас 2004 оны V сар) Б.Чими д. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 37 дахь талд. 2004 он. Ханнес-Зайделийн сан.

39) Монгол Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухайд. Г.Банзрагч. Шүүх эрх мэдэл сэтгүүл 2016 оны №1.

40) Захиргааны процессын эрх зүйн шинэчлэл: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго ба Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл. Ц.Цогт. Эрх зүй сэтгүүл 2016 оны №2, Цуврал 34.

зохицуулагдах тухай асуудал байдаг. Шүүхэд хянагдах захиргааны үйл ажиллагааны төрөл, цар хүрээ ямар байхыг тодорхойлохдоо Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн зохицуулалт буюу захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн (шүүхийн) хяналттай уялдуулан ойлгох учиртай.

Хэдийгээр манай улс 2002 оноос хойш захиргааны акт, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр шүүхийн журмаар хянагдах боломжтой байхаар зохицуулсан ч 10 гаруй жилийн практикт захиргааны үйл ажиллагаанд шүүхийн хэрэгжүүлж буй хуулийн хяналтын зорилго, цар хүрээ, хязгаарлалтын “*онолын үзэл баримтлал тодорхойгүй*”-гээс маргаантай асуудлууд нилээн гарч байна. Тухайлбал, тодорхой этгээдийн эрхийн зөрчлийг шалгаж тогтоох зорилготой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлийг хуульчилсан боловч онол, практикын түвшинд нэхэмжлэл гаргаж буй этгээдэд тавигдах шаардлагыг төдийлөн нягтлахгүйгээр маргах эрхийг шалгуургүйгээр нээсэн байдлаар явж ирсэн нь ерөнхий хяналт буюу объектив хуулийг хамгаалах уламжлалт сэтгэлгээ⁴¹⁾ одоог хүртэл нөлөөтэй байгаатай холбоотой. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг анх боловсруулахдаа Германы хууль, туршлагыг түлхүү судалсан⁴²⁾ бөгөөд Монгол Улс түүнийг нутагшуулахад шаардагдах өөрийн гэсэн практик, онолын суурь судалгаа төдийлөн өндөр түвшинд тодорхой байгаагүй гэж үзэж болно. Тухайлбал, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан ганцхан зарчим нь субъектив эрхийн маргааныг хянан шийдвэрлэх зорилго байх боловч бодит байдал дээр “*хуулийн зөрчил байгааг хэн шийдэх вэ, нэхэмжлэл гаргах эрхийг нь хязгаарлавал цаана хууль зөрчигдсөн байдал байсаар байх болно*” зэрэг үндэслэлээр “маргах эрхийн шалгуурыг” хэрэглэхгүйгээр захиргааны хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж ирсэн нь шүүх захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн зөрчлийг “хянах” зорилготой⁴³⁾ байсан өмнөх үеийн үзэл баримтлал онол,

41) Энэхүү ойлголтыг “*Path Dependence*” гэдэг нэршлээр тодорхойлж судалдаг бөгөөд хуучин цаг, нөхцөл байдал өөрчлөгдсөн хэдий ч өмнө нь гаргаж байсан шийдэл, санаа шинэ нөхцөл байдалд ч хэрэглэгдсээр, нөлөөтэй оршоор байхыг илэрхийлдэг ойлголт билээ. Ц.Ц

42) “Эрх зүйн бүлийн хамаарал хийгээд захиргааны дагнасан шүүхийн бие даасан тогтолцоотойг харгалзан ХБНГ У-ын жишгыг голлон харгалзах нь зүйтэй гэдэгт санал нэгдсэн болно. Иймийн учир явж судалж, урьж сонсож эрдэмтдийн арга зүйн туслалцаа авсан нь ихээхэн ач тустай болсныг дурдахын хамт эцэслэн шийдвэрлэхдээ нэгэн улсын хуулийг үгчлэн хуулж, тогтолцоог хөдлөшгүй загвар болгож, бусдын зөвлөгөөг бурханчлан дагаагүй, зөвхөн харглан үзсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.” Б.Чимид. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. 44-45 талд. 2004 он. Ханнс-Зайделийн сан.

43) “Захиргааны эрхийн шинжлэх ухаан бол зөвхөн төрийн удирдлагад буюу захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсыг хангах талаар гүйцэтгэх үүрэг, эрхийн арга хэлбэрийн талаас нь авч үздэг байна” Б.Чими

практикын аль алинд хадгалагдсан хэвээр байгаагийн илэрхийлэл гэж дүгнэхэд хүргэж байна.

Захиргааны ерөнхий хууль батлагдсан, уг хуульд захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүд, зарчим, үр дагавар⁴⁴⁾ зэргийг тодорхойлон зохицуулсантай уялдуулан захиргааны хэргийг шүүхийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны онолын чиглэл илүү тодорхой болж, тогтох боломжтой болсон хэдий ч процессын эрх зүй дараах асуудлаар юун түрүүн шинэчлэл хийх шаардлагатай тулсан. Тиймээс шүүхийн процессын шинэ хуулиар: Захиргааны акт (зах.гэрээ, хэм хэмжээний акт)-тай холбоотой маргаан буюу тодорхой субъектын эрхийн зөрчлөөс үүдсэн маргааныг (1) *Хянан шийдвэрлэх ажиллагаа* -наас гадна, объектив эрх зүйн (нийтийн эрх ашгийн төлөөлөх, хуулиар тусгайлан маргах эрх олгогдсон этгээд түүнчлэн захиргаа хоорондын нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн) маргааныг (2) *Хянан шийдвэрлэх ажиллагаа* -г төрөлжүүлэн зохицуулж өгсөн.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дээрх байдлаар төрөлжүүлэн ангилснаар оролцогч (эрх зүйн байдлын хувьд тодорхойлох) нарт тавигдах шаардлага, нэхэмжлэх эрхийн нөхцөл, шаардлага, маргаан шийдвэрлэлтийн үр дагаварын онол, зарчмын асуудлууд нь тус тусдаа ялгамжтай байдлаар даган зохицуулагдаж, улмаар практикт жигдрэх боломжтой юм. Тухайлбал, тодорхой субъектын эрхийн зөрчлөөс үүдсэн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүх хэрэг үүсгэх үед нэхэмжлэл гаргаж буй этгээдийн “эрх, хууль ёсны ашиг сонирхол болон маргаж буй захиргааны үйл ажиллагаа”-ны хоорондын шалтгаант холбоо, уялдааг шалгах, уг захиргааны шийдвэр тэрхүү этгээдийн хувьд тухайлсан үйлчлэл бүхий эсэхийг⁴⁵⁾ тодруулсны үндсэн дээр захиргааны хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой байх. Ингэхдээ тухайн захиргааны шийдвэрийн талаар “маргах эрх”-тэй эсэхийг хэрэг үүсгэхдээ судалж тодруулах үүрэгтэй байх нь субъектив эрхийн зөрчлийг Хянан шийдвэрлэх ажиллагааны төрлийн онцлог юм. Маргах эрх буюу *Standing* шалгуур нь энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгийн эхний шалгуурын нэг байх бөгөөд хүлээн зөвшөөрөгдөж, судлагдсан онол номлолын хувьд ч

д. БНМАУ-ын Захиргааны эрх. УБ., 1973, 392- 404 дэх тал.

44) Захиргааны эрх зүй дэх “*functus officio*” зарчим ба Захиргааны албан тушаалтны шийдвэрээ хүчингүй болгох эрхийн зарим асуудал. Өгүүлэлээс “хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийн үр дагаварыг арилгах” зохицуулалт шаардлагатай талаар дэлгэрүүлэн үзнэ үү. Д.Мөнхтуяа. Шүүх эрх мэдэл сэтгүүлийн 2014 оны №4.

45) Тодорхой субъектын тодорхой эрх зөрчигдсэн эсэхийг шалгаж тогтоох зорилготой байдгынх нь хувьд захиргааны актыг объектив талаараа хуульд нийцсэн эсэхийг шалгах ХХША-наас ялгаатай байдаг. Ц.Ц

энэхүү шалгуурыг давсны дараа шүүхийн процесс эхлэх боломжтой байх ёстой байдаг.

Нэг үгээр хэлбэл, тодорхой нэг захиргааны актын агуулга, зохицуулалт нь нэхэмжлэл гаргаж буй этгээдийн хууль ёсны эрх ашиг сонирхолтой ямар нэгэн байдлаар огтлолцох, зөрчилдөх буюу эрх зүйн хувьд үйлчлэл бүхий байж болох эсэхийг судалж тогтоох нь захиргааны эрх зүйн онолд *Standing* гэсэн нэршлээр судлагдаж ирсэн бөгөөд Монгол Улсын орчин цагийн захиргааны эрх зүйд энэ ойлголттой дүйцэхүйц судлагдахуун нь бидний нэршиж заншсанаар “субъектив эрх” –ын шаардлагатай дүйцэх юм. *Standing question* эсхүл *Standing issue* гэх мэтээр хэрэглэгддэг энэхүү ойлголт нь тухайн этгээд нь шүүхэд нэхэмжлэл гаргаж буй уг захиргааны шийдвэрийн талаар шүүхэд хянан шийдвэрлэхэд “бие даасан оролцогч болж маргах эрхтэй этгээд” мөн үү биш үү гэдгийг тодорхойлох тухай асуудал бөгөөд тодорхой захиргааны шийдвэр болон түүнтэй маргахыг хүссэн этгээдийн эрхийн хооронд үйлчлэл, харилцаа байж болох нь тогтоогдвол тэрхүү этгээдийг “маргах, шаардах эрхтэй” гэж тооцох зэргээр эрх зүйн байдлыг нь тодорхойлоход зорьдог. Энэ нь тодорхой захиргааны үйл ажиллагаанд өртөөгүй, үйлчлэл нь хамааралгүй этгээдүүд хийсвэр байдлаар маргаан үүсгэхээс сэргийлэн үүсэж, хөгжсөн онолын ойлголт юм. Гэвч захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны өнгөрсөн хугацаанд *objective* буюу ерөнхий эсхүл *subjective* буюу тодорхой эрхийн зөрчлөөс үл хамааран нэхэмжлэгчид субъектив эрхийн зөрчил үүссэн байх шаардлага тавьж ирсэн нь ойлголт, хэрэглээний төвшинд зөрчил, маргаан⁴⁶⁾ үүсгэх үүсвэр болж байсан бөгөөд уг салбарын судлаач, эрдэмтэдийн зүгээс ч үүнийг ялгах онол, эрх сурвалжийн талаар тодорхой судалгаа бүтээл хийгдээгүй байсан нь нөлөөлсөн юм.

Харин объектив буюу захиргааны шийдвэрийн үйлчлэл тодорхой субъектын эрхийн зөрчил үүсгэсэн эсэхээс үл хамааран хуулиар маргах эрх олгогдсон этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй тохиолдолд шүүх тэрхүү этгээд

46) Тухайлбал, захиргааны хрэгийн шүүх байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэний дараахан энэ асуудлаар м анай захиргааны эрх зүйн тэргүүлэх багш нарын нэг “Нэхэмжлэл гаргах эрхийг зөвхөн эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд эдлэх үү эсхүл эрх зөрчигдөөгүй ч гэсэн тухайн захиргааны актыг хууль бус гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байх уу гэсэн асуудал нь сонирхол татсан, бас маргаантай асуудал бололтой. Шүүхээс зөвхөн эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд л шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байх уу гэсэн асуудал нь сонирхол татсан, бас маргаантай асуудал бололтой. Шүүхээс зөвхөн эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээд л шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээр хангагдана гэсэн практикийг хэвшүүлж байна гэж ойлгогдож байна” хэмээн энэ асуудал маргаантай байга талаар асуудал дэвшүүлсэн өгүүлэл нийтлүүлж байсан юм. Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Д.Ганзориг. 27 дахь талд. Хүний эрх сэтгүүлийн 2005 оны №4.

тухайн асуудлаар “маргах, шаардах эрхтэй” эсэхийг субьектив хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны адил судалж, шалгах шаардлагагүй байдаг. Учир нь энэхүү төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь нэхэмжлэгч этгээдийн эрх зөрчигдсөн эсэхээс үл хамааран захиргааны үйл ажиллагаа, шийдвэр дэх хуулийн зөрчлийг арилгуулах явдал байдаг бөгөөд уг этгээдэд маргах эрхийг хуулиар урьдчилан олгосон байдагт оршдог. Нэгэнт энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь тодорхой этгээдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, эсхүл зөрчигдсэн эрхийг сэргээн тогтооход чиглэгдээгүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд хэн нэгэн этгээдийг эрх ашиг сэргэсэн, хамгаалагдсан байх биш харин захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн зөрчил арилсан байх явдал байдаг.

Тиймээс (1) нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх, (2) захиргааны байгууллагад хуулиар тодорхой асуудлаар тусгайлан маргах эрх олгогдсон, түүнчлэн (2) захиргаа хоорондын⁴⁷⁾ маргааныг *хянан шийдвэрлэх ажиллагаа* -ны дүнд захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн зөрчил арилж, нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн объектив маргаан шийдвэрлэгдэх боломжтой болох юм. Энэхүү төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэт нээлттэй биш, хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрөх нь захиргааны нийгэмд гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд тус дөхөмтэй бөгөөд гагцхүү “хуульд эрх олгогдсон” тохиолдолд, мөн тусгайлан эрх олгогдсон этгээд маргах эрхтэй байхаар зохицуулагддаг.

Харин үүнд захиргааны байгууллагын “бүрэн эрх” хэрэгжээгүй, зөрчигдсэн гэх зэрэг асуудлаар захиргааны хэргийн шүүхэд хандах явдлыг хамааруулах боломжгүй. Захиргааны байгууллага хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийг хуулиар зөвшөөрөгдсөн цар хүрээ, арга журмаар өөрөө хэрэгжүүлээд дуусах учиртай, түүнээс “бүрэн эрх хэрэгжсэнгүй, зөрчигдлөө, нөгөө этгээд бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийг биелүүлэхгүй байгаа” гэх зэргээр өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх асуудлаар шүүхийн журмаар маргах эрхийг ерөнхий зохицуулалт байдлаар захиргаанд олгодоггүй. Шүүх ч энэ төрлийн шаардлага, үндэслэлээр захиргааны хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй, учир нь энэ

47) Энэ тохиолдолд маргаж буй захиргааны байгууллагууд нь өөр хоорондоо шатлан захирагдах байгууллага эсхүл нэг системн буюу нэг дээд шатны байгууллагатай этгээдүүд биш байх шаардлага тавигдана. Жишээлбэл, Засгийн газрын харьяа яамд хооронд, яам агентлаг хоорондын маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэхгүй, харин тэдгээрийг нэгтэн удирдах эрх бүхий Засгийн газар шийдвэрлэх учиртай. Харин нутгийн өөрөө удирдах байгууллагад, бие даасан агентлаг болон Засгийн газрын яам, агентлаг хоорондын маргаан хамаарах юм. Ц.Ц

нь захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцэхгүй.

Захиргааны тодорхой байгууллага нийгмийн харилцаанд оролцохдоо хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагдаж байдаг “хуулийн этгээд” болохынхоо хувьд хоёр өөр эрх зүйн байдалтайгаар оролцдог. Нэгдүгээрт, өөрт нь хуулиар удирдах, зохион байгуулалт хийх эрх олгогдсон тэр харилцаанд “захиргааны хувиар”, харин өөр бусад захиргааны байгууллагад захирах эрх олгогдсон харилцаанд зохицуулалтад өртөж хамрагдаж буй “субъектын хувиар” оролцдог. Тухайлбал, шударга өрсөлдөөнийг хангаж, зохицуулалт хийх үүрэг бүхий захиргааны агентлаг нь өрсөлдөөнийг зохицуулах харилцаанд “захиргаа” харин уг байгууллагын барилга оршин байдаг газрын эзэмшлийн асуудлаар газрын харилцааны талаарх төрийн байгууллагын шийдвэрт захирагдах этгээдийн хувьд эсхүл төрийн аудитын харилцаанд уг байгууллагын хяналт шалгалт чиглэж буй этгээд болж оролцох болдог зэргээс харж болох юм. Эдгээр харилцаанаас маргаан үүсвэл өрсөлдөөнийг зохицуулах үүрэг бүхий захиргааны байгууллага дээрх байгууллагуудын шийдвэрийн талаар захиргааны хэргийн шүүхэд хандахдаа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлсон нэхэмжлэгч⁴⁸⁾ “хуулийн этгээд”-ийн хувиар маргах эрхтэй.

Ийнхүү захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зорилготой уялдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлжүүлэн тодорхойлох нь процессын эрх зүйн шинэчлэлийн чухал асуудал болон судлагдаж байна.

Б. Хэргийн харьяалал, маргааны төрөл, онцлог (*From Enumeration Clause to General Clause*)

1990 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Монгол Улсын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хууль болонтүүнээс өмнөх БНМАУ-ын иргэний байцаан шийтгэх хуульд (1967.06.29) төр ба иргэний хоорондын харилцаанаас үүссэн тоотойцөөн⁴⁹⁾ хэргийг л шүүх шийдвэрлэх боломжтой байсан. Ингэхдээ эрхийн зөрчилд автсан иргэн нэхэмжлэгчийн хувиар бус харин ердөө л сонирхогч⁵⁰⁾ (гомдол, мэдээлэл гаргагч)-ийн хувиар буюу захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн зөрчлийг мэдээллэх “сигнал”⁵¹⁾ болж

48) ЗХХШТхуулийн 1.1, 3.1.7 –д заасан “хуулийн этгээд”.

49) Гурван төрлийн хэрэг. БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 197 зүйлд.

50) БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн тайлбар. Редактор Д.Зундуй, Н.Чинбат. 223 дахь талд. 1984 он.

51) “On Rules for Deciding Citizens’ Proposals, Applications and Appeals”, D.Danzandorj, The Mongolian Legal System.

оролцох төдий бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд гомдол, мэдээлэл гаргагчийн эрхийг сэргээхэд бус захиргааны үйл ажиллагаан дахь зөрчлийг залруулахад чиглэгдсэн, захиргааны байгууллага, албан тушаалтан “хариуцагч”-ийн эрх зүйн байдалтайгаар оролцохгүй харин төлөөлөгч оролцуулж болох зэрэг зохицуулалттай байлаа.

Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль анх 2002 онд батлагдах үед захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдэх хэрэг, маргааны төрөл нь жагсаалтын зарчмаар (enumeration clause) мөн хуулийн гурав, дөрөвдүгээр зүйлд тусгагдан зохицуулагдсан билээ. Ингэхдээ хариуцагч болох байгууллагуудыг оноосон нэрээр⁵²⁾ зааж жагсаалт үүсгэсэн нь хожим “тоосго сугалах” аргаар энэхүү жагсаалтаас тодорхой захиргааны байгууллагын нэрийг хасах⁵³⁾, шинээр байгуулагдсан захиргааны байгууллага уг жагсаалтад байхгүй⁵⁴⁾ гэх зэрэг шалтгаар иргэний нэхэмжлэлийн хариуцагчаар, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос цааргалах, булзах үндэслэл болжулмаар эрхийн зөрчил амссан иргэний асуудлыг дагнасан шүүх, тухайлсан журмаар шийдвэрлэн сэргээх ажиллагаанд саад болж байсан юм. Нөгөө талаар зарим захиргааны байгууллага, албан тушаалтныг нэр зааж оруулаагүй нь, тухайлбал улсын ерөнхийлөгч⁵⁵⁾-ийг уг жагсаалтын эхэнд буюу Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт оруулсан хувилбарын 4 дүгээр зүйлийн 4.1.1-д бичигдсэн байсныг хассан нь тэдгээр байгууллага, албан тушаалтны нийтийн эрх зүйн харилцаанд үүссэн тодорхой нэг

pp154. William Elliott Butler. 1982.

52) Тухайлбал, 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “Үнэт цаасны хороо” гэж заасан байсныг төрийн байгууллага өөрчлөгдөн байгуулах замаар тухайн байгууллагын оноосон нэр өөрчлөгдсөн учир “Санхүүгийн зохицуулах хороо” болго н хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон зэрэг.

53) 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар 4 дүгээр зүйлийн “4.1.1. Монгол Улсын Засгийн газар,” мөнзүйлийн “4.1.6. Сонгуулийн ерөнхий хороо,” гэсэн заалтыг тустус хүчингүй болсонд тооцсон. Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Д.Ганзориг. Хүний эрх сэтгүүлийн 2005 оны №4 26 дахь тал болон 3-р ишлэлээс үзнэ үү.

54) “Нийгмийн хөгжлийн шаардлага болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны олон талт байдал нь жагсаалтын зарчмын хүрээгээр хязгаарлагдахгүй нь тодорхой тул нийтийн эрх зүйн маргаан ойлголтыг онол-практикийн үүднээс нэгтгэн дүгнэж, цаашдын хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох шаардлага нэгэнт т улгарчээ.” хэмээн доктор А.Эрдэнэцогт Захиргааны хэргийн шүүх үүсч, байгуулагдсны 10 жилийн ойд зориулсан бага хурал тавьсан илтгэлдээ дурьдаж байжээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсролгүй болгох асуудал. Эрх зүй сэтгүүл 2016 оны №1 Цуврал 33.

55) Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Хувийн хэргийн 162-164, 206-209 дэх талд. 2002 оны 12 дугаар сарын 24-ны өдөр эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж оруулсан төсөлд байгаад Эцсийн хэлэлцүүлгийн үед санал хураалгах зарчмын зөрүүтэй саналын жагсаалтад гишүүн Д.Лүндээжанцангийн “хасах” саналтайгаар Байнгын хорооноос дэмжигдэж, танилцуулагдсаны дагуу хасагдсан байдаг.

тохиолдлыг шийдвэрлэсэн, иргэнд эрх зүйн шууд үр дагавар, үйлчлэл бүхий шийдвэр үйл ажиллагаа хуулийн хяналтад орохгүй байх боломжийг бүрдүүлсэн, цаана хүний эрх зөрчигдсөн байдал шийдвэрлэгдэхгүй үлдсэн байдаг.

Тийм учир манай орчин цагийн үндсэн хууль, захиргааны эрх зүйн тэргүүлэх судлаач Б.Чимид багшийн тодорхойлсончлон “тэнгэрээс газар хүртэлх” олон төрлийн хэргийг шийдвэрлэхүүрэгтэй захиргааны хэргийн шүүхийн хэргийн харьяаллын асуудлаар Захиргааны ерөнхий хуульд (5 дугаар зүйлд) захиргааны байгууллагыг тодорхойлохдоо оноосон нэрийн “жагсаалтаас татгалзаж, төрөлжүүлэн” томъёолсон бол Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг маргааныг “*Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ*” хэмээн сонгодог ерөнхий зарчмаар (general clause) тодорхойлон хуульчилж өгсөн. Энэ талаар “Монголын эрх зүй тоочих зарчмаас ерөнхийлөн заах зарчим руу шилжиж байгаа эсэх нь сонирхол татахуйц асуудал. Ерөнхийлөн заах тохиолдолд аль ч захиргааны байгууллагын гаргасан захиргааны актын эсрэг шүүхэд гомдол гаргах боломжтой болох юм. Энэ ч утгаараа монголын эрх зүйн хөгжилд түлхэц үзүүлэх бөгөөд эрх зүйт төрийн зарчимд чиглэсэн бас нэгэн чухал ахиц дэвшил болох юм.”⁵⁶⁾ хэмээн Германы төдийгүй, Монголын захиргааны хэргийн шүүх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар өргөн мэдлэг, мэдээлэлтэй ХБНГУ-ын эрдэмтэн доктор Юрген Харбих дүгнэсэн байдаг.

В. Маргааны төрөл, ачаалал, шийдлийн талаар товчхон:

Монгол Улсын захиргааны хэргийн гурван шатны шүүх 2004-2013 онд нийт 19.683 хэрэг хүлээн авснаас, анхан шатны шүүхээр 7.441, давж заалдах шатны шүүхээр 3.519, хяналтын шатны шүүхээр 1.807, нийт 12.767 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нь нийт хүлээн авсан захиргааны хэргийн 64.9 хувийг эзэлж байна⁵⁷⁾. Өмнө дурьдсанчлан, анхан шатны шүүхүүдийн ачаалал харьцангуй, ялангуяа нийслэл дэх шүүх ачаалал бусадтай нь

56) “Өрнө, дорнын эрх зүйн харилцан уялдаа - Монгол Улсын нийтийн эрх зүйн жишээндээр” сэдэвт судалгааны илтгэл. Юрген Харбих “Монгол Улсын эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй” олон улсын эрдэм шинжилгээний хураал. 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан.

57) Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн тойм 2004-2014. Монгол Улсын Дээд шүүх. 2014 он.

харьцуулбал хэт өндөр, анхан шатны журмаар шийдвэрлэсэн бүх хэргийн 50.1 гаруй хувь⁵⁸⁾ байсаар ирсэн нь мэдээж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “*нэхэмжлэлийг тухайн захиргааны акт гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны харьяалах захиргааны хэргийн шүүхэд гаргана*” хэмээн зохицуулсантай холбоотой бөгөөд нийслэл хотод зөвхөн нутгийн захиргааны байгууллага төдийгүй, Монгол Улсын захиргааны төв байгууллагууд оршин байрлаж, хүн амын тэн хагас орчмын амьдрал ахуйг зохицуулсан шийдвэр гаргаж байдгаас үүдэлтэй билээ.

Энэхүү ачааллыг зохицуулах зорилгоор нийслэл дэх анхан шатны шүүхэд орон тоо нэмэгдүүлэхээс гадна, анхан шатны журмаар 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх хэргийн хариуцагчийн төрөл, гаргадаг шийдвэрийн үйлчлэлийн хүрээ (*тухайлбал, захиргааны хэм хэмжээний акттай холбоотой хэрэг*), далайц зэргийг харгалзан өөрчлөх⁵⁹⁾, “хэргийн онцлог, маргааны цар хүрээ” зэргээс хамааран тухайн шүүх шийдвэрлэж байхаар⁶⁰⁾ зохицуулах замаар шүүхийн ачаалалд нөлөөлдөг зүйлсийг уяан хатан байдлаар шийдэх ажил хийгдэж байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх байгуулагдсан эхний жилд буюу 2004 онд 145 хэрэг шийдвэрлэгдэж байсан бол 2013 онд 1106 хэрэг хянан шийдвэрлэсэн нь 6.6 дахин өссөн байна⁶¹⁾. Цаашид ч Захиргааны ерөнхий хууль, шинэ шүүхийн процессын хуулийн дагуу шүүхийн хэргийн харьяалал нь захиргааны гэрээ зэргээр нэмэгдэн зохицуулагдсан тул улам өсөх нь дамжиггүй юм.

Маргааны төрлийн хувьд

2004 онд “Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн анхны 4 сард хүлээж авсан 100 гаруй хэргийн 10 гаруй хувь нь татвар ногдуулсан татварын улсын байцаагчийн актыг үл зөвшөөрсөн, 21 хувь нь газар эзэмшүүлэх болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй

58) Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал 2008 оноос 2012 онд 31 хувь өссө н. 2012 оны байдлаар нэг шүүгчид 103 шийдвэрлэсэн хэрэг ногдож байсан. Мөн дээрх тоймд.

59) Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.2 –д “аймаг, нийслэлийн Засаг дарг а” байсныг 2014 онд “аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон түүний Тэргүүлэгчдийн гаргасан захиргааны акттай холбоотой” хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр болгож өөрчилж байсан.

60) Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.3 –д “тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр тогтоосон” хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

61) Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн тойм 2004-2014. Монгол Улсын Дээд шүүх. 2014 он.

холбогдсон актад гомдол гаргасан”⁶²⁾ хэрэг байсан, арав гаруй жилийн дараа ч энэ харьцаа өөрчлөгдөөгүй байгаа нь Улсын дээд шүүхээс захиргааны хэргийн шүүхийн өнгөрсөн 10 жилийн шийдвэрлэсэн хэрэг маргааны тойм судалгаанд “2004-2013 онд шийдвэрлэгдсэн нийт захиргааны хэрэг маргаанд Газрын тухай хуулиуд болон Төрийн албаны тухай хуулиар хянан шийдвэрлэгдсэн хэрэг маргаан давамгайлж” гэж тусгагдсанаар батлагдаж байна. Эдгээр хоёр төрлийн хэргээс гадна, тогтмол шийдвэрлэгддэг эхний хэдэн маргааныг дурьдвал, татварын акттай холбоотой, ашигт малтмалын болон бусад төрлийн лицензтэй холбоотой, эд хөрөнгийн болон иргэний бүртгэлтэй холбоотой болон төрийн хяналт шалгалттай холбоотой маргаан байдаг. Харин цаг үеийн байдлаас шалтгаалан сонгуультай жилд сонгуулийн маргаантай хэрэг, татварын томоохон зөрчил илэрсэн тохиолдолд татварын маргаантай хэрэг эрс өссөн байх тохиолдол байдаг.

Шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хангаж, маргаан бүхий захиргааны шийдвэр үйл ажиллагааг хуулийн зөрчилтэй тогтоож, нэхэмжлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалсан, сэргээн тогтоосон шийдвэрийн хувь (хяналтын буюу эцсийн шатны шүүхээр орж шийдвэрлэгдсэн хэргийн тухайд авч үзвэл) нийт шийдвэрийн 55.7 хувийг эзэлж байна. Хэдийгээр нэхэмжлэлийг хангаж байгаа тоон үзүүлэлтээр Монгол Улсын захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хууль зүйн талаас нь дүн тавьж болох ч, энэ нь дангаараа иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалсан, сэргээсэн хувь хэмжээний бүрэн утгыг илэрхийлэхгүй юм. Учир нь захиргааны хэргийн хувьд нэхэмжлэгчээс гадна, тухайн хэрэг, шийдвэрийн улмаас эрх ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй гуравдагч этгээд оролцох⁶³⁾ нь элбэг бөгөөд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийн цаана тухайн захиргааны шийдвэрээр эрх олж авсан гуравдагч этгээдийн эрх хамгаалагдаж үлддэг гэдгийг тооцох ёстой. Шүүн таслах ажиллагааны чанар, үзүүлэлт формал талаас дээд шатны шүүхээр хянагдсан байдлаар хэмжигдэх боловч, хэргийн оролцогчид, хуульчид, мэргэжилтнүүдийн зүгээс өгөх дүн, хандлага болон судлаач, эрдэмтэдийн шинжилгээ, судалгааны үзүүлэлт хамгийн чухал шалгуур болох юм. Цаашилбал, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт

62) Монгол Улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдаж буй үйл явц, түүний онцлог. Ч.Ганбат. Монголын төр, эрх зүй сэтгүүл. 2004 оны №4.

63) Эхний жилүүдэд шийдвэрлэгдсэн хэрэгт гуравдагч этгээд оролцуулсан талаар судалгааг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил [судалгааны тайлан-2006]. 9 дэх талд. Б.Чимид нарын судалгааны баг. Хууль зүйн үндэсний төв. Дэлхийн банк “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл. 2008 он.” –ээс үзнэ үү. Сүүлийн үед буюу өнгөрсөн хугацаанд энэ сэдвээр цогц судалгааг хийгдээгүй байгаа болно.

зүгээр нэг явган хэрүүлийн чанартай хандах биш, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах, эрх зүйн шүүмж судлалын үүднээс дүгнэлт⁶⁴⁾ өгөх шинж хэдийн харагдаж эхэлсэн билээ.

Г. Нэхэмжлэлийн шаардлагын төрөл:

Өнгөрсөн хугацаанд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох (*public law related action - existence or non-existence of a legal relationship*⁶⁵⁾) нэхэмжлэлийн шаардлагын талаар хаа хаанаа бодиттой ойлголтоггүй явж ирсэн бөгөөд захиргааны актыг хүчингүй болгуулах, илт хууль бусад тооцуулах (ялгаа тодорхойгүй), эрэмбэ буюу аль нь эрх зүйнхамгаалалтын хувьд илүү гэдгийг ялгаж тодорхойлж ирээгүй.Нэхэмжлэлийн шаардлагын төрлүүдийг судлах, түүнийг шүүхээс ялгаж салгажшийдвэрлэх асуудал анхнаасаа⁶⁶⁾ ярвигтай асуудлын нэгбайсан бөгөөд одоогоор онол, хууль, хэрэглээний төвшинд нэр тэргүүнд судлж, практикт цэгцлэх шаардлагатай асуудал хэвээр байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 –д “нэхэмжлэлийн шаардлагын агуулга” гэсэн тодорхойлолт (нэр)-ын дор нэхэмжлэлийн шаардлагын төрлүүдийг зохицуулахыг зорьсон байсныг уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа⁶⁷⁾хасаж, “нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл”-ыг тодорхойлсон байдлаар өөрчлөн найруулсан байдаг. Зүй нь уг зүйл, хэсэгт “нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл” гэдэгт юуг ойлгох вэ гэдэг тодруулга нэмж оруулахын зэрэгцээ, “нэхэмжлэлийн шаардлагын агуулга” нэрийн дор нэхэмжлэлийн шаардлагын төрлүүдийг тодорхойлж байсныг зөвтгөн залруулж, агуулгыг нь хэвээр хадгалах шаардлагатай байжээ.

Тиймээс өнөөг хүртэл, захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн шаардлагын төрлүүдийг тодорхойлсон зохицуулалт тодорхойгүйгээс⁶⁸⁾хуульч, өмгөөлөгчид гагцхүү

64) Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ. Г.Банзрагч. Шүүх эрх мэдэл сэтгүүлийн 2014 оны №4.

65) ХБНГУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн (1)-д.Code of Administrative Court Procedure in the version of the promulgation of 19 March 1991 (Federal Law Gazette I page 686), most recently amended by Article 5 of the Act of 10 October 2013 (Federal Law Gazette I page 3786)

66) “Тухайлбал, захиргааны актыг *хүчингүй болгох* болон захиргааны байгууллагаа гаргасан захиргааны актыг *илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрөх* 2 заалтыг шүүхийн нэг шийдвэрт [нэхэмжлэлийн нэг шаардлагыг шийдвэрлэхэд гэсэн утгаар бичигдсэн болтой Ц.Ц] нэгэн зэрэг тусгаж болохгүй...” Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил [судалгааны тайлан-2006]. 59 дэх талд.

67) 2010 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн хуулиар.

68) Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9, 10, 11 дүгээр зүйлд маргаан бүхий захиргааны акт, илт хууль бус захиргааны акт, захиргааны акт гаргахыг даалгах талаар зохицуулсныг эс тооцвол. Ц.Ц

шүүхийн практик, шүүхээс захиргааны хэргийг хянан шийдвэрлээд гаргаж болох шийдвэрийн төрлүүдэд⁶⁹⁾ үндэслэнбаримжаалж даалгах, хүчингүй болгох, илт хууль бусад тооцуулах, хохирол гаргуулах гэсэн ерөнхий агуулгаар нэхэмжлэл гаргаж ирсэн, шүүх нь ч шийдсээр ирсэн. Ялангуяа захиргааны актыг хүчингүй болгуулах (*action for the revocation*), эсхүл түүнийг илт хууль бусад тооцуулах (*action for the declaration of nullity*), мөн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох (*action for the declaration of illegality of inaction*), эсхүл тодорхой шийдвэр гаргахыг даалгах (*mandamus action*) нэхэмжлэлийн шаардлагыг өөр хооронд нь онцын ялгамжгүйгээр ойлгож, хэрэглэж ирснийг онол, хууль, хэрэглээний төвшинд уг сурвалжаас нь судалж, эрх зүйн ойлголт, үр дагавар ялгамжтайг нь тодорхойлон зааглаж хууль номд тусгах, хэрэглэж хэвших нь захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал болоод байгаа юм. Иймийн учир Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 -д нэхэмжлэлийн шаардлагын төрлүүдийг болон түүнд тавигдах шаардлагыг (шүүхээс тухайн шаардлагыг шийдвэрлэх шийдвэрийн төрөлтэй уялдуулан) ялгамжтайгаар зохицуулж өгөхийг зорьсон билээ.

Цаашид захиргааны байгууллагаас тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахгүй байхыг урьдчилан хориглох (*action for injunctive order*) нэхэмжлэлийг судлах, нэхэмжлэгчийнэрх, хуульёсныашигсонирхолнь“зөрчигдөжболзошгүй”талаарх нэхэмжлэлийн шаардлагад тавигдах шаардлага, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн агуулга зэргийг тодорхойлох шаардлагатай. төдийгүй, нэхэмжлэлийн шаардлагын төрлөөс хамааран захиргааны хэргийн шүүхэд маргах эрх (Маргахэрхбуюу Standing) –дтавигдах шалгуур, шаардлагыг ялгамжтайгаар зааж, тодорхойлсон зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг бодит байдлаар сэргээн тогтооход чиглэж байдаг⁷⁰⁾. “Тоон үзүүлэлт болон судалгааны бусад үр дүнгээс үзэхэд Захиргааны

69) Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэгт. Ц.Ц

хэргийн шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа байдал нилээд өргөн хүрээтэй байгаа нь ажиглагдаж байна”⁷¹⁾ гэж 2007 оны байдлаар хийгдсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн талаарх судалгаанд тусгагдсан байх бөгөөд одоо ч энэ байдал төдийлөн өөрчлөлтгүй явсаар байгаа. Ойрын жишээ татвал, аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхүүд 2011 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 76 хэрэг маргаан шийдвэрлэсэн боловч шүүхийн шийдвэрийн 30 буюу дөнгөж 39.4 хувь нь биелсэн⁷²⁾ байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд нэг талаас шүүх шийдвэрээ хэрхэн биелүүлэх арга журмыг тодорхой зааж өгч байх⁷³⁾ зэрэг шүүх, шүүгчээс⁷⁴⁾ хамааралтай зохион байгуулалтын шинжтэй арга ажиллагааг анхаарахаас гадна захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн⁷⁵⁾ орчинг бий болгох⁷⁶⁾ зайлшгүй шаардлагын үүднээс энэхүү дагнасан шүүх байгуулагдаж ажилласнаас хойш даруй 12 жилийн дараа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг батлахтай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шинээр “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” –ны талаар бүлэг⁷⁷⁾ оруулж өгсөн

70) Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил |судалгааны тайлан-2006|. 67 дахь талд.

71) Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал. Д.Ганз ориг. Хүний эрх сэтгүүл 2007 оны №4.

72) Захиргааны шинэтгэл ба Захиргааны хэргийн шүүх. Захиргааны эрх зүйн өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл. 11 дэх талд. Ц.Цогт. 2016 он.

73) Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2 –т “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно” хэмээн заасан, харин шинэ шүүхийн процессын хуульд энэ заалт тусгагдаагүй байна.

74) Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.10. шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээлэл дхяналт тавьж, холбогдох байгууллагад шаардлагатавх;

75) “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр зарим тохиолдолд “хий хоосон шийдвэр” болж болзошгүй байдал ажиглагдлаа. Ялангуяа төрийн захиргааны дээд, төв байгууллагатай шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа багагүй хүндрэлтэй явагдаж байна. Тиймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тогтолцооны асуудлыг дахин нягталж болж өгвөл захиргааны байгууллагаас хамаарал багатай тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай болжээ” Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал. Д.Ганз ориг. Хүний эрх сэтгүүл 2007 оны №4.

76) Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхэд тулгарч буй асуудлын талаар Х.Батсүрэн. “Шударга ёсны хэмжүүр” сэтгүүлийн 2011 он № 01 /001/ үзнэ үү. Мөн Шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь зарим захиргааны дээд шатны байгууллагын тухайлбал, өөрийг нь харьяалах шууд урирдлага болох Хууль зүйн яамны эсрэг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжгүйд хүргэхээр байгаа талаар бичсэнийг “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тулгамдсан асуудал”. П.Соёл-Эрдэнэ. Шүүхээс хууль тайлбарлан хэрэглэх онол практикийн тулгамдсан асуудал. 2008 он. Улсын дээд шүүх. 214 дэх талаас үзнэ үү.

77) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуульд 2016 оны 2 дугаар сарын 04-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 101 дүгээр бүлэг буюу 791 зүйлээс 794 зүйлд.

нь бүрэн төгс зохицуулалт биш ч гэсэн дэвшил болсон байх бодно. Түүнчлэн, өнөөгийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн шинэчилсэн найруулгад энэ агуулгаараа тусгагдан УИХ-р хэлэлцэгдээд⁷⁸⁾ байгаа билээ.

Эцэст нь тэмдэглэхэд,

Монгол Улс дахь захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчинг материаллаг буюу шүүхийн хэрэглэх хууль, шүүхийн тогтолцоо, чиг үүрэг, мэргэшсэн шүүгч зэрэг харилцааг зохицуулсан нэг хэсэг, шүүх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүний шийдвэрийн гүйцэтгэл гэсэн хэсэгт бүлэглэн авч үзэж дүгнэлт өгөхийг зорьлоо. Монгол Улсын захиргааны хэргийн шүүх хэвийн ажиллаж, захиргааны үйл ажиллагааны улмаас иргэний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалж, сэргээн тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг болон процессын эрх зүйн орчин энэ өгүүллийн холбогдох хэсгүүдэд дурьдсанчлан өөрчлөгдөж, боловсронгуй болохыг зэрэгцээ өөрийн орны соёл уламжлалд нийцүүлэн, орчин цагийн дэлхийн улсуудын төвшинд хүрэх зорилго өмнө маань оршсоор байна.

Ашигласан эх сурвалж

78) УИХ-р 2016 оны хаврын чуулганаар хэлэлцэгдсэн, Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдээгүй байгаа.

몽골행정법원의 법환경과 분석¹⁾

Ts. Tsogt

행정고등법원 판사

요약

이 논문에는 몽골행정법원이 설치된 법적근거와 사법체계에서의 행정법원의 지위, 사법업무의 발전, 특별법원체계의 특징, 사건관할, 분쟁종류, 법원의 업무량, 소송과정의 특징, 당면과제 등의 문제들을 다루었다. 행정법원업무의 결과는(1) 행정사건의 특성에 맞는 고유한 소송절차와 (2) 전문화된 법관과 법조인들의 능력으로 드러나고 가늠되어지기 때문에 법규정을 이러한 방향으로 향후 정비할 필요가 있다. 다른 면에서, 행정법원판결의 실질적 집행과 적용이 이러한 특별법원과 소송목적의 완성을 최종척도가 된다는 의미에서 당면과제 중 하나임에 대해서는 후미에 소개하려한다.

키워드

행정법원, 행정사건, 특별법원, 전문화된 법관, 행정소송, 행정법원체계, 행정법원의 발전

사법체계 내 행정법원의 지위와 역할

몽골의 정치인들과 법전문가들은 헌법법안 입안 전이나 입안 중에도 외국법원 그 중 행정법원체계와 그 업무의 법적근거에 대해 꾸준히 연구해왔으며, 그 결과로 행정법원에 관하여 신헌법에 최초로 규정되었다²⁾. 민주국가의 기본원칙의 적용하여 특히 인권 및 자유보장을 위하여 사법기관의 체계는 적합하고 이를 충분히 실행할 만큼의 권한을 가져야 한다³⁾. 신헌법이 소송종류에 따라 특별법원을 설치하도록 규정한 바에 의하여, 국가최고회의에서 1998년 제18호 법령으로 제정한 몽골 법제개혁정책의 제27조와 2000년 39호 법령으로 제정한 몽골사법부전략계획의 전략목표와 조치제1조2항1호에 행정특별법원설치를 위한 단계적 요건에 대하여 규정하였다. 게다가 정부공약⁴⁾에서 강조한 소송종류로 전문화된 특별법원인 행정법원을 설치한다는

1) “한국-몽골의 법발전의 현황과 향후경향”을 주제로 한 국제학술대회 논문

2) 몽골행정법원의 의의와 사회-사법적 연관성, B. Chimid, 행정법원: 몽골의 개혁, 해외판례 44면, 2002년.

3) 행정법원-인권, Ts. Tsogt, 인권 학술지 2005년 4호.

4) 2000년 제179호 시행령으로 제정된 “정부사업공약 실행조치계획”의 제314조 6항4호6목 1072에 특별법원의 법적근거를 조성하고, 행정법원을 설치하여 운영한다고 명확히 계획하였다.

목적은 2002년 12월 26일 제정된 행정법원설치법이 제정됨으로써 본격적으로 실체화되었다5). 이에 따라 국가의 “자의적 횡포” 가능성을 감소시키기 위해서는 정부는 법령을 준수하고, 법원은 중립을 지킴으로써 입헌주의에 따른 준법의식이 중요한 역할을 할 것이다6).

사법체계상 행정법원은 행정사건이라는 특별사건을 재판하기 위해 설치된 제1심특별법원으로 정의되며, 특별법원 행정소송의 법적근거로서 독립된 법률을 새로 제정하여, 이에 따라 전문화된 인력양성 등 부수적 특징과 요건이 충족되어야 하며 이로써 발전할 수 있다는 것은 분명하다. 이리므로 특별법원은 사법체계의 그냥 한 부분이 아닌, 사법체계의 향후 경향, 발전의 미래이기도 하다7). 현대 행정법관계의 경향은 국민에게는 가깝고, 업무는 만족할만한 행정을 만들기 위해 변화되고 있지만, 행정법의 전통적 편파관계, 국민의법의 위에 군림하는 행정청의(공익이 아닌 관할 기관과 공무원의 업무를 위한)의지를 강제하려는8) 구시대적 입장을 여전히 유지하고 있는 편이다. 그러므로 행정행위 상 국민의 권리침해를 예방하고 배제하려는 의도로 한 감독체계는 단지 행정청 자체 조직과 내부심사에 의존할 수 없는 수준에 이르렀으므로 행정행위에 특별법원이 견제할 수 있게끔 하여 이를 통해 국민권리침해를 제한, 보호하고 개방적이고 책임감 있는 행정으로 발전해 나가게 하였다. “행정법원의 주된 목적은 국민의 공법 상 주권적 권리를 보호하고, 행정행위의 적법여부를 심사하는 데에 있다”9) 고 행정법 학자 P. 어드게렐은 결론지었다. 2010년 “몽골행정법원의 발전, 행정소송법의 실행”이라는 통합연구보고서에 언급한대로10), 행정법원이 과거에 국민과 법인이 제안한 청원에 따라 그들의 권리와, 법익을 보호해 왔으며, 비교적 빠른 시일내에 발전했다.

다른 면에서, 1992년 헌법으로 공포한 국가권력분립원칙의 적용과 실행 그리고 최초로 행정권 및 사법권간의 차이가 분명해질 수 있었던 현실적 근거는 행정법원이라는 특별법원의 설치이다. 그러나 이것은 국가기관 상호의 권한분립과 견제와 균형보다는 행정행위로 침해된 국

5) “몽골에서 1998년 “행정소송법안”을 발의하여 국회에 상정했음에도 현재까지 이 법을 제정하지 않았다. 행정법원을 지체 없이 설치하는 것은 국가와 국민 간의 법 앞에서 평등할 원칙을 보장하고, 몽골국민의 기본권과 자유의 향유를 보장하는 것이며, 이렇게 함으로써 민주사회의 발전으로 진보하게 된다.” 라고 행정법학 연구자 D. Sunjid박사는 2002년에 기록하였다. 행정법원을 설치함으로써 인권보호의 큰 일보를 내딛게 된다. D. Sunjid, 법제개혁신문, 2002년12월3호.

6) 몽골 민주주의 발전에 기여한 헌법의 역할: 분석, 2015년, 13면

7) 몽골의 심급제도 : 영향력, 유의점, M. Batsuuri, 입헌주의 학술지, 2013년 4호., 49면

8) “국민의 의식에의 변화/상관에게 복종, 행정기관, 공무원들은 무결점하다는 의식이 있다/ 인류의 기본권을 누구도 임의적으로 침해하고, 위법한 행위를 해서는 안 된다는 것을 반복적으로 공표하는 것이 가장 중요하다고 본다” 고 행정법원의 한 법관이 행정소송으로 침해된 권리를 구제하는 것의 중요성에 대해 의견을 작성하였다. 행정소송법을 사용 시 발생하는 장애와 그 해결방안, U. Badaamsuren, 법원의 법해석 이론과 실제의 당면한 문제, 199면, 2008년, 대법원

9) 행정법총칙, P. Odgerel, 57면, 2016년, 3판

10) “몽골의 행정법원의 발전과 행정소송법의 실행” 연구보고서, 70면, 2010년, 한스자이텔 재단, 2010년 행정법원 현황과 그 업무에 대한 이 연구 및 당면문제 참고.

민의 권리를 구제 및 보호할 수 있는 환경이 조성되었다는 면에서 그 의의가 더 크다. 어떠한 국가에서든 행정법의 발전은 특정한 기관, 사건 및 법에 따라 발생하여 발전하여 왔다. 예를 들면 프랑스에서는 18세기 말 대혁명 이후에 발생한 국가위원회(Conseil d'Etat)의 업무¹¹⁾에 의하여, 미합중국에서는 19세기말에 연합국의 규제기관과 위원회(Regulatory Agencies and Commissions)가 개설되어 각 각 행정법의 급격한 발전을 이루었다고 보고 있다. 하지만 현대 몽골행정법은 행정법원이 처음 설치되어 업무를 시행한 때에 비하면 완전히 새로운 발전단계 수준에 이르렀다. 즉, 행정소송법체계 뿐만이 아니라 행정법 전체가 행정법원을 쫓아 발전하고 있다고 짐작할 수 있다.

체계의 문제

2002년 행정법원설치법으로 오직 아이막*(몽골의 행정구역의 하나로서 한국의 “광역시”에 해당-역자), 수도 단위의 지방행정법원, 즉 제1심법원을 설치하였으며, 아이막의 제1심 지방행정법원의 법원장이 해당 아이막의 고등법원(고등법원)의 법원장의 업무를 중임 하도록 조정¹²⁾ 하였다. 이와 동시에 법원법(2002년)의 개정되어¹³⁾ 지방행정법원을 제1심법원으로 정하는 규정을 신설하였다.

이러한 아이막 지방행정법원과 아이막 고등법원 “중복업무” 조정은 행정법원업무와 조직에 부정적 결과를 가져왔다. 울란타바르 시에 소재하는 지방행정법원만이 사무국과 법원장이 있는 유일한 독립적인 특별법원으로 설치되었다.

몽골 사법기본체계¹⁴⁾는 행정구역을 고려한 흔적이 있다. 즉, 행정구역의 기초단위인 сум, 두렉에 сум 및 сум 간의 지방법원, 두렉 지방법원을, 상위단위인 아이막 및 수도에는 아이막, 수도 고등법원을 두는 형태를 취했다. 그러나 행정특별법원을 설치하면서 이에 맞지 않게 아이막 및 수도 단위에 제1심법원을 설치하였다. 이것은 당시의 정치, 경제적 요인 및 법의식 발전단계와 맞물리면서 단번에 완전한 행정법원체계를 구성할 수 없었고, 그에 따라 행정사건발생빈도와 소송실무, 그리고 발전에 따라 향후 어떻게 조정할 지 결정하려던 목적과 관련된다.

향소, 상고에 따른 행정사건의 심판권을 법원법(2002년)에 신설된 제15조 2항과 행정소송

11) French Administrative Law and Common-Law World. Bernard Schwartz. 1954 (1923) pp23.

12) 2002년 12월 26일 제정된 법원법 제 32조 10항에 “아이막 행정법원의 법원장은 아이막 법원의 법원장을 겸한다” 라는 규정을 신설하였다.

13) 2002년 12월 26일 제정된 법원법 제 161조 신설.

14) 몽골의 1992년 헌법으로 법원체계를 일반법원 및 특별법원으로 구성하였지만 대법원의 경우 하나의 법원이 있도록 규정하였다.

법 제 15조 2항 1호에 근거하여¹⁵⁾ 대법원에 부여하였다. 환언하자면, 별도의 독립된 고등법원을 설치하지 않고 대법원의 행정청서에서 항소와 상고심판업무를 동시에 수행해 온 것이다. 행정사건을 상고심에서 심판할 시 “본안과 관련하여 전문화되지 않은” 대법관 2인이 참여하도록 규정한 것은 행정사건 1인의 대법관을 “설득할 수 있다면” 본안에 있어서 다수결로 인용판결이 가능하다는 뜻이다¹⁶⁾.

아무리 체계 면에서 완전하지 않고¹⁷⁾, 제1심과 제2심법원의 조직에 문제가 있더라도, 행정사건을 전담하는 특별법원을 설치한 것은 “행정청의 행위에 대한 일반법원의 감독 및 견제를 질적으로 변화시킨다는”¹⁸⁾ 목적에 부합한 일이었다.

행정법원의 업무가 시작된 지 6년이 지난 후에야 행정고등법원¹⁹⁾을 따로 설치 및 운영함으로써 2011년 4월 1일부터 행정법원체계가 비로소 온전하게 구성되었다. 이렇게 함으로써 대법원의 행정지원이 항소심으로 행정사건을 심판하게 된 것과 관련하여 본안을 상고심으로 심판할 대법원 행정지원 대법관이 부족했던 점²⁰⁾, 이로 인해 다른 지원의 대법관들의 참여로 판결한²¹⁾ 행정사건에 대하여 법조인과 전문가 측에서 법원판결의 전문성 여부에 대해 확신이 없는 점 등 기존의 문제들을 해결하였다. 다른 면에서, 행정고등법원이 설치되어 행정소송법 제 90조에 규정한 항소장을 심리하게 됨으로써 제1심법원의 행정소송법사용의 편차를 좁히는 긍정적인 영향을 끼쳤다.

2016년 7월 1일부터 시행되는 행정소송법에 항소심으로 행정사건의 심리원칙과 관할권 등에 대하여 적지 않은 개정이 이뤄졌으나 향후 고등법원의 역할을 다음의 문제들로 더욱 명확히 할 필요가 있다고 보는 바이다. 이를테면, 분쟁의 종류가 증가하여 새로운 종류의 행정법률

15) 개정 이전 즉 2002년 12월 26일 처음 제정된 행정소송법 제 15조 2항 1호에 “아이막, 수도 행정법원은 제1심으로 판결한 사건을 항소심으로” 대법원의 행정지원이 심리한다고 명시하였다.

16) “몽골행정법원의 발전, 행정소송법의 실무” 연구보고서, 11면, 2010년, 한스자이텔 재단

17) 항소심과 상고심 법원의 역할을 하나의 구조로, 즉 대법원의 행정지원이 수행하고 있으므로 특별법원의 사법심사체계가 완전하지 않다고 할 수 있다. 행정소송의 발전, 연구보고서, 2006년, 9면, B.Chimid 등 연구팀, 세계은행 “사법, 법제 개혁”안, 2008년

18) 행정법원 이전 시대의 법원심사와 신체계의 기초, B.Chimid, 행정법원: 몽골의 개혁, 해외판례, 38면, 2004년, 한스자이텔 재단, B.Chimid 교수가 여기에 “고등법원의 감독”이라고 한 것은 특별법원이 아닌 일반법원에서 행정분쟁을 심리시 발생했던 문제점을 드러내는데 그 목적을 두었다. Ts. Tsogt

19) 2010년 12월 31일 행정합소심법원의 설치에 관한 법

20) 대법원 행정부서는 당시 판사 6명이 인원이 있었고 합소심규정에 따라 심리 구성에 그들 중 3명이 임명된 경우 상고심규정으로 사건심리에 참여할 수 없었으므로 형사, 민사 부서에서 2명 이상의 판사들로 구성해 행정부서를 상고심규정으로 합의 판결하였다. Ts. Tsogt

21) “그러나 상고심에 대하여 사건, 분쟁을 대부분의 경우 다른 부서의 판사들이 판결하였다. 상고심재판에 가장 많이 참여한 행정법관 P.체츠게에게 5건을 배당했다면 다른 부서의 법관 C. 남자브트는 18건, B. 더르췌기터브트는 14건, D. 바트새항은 14건을 배당하였다는 것은 행정법원이 이 단계에서 전문화 원칙이 실현되지 않았다.” 행정소송의 발전, 연구보고서-2006, 10면

관계를 심판하게 된 것과 관련하여 국가규모의 고등법원의 경우 지원을²²⁾ 설치하여 조직적인 업무수행이 요구된다. 우선 세관, 조세, 이권(컨세션) 등 경제사건을 전담하는 지원 설치하는 것을 들 수 있다. 항소심 판결에 대한 의무적으로 상고하는 것은 제2심법원의 업무를 이렇다 할 성과와 결과 없이 그냥 “거치는 단계” 정도로 만들 수밖에 없게 만드는 것 또한 유의해야 한다.

“법관 53인을 지방행정법원에 임명하여 행정법원이 업무를 개시한 이후 4개월의 기간 동안 162건의 사건 중, 100건 이상을 수도행정법원 단독으로²³⁾ 심판하였다. 아직까지도 법원의 불균등한 업무 부담이 존재하며 제1심법원의 불균등한 업무부담²⁴⁾은 특정 아이막에 제1심행정법원이 소재하는지 여부가 아닌 인력배분과 법원조직을 효율적으로 조직함으로써 국민이 거주하는 아이막의 행정법원에 청구할 수 있도록 조정하는 것에 중점을 둘 필요가 있다. 예를 들면, 법원평의회에서 종합적인 “법원법”을 제정한 것과 관련하여 제1심법원을 행정구역 별로 구역화하여, 관할구역 형태로 설치하도록 국가최고회의에 의견을 전달한 것을 당시 각 급 법원에서 제시한 의견들 중 제1심법원이 국민에게 접근성이 좋고, 만족할 만하며 국민의 고소권을 시공간적 요인에 제약, 제한받지 않게 하고자 각 지방마다 이전처럼 설치하도록 결정하였다. 2013년 1월 24일에 제정된 법원설치법을 근거로 셀렙게, 불강 아이막에 행정법원 부재와 해당 아이막의 거주민의 청원에 따라 다르항-울, 어르헝 아이막 소재 행정법원의 관할로 귀속시킨 것은 후에 수정되었지만²⁵⁾, 그 당시에는 국민에게 적잖은 불편을 주었을 뿐 아니라, 이러한 고통²⁶⁾으로 인해 국민이 법원에 청구할 권리를 제대로 실행하지 못하는 경우까지 있었음을 부정할 수 없다.

다른 면에서, 행정법, 행정소송법을 쫓아 법원의 감독대상이 증가되어²⁷⁾ 행정처분으로만 한정하지 않고 행정계약, 행정계획 등²⁸⁾, 모든 행정의 위법한 업무에서 기인한 사건들을 판결하게 되었으므로 향후 지방에서의 행정사건의 업무가 “휴지상태”에 이르지 않을까 한다.

22) 몽골 법원법에 2015년 6월 19일 개정 시 항소심법원에 부서 개설 가능성을 오직 “도의 형사, 민사사건의 항소심법원으로” 한정된 내용의 변경을 잘 확인해야 한다. 또한 이 법의 제 22조 3항을 보아야 한다.

23) 몽골에서의 행정법원 설치 과정과 그 특징, Ch.강바트, 몽골의 국가, 법학 지, 2004년 4호.

24) 2006년에 작성된 연구보고서에 “지방에서의 행정법원의 업무부담 평준화가 상당히 ”느슨하게 멈춰있다”고 기록되어 있다. 행정소송의 발전, 연구보서-2006, 9면, B.Chimid 등 연구팀, 세계은행 “사법, 법제개혁”안, 2008년

25) 이 법은 2015년 6월 19일 법으로 폐지되었다.

26) “몇몇 법관 중에서 제외하는 심급법원을 구역화 하는 의견을 몽골과 같은 분산되어살고, 인구가 적은 국가의 경우에 적용하는 것은 국민으로부터 법원을 더욱 멀어지게 만드는 부정적 결과를 초래한다.” 행정소송의 발전, 연구보고서-2006, 9면

27) 몽골 행정소송법 전부개정에 관하여, G.반즈락취, 사법권 지, 2016년, 1호.

28) “행정법 위반 모든 업무 수정 및 교정 심사 범위가 존재하는가? ... 계약, 계획 등은 법 외의 것이다 ... 분쟁이 발생하면 행정법원은 그것을 각하하지, 현재 우리 몽골에서는.” P.Odgerel, “행정개혁: 문제와 결정” 주제에 사회학회의 기본발표들과 관련하여 제기한 제기와 의견들, 국가행정잡지, 2011, 특수 코드(18) 56면

인력(전문성과 안정성을 가지고 자주적으로 일할 기회)

현재 국가규모에서 22개의 제1심행정법원에 법원장 22명과 판사 82명²⁹⁾이 재직 중이고, 행정고등법원에는 판사 11명³⁰⁾, 대법원에는 대법관 8명이 재직 중이다. 시대적으로 제1심법원은 구조면에서 모두 독립적으로 발전 중이다. 고등법원의 의의는 고유한 소송절차원칙들을 기초로 하여, 전문화된 법관이 재판한다는 것에 있다. 2004년에 행정법원이 처음으로 설치될 때 준비된 인력이 없었지만 그때와 비교하면 10여 년 간 행정법원은 실무 상 경험과, 적용될 법률이 제정됨에 따라 현재로선 비교적 선발적으로 임용할 기회가 생겼다. 2013년부터 시행된 법원법에 따라 새로 법관으로 임용대상자들과 항소, 상고심법원에 임용대상자들에게 “해당 특별법원의 재판사무에 관하여 전문화”될 것을 임용기준으로 정하고 있으나 이러한 기준을 자세히 정하여 심사할 업무가 충분치 못함을 고려해야 한다.

이와 같이, 법률로 법관 본인의 허락 없이 파견하는 것을 특별히 금지한 규정을 삭제하여 “국가최고회의에서 제정한 법관임용안에 따라 행정고등법원에 법원장 1인, 판사 12인의 총 13인의 법관이 재판사무를 수행하게 되었지만, 당시 동법원은 부족한 법관으로 즉, 6인의 판사로만 재판사무를 수행했으므로, 국가최고회의에서 행정항소심법원의 법관들의 수를 감소시키기로 실제로 결정하지 않았음에도 불구하고, 법원평의회에서는 법원을 재설치하였다는 명분으로 동법원의 법관들을 지방에 소재 형사 및 민사법원으로 파견한 사건³¹⁾ 이 발생했으며, 이는 행정법원의 관할사건의 특성과 정치기관과 행정청 및 공무원의 결정과 업무를 견제하는 기능을 지닌 행정법원의 융통성을 저해하는 결과를³²⁾ 초래했다.

그러므로 향후 행정법원의 임용정책으로, 각심마다 전문화된 법관을 선발하여 법관들이 안정적으로, 전문성을 가지고, 자주적으로³³⁾ 재판할 수 있는 환경을 사실적으로(de facto) 조성하는 것이 반드시 필요하고, 행정법원은 “행정청의 변호자로, 부속적인 기관이 아니라 행정청의 행위를 견제 및 심사하여 법치주의를 충족하는 체계여야 한다... 법관들의 발전성과 정의로운 심판만이 모든 것을 좌지우지”³⁴⁾하기 때문에 이는 가장 중요한 당면과제 중 하나이다.

29) 2016년 5월 13일의 법원설치에 관한 법 개정, “법관 인원 개혁에 관한” 국회 규정으로 제정된 인원으로 그 보다 부족한 인원으로 업무를 수행하고 있다.

30) 상기 규정으로 제정된 인원은 행정항소심법원에 법원장이 1명, 그리고 판사 15명이 배정되었다.

31) 법원의 독립성과, 법관의 자주성의 보증: 법관임명 주제 정책연구보고서, 105면, 열린사회포럼, 2015년

32) “행정법원에 이러한 경향이 발생할 위험이 다른 법원들보다 크다”라고 2004년에 이 법원이 설치된 후 얼마되지 않아 학자들의 기록한 것들이 현재 증명되고 있다. 자세한내용은 “행정법원: 몽골의 개혁, 해외판례 ” 책의 4장 참고.

33) “제가치국”이란 법관 자신이 보호되어야지타인의 권리와 자유를 보호할 수 있다, 법원-인권의 보증, Ts. Tsogt, 인권 지, 2009년, 2호.

34) 법원의 신체계의 뿌리 - 행정법원 설치의 길, B.Chimid, 행정법원: 몽골의 개혁, 해외판례 , 2004년, 41면, 한스자이텔재단

행정법원의 역할과 목적 (“법적” 침해인가 아니면 국민의 “권리” 침해인가)

1990년 이전의 체계는 형사, 민사소송사건을 심리하는 과정에서 일반적인 선고를 내리는 등 제한된 범위에서 몇몇 행정행위에 대하여 법원이 개인의 권리와 법익을 간접적으로 보호(심사)하는 수준의 형식적인 규정이었다. 몽골행정소송법의 발전은 2002년 행정법원설치법과 행정소송법의 제정으로 2004년 이후 급속히 이루어져, 행정소송절차의 새로운 사법적, 이념적 목적은³⁵⁾ “행정청의 위법한 행위로 인한 권리침해방지와 국민의 침해된 권리구제”이 되었다.

그러나 이러한 이념은 사법실무와 법률의 실질적 집행의 수준에서 완벽히 이해되고 적용되지 못한 채 10여 년의 세월이 흘렀다. 행정법이론 상 1992년 헌법의 “국가는 인권과 자유를 보장할 수 있는 법적보장을 마련하고, 침해된 권리를 구제한다”는 의무를 국민 앞에 이행하고 2002년 행정소송법의 목적에 반영된 국민 및 법인의 권리보호를 보장한다는 원칙을 개선 및 발전시켜 자세하게 정의할 필요성이 제기되고 있다. “헌법 상 행정법원의 재판목적은 ”행정청을 견제“하는 것이 아니라 국민의 “권리와 법익을 보호하고 구제”하는 것이라고 정의할 수 있다. 사건재판의 목적에 따라 본안의 소송절차원칙, 본안 당사자적격 및 요건, 당사자의 법적지위, 권리와 의무 및 판결의 종류 등이 다른 것은 당연하다”³⁶⁾ .

행정소송의 목적은 - 침해된 권리와 법익구제보다는 분쟁대상이 되는 행정처분의 합법성을 판결하던 기존의 방식을 완전히 배제함에 따라 행정소송절차의 목적은 - 분쟁대상이 되는 행정처분이 개인의 권리를 침해했는지의 여부를 규명하여 판결하는 것을 지향하는 형태³⁷⁾로 이론적, 사법적, 실무적인 수준에서 완전히 변화하였다.

행정소송절차: 특징, 당면 과제

A. 행정법원설치법과 행정소송법이 같은 날 제정되어, 2004년 6월 1일부터 시행됨으로써 1990년 3월 23일 제정된 “몽골국민의 권리를 침해한 행정청, 공무원의 위법한 행정처분에 대하여 제기절차에 관한 법”이 폐지되었다. 헌법 전환기에 “국민의 소송권의 일원으로 행정청의 행정행위에 관하여 견제할 근거를 반영한 법률을 제정한 것은 시기적으로 중요한 의의를 지닌다”³⁸⁾. 정치 및 사회변화가 시기적으로 겹치게 되어 동법의 목적과 규정은 “거의 그대로”

35) 법원의 역할개혁 압제의 수단에서 정의의 파수꾼으로, B.Chimid, 행정법원: 몽골의 개혁, 해외판례, 2004년, 한스자이델재단, 참고.

36) 행정법 기고, Ts. Tsogt, 2016년, 34면

37) 행정법 이론 상 주 사상의 변화, 그 전신이 된 소련의 행정소송법 편집, 젤렌초브 알렉산더 보리소비치, 행정법 과 절차지, 2015년, 11호

2002년의 특별법원설치법에 반영되었다. 올해 7월 1일부터 시행될 행정소송법이 제정되기 전까지 동법은 총 10차례 개정되었으며, 이 중 2010년의 개정으로 발전하였다고 평가되었지만 2016년 7월 1일부터 새로운 행정소송법이 시행될 것이다.

“2002년 행정소송법의 특징과 개혁필요성에 관한 연구개요”에 관하여 G. Banzragch 박사의 기고문³⁹⁾에서 참고할 수 있으므로 자세히 언급하지 않겠다. 왜냐 하면, 본 논문에선 행정소송절차의 당면과제를 총체적으로 다루는 것을 목적으로 하지 않기 때문에 행정소송절차의 근본적이고 일반적인 원칙에 관하여 동 기고문⁴⁰⁾을 부분적으로 인용하겠다.

행정소송절차의 근본적인 문제 중 하나는 “어떤 종류의 행정행위를 행정법원의 재판대상으로 규정”할 것인가에 대한 문제이다. 법원에서 재판할 행정행위의 종류와 범위를 정의하려면 행정일반법 제 3조에 규정된 대로 행정행위에 관한 사법(법원의)적 심사와 연관지어 이해해야 한다.

아무리 몽골 2002년 이후로 행정처분과 행정명령이 행정소송의 대상이 되었지만 10여 년 동안 행정법원에서 행정청의 행위를 심사하는 목적, 범위와 통제에 대한 “이론적 이념”이 불분명하여 많은 문제가 발생하고 있다. 예를 들면, 특정 당사자의 침해된 권리를 재판할 목적으로 소송종류를 규정하였으나, 이론 및 실무적인 수준에서 원고적격과 소송권여부를 자세히 따져보지 않고 개방한 상태로 지속된 것은 기존의 법을 보존하고자 하는 전통적 정서⁴¹⁾가 현재까지 영향을 끼치고 있는 것과 관계가 있다. 행정소송법안을 수립할 때 독일법과 그 경험을 주로 연구하였지만⁴²⁾ 이를 몽골에 토착화에 필요한 기본적인 이론적, 실무 상 양질의 연구를 하지 못했다. 예를 들어, 행정소송법에 반영된 단 하나의 원리로서 당사자의 주관적권리가 침해된 경우에만 본안을 재판한다고 하지만, 현실적으로 “행정행위의 위법여부를 누구를 기준으로 결정할 것인지 불분명하며, 당사자의 소송권을 제한하는 경우 행정청의 위법한 행위는 지속된다”는 근거로 원고적격을 논의하지 않고 소장을 바로 접수하던 것은 행정청의 행위를 “심사⁴³⁾”하는

38) 신, 구의 경계 상의 법원의 감독의 개혁 (1990년 3월부터 2004년 5월) B.Chimid, 행정법원: 몽골의 개혁, 해외판례 : 37면, 2004년, 한스자이델 재단

39) 몽골 행정소송법 개정에 대하여, G.반즈락취, 사법권 지, 2016년, 1호.

40) 행정절차법 개혁: 행정소송의 목적과 소송의 종류, Ts. Tsogt, 법학 지, 2016년, 2호., 시리즈 34

41) 이러한 개념을 “Path dependence”라는 명칭으로 정의하여 연구한다. 시간적 조건이 변화되었다 하더라도 이전의 내렸던 결정과 의견은 새로운 조건에서도 사용되어지고 영향을 끼친다는 것을 표현하는 개념이다. Ts. Tsogt.

42) 법계의 포함 그리고 행정특별법원의 독립된 체계를 고려하여 독일의 예를 주안점으로 삼아 고려하는 것이 옳다는 데 합의 되었다. 그러므로 가서 연구하고, 초대해서 듣는 학자들의 방법론적인 부조를 받은 것이 큰 도움이 되었다는 것을 언급함과 동시에 최종결정을 내릴 때 한 국가의 법을 단어별로 복사하고 체계를 변치않는 형태로 만들어, 타인의 조인을 숭배하며 따르지 않고 오직 고려하였다는 것을 기록하는 바이다.” B.Chimid, 행정법원: 몽골의 개혁, 해외판례 . 44-45면, 2004년, 한스자이델 재단.

43) 행정권 과학이란 오직 국가지도세력 즉 행정기관업무의 적법성을 보장하는 것에 대해 수행할 역할, 권리의 방법형태 면에서 연구한다.” B.Chimid, 몽골인민국의 행정권, 울란바토르 시, 1973년, 392-404면

기존의 이념이 이론 및 실무 상 그대로인 것을 반영한다.

새로 제정된 행정일반법에 행정행위의 종류, 원칙 법적결과⁴⁴⁾ 등이 명확히 규정된 것과 관련하여 행정법원규정으로 소송이론의 방향성이 더욱 명확하게 되었으나 행정소송법은 다음과 같은 문제점이 있으며, 이들을 우선적으로 개정해야 할 필요성이 있다. 그러므로 새로운 행정소송법으로: 행정처분(행정계약, 명령)과 관련된 분쟁, 즉 특정한 주관적권리의 침해로 인한 분쟁을 (1)소송 외에 객관적 소송(공익을 대표하여 법률에 근거하여 특별히 소송권을 지닌 자, 기간상호간의 공법 상 분쟁) (2) 소송을 종류 별로 분류하여 규정하였다.

소송을 상기와 같이 분류함으로써 당사자(법적지위에 관하여 정의되는)적격, 소송권의 요건, 판결결과의 이론 및 원칙에 관한 사항을 구별하여 규정하고, 이로써 실무적으로 사용할 수 있다. 예를 들면, 특정 주체의 권리침해와 관련된 사건을 재판한다고 가정하자. 법원이 제기된 소를 접수할 때 원고의 “권리와 법익과 분쟁대상이 되는 행정행위” 사이의 인과관계 및 연관성과, 동 행정처분이 원고에게 기속력을 가지는지의 여부를 검토한 후에 사건을 접수하여야 할 것이다. 이 때 동 행정처분에 관하여 “소송권”이 발생했는지 여부를 조사할 의무는 주관적 소송의 특징을 반영한다. 소송권 즉 standing의 요건은 주관적 소송의 최초의 요건으로 인정되었으며, 이론 상으로 이 요건을 충족해야 다음 단계의 소송절차가 가능해진다.

한마디로 말하자면, 특정한 행정처분의 내용과 그 규율은 원고의 법익과 어떠한 형태로든 교차, 충돌하는 식의 영향력이 있는지 여부를 조사하는 것을 standing이라는 용어로 연구해 왔으며, 현대 몽골행정법에 이와 동일한 개념은 “주관적 권리”와 상응한다. Standing question 또는 standing issue 등으로 사용되는 이러한 개념은 분쟁대상이 되는 행정처분에 대하여 원고가 법원에 소를 제기하여 심리 시 “독립적인 당사자가 되어 변론할 권리가 있는 자”인지 아닌지를 정하여, 당사자를 “분쟁, 요구할 권리가 있다”고 인정함으로써 그의 법적지위를 정하는 것을 목적으로 한다. 이것은 특정한 행정행위로 권리침해되고 영향을 받지 않는 자가 추상적으로 분쟁을 발생시키는 것을 방지하기 위한 이론적 개념이다. 그러나 지난 기간동안 행정법원은 객관적(objective) 권리와 주관적(subjective) 권리의 침해 여부와 상관 없이 원고적격을 위해 주관적권리가 침해되어야 한다는 요건을 둔 것은 이론,실무 상의 모순⁴⁵⁾을 발생시키는 원천이

44) 행정법에서의 “functus officio” 원칙과 행정공무원의 결정을 무효화할 권리의 몇가지 문제, 기고에서 “위법한 결정의 결과를 제거” 조정이 필요성 참고. D.Munkhtuya, 사법권지, 2014년, 4호.

45) 예를 들면, 행정법원이 설치되어 업무 수행 이후 이 문제로 우리 행정법의 수장되시는 교수님들 중 한분은 “소제기 권을 오직 권리를 침해당한 국민과 법인이 향유하느냐 아니면 권리를 침해당하지 않았지만 해당 행정처분을 위법이라고 본다면 법원에 소제기할 권리가 있는가 나는 문제는 흥미롭고 논란이 많은 문제이다. 법원에서는 오직 권리를 침해당한 국민과 법인만 법원에 소제기할 수 있는 권리가 보장된다는 판례를 통해 실재를 이해하고 있다.”라고 이 문제가 논란이 되는 면에 대해 문제제기한 기고문을 출판하였다. 행정법원 소제기권, D. Ganzorig, 27면, 인권 지, 2005년, 4호.

되었으며, 그 원인으로 해당 분야의 연구자와 학자들 측에서도 양자를 구분할 이론과 그 근거에 대해 연구가 활발히 되지 않을 것을 들 수 있다.

그러나 객관적소송 즉 행정처분이 특정 주체의 권리침해 여부와 상관없이 법률으로 소송권을 부여받은 자가 소를 제기하는 경우, 법원은 당사자가 본안에 대해서 “분쟁, 요구할 권리” 여부를 주관적소송과 같이 일일이 검토할 필요가 없다. 왜냐하면, 객관적 소송은 원고의 권리침해 여부와 상관없이 위법한 행정행위와 처분을 교정할 것을 목적으로 하기 때문에 원고에게 소송권을 법률로서 미리 부여한 것이다. 객관적 소송의 목적이 특정 당사자의 권리침해방지 혹은 침해된 권리구제에 지향하지 않았기 때문에 소송결과로 어떤 한 당사자의 법익이 구제, 보호된 것이 아닌 위법한 행정행위 자체를 교정하는 것이다.

그러므로 (1) 공익을 대표하여 소를 제기하여 (2) 행정청을 상대로 특정문제에 대하여 분쟁할 권한이 특별히 법률으로 부여된 경우 혹은 (3) 행정청 상호간의⁴⁶⁾ 분쟁을 대상으로 하는 경우 행정청의 위법한 행정행위를 교정하고, 공법 상 발생한 객관적인 분쟁을 해결할 수 있게 된다. 이런 종류의 소송을 지나치게 개방하지 않고, 제한적인 범위 내에서 허용하여야 행정청의 정상적인 기능을 실행할 수 있기 때문에 오직 “법률로서 권한이 부여된” 경우에만, 권한이 부여된 자가 소를 제기할 수 있도록 해야 한다.

그러나 여기에는 행정청이 “공권력”을 행사하지 않아 공권력이 침해되었다는 등의 문제로 행정법원에 소를 제기하는 것은 포함되지 않는다. 행정청은 법률로 부여된 권한을 법률로 허용된 범위, 방법 내에서 행사해야 하며, 행정청이 “그 권한을 행사하지 못 하여 침해되었으며, 상대방이 행정처분을 이행하지 않았다” 라는 식으로 행정청 자체의 권한행사 상의 문제를 근거로 행정법원에 소를 제기할 법적 근거가 없다. 행정법원 또한 이러한 청구취지와 근거로 행정사건을 접수하여 재판하지 않는다. 왜냐하면 이것은 행정법원의 소송업무의 목적에 부합하지 않기 때문이다.

사회의 법률관계에 참여하는 특정한 “법인”인 행정청은 두 가지의 법적지위를 가진다. 첫번째, 법률로서 지도 및 행정권한을 부여받은 경우 “행정청으로서”, 그러나 다른 행정청을 통치하는 권한이 부여 경우에는 “주체로서” 법률관계에 참여한다. 예를 들자면, 공정거래 및 공정한 경쟁을 보장 및 규율하는 기능을 하는 행정청은 공정거래에 관하여 “행정청”으로서, 동 행정청 건물이 소재하고 있는 토지의 점유문제로 토지관계를 규율하는 행정청의 처분에 기속되는

46) 이 경우 분쟁중인 행정기관은 서로의 하위기관 아니면 한 체계의 즉 한 상위기관의 당사자가 아닐 요건이 요구된다. 예를 들면, 정부산하 부 간, 부-청 간의 분쟁을 법원의 규정으로 판결하지 않고 그들을 통합하여 이끄는 정부가 결정하기 때문이다. 그러나 지방자치기관과 독립적인 행정청들, 정부 각부와 행정청 간의 분쟁은 포함된다. Ts. Tsogt

경우 혹은 행정청 및 공무원의 직무에 관한 감사의 대상이 되는 경우 당사자로서 법률관계에 참여한다. 공정거래위원회의 처분에 관하여 동 행정청에서 행정법원에 소를 제기하는 경우 동 행정청은 “법인”으로서 행정소송법 상의 원고⁴⁷⁾가 된다.

이러한 행정소송절차의 목적과 연관지어 소송을 분류하여 명확히 하는 것은 행정소송법 개혁의 중대한 과제로서 연구되어지고 있다.

47) 행정소송법 제 1조 1항, 제 3조 1항 7호에 명시한 “법인”

Session 2

Захиргааны эрх зүйн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага 행정법의 개혁과 과제

БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ БА ҮНЭЛЭЛТ 한국 행정소송법 개정과정 및 평가

Илтгэгч: Проф. Ким Сонбэ (КИС)

발표: 김성배 교수(한국국민대)

Хэлэлцүүлэгч: Шүүгч Ц.Цогт (Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх)

토론: Ts. Tsogt 판사(몽골 행정 고등법원)

БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ БА ҮНЭЛЭЛТ

Ким Сон Бэ (Күүкмин Их Сургууль Хууль зүйн сургуулийн профессор)

I. УДИРТГАЛ

БНСУ-ын Захиргааны эрх зүйн судлах зүйл нь маш өргөн хүрээтэй байдаг. 1373 хуулийг оруулаад нийт 4587 хууль дундаас ихэнх нь Захиргааны эрх зүйн судлагдахуун болно. Ийм учраас Захиргааны эрх зүйг нэг илтгэл, нэг сурах бичгээр бүгд судлах боломжгүй. БНСУ-ын Захиргааны эрх зүй нь Японоор дамжиж ирсэн барууны Захиргааны хуулийг нэвтрүүлэх явцад хөгжсөн бөгөөд 1961 он хүртэл БНСУ-ын Захиргааны эрх зүйн дийлэнх хэсэг нь Японы колоничлолын үед батлагдсан ба үнэндээ төрийн ашиг сонирхлын төлөө ашиглах зориулалттай байв. Захиргааны эрх зүйн хөгжлийн үе шатны ангиллыг Харьцуулан эрх зүй, Шүүхийн жишиг судлал, Үндсэн хууль ба Захиргааны хуулийг нэгтгэх, бусад эрх зүйн салбартай харилцан хөгжүүлэх, Захиргааны хуультай ойролцоо хууль, эрх зүйн салбарыг судалж Захиргааны эрх зүйн шинжлэх ухаан болгон хөгжүүлэх зэргээр ангилах боломжтой боловч ямар нэгэн улсын захиргааны эрх зүйн хөгжлийг ийнхүү нэгдсэн байдлаар ангилж үзэх нь зүй бус бөгөөд эдгээр ангиллын тус бүрийн үе шатыг дамжин өнгөрөөх биш харин тус бүрийн үе шат хороондоо үргэлжлэн харилцан нөлөөлж цаг үеийн онцлогийг хадгалдаг. Орчин үед БНСУ нь Японоос барууны эрх зүйг механикаар дамжлуулан нэвтрүүлэх биш харин бие дааж харьцуулан эрх зүйн судлалын үе шатыг дамжиж, барууны улсуудаас гадна бусад улс орнуудын эрх зүйн тогтолцоог практик хэрэгжилт, эрдэм шинжилгээний судалгааны зориулалтаар хэрэгжүүлж байгаа үе шатанд байна хэмээн үзэж болно. Мөн тодорхой нийгмийн үзэгдэлд илүү үр дүнтэй хандаж, алдааг багасгахын тулд баруунаас гадна соёл, нийгэм, эдийн засгийн хувьд төсөөтэй улсын эрх зүйн тогтолцоог судалж байна. Японтой харьцуулахад БНСУ-ын захиргааны эрх зүйн шүүхийн жишиг өргөн хүрээтэйгээр бий болж байгаа тус улсын захиргааны эрх зүйн хөгжилд хувь нэмэр болж байна. 1975 онд хэвлэгдсэн “Захиргааны эрх зүйн шүүхийн шийдвэрийн эмхтгэл(1,2,3 дугаар боть)”-д 9000

гаруй шүүхийн шийдвэр байгаа бөгөөд 1984 онд “БНСУ-ын Захиргааны эрх зүйн шүүхийн жишиг судлалын хороо” байгуулагдаж захиргааны шүүхийн шүүгч болон захиргааны эрх зүйн судлаач хамтран сар болгон мэтгэлцэн ярилцаж байгаа нь Захиргааны эрх зүй хөгжихөд эрчимтэй нөлөөлсөн. “БНСУ-ын Захиргааны эрх зүйн шүүхийн жишиг судлалын хороо” нь жил болгон дотоодын шүүхийн шийдвэрээс гадна гадаадын шүүхийн шийдвэрийг судалдаг. Анхан шатны шүүхийн шийдвэрийн тоо нь статистик судлал эхэлсэн 1953 онд 157 хэрэг байсан боловч 2014 оны 17630 хэрэг болсон. 2015 онд Сөүл захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан хэрэг нь 7846 хэрэг байх ба энэ дундаас 7608 хэргийг шийдвэрлэж 2933 хэргийг давж заалдсан. 2016 оны 5 дугаар сарын байдлаар 2016 онд Улсын дээд шүүхэд нэхэмжлэл гаргасан захиргааны хэргийн тоо гэхэд л 1438 хэрэг байна. БНСУ-ын захиргааны эрх зүйн шинжлэх ухааны судлагдахуун нь захиргааны эрх зүйн процессоор хязгаарлагдаж байсан уламжлалаас ангижирч хуулийн төсөл болон бодлого боловсруулах үед ч идэвхтэй судлах болсон боловч захиргааны эрх зүйн шинжлэх ухааны цөмд захиргааны эрх зүйн процесс оршиж байгаа бөгөөд үүний шалгуур болсон Захиргааны процессын хуулийг судалж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тасралтгүй нэмэгдсээр байна.

БНСУ-ын захиргааны процессын эрх зүйн тогтолцооны эхлэл нь БНСУ-ын анхны Үндсэн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт үндэслэж батлагдсан Захиргааны процессын хуулиас эхтэй. Анхны Захиргааны процессын хууль нь нийт 14 зүйлтэй байсан мөн хуулиар зохицуулаагүй асуудлыг Шүүхийн тухай хууль, Иргэний процессын хуулиар нөхөж зохицуулах байдлаар батлагдсан. Мөн хууль нь захиргааны хэргийн төрөл, нэхэмжлэл гаргах хугацаа, захиргааны эрх зүйн мөрдөн байцаах, захиргааны актын үйлчлэлийг түдгэлзүүлэх, нийтийн ашиг сонирхлын үүднээс нэхэмжлэлийг буцаах зэргийн зарчмыг тусгасан зүйл заалттай байсан. Хуучин хуулийг тайлбарлах, хэрэгжүүлэхэд илэрч байсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай хэмээн эрдэмтэн, судлаачид ярьсаар байсан боловч 37 жилийн дараа буюу 1988 онд л бүрэн шийдвэрлэгдсэн билээ. Шинэ Захиргааны процессын хууль(Хууль дугаар номер 3754)-ийн дагуу захиргааны процессын эрх зүйн процессын тогтолцооны давуу тал нь захиргааны хэргийг ангилал улам нарийн тодорхой болсон оршино. Захиргааны хэргийг хэлбэрийн хувьд ①захиргааны үйлдлийг хүчингүй болгох, ②Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл, ③нийтийн ашиг сонирхлын төлөө гаргасан нэхэмжлэл, ④захиргааны байгууллагууд хоорондын эрх мэдлийг зааглан тодорхойлох гэж

ангилах бөгөөд захиргааны үйлдлийг хүчингүй болгох тухай хэргийг ①захиргааны актыг хүчингүй болгуулах, ②захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх, ③эс үйлдэхүйг хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх гэж дотор нь ангилж үүнд үйлчлэх хуулийг зүйлийг заасан(мөн хуулийн 3 дугаар зүйл, 3-5 дугаар бүлэг). Хэлбэрийн хувьд захиргааны хэргийг 4 ангилах боловч энэ дундаас хүчингүй болгох хэрэг, тэр дундаас ч захиргааны актыг хүчингүй болгуулах хэрэг ач холбогдолтой юм. Хүчингүй болгох хэргийн хувьд захиргааны үйлдэл(§2.1.1), ашиг сонирхол нь зөрчигдсөн захиргааны нэхэмжлэл гаргах боломжтой этгээд (§12)-ийн ойлголт болон үүний хүрээг тодорхойлсон позитив зүйл заалтыг агуулж, хуулийг тайлбарлаж хэргийг шийдвэрлэхээс зайлсхийх боломжтой болсон. 1990-иод оны эхэнд эрх зүйн шинэчлэлээр 1994 ооны 07 дугаар сарын 27-ны өдөр Захиргааны процессын хуулийн зарим хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж өдийг хүртэл хэрэгжиж байна. Гэвч 1994 оны нэмэлт өөрчлөлтөөр ч тухайн үед тулгамдсан асуудал болж байсан даалгах нэхэмжлэл, захиргааны хэргийн шүүхэд гаргаж болох нэхэмжлэлийн төрөл, хүрээг өргөжүүлэх, нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдийг нэмэгдүүлэх зэргийн асуудлыг шийдвэрлэж чадаагүй юм. Харин 1994 онд захиргааны хэргийн шүүхэд хандахын өмнө заавал урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлсэн байх тухай зүйл заалтыг хасаж урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх эсэхээ өөрөө шийдвэрлэх болсон нь иргэдийн захиргааны хэргийг шийдвэрлэхийг хялбар болгож, урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх захиргааны байгууллага болон захиргааны шүүх хооронд өрсөлдөх боломжийг нээж захиргааны процессын эрх зүйн хөгжилд хувь нэмэг оруулсан гэж үзэж болно. Захиргааны процессын хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хамт Шүүхийн тухай хуульд шинэчлэл орж Сөүл Захиргааны хэргийн шүүхийг байгуулах эрх зүйн үндэс бий болсон бөгөөд үүний байгуулалтаар захиргааны шүүхийн жишиг судлалд хувь нэмэр оруулсан. Мөн анхан шатны шүүхээс захиргааны хэргийг авч хэлэлцдэг болсноор захиргааны хэргийг гурван шатны шүүхээр хянан хэлэлцдэг болсон. Ийнхүү захиргааны хэргийг гурван шатаар хянан шийдвэрлэх нь захиргааны эрх зүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ хэмээн эрдэмтэд дүгнэж байгаа боловч захиргааны хэргийн бие даасан байдал ба хөгжлийн төлөө шүүхийн ачааллыг багасгаж захиргааны хэргийг хоёр шатаар хянан хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байгаа судлаачид ч цөөнгүй байна. захиргааны процессын хууль нь иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, захиргааг хянах үүднээс 1984 онд шинэчлэн

найруулсан бөгөөд 1994 онд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт орсон боловч эрдэмтэн, судлаачид нь БНСУ-ын эрчимтэй хөгжиж байгаа эдийн засаг, иргэдийн эрх, ашиг сонирхлыг бүрэн хамгаалж хангахын тулд захиргааны процессын хуулийн зарим идэвхгүй талыг шийдвэрлэх шаардлагатай хэмээн үзэж байгаа боловч одоог хүртэл энэ асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй юм. 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 20 дугаар Ерөнхий Ассамблей захиргааны процессын хуулийн төслийг боловсруулаагүй байгаа боловч 19 дүгээр Ерөнхий Ассамблей төслийг боловсруулж гаргасан боловч төсөл хэлэлцэх хугацаа дуусаж хүчингүй болсон. Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон захиргааны процессын хууль болон 19 дүгээр Ерөнхий Ассамблейээс боловсруулсан захиргааны процессын хуулийн төслийн зарим зүйл заалт, 2011, 2012, 2013 оны эрдэмтэд, Хууль зүйн яам, Улсын дээд шүүхийн хамтран хэлэлцэж байсан захиргааны процессын хуулийн төслийг авч үзье.

1. Нэмэлт өөрчлөлт орсон шалтгаан ба үүний агуулга

“Сэжун захиргааны нэгдсэн хот” байгуулагдсанаар Ерөнхий сайдын байр болон бусад төв захиргааны байгууллагууд Сэжун хот руу нүүж, ихэнх захиргааны байгууллага Сөүл хотод байгаа гэж үзэн зохицуулж байсан захиргааны процессын хуулийн 9 дүгээр зүйл(шүүхийн харьяалал)-ийг өөрчлөх шаардлагатай болсон. Үүний талаар 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Пак Бом Кэ гишүүн захиргааны процессын хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан. Тус төслийг шалтгааныг авч үзэхэд захиргааны байгууллагууд Сэжун хот руу нүүхийн өмнө бүгд Сөүл хотод байсан учраас Улсын дээд шүүхийн оршин байгаа Сөүл хотод хэргийг хэлэлцэхэд асуудал байсангүй боловч нөхцөл байдал өөрчлөгдсөн байхад дийлэнх захиргааны байгууллагын оршин байгаа Сэжун хотод бус харин Сөүл хотод л захиргааны хэргийг хянан хэлэлцэх нь зүй бус гэж үзсэнтэй холбоотой юм.

Ерөнхий Ассамблейн “Хууль батлах, эрх зүйн хороо”-ны гишүүд нь захиргааны байгууллагын ихэнх нь Сэжун хот руу нүүсэн байхад зөвхөн Улсын дээд шүүхийн оршин байгаа Сөүл хотоор шүүхийн харьяаллыг хязгаарлах нь нэхэмжлэгчийн ашиг сонирхолд харш гэж үзэж хуулийн төслийг дэмжсэн. Гэвч Захиргааны процессын хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт нэгэнт “хариуцагчийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүх” хэмээн шүүхийн харьяаллыг тодорхойлсон учраас “төв захиргааны байгууллагын оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүх” гэж нэмэлт оруулбал агуулгын хувьд

давхардах учраас “Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхийг мөн шүүхийн харьяалал болгоно.” гэж өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Хүснэгт – Пак Бом Кэ гишүүний төсөл ба
“Хууль батлах, эрх зүйн хороо”-ны тайлан

Хуучин зүйл, заалт	Хуулийн төсөл	Өөрчлөлт(төсөл)
§9. (Шүүхийн харьяалал) ① Захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг анх ан шатны шүүхийн харьяалал нь хариуцагчийн оршин байгаа газрынзахиргааны хэргийн шүүх юм. Гэвч, хариуцагч нь төв захиргааны байгууллага эсхүл үүний дарга байх тохиолдолд шүүхийн харьяалал нь Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын захиргааны шүүх болно.	§9. (Шүүхийн харьяалал) ① ----- ----- ----- ----- --- шүүхийн харьяалал нь Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын эсхүл төв захиргааны байгууллагын оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүх -----	§9. (Шүүхийн харьяалал) ① ----- ----- ----- ----- --- тохиолдолд Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхийг мөн шүүхийн харьяалал болно.

Үүний дараа 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 323 дугаар Ерөнхий Ассамблейн ээлжит бус хуралд 1 дүгээр ээлжийн хуулийн төслийн 1 дүгээр комисст оролцсон Ким Хён Үнг Хууль яамны дэд дарга нь уг хуулийн төсөлд багагүй асуудал байгаа учраас сайтаар хэлэлцэх ёстой боловч хуулийн төслийн агуулгыг дэмжиж байна гэж Хууль зүйн яамнаас албан ёсоор саналаа илэрхийлсэн бөгөөд 2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан.

[Хууль, дугаар номер 4770, 1994 оны 7 дугаар сарын 27-ны өдөрт хэсэгчлэн өөрчлөлт орсон.]	[Хууль, дугаар номер 12596, 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдөрт хэсэгчлэн өөрчлөлт орсон.]
§9.(Шүүхийн харьяалал) ①Захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг анхан шатны шүүхийн харьяалал нь хариуцагчийн оршин байгаа газрынзахиргааны хэргийн шүүх юм. Гэвч, хариуцагч нь төв захиргааны байгууллага эсхүл үүний дарга байх тохиолдолд шүүхийн харьяалал нь Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын захирга	① Захиргааны актыг хүчингүй болгох анхан шатны шүүх нь хариуцагчийн оршин байгаа газрыг шүүхийн харьяалал болгоно. <Өөрчлөлт 2014.5.20> ② 1 дүгээр хэсэгт заасан боловч дараах зүйлд хамаарч байгаа хариуцагчид холбогдуулан захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийн хувьд Улсын дээд шүүхийн оршин

<p>аны шүүх болно.</p> <p>② Газрыг хураан авах, үл хөдлөх хөрөнгө эсхүл бусад тодорхой байршилтай холбоо той захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг тухайн үл хөдлөх хөрөнгө буюу байршлын оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд гаргана.</p>	<p>байгаа газрын захиргааны шүүхэд гаргаж болно. <Нэмэлт 2014.5.20></p> <p>1. Төв захиргааны байгууллага, төв захиргааны байгууллага харьяа байгууллага, захиргааны байгууллагын нэгдэл эсхүл түүний дарга</p> <p>2. Төрийн ажиллагааг төлөөлөн гүйцэтгэх нийтийн эрх зүйн байгууллага эсхүл түүний дарга</p> <p>③ Газрыг хураан авах, үл хөдлөх хөрөнгө эсхүл бусад тодорхой байршилтай холбоотой захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг тухайн үл хөдлөх хөрөнгө буюу байршлын оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд гаргана. <Өөрчлөлт 2014.5.20></p>
--	---

2. Үнэлэлт

Төв захиргааны байгууллага Сөүл хотоос Сэжун хот эсхүл бусад орон нутаг руу шилжсэн хэдий ч хуучин захиргааны процессын хуулийн дагуу Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын буюу Сөүл захиргааны хэргийн шүүхэд л нэхэмжлэл гаргах боломжтой байсан учраас хариуцагч болон нэхэмжлэгчид төвөгтэй байсан боловч уг нэмэлт өөрчлөлтийн дагуу нэхэмжлэгч болох иргэн нь шүүхийн харьяаллаа хариуцагчийн оршин байгаа газрын шүүх, Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын шүүх дундаас сонгон нэхэмжлэлээ гаргах боломжтой болсон. Мөн “Хууль батлах, эрх зүйн хороо”-г дамжиж төв захиргааны байгууллага төдийгүй үүний харьяа байгууллага, захиргааны байгууллагын нэгдэл, нийтийн эрх зүйн байгууллага зэргийн хариуцагчийн хувьд ч уг байгууллагын оршин байгаа болон Улсын дээд шүүхийн газрын захиргааны хэргийн шүүхэд хэргээ хянан хэлэлцэх боломжтой болсноор иргэд илүү өргөн сонголтын хүрээтэй болсон. Тухайлбал, Үлсан хот руу шилжсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын нэгдлээс төрийн эрх мэдлийг шилжүүлэн авч төлөөлөн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд ч нэхэмжлэгч нь Үлсан хотод байгаа захиргааны хэргийн шүүх эсхүл Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүх дундаас сонгон нэхэмжлэлээ гаргаж болно. Уг төслийг хэлэлцэх явцад Сөүл хотын өмгөөлөгч, Сэжун хотын өмгөөлөгчийн саналыг асуусан гишүүн байсан бөгөөд тодорхой орон нутаг хоорондын ашиг сонирхлын зөрчил байж болзошгүй гэж сөргөөр хандах тал ч байсан боловч төсөл батлагдсан шалтгаан нь аль болох иргэд нэхэмжлэл гаргах боломжийг нэмэгдүүлж, хялбар болгоход оршиж байгаа болно.

II. 19 ДҮГЭЭР ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ (2012.5-2016.5.29)-Д ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Дээр авч үзсэнчлэн шүүхийн харьяаллаас гадна 5 хуулийн төслийг өргөн барьсан боловч бүгд төсөл хэлэлцэх хугацаа нь дууссаны улмаас хүчингүй болсон. Хуулийн төсөл өргөн барьсан дарааллаар дараах 5 хуулийн төслийг танилцуулъя.

1. 2014.5.2. Ким Мин Ки гишүүний өргөн барьсан хуулийн төсөл (Даалгах нэхэмжлэл)

1) Хуулийн төсөл өргөн барьсан шалтгаан ба үүний агуулга

Ким Мин Ки гишүүн нь Захиргааны эрх зүйн салбарт тасралтгүй яригдаж байсан захиргааны үйлдэл хийхийг даалгах нэхэмжлэлийн тогтолцоог нэвтрүүлэх тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төсөл нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Захиргааны процессын хуульд зааснаар захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл зэргийн хүсэлтэд үндэслэлгүй татгалзсан эсхүл хариу өгөхгүй эс үйлдэхүй зэрэгт иргэн хохирсон эрх ашгаа хамгаалах үүднээс “Эс үйлдэхүй хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл” болон “Үндэслэлгүй татгалзсаныг хүчингүй болгох нэхэмжлэл” гаргаж шүүхээс эдгээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн ч захиргааны байгууллагаас үүргээ биелүүлэхийг шаардах боломжгүй байхаас гадна уг үүргийн биелэлтийг шаардахын тулд нэмэлт нэхэмжлэл гаргах ёстой гэдгээр үр бүтээлгүй тогтолцоо байсан. Иймд захиргааны байгууллагын хууль бус эс үйлдэхүй, татгалзал зэргээс үүдсэн маргааныг нэг удаагийн шүүх хуралдаанаар шийдвэрлэхийн тулд “даалгах нэхэмжлэл”-ийн тогтолцоог оруулж иргэд өөрсдийн эрх ашгаа үр бүтээлтэй хамгаалах боломжийг олгох шаардлагатай гэж үзэв.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль	Хуулийн төсөл
<p>§4 (Хүчингүй болгох) Захиргааны үйлдлийг хүчингүй болгох нэхэмжлэл нь дараах байдлаар ангилна.</p> <p>1. Захиргааны үйлдлийг хүчингүй болгох : Захиргааны байгууллагын хууль бус үйлдлийг хүчингүй болгох буюу өөрчлөх нэхэмжлэл</p> <p>2. Захиргааны акт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх : Захиргааны байгууллагын акт бий эсэх, хүчин төгөлдөр үйлчлэх эсэхийг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл</p> <p>3. Эс үйлдэхүй хууль бус эсэхийг хүлээн зөвшөөрөх : Захиргааны байгууллагын эс үйлдэхүй хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл</p>	<p>3. Даалгах : Оролцогчийн хүсэлтийн дагуу захиргааны байгууллагын хууль бус татгалзал буюу эс үйлдэхүйн тухай тодорхой үйлдэл хийхийг даалгах нэхэмжлэл</p>
	<p>1 дүгээр заалт Захиргааны акт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх нэхэмжлэл (Нэмэлт)</p>
	<p>§38.2 (Нэхэмжлэл гаргах эрх нээгдсэн эсэх) Даалгах нэхэмжлэл нь захиргааны акт гаргах тухай захиргааны байгууллагад хүсэлт гаргасан этгээд бөгөөд захиргааны хууль бус татгалзал буюу эс үйлдэхүйн тухай тодорхой үйлдэл хийхийг даалгаснаар хууль зүйн эрх, ашиг сонирхол нь хангагдах этгээд нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>§38.3 (Нэхэмжлэл гаргах хугацаа) ① Захиргааны байгууллагын татгалзсан хариуд даалгах нэхэмжлэл гаргах тохиолдолд 20 дугаар зүйлийг төсөөтэй хэрэглэнэ.</p> <p>② Захиргааны байгууллагын эс үйлдэхүйн тухай даалгах нэхэмжлэл гаргах тохиолдолд хуулиар захиргааны акт гаргах хугацааг заасан бол уг хугацаа дуусахын өмнө нэхэмжлэл гаргах боломжгүй бөгөөд хуулиар хугацаа заагаагүй бол хүсэлт гаргаснаас хойш 90 хоногийн дотор нэхэмжлэл гаргана.</p> <p>§38.4 (Нэхэмжлэлийг өөрчлөх) ① Захиргааны байгууллагын татгалзал буюу эс үйлдэхүй хууль бус байх тохиолдолд шүүх дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.</p> <p>1. Оролцогчийн гаргасан хүсэлтийн дагуу захиргааны акт гаргах үүрэгтэй бөгөөд захиргааны акт гаргах үндэслэлтэй бол захиргааны байгууллага уг захиргааны акт гаргахыг даалгаж шийдвэрлэнэ.</p>

2. Үүнээс бусад тохиолдолд захиргааны байгууллагаас оролцогчийн хүсэлтэд шүүхийн шийдвэрийн зорилгын дагуу зохих захиргааны акт гаргахыг даалгаж шийдвэрлэнэ.

§38.6 (Даалгах шийдвэрийн хүчин төгөлдөр байдал) Захиргааны байгууллагад оролцогчийн хүсэлтийн дагуу захиргааны акт гаргахыг даалгах, эсхүл шүүхийн шийдвэрт заасан зорилгын дагуу зохих захиргааны акт гаргахыг даалгах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор тухайн хэргийн хувьд оролцогч буюу захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллага шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

§38.7 (Даалгах шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэх) ① Захиргааны байгууллага 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийн дагуу шүүхийн шийдвэрт заасан захиргааны акт гарга

гүй байх тохиолдолд анхан шатны шүүх нь оролцогчийн хүсэлтийн дагуу шүүхийн шийдвэр биелүүлэх тодорхой хугацаа зааж, хэрвээ захиргааны байгууллага уг хугацаанд захиргааны акт гаргаагүй тохиолдолд хугацаа хожимдсоны улмаас үүсэх хохирлыг нөхөн төлүүлнэ.

② Нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд шүүхээс оролцогчийн хүсэлтийн дагуу 1 дэх заалтын дагуу гаргасан шийдвэрээ өөрчилж болно.

③ 1 буюу 2 дахь заалтын дагуу шүүх шийдвэр гаргахдаа хүсэлт гаргагчийн эсрэг тал аас асуулт асууж болно.

④1 буюу 2 дахь заалтын дагуу гаргасан шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхтэй. Энэ тохиолдолд шүүхийн шийдвэрийг түдгэлзүүлэхгүй.

⑤1 буюу 2 дахь заалтын дагуу шүүх шийдвэр хүчинтэй болсон бол хариуцагч болох захиргааны байгууллагын харьяалах төр эсхүл нийтийн эрх зүйн байгууллагад уг шийдвэр үйлчилнэ.

§38.8 (Төсөөтэй хэрэглэх) 9,10 дугаар зүйл, 13-18 дугаар зүйл, 22 дугаар зүйл, 25-29 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 31-33 дугаар зүйлийг даалгах нэхэмжлэлийн хувьд төсөөтэй хэрэглэнэ.

2) Тайлан

(1) Нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага

“Хууль батлах, эрх зүйн хороо”-ны байнгын гишүүний хуулийн төслийг хянаж үзээд гаргасан тайланд даалгах нэхэмжлэлийн тогтолцоог оруулах тохиолдолд шүүхээс захиргааны байгууллагад тодорхой үйлдэл хийхийг шууд даалгах эрхтэй болох учир маргааныг шуурхай, нэг удаагийн шүүхийн хэлэлцүүлгээр шийдвэрлэх боломжтой болж, оролцогчийн хууль зүйн эрх, ашиг сонирхлыг бүрэн хамгаалж шүүхийн ачааллыг багасгах давуу талтай хэмээн үнэлсэн. Мөн захиргааны хэргийн шүүхийн өмнөх шат буюу урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хувьд ч даалгах шийдвэр гаргаж болохоор “Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль”-д заасан учраас захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд ч даалгах шийдвэр гаргаж болохоор нэмэлт өөрчлөлт оруулбал дээрх хоёр ажиллагааны хооронд тэнцвэртэй байдал хангагдана гэж үзсэн.

(2) Даалгах нэхэмжлэлийн тогтолцоог нэвтрүүлж, эс үйлдэхүй хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэлийг хүчингүй болгох

Гэвч байнгын хорооны гишүүний тайланд зааснаар даалгах нэхэмжлэлийн тогтолцоог оруулахын хамт эс үйлдэхүй хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэлийг устгахад болгоомжтой хандах хэрэгтэй гэж үзэв. Мөн хуулийн төсөлд зааснаар даалгах нэхэмжлэлийг оруулсан ч шүүхээс оролцогчийн гаргасан хүсэлтийн дагуу захиргааны акт гаргах үүрэгтэй бөгөөд захиргааны акт гаргах үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд л даалгах шийдвэр гаргах учраас оролцогч даалгах нэхэмжлэл гаргаснаар хэдий ч хүсэлт гаргасан захиргааны актыг гардан авах боломжгүй бөгөөд даалгах нэхэмжлэлийн дагуу үүсгэсэн хэргийн мэтгэлцээн дууссан үеийг шалгуур болгон хуульд нэмэлт өөрчлөлт орсон бол захиргааны байгууллагад даалгах шийдвэр гаргах боломжгүй боловч захиргааны хууль бус эс үйлдэхүйн хувьд ч хэлэлцэх боломжтой гэв. Иймд “Хууль батлах, эрх зүйн хороо”-ны гишүүн нь даалгах нэхэмжлэлээс гадна эс үйлдэхүй хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэл, хэргийг хэвээр үлдээх хэрэгтэй бөгөөд хуулийн төслийн холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай гэв.

(3) Захиргааны эрх зүйн процесс ба иргэний эрх зүйн процесс дахь нэхэмжлэлийн өөрчлөлт

Хуулийн төсөл нь хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх, даалгах нэхэмжлэлийг иргэний эрх зүйн процесс дахь нэхэмжлэл болгон өөрчлөх, эсрэгээр иргэний эрх зүйн процесс дахь нэхэмжлэлийг хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх, даалгах нэхэмжлэл болгон өөрчлөхийг зөвшөөрсөн агуулгатай. Уг төслийг хянаад гаргасан тайланд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 21 дүгээр зүйл болон 37 дугаар зүйл нь хүчингүй болгох, хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх, эс үйлдэхүй хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх нэхэмжлэлийн тус бүрийг Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл, эсхүл бусад төрлийн хүчингүй болгох нэхэмжлэлээр л өөрчлөхийг зөвшөөрч байгаа бөгөөд иргэний эрх зүйн процесс дахь нэхэмжлэлийг захиргааны эрх зүйн нэхэмжлэл болгон, эсхүл захиргааны эрх зүйн нэхэмжлэлийг иргэний эрх зүйн нэхэмжлэл болгон өөрчлөх боломжтой эсэхийг хуульд тодорхой заагаагүй байгааг анхааруулав. Мөн хууль, эрх зүйн мэдлэг сул ард иргэдийн хувьд иргэний болон захиргааны эрх зүйн процесс хоёрыг хооронд нь ялгаж чадахгүй байх тохиолдол цөөнгүй бөгөөд захиргааны эрх зүйн процессын хувьд ямар төрлийн нэхэмжлэл гаргаа сайн мэдэхгүй байх, буруу төрлийн нэхэмжлэл гаргасны улмаас нэхэмжлэл буцаагдаж эхнээс нь дахин хэрэг хэлэлцэх, хүчингүй болгох нэхэмжлэл гаргах ёстой байтал иргэний эрх зүйн нэхэмжлэл гаргаж буцаагдсан тохиолдолд захиргааны хэрэг үүсгэх хугацаа дууссан байх зэргийн асуудал үүсэж байгаа учраас хүчингүй болгох болон бусад төрлийн хүчингүй болгох нэхэмжлэл, Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл зэрэг нэхэмжлэлийг хооронд нь өөрчлөхөөс гадна иргэний болон захиргааны эрх зүйн нэхэмжлэлийг хооронд нь өөрчилж болохоор хуульд нэмэлт өөрчлөлт оруулж иргэдийг захиргааны хэргээ хялбар хянан шийдвэрлүүлэх боломжоор хангах зорилго бүхий хуулийн төсөл үндэслэлтэй. Гэвч энэ тохиолдолд хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх, даалгах нэхэмжлэлийн хувьд л иргэний болон захиргааны эрх зүйн нэхэмжлэл хоорондын өөрчлөлтийг зөвшөөрөх нь зүй бус бөгөөд иргэдийн эрх ашгийг аль болох хамгаалахын тулд хэргийг үр бүтээлтэй хянан шийдвэрлэхийн тулд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүчингүй болгох нэхэмжлэлийн тухай 21 дүгээр зүйл болон Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл тухай 42 дугаар зүйлийг ч мөн иргэний болон захиргааны эрх зүйн нэхэмжлэл хоорондын өөрчлөлтийг зөвшөөрөх агуулгаар хамт нэмэлт өөрчлөлт оруулж эрх

зүйн хэм хэмжээний нэгдсэн байдлыг хангах нь чухал юм.

(4) Хэлэлцүүлэг ба үнэлэлт

2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Хууль батлах, эрх зүйн хороо”-ны 329 дугаар хуралдаанаар Захиргааны процессын хуулийн төсөл ба бусад асуудлаар хэлэлцүүлэг хийсэн боловч Захиргааны процессын хуулийн төсөл нь Хууль зүйн яамны гол батлах хуулийн нэгэнд багтаж байгаагүй учраас уг хуулийн төслийн танилцуулгыг бичгээр хийх болсон. Мөн дээрх хуралдаан нь “Севол” усан онгоц живсэн тухай хэргийн анхан шатны шүүхийн хэлэлцүүлэг болсны дараах өдөр болсон учраас Шүүхийн захиргааны хэлтсийн дарга болон Хууль зүйн яамны сайдаас “Севол” усан онгоцны хэрэгтэй холбогдуулан асуулт их асууж, Захиргааны процессын хуулийн төслийн талаар харьцангуй бага хэлэлцсэн.

Тус хуулийн төсөл нь Захиргааны эрх зүйн салбарт удаан хугацааны туршид яригдаж байсан даалгах нэхэмжлэлийн тогтолцоог оруулах тухай хуульд хэсэгчлэн нэмэлт өөрчлөлт оруулах оролдлого нь хангалтгүй гэж дүгнэх боловч багахан ч гэсэн асуудлыг шийдвэрлэх боломжтой гэдгээр өндөр үнэлгээтэй байв. Гэвч Ерөнхий Ассамблейн хэлэлцэх гол асуудал болж чадалгүй хуулийн төсөл хэлэлцэх хугацаа нь дуусаж хүчингүй болсон.

2. 2015.1.22. Хам Жин Кюү гишүүний өргөн барьсан хуулийн төсөл(нэхэмжлэл гаргах хугацааг сунгах тухай) болон 2015.2.13. Ү Юүн Кын гишүүний төлөөлөн өргөн барьсан хуулийн төсөл(нэхэмжлэл гаргах хугацааг сунгах тухай)

1) 2015.1.22. Хам Жин Кюү гишүүний хуулийн төсөл өргөн барьсан шалтгаан ба үүний агуулга

Уг хуулийн төслийг өргөн барьсан шалтгаанд зааснаар захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь нийтийн эрх зүйн харилцаанд үүссэн хэрэг, маргааныг шийдвэрлэх ажиллагаа бөгөөд “Захиргааны процессын хууль” нь “Иргэний процессын хууль”-иас ялгаатай тал нь захиргааны байгууллагын үйлдсэн тодорхой хууль зүйн фактын дагуу хуулийг хэрэгжүүлэх буюу төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл үүнээс татгалзах, захиргааны үйлдэл хийх, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны дагуу гаргасан захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргах тохиолдолд цаг хугацааны хувьд хязгаарлалт тавьж,

уг хугацаа дууссан тохиолдолд захиргааны актын хүчинтэй байдлын талаар маргах боломжгүй болох зэргийн асуудалтай байгаа учраас захиргааны акт гарсныг мэдсэнээс хойш 90 хоногийн дотор гомдол гаргах нь хэт богино бөгөөд ард иргэд нотлох баримт цуглуулж, өмгөөлөгч авсаар байтал 90 хоног дуусаж хохирох тохиолдол цөөнгүй байдаг. Иймд тус хуулийн төсөл нь захиргааны акт гарсныг мэдсэнээс хойш 90 хоног биш харин 180 хоногийн дотор нэхэмжлэл, гомдол гаргаж болохоор иргэд өөрсдийнхөө эрх ашгаа хамгаалах боломжийг олгохоор хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэв (Төслийн 20 дугаар зүйл).

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль	Хуулийн төсөл
<p>§20 (нэхэмжлэл гаргах хугацаа) ① Хүчингүй болгох нэхэмжлэлийг захиргааны акт гарсныг мэдсэнээс хойш 90 хоногийн дотор гаргана. Гэвч 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан ба урьдчилан шийдвэрлэх ажиллагааны гомдол гаргах боломжтой, захиргааны байгууллагаас урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулж болно хэмээн буруу мэдэж элсэн тохиолдолд урьдчилан шийдвэрлэх ажиллагааны дагуу гомдлыг хянан үзээд гаргасан шийдвэрийг эх хувиар нь хүлээн авсан өдрөөс эхэлж хугацаа тоолно.</p>	<p>§20 (нэхэмжлэл гаргах хугацаа) ① ----- ----- -----180 хоногийн дотор----- ----- ----- -----.</p>

2) 2015.2.13. Ү Юүн Кын гишүүний төлөөлөн өргөн барьсан хуулийн төсөл (нэхэмжлэл гаргах хугацааг сунгах тухай)

(1) Өргөн барьсан шалтгаан ба үүний агуулга

Тус хуулийн төсөл нь “Захиргааны процессын хууль” нь “Иргэний процессын хууль”-иас ялгаатай тал нь захиргааны байгууллагын үйлдсэн тодорхой хууль зүйн фактын дагуу хуулийг хэрэгжүүлэх буюу төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, эсхүл үүнээс татгалзах, захиргааны үйлдэл хийх, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны дагуу гаргасан шийдвэрийн хувьд захиргааны акт гарсныг мэдсэнээс хойш 90 хоногийн дотор, захиргааны акт гарснаас хойш 1 жилийн дотор үүнийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргаж болохоор хугацааг хязгаарласныг шүүмжилж, ард иргэд хууль, эрх зүйн мэдлэггүй буюу өмгөөлөгч авахад хэт урт хугацаа шаардаж өөрийн эрх ашгаа хамгаалах оролдлого хийхээс ч өмнө нэхэмжлэл гаргах хугацаа дуусах зэргийн асуудал үүсэж байна. Иймд захиргааны актыг хүчингүй

болгох нэхэмжлэлийг захиргааны акт гарсныг мэдсэнээс хойш 90 хоног биш харин 180 хоног болгон нэмэгдүүлэх нь иргэд өөрсдийн эрх ашгаа хамгаалах боломжийг олгох давуу талтай гэж үзсэн(төслийн 20 дугаар зүйл) ба энэ нь Хам Жин Кюү гишүүний хуулийн төслийн агуулгатай давхцаж байна.

3) Тайлан

Дээрх хоёр хуулийн төсөл нь иргэний эрх ашгийг хамгаалах зорилгоор захиргааны байгууллагын гаргасан актыг хүчингүй болгох тухай нэхэмжлэл гаргах хугацааг 90 хоногоос 180 хоног болгон нэмэгдүүлэх агуулгатай учраас нэг тайланд уг хуулийн төслүүдийг дүгнэв. Нэхэмжлэл гаргахад хугацаа заасан шалтгаан нь захиргааны үйлдэлтэй холбогдуулан эрх зүйн харилцааг шуурхай үүсгэх, тогтвортой байлгах зорилго бүхий тогтолцоо бөгөөд захиргааны байгууллагад өөрийн гаргасан захиргааны акт тодорхой хугацааны дараа хүчин төгөлдөр үйлчлэх баталгааг олгож хэвийн үйл ажиллагаа явуулах боломжоор хангах, иргэдийн хувьд нэхэмжлэл гаргах хугацааг зааснаар эрх зүйн хэм хэмжээг урьдчилан таамаглан дагаж мөрдөх үүрэгтэй. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хувьд хүчингүй болгох нэхэмжлэл гаргах хугацаа нь 90 хоног байхад хуулийн төсөлд заасны дагуу 180 хоног болгон өөрчлөх тохиолдолд захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нэхэмжлэл гаргахад хялбар болж иргэний эрх ашиг хамгаалах боломж нэмэгдэнэ. Харьцуулсан эрх зүйн судалгааны хувьд Япон улсаас 2004 онд “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж нэхэмжлэл гаргах хугацаа (出訴基間)-г 3 сараас 6 сар болгон хоёр дахин нэмэгдүүлсэн. Гэвч ийнхүү нэхэмжлэл гаргах хугацааг нэмэгдүүлэхийн сул тал нь захиргааны байгууллагад өөрийн гаргасан захиргааны акт тодорхой хугацааны дараа хүчин төгөлдөр үйлчлэх баталгааг олгож хэвийн үйл ажиллагаа явуулах боломжоор хангах үүрэгтэй бөгөөд уг хугацааг хоёр дахин нэмэгдүүлэх нь иргэний эрх ашгийг хэт нэмэгдүүлж захиргааны эрх зүйн харилцааны хувьд тэгш бус байдлыг үүсгэх аюултай. Мөн “Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль”-д заасны дагуу заавал урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулсны дараа захиргааны хэргийн шүүхэд хандах эсхүл урьдчилан шийдвэрлэх ажиллагааны дагуу гаргасан захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргах боломжтой гэдгийг авч үзвэл нэгдүгээрт захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь

захиргааны акт гарсныг мэдсэнээс хойш 90 хоногийн дотор эсхүл захиргааны акт гарснаас хойш 180 хоногийн дотор гомдол гаргах боломжтой, хоёрдугаарт нэгэнт урьдчилан шийдвэрлэх ажиллагааны гомдол гаргасан бол уг ажиллагаа 60-аас 90 хоног явагдах бөгөөд урьдчилан шийдвэрлэх ажиллагааны дагуу гарсан шийдвэрт дахин 180 хоногийн нэхэмжлэл гаргах хугацааг олгох нь захиргааны акт гарснаас хойш бараг 1 жилээс дээш хугацааны туршид хууль зүйн маргаантай хэвээр байх асуудалтай. Ингэснээр тайланд хөгжингүй орнуудын нэхэмжлэл гаргах хугацаа нь ихэнхдээ 90 хоногоос бага байх ба БНСУ-ын хувьд жилд 38,000 гаруй захиргааны хэргийг хянан хэлэлцдэг гэдгийг авч үзвэл хуулийн төсөлд зааснаар нэхэмжлэл гаргах хугацааг нэмэгдүүлэх нь хууль зүйн тогтворгүй байдлыг үүсгэж болзошгүй тул ийнхүү нэмэгдүүлэх давуу болон сул талыг сайтаар судалж, гадаадын жишгийг харьцуулах шаардлагатай.

Хүснэгт– гадаад улсуудын нэхэмжлэл гаргах хугацаа

	ХБНГУ	Япон	Франц	Их Британи	Европын Холбоо
Нэхэмжлэл гаргах хугацаа	1 сар	6 сар	2 сар	3 сар	2 сар

4) Хэлэлцүүлэг ба үнэлэлт

Хам Жин Кюү болон Ү Юүн Кын гишүүний өргөн барьсан хуулийн төсөл нь нэхэмжлэл гаргах хугацааг нэмэгдүүлэх тухай адил агуулгатай байсан бөгөөд 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдөр өргөн барьж 6 дугаар сарын 15-ны өдөр танилцуулсан боловч Ерөнхий Ассамблейн 334 дүгээр ээлжит бус хуралдааны 1 дүгээр бүрэн хэлэлцүүлэгт ач холбогдолтой яригдаагүй юм.

3. 2015.2.13. Ү Юүн Кын гишүүний төлөөлөн өргөн барьсан хуулийн төсөл(нэхэмжлэл гаргах хугацааг сунгах тухай)

1) Өргөн барьсан шалтгаан ба үүний агуулга

Тус хуулийн төсөл нь хуульд зааснаар захиргааны хэргийг хянан хэлэлцэх шат болон шүүхийн харьяалал хоорондоо өөр байх тохиолдолд иргэд үүнийг сайн ялгах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэгдсэн байдлаар зохицуулах боломжгүй гэдэг асуудалтай

учраас “Захиргааны процессын хууль”-д шүүхийн харьяаллыг нэгтгэх шаардлагатай гэж үзэв. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зааснаар хүчингүй болгох нэхэмжлэл дундаас “захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл” гаргах шүүхийн харьяаллыг бусад төрлийн бүх нэхэмжлэлд төсөөтэй хэрэглэж байгаа бөгөөд өөр шинж чанартай нэхэмжлэлд нэг нэхэмжлэлийн шүүхийн харьяаллыг төсөөтэй хэрэглэх нь онолын хувьд буруу юм. Иймд ХБНГУ-ын нэгэн адил Захиргааны процессын хуулийн Ерөнхий ангид шүүхийн харьяаллын тухай зохицуулалтыг хуульчилж, Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл болон захиргааны байгууллагууд хоорондын эрх мэдлийг зааглан тодорхойлох нэхэмжлэлийн хувьд шүүхийн харьяаллын тусгай зохицуулалтыг шинээр нэмж, захиргааны хэргийн төрлөөс хамаарч өөр шүүхийн харьяалалтай байх зарчмыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль	Хуулийн төсөл
§8 (хууль үйлчлэх) ① Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх үед бусад хуульд өөрөө заагаагүй бол энэ хуулийг хэрэглэнэ.	① ----- Гэвч захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай энэ хуульд заасан асуудлын хувьд энэ хууль бусад хуулиас илүү хүчин чадалтайгаар хэрэглэнэ.
§9 (шүүхийн харьяалал) ① Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийн хувьд хариуцагчийн оршин байгаа газрын харьяалах захиргааны шүүхэд гаргана. ② 1 дэх заалтад заасан боловч дараах заалтад хамаарч байвал захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг Улсын дээд шүүхийн оршин байгаа газрын харьяалах захиргааны шүүхэд гаргана.	① Хүчингүй болгох нэхэмжлэлийн хувьд -----. ②----- хүчингүй болгох нэхэмжлэлийг -----.
§40 (шүүхийн харьяалал) 9 дүгээр зүйлийг Тэгшэрхбүхийоролцогчийннэхэмжлэл төсөөтэй хэрэглэнэ. Гэвч төр эсхүл нийтийн эрх зүйн байгууллага хариуцагч болох тохиолдолд холбогдох захиргааны байгууллагын оршин байгаа газрыг хариуцагчийн оршин байгаа газар гэж үзнэ.	§40 (шүүхийн харьяаллын тусгай заалт) Төр буюу нийтийн эрх зүйн байгууллага хариуцагч болох тохиолдолд холбогдох захиргааны байгууллагын оршин байгаа газрыг хариуцагчийн оршин байгаа газар гэж үзнэ.
	Нэмэлт §45.2 (шүүхийн харьяаллын тусгай заалт) Захиргааны байгууллагууд хоорондын эрх мэдлийг зааглан тодорхойлох нэхэмжлэлийн хувьд анхан шатны харьяалах шүүх нь хариуцагчийн оршин байгаа газрын харьяалах ахлах шүүх болно.

2) Тайлан

“Хууль батлах, эрх зүйн хороо”-ны гишүүний тайлан нь маш богино, энгийн байсан. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хүчингүй болгох нэхэмжлэл, Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл, нийтийн ашиг сонирхлын төлөө гаргасан нэхэмжлэл, захиргааны байгууллагууд хоорондын эрх мэдлийг зааглан тодорхойлох тухай нэхэмжлэл гэсэн дөрвөн нэхэмжлэлийн дагуу үүсгэдэг бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд заасны дагуу хүчингүй болгох нэхэмжлэл дундаас захиргааны актыг хүчингүй болгох тухай л шүүхийн харьяаллын талаар хуульчилж захиргааны актаас бусад төрлийн үйлдлийн хувьд бусад төрлийн нэхэмжлэлийн холбогдох зүйл, заалтыг төсөөтэй хэрэглэнэ. Хуулийн төсөл нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хэлбэрийг хэвээр хадгалахын зэрэгцээ зүйл заалтын байршлыг өөрчилж шинэлэх гэж байгаа тул үндэслэлтэй гэж дүгнэв.

3) Хэлэлцүүлэг ба үнэлэлт

Тус хуулийн төсөл нь холбогдох хороогоор “Бодлогын хороо” болон “Аюулгүй захиргааны хороо” байгаа боловч 2015 оны 7 дугаар сарын 22—ны өдөр дээрх хоёр хороодоос хуулийн төслийг авч хэлэлцсэн боловч хэлэлцүүлэг болон санал хураалтын тухай протокол үйлдээгүй. Мөн 12 дугаар сарын 30-ны өдөр Ерөнхий Ассамблейн ээлжит бус 338 дугаар хуралдаанаар “Хууль батлах, эрх зүйн хороо”-ны хурлын протоколд Захиргааны процессын хуулийн төслийг бүхэлд нь хэлэлцсэн гэж бичсэн байгаа боловч үнэндээ энэ тухай хэлэлцэж, Засгийн газраас саналаа илэрхийлээгүй юм.

4. 2015.10.30. Чон Жонг Бэ гишүүний өргөн барьсан хуулийн төсөл

1) Өргөн барьсан шалтгаан ба үүний агуулга

Уг хуулийн төсөлд зааснаар Ерөнхий Ассамблей нь дээд хэмжээний хуралдаан бөгөөд хууль батлах эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага болохын хувьд захиргааны байгууллагаас гаргах эрх зүйн хэм хэмжээг ардчиллын зарчмын дагуу хянах үүрэгтэй. Гэвч одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зааснаар хүчингүй болгох нэхэмжлэлийн дагуу үүсгэсэн захиргааны хэргийг Улсын дээд шүүхийн тогтоолоор захиргааны байгууллагын гаргасан тогтоол, шийдвэр нь Үндсэн хууль болон бусад ердийн хуульд

нийцэхгүй байгаа нь тогтоогдвол Захиргааны дотоод хэргийн яамны сайдад энэ тухай мэдэгддэг. Иймд захиргааны байгууллагын тогтоол, шийдвэрийг хянаж үзээд гаргасан шүүхийн шийдвэрийг Ерөнхий Ассамблейд хүргүүлж, хуулийн зорилгод нийцэхгүй захиргааны актыг Ерөнхий Ассамблейээс үр дүнтэй хянаж иргэдийн эрх ашгийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх боломжоор хангах нь ач холбогдолтой(Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг).

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль	Хуулийн төсөл
§6 (хэм хэмжээ тогтоосон акт, захиргааны акт хууль бус болохыг мэдэгдэх) ① Хүчингүй болгох нэхэмжлэлийн дагуу Улсын дээд шүүхийн тогтоолоор захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, захиргааны актыг Үндсэн хууль, бусад ердийн хуульд нийцэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд Улсын дээд шүүх цаг алдалгүй энэ тухай Захиргааны дотоод хэргийн яамны сайдад мэдэгдэнэ.	§6 (хэм хэмжээ тогтоосон акт, захиргааны акт хууль бус болохыг мэдэгдэх) ① ----- Ерөнхий Ассамблей болон 3 захиргааны дотоод хэргийн яамны сайдад -----.

2) Тайлан

“Хууль батлах, эрх зүйн хороо”-ны гишүүний тайланд захиргааны байгууллагаас хэм хэмжээ тогтоосон акт гаргах нь үндсэндээ Ерөнхий Ассамблейн Үндсэн хуулиар олгосон хууль тогтоох эрх мэдлийг захиргааны байгууллагад шилжүүлсэн гэж үзэх учраас Ерөнхий Ассамблейээс шилжүүлсэн эрх мэдлийн хүрээнд захиргааны байгууллага хэм хэмжээ тогтоож байгаа эсэхийг шалгаж хянах механизмыг эрэлхийлэх нь зүйтэй гэж үзэв. Иймд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Ерөнхий Ассамблейн тухай хууль”-ийн 98 дугаар зүйлийн 98.2.1 дэх заалтад зааснаар төв захиргааны байгууллагын дарга нь Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаал болон дүрэм, журам зэргийн захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг батлах буюу нэмэлт өөрчлөлт оруулснаас 10 хоногийн дотор үүнийг Ерөнхий Ассамблейд хүргүүлж, мөн зүйлийн 3 дахь заалтад зааснаар Байнгын хорооноос тухайн төв захиргааны байгууллагаас баталсан Ерөнхийлөгчийн зарлигийг хянаж хуулийн зорилго, агуулгад нийцэхгүй гэж дүгнэвэл тухайн төв захиргааны байгууллагын даргад мэдэгдэж Ерөнхий Ассамблейн хяналтыг нэмэгдүүлдэг гэдгийг онцлов. Тайланд хуулийн төсөлд заасанчлан Улсын дээд шүүхийн тогтоолоор захиргааны

хэм хэмжээ тогтоосон акт Үндсэн хууль болон бусад ердийн хуульд нийцэхгүй байгаа нь тогтоогдвол үүнийг Ерөнхий Ассамблейд мэдэгдэх нь ийнхүү мэдэгдэж байгаагаараа хяналт тавьж байгаатай адил бөгөөд захиргааны хэм хэмжээ тогтооход эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлэх төдийгүй “Ерөнхий Ассамблейн тухай хууль”-ийн 98 дугаар зүйлийн 98.2.3 дахь заалтад заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хянахад шаардлагатай мэдээллийг цуглуулахад ч нэмэртэй учир хуулийн төсөл үндэслэлтэй гэж үзсэн.

3) Хэлэлцүүлэг ба үнэлэлт

“Хууль батлах, эрх зүйн хороо”-нд 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн барьсан боловч Ерөнхий Ассамблейн ээлжит бус 338 дугаар хуралдааны “Хууль батлах, эрх зүйн хороо”-ны хурлын протоколд Захиргааны процессын хуулийн төслийг бүхэлд нь хэлэлцсэн гэж бичсэн байгаа боловч үнэндээ энэ тухай хэлэлцэж, Засгийн газраас саналаа илэрхийлээгүй юм.

III. ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Захиргааны процессын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах оролдлого нь 2004, 2007, 2011 онд гурван удаа болсон боловч бүгд хэрэгжиж чадсангүй. 2012 оноос өмнө болсон хэлэлцүүлэг нь 2011 оны Захиргааны эрх зүйн салбар, Улсын дээд шүүх, Хууль зүйн яамнаас тус бүр судалгааны багийг байгуулж, өмнө яригдаж байсан асуудал ба гадаад улсын туршлагыг судалсан бөгөөд үүний дагуу Улсын дээд шүүх, Хууль зүйн яам, Эрх чөлөө, хөгжлийн улс төрийн намын Пак Сон Ён гишүүний төслийг тус тус боловсруулсан. Энэ дундаас Пак Сон Ён гишүүний боловсруулсан хуулийн төслийг л танилцуулсан бөгөөд Хууль зүйн яамны боловсруулсан хуулийн төслийг 2011 оны 4 дүүгээр сарын 7-ны өдрөөс мөн оны 4 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл батлах тухай яригдаж байсан боловч Ерөнхий Ассамблейд өргөн бариагүй билээ. Хамгийн сүүлийн 2011 он, 2012 оны хуулийн төслүүдийг доор авч үзье.

1. Эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх шинж бүхий нэхэмжлэл

1) 2012 оноос өмнөх ярилцлагууд

Улсын дээд шүүхийн хуулийн төсөл	Хууль зүйн яамны хуулийн төсөл	Пак Сон Ён гишүүний хуулийн төсөл
<p>§4(Хүчингүй болгох нэхэмжлэл) Хүчингүй болгох нэхэмжлэл нь дараах төрлүүдтэй байна.</p> <p>4. Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл : Захирааны байгууллагаас <u>ирээдүйд тодорхой акт буюу шийдвэр гаргах нь дөхөж байгаа тохиолдолд</u> тухайн акт буюу шийдвэр гаргахыг хориглох нэхэмжлэл</p>	<p>§4(Хүчингүй болгох нэхэмжлэл) Хүчингүй болгох нэхэмжлэлийг дараах байдлаар ангилна.</p> <p>4. Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл : Захирааны байгууллагаас <u>ирээдүйд хууль бус</u> захиргааны акт гаргах нь дөхөж байгаа тохиолдолд тухайн акт гаргахыг хориглох нэхэмжлэл</p>	<p>§4(Хүчингүй болгох нэхэмжлэл) Хүчингүй болгох нэхэмжлэлийг дараах байдлаар ангилна.</p> <p>4. Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл : Захирааны байгууллагаас <u>ирээдүйд тодорхой акт буюу шийдвэр гаргах нь дөхөж байгаа</u> тохиолдолд тухайн акт буюу шийдвэр гаргахыг хориглох нэхэмжлэл</p>
<p>3 дугаар бүлэг Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл</p> <p>§55(Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд) Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл нь Захирааны байгууллагаас <u>ирээдүйд тодорхой захиргааны акт буюу шийдвэр гаргах нь дөхөж байгаа тохиолдолд</u> тухайн захиргааны акт буюу шийдвэр зэргийг гаргахыг хориглосноор хууль ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдирээдүйд үүний хүчинтэй эсэх талаар маргах аргар өөрийн эрх ашгийг сэргээх боломжгүй хэмжээгээр хохирох аюултай байвал нэхэмжлэл гаргана.</p>	<p>3 дугаар бүлэг Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл</p> <p>§55 (Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд) Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл нь Захирааны байгууллагаас <u>ирээдүйд тодорхой акт буюу шийдвэр гаргах нь дөхөж байгаа</u> тохиолдолд тухайн захиргааны актыг гаргахыг хориглосноор хууль ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдирээдүйд үүний хүчинтэй эсэх талаар маргах аргар өөрийн эрх ашгийг сэргээх боломжгүй хэмжээгээр ноцтой хохирох тодорхой болсон тохиолдолд л нэхэмжлэл гаргана.</p>	<p>3 дугаар бүлэг Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл</p> <p>§55 (Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд) Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл нь <u>Захирааны байгууллагаас ирээдүйд тодорхой акт буюу бусад үйлдэл</u> хийх нь дөхөж байгаа тохиолдолд тухайн захиргааны актыг гаргахыг хориглосноор хууль ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдирээдүйд үүний хүчинтэй эсэх талаар маргах аргар өөрийн эрх ашгийг сэргээх боломжгүй хэмжээгээр хохирох аюултай байвал нэхэмжлэл гаргана.</p>
<p>§56 (Нэхэмжлэлийг өөрчлөх) 22 дугаар зүйлийн зохицуулалтыг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлээс</p>	<p>§55 (Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд)</p>	<p>§56 (Нэхэмжлэлийг өөрчлөх) 22 дугаар зүйлийн зохицуулалтыг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлээс</p>

<p>Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл , иргэний эрх зүйн нэхэмжлэл болгон эсхүл эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлээс бусад х үчингүй болгох нэхэмжлэл болгон, иргэний эрх зүйн нэхэмжлэлийг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл болгон өөрчлөхөд төсөөтэй хэрэглэнэ.</p>		<p>Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл , иргэний эрх зүйн нэхэмжлэл болгон эсхүл эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлээс бусад х үчингүй болгох нэхэмжлэл болгон, иргэний эрх зүйн нэхэмжлэлийг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл болгон өөрчлөхөд төсөөтэй хэрэглэнэ.</p>
<p>§57 (Хориглох нэхэмжлэл) Шүүх нь захиргааны байгууллагаас ирээдүйд захиргааны акт буюу шийдвэр зэрэг хууль бус бөгөөд үүнийг гаргахыг хориглох нь үндэслэлтэй гэж үзвэл захиргааны байгууллагад тухайн захиргааны акт буюу шийдвэрийг гаргахгүй байх талаар шүүхийн шийдвэр гаргаж болно.</p>	<p>§49 (Хориглох нэхэмжлэл) Шүүх нь захиргааны байгууллагаас ирээдүйд гаргах тодорхой захиргааны акт хууль бус бөгөөд үүнийг гаргахыг хориглох нь үндэслэлтэй гэж үзвэл захиргааны байгууллагад тухайн захиргааны акт гаргахгүй байх талаар шүүхийн шийдвэр гаргаж болно.</p>	<p>§57 (Хориглох нэхэмжлэл) Шүүх нь захиргааны байгууллагаас ирээдүйд захиргааны акт буюу шийдвэр зэрэг хууль бус бөгөөд үүнийг гаргахыг хориглох нь үндэслэлтэй гэж үзвэл захиргааны байгууллагад тухайн захиргааны акт буюу шийдвэрийг гаргахгүй байх талаар шүүхийн шийдвэр гаргаж болно.</p>
<p>§58 (Төсөөтэй хэрэглэх) 8-10 дугаар зүйл, 13-19 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, 26-29 дүгээр зүйл, 33 дугаар зүйл, 35 дугаар зүйл, 36 дугаар зүйл, 39 дүгээр зүйл, 41 дүгээр зүйл, 43 дугаар зүйл, 52 дугаар зүйл, 53 дугаар зүйлийг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхийнэхэмжлэлийн хувьд төсөөтэй хэрэглэнэ.</p>	<p>§50 (Төсөөтэй хэрэглэх) Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхийнэхэмжлэлийн хувьд 8-10 дугаар зүйл, 13-19 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, 26-29 дүгээр зүйл, 33 дугаар зүйл, 34дугаар зүйлийн 34.1 дэх хэсэг, 35 дугаар зүйл, 37 дугаар зүйлийг төсөөтэй хэрэглэнэ. Гэвч 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн 38 дугаар зүйлд хамаарах хэсгийг төсөөтэй хэрэглэхгүй.</p>	<p>§58 (Төсөөтэй хэрэглэх) 8-10 дугаар зүйл, 13-19 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, 26-29 дүгээр зүйл, 33 дугаар зүйл, 35 дугаар зүйл, 36 дугаар зүйл, 39 дүгээр зүйл, 41 дүгээр зүйл, 43 дугаар зүйл, 52 дугаар зүйл, 53 дугаар зүйлийг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхийнэхэмжлэлийн хувьд төсөөтэй хэрэглэнэ.</p>

2) 2013 оны хуулийн төслүүд

Одоогийн хүчин төгөлдөр Захиргааны процессын хууль	2012 оны хуулийн төсөл
Нэмэлт	§4 (Хүчингүй болгох нэхэмжлэл) Хүчингүй болгох нэхэмжлэлийг дараах байдлаар ангилна. 4. Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл : Захиргааны байгууллагаас ирээдүйд хууль бус захиргааны акт гаргах нь дөхөж байгаа тохиолдолд тухайн акт гаргахыг хориглох нэхэмжлэл
Нэмэлт	§51 (Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд) Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл нь захиргааны байгууллагаас ирээдүйд хууль бус захиргааны акт гаргах нь дөхөж байгаа тохиолдолд тухайн захиргааны актыг гаргахыг хориглосноор хууль ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд ирээдүйд үүний хүчинтэй эсэх талаар маргах аргаар өөрийн эрх ашгийг сэргээх боломжгүй хэмжээгээр ноцтой хохирох тодорхой болсон тохиолдолд л нэхэмжлэл гаргана.
Нэмэлт	§52 (Нэхэмжлэлийг өөрчлөх) Эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлээс Тэгш эрх бүхий орлоцогчийн нэхэмжлэл , иргэний эрх зүйн нэхэмжлэл болгон эсхүл эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлээс бусад хүчингүй болгох нэхэмжлэл болгон, иргэний эрх зүйн нэхэмжлэлийг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэл болгон өөрчлөхөд 22 дугаар зүйлийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэнэ.
Нэмэлт	§53 (Хориглох нэхэмжлэл) Шүүх нь захиргааны байгууллагаас ирээдүйд захиргааны акт буюу шийдвэр зэрэг хууль бус бөгөөд үүнийг гаргахыг хориглох нь үндэслэлтэй гэж үзвэл захиргааны байгууллагад тухайн захиргааны акт гаргахгүй байх талаар шүүхийн шийдвэр гаргаж болно.
Нэмэлт	§54 (Төсөөтэй хэрэглэх) 8-10 дугаар зүйл, 13-19 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, 26-29 дүгээр зүйл, 33 дугаар зүйл, 34 дугаар зүйлийн 34.1 дэх хэсэг, 35-38 дугаар зүйлийг эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлийн хувьд төсөөтэй хэрэглэнэ.

3) Үнэлэлт

Улсын дээд шүүх, Хууль зүйн яам, Пак Сон Ён гишүүний 2012 оны хуулийн төслүүд дундаас Хууль зүйн яамны хуулийн төсөл нь эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлийн объектыг зөвхөн захиргааны акт гэж заасан бөгөөд эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлийн хэлбэрийн

шаардлагыг хатуу хязгаарлах хандлагатай. Иймд захиргааны эрх зүйн салбарын эрдэмтэд Улсын дээд шүүх, Пак Сон Ён гишүүний хуулийн төсөлд заасанчлан захиргааны актаас гадна бодит үйлдэл зэргийн захиргааны үйлдлийг ч гэсэн эрх ашиг нь зөрчигдөхөөс урьдчилан шийдвэрлэх шинж бүхий нэхэмжлэлийн объект болгож үүний хүрээг тэлсэн. Гэвч бодит байдал 2011 он, 2012 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах оролдлого нь бүтэлгүйтсэн бөгөөд үүний шалтгаан нь дээрх нэхэмжлэлийг зөвшөөрвөл захиргааны байгууллагаас хэвийн үйл ажиллагаа явуулахад саад болох магадлалтай гэдэгт байсан. Иймд 2013 оны хуулийн төслүүд нь 2011 оны Хууль зүйн яамны хуулийн төслийг бага зэрэг засаж нэхэмжлэлийг өөрчлөх тухай зохицуулалтыг оруулах төвшинд тусгасан болно. Захиргааны эрх зүйн салбарт дээрх дөрвөн хуулийн төсөл дундаас Улсын дээд шүүхийн хуулийн төсөлд багагүй ач холбогдол өгсөн.

2. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл*1)

1) 2012 оноос өмнөх хуулийн төслүүдийн харьцуулалт

Улсын дээд шүүхийн хуулийн төсөл	Хууль зүйн яамны хуулийн төсөл	Пак Сон Ён гишүүний хуулийн төсөл
<p>§3 (Захиргааны эрх зүйн нэхэмжлэлийн төрөл) Захиргааны эрх зүйн нэхэмжлэл нь дараах төрлүүдтэй байна.</p> <p>2. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл : Захиргааны хувьд хохирлын нөхөн олговор, захиргааны акт зэрэг хууль бус байдлаас шалтгаалсан хохирол барагдуулах, үндэслэлгүй хөрөнгөжих, бусад нийтийн эрх зүйн харилцаатай холбогдуулан гаргах нэхэмжлэлийг ойлгох бөгөөд тухайн эрх зүйн харилцааны нэг талыг хариуцагчаар татна.</p>	<p>§3 (Захиргааны эрх зүйн нэхэмжлэлийн төрөл) Захиргааны эрх зүйн нэхэмжлэлийг дараах дөрвөн төрлөөр ангилна.</p> <p>2. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл : Захиргааны хувьд хохирлын нөхөн олговор, захиргааны акт зэрэг хууль бус байдлаас шалтгаалсан хохирол барагдуулах, үндэслэлгүй хөрөнгөжих, бусад нийтийн эрх зүйн харилцаатай холбогдуулан гаргах нэхэмжлэлийг ойлгох бөгөөд тухайн эрх зүйн харилцааны нэг талыг хариуцагчаар татна.</p>	<p>§3 (Захиргааны эрх зүйн нэхэмжлэлийн төрөл) Захиргааны эрх зүйн нэхэмжлэлийг дараах дөрвөн төрлөөр ангилна.</p> <p>2. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл : Оролцогч хооронд эрх зүйн харилцаа үүсгэх буюу үүссэнийг тогтоосон захиргааны акт эсэхүл урьдчилан шийдвэрлэх журмаар гаргасан шийдвэрт холбогдуулан гаргах нэхэмжлэлийг ойлгох бөгөөд хуульд заасны дагуу тухайн эрх зүйн харилцааны оролцогчийн нэг талыг хариуцагчаар татсан нэхэмжлэл эсхүл нийтийн эрх зүйн</p>

1) 당사자소송(Party litigation) : Захиргааны акт буюу шийдвэрээс бусад захиргааны үйлдэлд холбогдуулан гаргах нэхэмжлэлийг хэлэх бөгөөд захиргааны байгууллага болон иргэн хооронд тэгш эрхийн зарчимд үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. (Орчуулагч*)

		н харилцааг тогтоох нэхэмжлэл, бусад нийтийн эрх зүйн харилцаатай холбоотой нэхэмжлэл үүнд хамаарна.
--	--	--

2) 2013 оны хуулийн төсөл

Одоогийн хүчин төгөлдөр Захиргааны процессын хууль	2013 оны хуулийн төсөл
<p>§3 (Захиргааны эрх зүйн нэхэмжлэлийн төрөл) Захиргааны эрх зүйн нэхэмжлэл нь дар аах төрлүүдтэй байна.</p> <p>2. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл : Захиргааны хувьд хохирлын нөхөн олговор, захиргааны акт зэрэг хууль бус байдлаас шалтгаалсан хохирол барагдуулах, үндэслэлгүй хөрөнгөжих, бусад нийтийн эрх зүйн харилцаатай холбогдуулан гаргах нэхэмжлэлийг ойлгох бөгөөд тухайн эрх зүйн харилцааны нэг талыг хариуцагчаар татна.</p>	<p>§3 (Захиргааны эрх зүйн нэхэмжлэлийн төрөл) Захиргааны эрх зүйн нэхэмжлэл нь дар аах төрлүүдтэй байна.</p> <p>2. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл : Захиргааны акт зэргээс үүссэн эрх зүйн харилцаатай холбоотой нэхэмжлэл, бусад нийтийн эрх зүйн харилцаанд холбоотой нэхэмжлэл бөгөөд тухайн эрх зүйн харилцааны нэг талыг хариуц агтаар татсан дараах заалтад хамаарах нэхэмжлэлийг ойлгоно.</p> <p>А. Нийтийн эрх зүйн хувьд нийгмийн байдал, зэрэглэл гэх мэт тухайн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох нэхэмжлэл</p> <p>Б. Захиргааны эрх зүйн хохирол нөхөн төлөх нэхэмжлэл (Гэвч автомашины хохирол нөхөн төлөх хуулийн үйлчлэлд байгаа зүйл хамаарахгүй.)</p> <p>В. Захиргааны эрх зүйн хохирол нөхөн төлөх, үндэслэлгүй хөрөнгөжсөн зүйлээ буцаах, нөхөн сэргээх зэргийн нэхэмжлэл</p> <p>Г. Захиргааны эрх зүйн бусад үүрэг гүйцэтгүүлэхийг шаардах нэхэмжлэл</p>

3) Үнэлэлт

Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл нь Захиргааны процессын хуульд хуульчилсан боловч практикт бараг хэрэглэдэггүй бөгөөд нийтийн эрх зүйн тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэлээр үүсгэх хэргийг оронд нь иргэний эрх зүйн хэргээр хянан шийдвэрлэдэг байсан. Захиргааны эрх зүйн салбарын судлаачид нь иргэний эрх зүйн нэхэмжлэлээр үүсгэж байсан төрийн нөхөн олговортой холбоотой хэргийг нийтийн эрх зүйн тэгш эрх бүхий

оролцогчийн нэхэмжлэлээр үүсгэж хянан шийдвэрлэх ёстой хэмээн саналаар илэрхийлж байсан бөгөөд шүүхийн жишигт ч үүнийг тусгаж нийтийн эрх зүйн нэхэмжлэлээр хэрэг хянан шийдвэрлэх хандлагатай болов. Нийтийн эрх зүйн тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрчимжүүлэх оролдлого нь төрийн эрх мэдэлтэй холбоотойгоор хөгжиж ирсэн захиргааны эрх зүйн онолыг төрөл бүрийн захиргааны эрх зүйн харилцаагаар хүрээг нь тэлэх зорилготой бөгөөд орчин үеийн захиргааны олон талт үйл ажиллагааг багтааж нийтийн эрх зүйн тогтолцоонд төрийн буюу нийтийн эрх ашгийг хамгаалахад иргэний эрх зүйн нэхэмжлэлээс илүүтэйгээр захиргааны эрх зүйн харилцаа илүү тохиромжтой гэдэгт оршиж байна. Тухайлбал татвар ногдуулсан захиргааны актын дагуу төлсөн татварыг буцаан авах талаар иргэний эрх зүй дэх үндэслэлгүй хөрөнгөжих тухай хэргээр биш захиргааны эрх зүйн тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэлээр үүсгэсэн хэргээр хянан шийдвэрлэх нь зүйтэй. Энэ нь нийтийн эрх зүйн тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэлийг эрчимжүүлснээр нийтийн эрх зүйн тогтолцоонд хувийн эрх зүйн онол нэвтрэн орох ба хувийн эрх ашгаас үүсэх үр дагаврыг багасгах захиргааны эрх зүйн салбарын зүтгэл юм. Иймд 2013 оны хуулийн төсөл нь дээрх дурдсан зүйлсийг шүүхийн жишигт тусгаж, нийтийн эрх зүйн тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэх боломжийг олгохоор Захиргааны процессын хуульд тухайн төрлийн нэхэмжлэлийг хуульчилсан бөгөөд захиргааны эрх зүйн салбарын эрдэмтэд, судлаачдын дэмжлэгийг хамгийн их авсан хуулийн төсөл юм.

3. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тогтолцоо

1) 2012 оноос өмнөх хуулийн төслүүд

Улсын дээд шүүхийн хуулийн төсөл	Хууль зүйн яамны хуулийн төсөл	Пак Сон Ён гишүүний хуулийн төсөл
§24 (Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх) ① Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл нь үүний хүчинтэй байдал ба үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелүүлэх зэрэгт нөлөөлөхгүй. ② Захиргааны актыг хүчингү	§24 (Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх) ① Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл нь үүний хүчинтэй байдал ба үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелүүлэх зэрэгт нөлөөлөхгүй. ② Захиргааны актыг хүчингү	§24 (Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх) ① Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл нь үүний хүчинтэй байдал ба үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелүүлэх зэрэгт нөлөөлөхгүй. ② Захиргааны актыг хүчингү

<p>й болгох нэхэмжлэлийг гаргасан тохиолдолд тухайн захиргааны акт <u>хууль бус гэж үзэж байгаа</u> эсхүл захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтээр <u>нөхөн сэргээх боломжгүй хэмжээнд хохироход</u> урьдчилан сэргийлэх шаардлагатай гэж үзвэл шүүх өөрийн бүрэн эрхээр буюу орлоцогчийн хүсэлтээр шүүгчийн захирамж гарган захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түдгэлзүүлэх (цаашид “биелэлтийг түдгэлзүүлэх” гэх) болно. Гэвч, тухайн актын биелэлт буюу процессын хувьд шуурхай биелэлтийг түдгэлзүүлснээр захиргааны актын хүчинтэй байдлыг зогсоохоор байвал үүнийг түдгэлзүүлэхийг хориглоно.</p> <p>③ Шүүх 2 дахь хэсгийн зохицуулалтаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эер шийдвэрлэх үед төр, нийтийн эрх зүйн байгууллага буюу захиргааны акт нөгөө талд хохирол учруулж магадлалтай тохиолдолд тухайн этгээдэд хохиролд холбогдуулан барьцаа гаргаж болно.</p> <p>④ Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд ноцтой нөлөөлөхөөр байвал үүнийг хориглоно.</p> <p>⑤ 2 дахь хэсгийн зохицуулалтын хувьд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргахад үүний шаардлаганыг тодорхой дурдана.</p> <p>⑥ 2 дахь хэсгийн зохицуула</p>	<p>й болгох нэхэмжлэлийг гаргасан тохиолдолд захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтээр <u>ноцтой хохирлоос урьдчилан сэргийлэхийн тулд яаралтай арга хэмжээ шаардлагатай</u> гэж үзвэл шүүх өөрийн бүрэн эрхээр буюу орлоцогчийн хүсэлтээр шүүгчийн захирамж гарган захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түдгэлзүүлэх (цаашид “биелэлтийг түдгэлзүүлэх” гэх) болно. Гэвч, тухайн актын биелэлт буюу процессын хувьд шуурхай биелэлтийг түдгэлзүүлснээр захиргааны актын хүчинтэй байдлыг зогсоохоор байвал үүнийг түдгэлзүүлэхийг хориглоно.</p> <p>③ Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд ноцтой нөлөөлөхөөр байгаа эсхүл орлоцогчийн хүсэлт нь үндэслэлгүй байгаа нь тодорхой байвал үүнийг хориглоно.</p> <p>④ 2 дахь хэсгийн зохицуулалтын хувьд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргахад үүний шаардлаганыг тодорхой дурдана.</p> <p>⑤ 2 дахь хэсгийн зохицуулалтын дагуу гаргасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж хүсэлтийг хангасан эсхүл хүсэлтийг хангахгүй буцаах шийдвэрт шууд давж заалдаж болно. Энэ тохиолдолд шууд давж заалдсанаар тухайн шийдвэрийн хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.</p> <p>⑥ 2 дахь хэсгийн зохицуула</p>	<p>й болгох нэхэмжлэлийг гаргасан тохиолдолд захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтээр <u>ноцтой хохирлоос урьдчилан сэргийлэхийн тулд яаралтай арга хэмжээ шаардлагатай</u> гэж үзвэл шүүх өөрийн бүрэн эрхээр буюу орлоцогчийн хүсэлтээр шүүгчийн захирамж гарган захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түдгэлзүүлэх (цаашид “биелэлтийг түдгэлзүүлэх” гэх) болно. Гэвч, тухайн актын биелэлт буюу процессын хувьд шуурхай биелэлтийг түдгэлзүүлснээр захиргааны актын хүчинтэй байдлыг зогсоохоор байвал үүнийг түдгэлзүүлэхийг хориглоно.</p> <p>③ 2 дахь хэсгийн зохицуулалтаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэрийн гаргасан шүүх нь төр, нийтийн эрх зүйн байгууллага буюу захиргааны акт нөгөө талд хохирол учруулж магадлалтай тохиолдолд хохирол магадлалтай этгээдэд тухайн хохиролд холбогдуулан барьцаа гаргаж болно. Энэ тохиолдолд тухайн этгээд нь барьцааны эрх бүхий этгээдтэй нэгэн адил шаардах эрхтэй байна.</p> <p>④ Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд ноцтой нөлөөлөхөөр байвал үүнийг хориглоно.</p> <p>⑤ 2 дахь хэсгийн зохицуулалтын хувьд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх х</p>
---	---	--

<p>лтын дагуу захиргааны акты н биелэлтийг түдгэлзүүлсэн шийдвэрт шууд давж заалд аж болно. Энэ тохиолдолд тухайн шийдвэрийн хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.</p> <p>⑦ 33 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг нь дээрх 2 дахь хэсгийн дагуу захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд төсөөтэй хэрэглэнэ.</p>	<p>лтын дагуу гаргасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж хүсэлтийг хангасан шийдвэрт 33 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг төсөөтэй хэрэглэнэ.</p>	<p>үсэлтийг гаргахад үүний шалтгааныг тодорхой дурдана.</p> <p>⑥ 2 дахь хэсгийн зохицуулагын дагуу захиргааны акты н биелэлтийг түдгэлзүүлсэн шийдвэрт шууд давж заалд аж болно. Энэ тохиолдолд тухайн шийдвэрийн хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.</p> <p>⑦ 33 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг нь дээрх 2 дахь хэсгийн дагуу захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд төсөөтэй хэрэглэнэ.</p>
---	---	--

2) 2013 оны хуулийн төсөл

Одоогийн хүчин төгөлдөр Захиргааны процессын хууль	2013 оны хуулийн төсөл
<p>§23 (Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх) ① Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг гаргах нь захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтэд нөлөөлөхгүй.</p> <p>② Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг гаргасан тохиолдолд захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтээр шалтгаалж үүсэх нөхөн сэргээх боломжгүй ноцтой хохирлоос урьдчилан сэргийлэхийн тулд яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл шүүх өөрийн бүрэн эрхээр буюу оролцогчийн хүсэлтээр шүүгчийн захирамж гарган захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түдгэлзүүлэх (цаашид “биелэлтийг түдгэлзүүлэх” гэх) болно. Гэвч, тухайн актын биелэлт буюу процессын хувьд шуурхай биелэлтийг түдгэлзүүлснээр захиргааны актын хүчинтэй байдлыг зогсоохоор байвал үүнийг түдгэлзүүлэхийг хориглоно.</p> <p>③ Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд ноцтой нөлөөлөхөөр байвал үүнийг хориглоно.</p>	<p>§24 (Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх) ① Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл нь үүний хүчинтэй байдал ба үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелүүлэх зэрэгт нөлөөлөхгүй.</p> <p>② Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг гаргасан тохиолдолд захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтээр ноцтой хохирлоос урьдчилан сэргийлэхийн тулд яаралтай арга хэмжээ шаардлагатай гэж үзвэл шүүх өөрийн бүрэн эрхээр буюу оролцогчийн хүсэлтээр шүүгчийн захирамж гарган захиргааны акт буюу үүний биелэлт, процессын хувьд шуурхай биелэлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түдгэлзүүлэх (цаашид “биелэлтийг түдгэлзүүлэх” гэх) болно. Гэвч, тухайн актын биелэлт буюу процессын хувьд шуурхай биелэлтийг түдгэлзүүлснээр захиргааны актын хүчинтэй байдлыг зогсоохоор байвал үүнийг түдгэлзүүлэхийг хориглоно.</p> <p>③ Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд ноцтой нөлөөлөхөөр байгаа эсхүл оролцогчийн хүсэлт нь үндэслэлгүй байгаа нь тодорхой байвал</p>

<p>④2 дахь хэсгийн зохицуулалтын хувьд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргахад үүний шалтгааныг тодорхой дурдана.</p> <p>⑤ 2 дахь хэсгийн зохицуулалтын дагуу захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шийдвэрт шууд давж заалдаж болно. Энэ тохиолдолд тухайн шийдвэрийн хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.</p> <p>⑥ 33 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг нь дээрх 2 дахь хэсгийн дагуу захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд төсөөтэй хэрэглэнэ.</p>	<p>үүнийг хориглоно.</p> <p>④ 2 дахь хэсгийн зохицуулалтын хувьд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргахад үүний шалтгааныг тодорхой дурдана.</p> <p>⑤ 2 дахь хэсгийн зохицуулалтын дагуу гаргасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж хүсэлтийг хангасан эсхүл хүсэлтийг хангахгүй буцаах шийдвэрт шууд давж заалдаж болно. Энэ тохиолдолд шууд давж заалдсанаар тухайн шийдвэрийн хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.</p> <p>⑥2 дахь хэсгийн зохицуулалтын дагуу гаргасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж хүсэлтийг хангасан шийдвэрт 33 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг төсөөтэй хэрэглэнэ.</p>
---	--

3) Үнэлэлт

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль нь зарчмын хувьд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргасан ч тухайн захиргааны актын болон үүний биелэлтэд нөлөөлдөггүй бөгөөд захиргааны эрх зүйн сурах бичигт захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх урьдчилсан нөхцөлүүд дундаас “нөхөн сэргээх боломжгүй хэмжээнд хохирох” гэдгийг Улсын дээд шүүхийн шийдвэрийн жишигт үндэслэн, эдийн засгийн хохирол нь нөхөн сэргээх боломжгүй хэмжээнд хамаарахгүй гэж тайлбарласан. Гэвч захиргааны хэргийг хянан шийдвэрлэдэг анхан шатны шүүх нь нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэх хандлагатай хэргийн хувьд дээрх урьдчилсан нөхцөлд тавих шаардлагыг багасгаж захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг хангаж шийдвэрлэх тохиолдол цөөнгүй. Захиргааны акт алдаатай байсан ч тухайн захиргааны актын хүчинтэй байдалд нөлөөлдөггүй учраас захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтээр үүний үйлчлэлийг зогсоох ёстой гэж үздэг эрдэмтэд харьцангуй бага бөгөөд захиргааны акт алдаатай байсан ч тухайн захиргааны актын хүчинтэй байдалд нөлөөлөхгүй байх зарчим захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийн хороонд дахь харилцаа нь хууль тогтоох байгууллагын эрх хэмжээний асуудал юм. 2013 оны хуулийн төсөл нь 2011 оны Хууль зүйн яамны хуулийн төсөл болон 2011 оны Улсын дээд шүүхийн хуулийн төслийн

барьцааны эрхтэй холбоотой хэсгийг тусгасан болно. Харин 2011 оны хуулийн төслүүд дундаас Хууль зүйн яамны хуулийн төсөл нь хамгийн консерватив хандлагатай байсан бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж баагаа хуулиас ч хуучинсаг зохицуулалтыг агуулсан гэдэг шүүмжлэлийг авсан. Барьцааны эрхийн тухай зохицуулалт нь Улсын дээд шүүхийн хуулийн төсөл одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тогтолцоог нөхөх зорилготой байсан. Практикт захиргааны акт гуравдагч этгээдэд нөлөөлөхөөр байвал захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа ч хэрвээ үүнийг хүлээн зөвшөөрвөл нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчилдөөн бүхий маргаанаас хувийн ашиг сонирхлуудын зөрчил бүхий маргаан болж хувирах магадлалтай. Гэвч захиргааны эрх зүйн салбарын эрдэмтэд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тогтолцоог Улсын дээд шүүхийн хуулийн төсөлд заасан шиг зөөлрүүлэх эсхүл ХБНГУ шиг захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргасан ч тухайн захиргааны актын болон үүний биелэлтэд нөлөөлөхгүй байх зарчмыг тусгая гэдэг байр суурьд бат зогсож байгаа.

4. Шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах

1) 2012 оноос өмнөх хуулийн төслүүдийн харьцуулалт

Улсын дээд шүүхийн хуулийн төсөл	Хууль зүйн яамны хуулийн төсөл	Пак Сон Ён гишүүний хуулийн төсөл
<p>§26 (Шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах) ① Захиргааны акт зэрэг хууль бус гэж үзэх зохих үндэслэлтэй байвал дараах хэсгийн 1-т хамаарах тохиолдолд тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх нь орлоцогчийн хүсэлтээр шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж болно.</p> <p>1. Маргааны зүйлийн байдал өөрчлөгдсөнөөр оролцогч өөрийн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй буюу хэрэгжүүлэхэд хэцүү болохоор байгаа уч</p>	<p>§26 (Шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах) ① Захиргааны акт зэрэг хууль бус гэж үзэх зохих үндэслэлтэй байвал дараах хэсгийн 1-т хамаарах тохиолдолд тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх нь орлоцогчийн хүсэлтээр шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж болно.</p> <p>1. Маргааны зүйлийн байдал өөрчлөгдсөнөөр оролцогч өөрийн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй буюу хэрэгжүүлэхэд хэцүү болохоор байгаа учраас маргааны зүйлийн хэв</p>	<p>§26 (Шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах) ① Захиргааны акт зэрэг хууль бус гэж үзэх зохих үндэслэлтэй байвал дараах хэсгийн 1-т хамаарах тохиолдолд тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх нь орлоцогчийн хүсэлтээр шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж болно.</p> <p>1. Маргааны зүйлийн байдал өөрчлөгдсөнөөр оролцогч өөрийн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй буюу хэрэгжүүлэхэд хэцүү болохоор байгаа учраас маргааны зүйлийн хэв</p>

<p>раас маргааны зүйлийн хэв ийн байдлыг хадгалах шаардлагатай тохиолдол</p> <p>2. Маргаан бүхий эрх зүйн харилцаанд оролцогчид тохиолдох гэнэтийн хохирол буюу аюулаас хамгаалах эсхүл түүнд түр зуур статус тогтоох шаардлагатай тохиолдол</p> <p>② 1 дэх хэсгийн зохицуулалтын дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад 24 дугаар зүйлийн 24.3-6 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 52 дугаар зүйл, 53 дугаар зүйлийг төсөөтэй хэрэглэнэ.</p> <p>③1 дэх хэсгийн зохицуулалт нь 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх үр дагавартай байвал үүнийг хэрэглэхийг хориглоно.</p>	<p>ийн байдлыг яаралтай хадгалах шаардлагатай тохиолдол</p> <p>2. Маргаан бүхий эрх зүйн харилцаанд оролцогчид тохиолдох гэнэтийн хохирол буюу аюулаас хамгаалах эсхүл түүнд түр зуур статус тогтоох шаардлагатай тохиолдол</p> <p>② 1 дэх хэсгийн зохицуулалтын дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад 24 дугаар зүйлийн 24.3-5 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 34.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийг төсөөтэй хэрэглэнэ.</p> <p>③1 дэх хэсгийн зохицуулалт нь 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх үр дагавартай байвал үүнийг хэрэглэхийг хориглоно.</p>	<p>ийн байдлыг хадгалах шаардлагатай тохиолдол</p> <p>2. Маргаан бүхий эрх зүйн харилцаанд оролцогчид тохиолдох гэнэтийн хохирол буюу аюулаас хамгаалах эсхүл түүнд түр зуур статус тогтоох шаардлагатай тохиолдол</p> <p>② 1 дэх хэсгийн зохицуулалтын дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад 24 дугаар зүйлийн 24.3-6 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 52 дугаар зүйл, 53 дугаар зүйлийг төсөөтэй хэрэглэнэ.</p> <p>③1 дэх хэсгийн зохицуулалт нь 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх үр дагавартай байвал үүнийг хэрэглэхийг хориглоно.</p>
--	---	--

2) 2013 оны хуулийн төсөл

Одоогийн хүчин төгөлдөр 3 ахиргааны процессын хууль	2013 оны хуулийн төсөл
<p>Нэмэлт</p>	<p>§26 (Шүүхээс гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах) ① Захиргааны акт зэрэг хууль бус гэж үзэх зохих үндэслэлтэй байвал дараах хэсгийн 1-т хамаарах тохиолдолд тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх нь оролцогчийн хүсэлтээр шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж болно.</p> <p>1. Маргааны зүйлийн байдал өөрчлөгдсөнөөр оролцогч өөрийн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй буюу хэрэгжүүлэхэд хэцүү болохоор байгаа учраас маргааны зүйлийн гэвийн байдлыг яаралтай хадгалах шаардлагатай тохиолдол</p> <p>2. Маргаан бүхий эрх зүйн харилцаанд оролцогчид тохиол</p>

	<p>дох гэнэтийн хохирол буюу аюулаас хамгаалах эсхүл түүнд түр зуур статус тогтоох шаардлагатай тохиолдол</p> <p>② 1 дэх хэсгийн зохицуулалтын дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад 24 дугаар зүйлийн 24.3-7 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 34.1 дэх хэсгийг төсөөтэй хэрэглэнэ.</p> <p>③1 дэх хэсгийн зохицуулалт нь 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх үр дэгавартай байвал үүнийг хэрэглэхийг хориглоно.</p>
--	--

3) Үнэлэлт

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Захиргааны процессын хуулийн дагуу Иргэний процессын хуульд хуульчилсан шүүхийг шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тогтолцоог нэвтрүүлэн оруулах боломжтой боловч хуулийг тайлбарлах явцад Захиргааны процессын хуульд Иргэний процессын хуулийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэх талаар маргаан байсан бөгөөд практикт бараг хэрэглээгүй болно. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх болон шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах хоорондын харилцаа мөн маргаантай байсан. Захиргааны акт алдаатай байсан хэдий ч үүний үйлчлэл хэвээр байх зарчим үйлчилж байгаа учраас Иргэний процессын хууль дахь шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тогтолцоог төсөөтэй хэрэглэх боломжгүй гэж үзэх хандлага ч байв. Япон болон бусад улстай харьцуулахад захиргааны хэргийн тоо давамгайлдаг БНСУ-ын хувьд иргэний эрх ашгийг хамгаалахаас гадна захиргааны байгууллагын хэвийн үйл ажиллагааг мөн харгалзах ёстой байсан учраас Улсын дээд шүүх, Хууль зүйн яамны хуулийн төсөлд заасан “захиргааны акт зэрэг хууль бус гэж үзэх зохих үндэслэлтэй байвал” гэдгийг “захиргааны акт зэрэг хууль бус гэж үзэх тодорхой үндэслэлтэй байвал” гэж өөрчилсөн. Ийнхүү өөрчлөлт маргаантай байгаа бөгөөд үүнийг дэмжиж байгаа хэсэг эрдэмтэд хэт консерватив хандлагатай хэмээн шүүмжлэлд өртөж байгаа. Шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зохицуулалт нь захиргааны акт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх, даалгах, эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх шинж бүхий нэхэмжлэл зэргийн хүчингүй болгох нэхэмжлэлд төсөөтэй хэрэглэх хуулийн зүйл, заалт байгаа боловч тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэлийн хувьд алга. Үүний шалтгаан нь Иргэний процессын хуульд заасан шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах

зохицуулалтыг шууд хэрэглэх боломж олгох зорилготой юм. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэлийн хувьд Иргэний процессын хуульд заасан шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зохицуулалтыг шууд хэрэглэж, хүчингүй болгох нэхэмжлэлийн хувьд Захиргааны процессын хуульд тусгайлан хуульчилсан тусгай зохицуулалтыг хэрэглэх нь хоёрдмол тогтолцоог бий болгоно. Тэгш эрх бүхий оролцогчийн нэхэмжлэл нь иргэний процесс дахь нэхэмжлэлтэй төсөөтэй учраас хүчингүй болгох нэхэмжлэлээс илүү дээрх тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж болох боловч үүнд болгоомжтой хандах нь зүйтэй.

V. ДҮГНЭЛТ

2002 оноос 2007 он хүртэл Захиргааны процессын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах оролдлого нь 18 дугаар Ерөнхий Ассамблейн хойно гарсаар байсан боловч амжилт олж чадсангүй. Захиргааны эрх зүйн эртэмдийг ихэнх оролцсон 2011 оны Улсын дээд шүүх, хууль зүйн яамны хуулийн төсөл гол байр суурь эзэлсэн бөгөөд энэ дундаас ч хууль зүйн яамны тэргүүлж байсан. 2011 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөс 27-ны өдөр хүртэл хууль тогтоохоор байсан боловч Ерөнхий Ассамблейд танилцуулаагүй. Улсын дээд шүүхын хувьд Захиргааны процессын хуулиар үйл ажиллагаагаа голчлон явуулдаггүй ба Улсын дээд шүүх хууль санаачлах эрхгүй байсан учраас захиргааны эрх зүйн салбарын ихэнх эрдэмтэд дэмжиж байсан ч Ерөнхий Ассамблейд хуулийн төслөө танилцуулах боломжгүй байв. Бодитоор Ерөнхий Ассамблейд танилцуулсан нь Пак Сон Ён гишүүний хуулийн төсөл ббайгаа боловч Ерөнхий Ассамблейд уг хуулийн төслийг хэлэлцэж л чадалгүй 18 дугаар Ерөнхий Ассамблейн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон. Өөрөөр хэлбэл одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Захиргааны процессын хууль нь 1951 онд батлагдсанаас хойш 30 жилийн дараа буюу 1984 онд шинэчлэн найруулаж, 1994 онд нэмэлт өөрчлөлт орж нэхэмжлэл гаргахаас өмнө заавал захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулсан байх зарчмыг халиах, захиргааны хэргийг гурван шатны шүүхээр хянан шийдвэрлэх болсноос өөр том өөрчлөлт ороогүй билээ. Үүнээс хойш иргэдийн эрх зүйн ухамсар төлөвшиж, захиргааны янз бүрийн үйлдэл бий болсон байхад Захиргааны процессын хууль үүнийг тусгаж чадахгүй байна гэсэн шүүмжлэлээр Хууль зүйн яамнаас 2007 онд Захиргааны

процессын хуулийн шинэчилсэн найруулга бүхий хуулийн төслийг Ерөнхий Ассамблейд танилцуулсан боловч 2008 оны 5 дугаар сард хуулийн 17 дугаар болон 18 дугаар Ерөнхий Ассамблейн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж уг хуулийн төсөл хүчингүй болсон.

Захиргааны процессын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах оролдлогын дагуу захиргааны эрх зүйн салбарын судлаачид Улсын дээд шүүх, хууль зүйн яамтай хамтран ажиллаж хуулийн төслийг боловсруулсан боловч Ерөнхий Ассамблейн үл хайхрах хандлага ба хариуцагчаар татагддаг захиргааны байгууллагын эсэргүүцлээс шалтгаалж амжилт олсонгүй. 20 дугаар Ерөнхий Ассамблейн бүрэн эрхийн хугацаа эхэлж үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч захиргааны эрх зүйн салбарын эрдэмтэн, судлаачдын хүсэн ерөөж буй Захиргааны процессын хуулийн шинэчлэл амаргүй харагдаж байна. Захиргааны процессын хуулийн шинэчлэл ийнхүү удааширч байгаагийн шалтгаан нь юуны өмнө Ерөнхий Ассамблейн үл хайхрах хандлага байх бөгөөд үүний шалтгаан нь хууль тогтооход саналын зөрүү их байхаас гадна иргэний анхаарлын гол төв байрладаггүй “арга хэрэгсэл”-ийн шинжтэй процессын хуулийг шинэчлэх шаардлагагүй гэж үзэж байсантай холбоотой юм. Мөн захиргааны байгууллага Захиргааны процессын хуулийг шинэчлэх тухай багагүй айдастай байсан. Захиргааны процессын хуулийг захиргааны эрх зүйн салбарын эрдэмтдийн хичээл чармайлтаар л шинэчлэх боломжгүй бөгөөд ард иргэдийн оролцоо чухал юм. Үүнээс гадна практикт ажиллаж байгаа Өмгөөлөгчийн холбооны гишүүдийн дэмжлэг мөн шаардлагатай боловч бодит байдалд тэдний анхаарлыг татаж чадахгүй байна. Иймд БНСУ-ын захиргааны эрх зүйн салбараас ард иргэдийн эрх ашгийг хамгаалах төдийгүй захиргааны байгууллагаас хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломж бүхий Захиргааны процессын хуулийн төслийг боловсруулж батлуулах шаардлагатай.

한국 행정소송법 개정과정 및 평가

김성배 (국민대학교 법과대학 교수)

I. 서론

한국에서 행정법의 연구대상은 무척 광범위하다. 1373개의 법률을 포함한 4,587개의 법령¹⁾중 대부분이 행정법의 연구대상이 되는 행정법영역에 속한다. 그래서 한국의 행정법을 단일한 논문이나 교과서에서 다 다루는 것은 사실상 불가능하다. 한국의 행정법은 일본을 통해서 서양의 행정법을 계수하는 과정을 거쳐서 발전하였으며 1961년까지 상당수의 한국 행정법령이 일제 강점기에 제정된 어용법령이었다.²⁾ 행정법의 발전을 분류하는 시도중에는 ①비교법연구, ②판례연구 ③헌법과 행정법의 통합 그리고 다른 법분야와 비교발전 ④행정법과 인접학문간의 학제적 연구를 통한 종합적인 행정과학으로 발전 등을 제시하는 견해도 있지만³⁾ 한 나라의 행정법의 발전을 획일적으로 구분하거나 평가하는 것은 오해를 불러일으킬 수 있으며, 각 단계는 통과되거나 사라지는 것이 아니라 계속해서 영향을 주고 시대별로 강조되는 부분의 차이가 발생한다고 보아야 할 것이다. 지금 한국은 일본을 통한 기계적 서양법학의 계수단계를 지나 독자적으로 수행한 단순한 비교법연구단계를 거쳐서, 서구국가뿐만 아니라 다양한 국가의 법제를 실무적 필요나 학문적 연구를 위해서 수행하고 있는 단계로 평가되며, 특정한 사회현상에 보다 효율적으로 대처하고 시행착오를 줄이기 위하여 서구국가뿐만 아니라 문화적·사회적·경제적 동질성이 있는 국가의 법제를 정책적·자율적으로 연구하고 있다. 일본에 비해서 풍부한 행정판례의 출현이 한국 행정법의 발전에 많은 긍정적인 역할을 수행하고 있다. 1975년 간행된 행정판례집(상·중·하)에 수록된 판례가 9,000천여 건에 달했으며, 1984년 한국행정판례연구회가 창립되어 행정재판을 수행하는 판사와 행정법학자가 모여서 토론하는 자리가 매달 개최되고 있다는 것도 한국 행정법의 발전에 큰 역할을 수행하였다. 행정판례연구회는 국내 판례뿐만 아니라 외국의 판례연구도 매년 말에 심도 있게 다루고 있다.⁴⁾ 제1심 본안사건 제기건수는 통계가 시작된 1953년에는 157건에 불과하였으나 2014년에는 17,630건이었으며 2015년 서울행정법원에 접수된 사건은 7,846건이며

1) 2016.6.30.기준 <http://www.moleg.go.kr/lawinfo/status/statusReport>

2) 박정훈, 행정법의 체계와 방법론, 2015, 441면 참조

3) 박정훈, 한국 행정법학 방법론의 형성·전개·발전, 공법연구 제44집 제2호, 한국공법학회, 2015, 164면이하

4) 2016.6.11. 행정판례연구회는 제주도에서 318회 특별세미나를 개최하였고, 일본 고베대 가도마츠 나후루미교수가 일본 행정소송법 개정의 성과와 한계로 발표하기도 하였다.

이 중 7,608건이 처리되었으며 2,933건이 상소되었다. 2016년 5월 기준으로 2016년 대법원에 접수된 행정사건만 1,438건이다.⁵⁾ 한국의 행정법학은 연구대상을 사법심사(행정소송)에 국한하던 전통에서 벗어나 법령을 입안하는 단계와 정책형성과정에도 능동적으로 참여하는 방향으로 변화하였지만 한국 행정법학의 중심에는 행정소송이 존재하며, 행정소송의 기본기준을 정하고 있는 행정소송법의 연구와 개정논의는 끊임 없이 제기되고 있다.

Мөн Зөрчлийн тухай хууль нь Үндсэн хуулийн 5.3⁶⁾ болон 16.13⁷⁾-ыг зөрчилдөж байна. Иргэдийн эрх, эрх чөлөөнд зөвхөн хуульд заасан тодорхой үндэслэл байхгүй бол төрийн байгууллагаас халдахыг хориглосон Үндсэн хуулийн суурь зарчим болох “хуульд үндэслэх зарчим”-ыг зөрчсөн. Иргэдийг шийтгэж эрх, эрх чөлөөнд нь халдаж байгаа бол яг ямар үйлдэл, эс үйлдэхүйд шийтгэл оногдуулах нь хуульд тодорхой заагдсан байхыг Үндсэн хуулийн дээрх заалтууд шаардаж байна. Гэтэл Зөрчлийн тухай хуульд “**хэм хэмжээний актыг дагаж мөрдөөгүй бол торгоно**”⁸⁾ гэсэн заалт салбарын хуулийн зөрчил бүр дээр байна. Монгол улсад 800 гаруй хэм хэмжээний акт бүртгэлтэй бөгөөд эдгээр нь тус бүрдээ дунджаар 30 дээш зүйл заалттай. Гэтэл Зөрчлийн тухай хуулиар заалт болгоныг нь зөрчвөл торгохоор хуульчилсан болохоос яг тодорхой үйлдэл бүхий зөрчлийг нэрлээгүй байна.

Хамгийн гол нь тухайн хуулиар зохицуулах гэж байгаа Монголын нийгмийн харилцааныхаа онцлогт Зөрчлийн хууль таарч тохирох эсэхэд анхаарах хэрэгтэй байна. Барилга, зам харилцаа холбоо, боловсрол, эрүүл мэндийн салбарын хуулиуд нь техник технологийн хөгжлөө дагаад байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг бөгөөд түүнийг иргэдэд мэдээлэн сурталчлах, хуулийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилтөрийн байгууллагаас бараг хийдэггүй бөгөөд шинэ хуулийн зохицуулалт Монголын хөрсөнд бууж иргэд дагаж мөрдөж суртлаа тодорхой хугацаа хүссэн хүсээгүй шаардагдана. Иймд захиргааны байгууллагаас салбарын хуулийн зөрчлийг илрүүлж торгож шийтгэх гэхээсээ илүүгээр захиргааны байгууллага иргэдэд мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтран ажиллах нь илүү үр дүнтэй. Цаашдын захиргааны эрх зүйн хөгжлийн чиг хандлага нь захиргааны мэргэжлийн хяналтыг төрийн байгууллага ялангуяа прокурор гэхээсээ илүүтэй төрийн бус байгууллага мэргэжлийн холбоодоор хийлгэхэд чиглэж байна.

Захиргааны эрх зүй судлаачийн хувьд цаашид бид юун дээр анхаарч ажиллах талаар өөрийн бодлоо хэлье:

Юуны өмнө Зөрчлийн тухай хууль болон Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийг

6) ҮХ5.3. Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.

7) ҮХ16.13. халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь язгаарлахыг хориглоно.

8) Тухайлбал ЗтХ10.19.8 Хуулийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдөөгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

хүчингүй болгох хэрэгтэй гэж үзэж байна. Эдгээр хуулиуд нь одоо байгаа хуулийн зохицуулалтыг улам дордуулсан, Үндсэн хуулийн зөрчилтэй мөн Монголын өнөөгийн нийгмийн харилцаанд тохирохгүй байна.

Судлаачийн хувьд зөрчлийг хянан шалгах ажиллагаа, захиргааны шийтгэл ногдуулах шийдвэр гаргах ажиллагааны хуулийн зохицуулалтыг сайжруулж боловсронгуй болгох шаардлагатай гэдэгтэй санал нэг байна. Үүнийг хийхдээ Захиргааны ерөнхий хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нийцүүлэн Захиргааны хариуцлагын тухай хуулийн процедур буюу шийдвэр гаргах ажиллагааны журмыг боловсруулж сайжруулах нь зүйтэй. Харин Захиргааны хариуцлагын тухай хуулийн тусгай анги буюу тодорхой зөрчлүүдийн жагсаалтыг хасах нь хэрэгтэй. Тодорхой шийтгэл бүхий зөрчлүүд нь салбарын хууль болон хэм хэмжээний актууддаа тусгагдаж явах нь оновчтой бөгөөд хэрэглэхэд хялбар байдаг.

Захиргааны ерөнхий хуультай холбоотойгоор дараах зүйлд анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Иргэний эрх зүй болон эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн нэгэн адил захиргааны ерөнхий хуулийн “захиргааны байгууллага”, “захиргааны шийдвэр гаргах ажиллагаа”, “захиргааны акт”, “захиргааны гэрээ”, “захиргааны хэм хэмжээний акт” гэсэн суурь институтууд нь захиргааны тусгай анги болох салбарын хуулиудад нэгэн адил хэрэглэгдэнэ. Мэдээжийн хэрэг зарим салбарын онцлогоос хамаараад тухайн салбарын хуульдаа нэмэлт зохицуулалт хийж болно. Тухайлбал татварын эрх зүй дэх захиргааны актын зохицуулалт нийгмийн халамжийн эрх зүй дэх захиргааны актын зохицуулалтаас ялгаатай байх нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл захиргааны ерөнхий хуулийн зохицуулалт салбарын хуулиар дамжиж улам нарийсаж тодорхой болно гэсэн үг. Салбарын онцлогт нь тохирсон зохицуулалт хийснээр хуулийн зохицуулах чадавхи нэмэгдэж боловсронгуй болох төдийгүй бусад хуультай харилцан уялдаж нэгдмэл байдлыг бий болгоно.

Судлаачийн хувьд нэгдүгээрт: дэд бүтцийг байгуулах төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны эрх зүйн орчинг, хоёрдугаарт: татварын эрх зүйг, гуравдугаарт: нийгэм хамгааллын эрх зүйг орчин үеийн түвшинд зайлшгүй аваачих хэрэгтэй гэж үзэж байна. Эдгээр нь тус бүртээ олон арван хууль, дүрэм, журамтай том эрх зүйн салбарууд бөгөөд бүгд захиргааны эрх зүйн тусгай ангид хамаарна.

Татварын эрх зүйн хувьд нэр томъёоноос эхлээд татварын байцаагчийн үйл ажиллагаа,

гаргаж буй шийдвэр зэрэгт цогцоор нь эрх зүйн шинэчлэлт хийх хэрэгтэй. Татварын эрх зүй нь татварын ерөнхий хууль болон татварын төрөлжсөн хуулиуд, тэдгээрийг даган гарсан хэм хэмжээний актуудаас бүрддэг захиргааны эрх зүйн нэгэн томоохон салбар. Иймд захиргааны эрх зүйн нэгдсэн системийн нэг хэсэг болох төдийгүй татварын эрх зүйн салбарын онцлогийг өөртөө агуулсан салбар эрх зүйн бие даасан тогтолцоо юм. Тодруулбал, захиргааны ерөнхий ангийн “захиргааны акт”, “захиргааны шийдвэр гаргах ажиллагаа” зэрэг институтууд Татварын ерөнхий хуулинд тухайн салбарын онцлогийг агуулж нарийвчлагдан хуульчлагдана гэсэн үг. Ингэж байж хуулийн зохицуулах чадавхи нэмэгдэж хоорондын зөрчилгүй нэгдсэн систем тогтолцоо бүрдэнэ.

몽골행정법의 발전

몽골국립대학교 법과대학 공법학

부교수, 박사 P.Odgerel

울란바타르 시

2016년 07월 27일.

본 논문의 목적은 몽골행정법의 변화와 문제점에 대하여 몽골행정법학 학자로서의 의견을 제시하는 것이다. 무엇보다도 몽골행정법의 구조 및 특징에 대하여 언급하자면 몽골에는 현재 571 개의 유효한 법률¹⁾과 약 800개의 명령 및 규칙²⁾중에서 약 400개의 성문법령이 행정법에 해당된다.

학자들은 여러 법률, 명령 및 규칙이 서로 상반되지 않고 부합하여 행정법학의 특징을 그대로 지녔으며, 사회경제적 관계를 효과적으로 규율 할 수 있는 현대적인 법체계를 조성하려고 노력하는 중이다. 몽골행정소송법은 민사소송법과 마찬가지로 “총론”과 “각론”으로 구성되어 있으며, 행정소송법 상 총론에 해당하는 부분을 전면 개정하여 2015년 독립된 행정일반법을 제정하였다.

행정법 각론으로 몇 몇 영역에 독립적인 법체계가 형성될 근거가 마련되었다. 예를 들면 환경법 영역은 “환경보호법”에 근거하여 자연자원에 따라 “산림법”, “식물법”, “물보호법”, “자연환경보전지역법”과 이에 상응하는 명령들을 제정하여 통합적으로 환경법의 특징을 지닌 행정법 각론체계로 발전하였다. 또한 세법을 예로 들 수 있다. 조세일반법으로 세법의 기본적인 법률 관계를 규율하며, “개인소득세법”, “법인세”, “소비세” 등의 각 법률을 제정하여 시행하고 있다.

현대 몽골법은 특유한 각각의 과정을 거치며 구성 및 발전하였다. 학자로서 몽골행정법의 발전과정을 시기적으로 다음과 같이 구분하려 한다. **1992년 이전:** 사회주의국가 시기의 행정법이 해당하며, 그 기본적인 특징은 국가업무에 단일당의 영향 즉, 공산주의식 이념의 통제를 받았다. **1992년부터 2004년까지:** 1992년 신헌법이 제정됨으로써 다당제가 도입되었으며, 몽골은 법치국가건설을 목표로 국가공무원에게 이념적 통제가 아닌 법치로, 정당을 행정법원으로서의 변화가 필요했다. 당시에 몽골에 약 50개의 법률이 시행되고 있었기 때문에 국가최

1) 사법정보통합시스템. www.legalinfo.mn 2015.11.09

2) 몽골법무부. www.moj.gov.mn 행정명령의 목록. 2015.11.09

고회의에서 2004년까지 약 400개의 법률을 제정하여 법치국가의 기반을 잡았으며 행정법원의 법적환경이 조성되었다. 그 결과, 행정법의 기능 및 기본이념이 근본적으로 바뀌게 되었으며, 그 이론-실무적 기초는 1998년부터 2004년(행정법원 설치 전까지) 형성되었다고 볼 수 있다. 덧붙여 말하자면, 이는 B.Chimid 교수님의 업적과 직접적인 관련이 있다. 새로운 법체계를 구성한다는 것은 걸맞은 법률용어를 찾아 정의하고, 규정하여, 상호연관적이고 모순적이지 않은 법규범, 국내외의 제도형성 등 과학적인 연구는 매우 큰 업적이며, 가장 중요한 것은 향후에 개선 및 발전할 수 있는 기초를 잡았다는 것이다. **2004년부터 2016년까지:** 2002년12월26일 국가최고회의에서 “행정법원설치법”, “행정소송법”을 제정하여 2004년6월1일부터 몽골에는 최초의 행정법원이 운영되기 시작하였다. 행정소송법에는 독일의 “행정처분”의 고전적 정의를 규정함으로써 몽골에 대륙법체계를 도입하였다. 이러한 현대 행정법의 중심인 “행정처분”에 관한 규정을 지난 10년 간 행정법원에서 사용해왔으며, 몽골에 적합한 규정이라는 것은 실무 상으로 증명이 되었다.

특히2004년부터 2008년까지 행정법 총론을 종합적으로 제정할 전제조건을 충족하였다고 학자로서 평가하며 2008년 이후에 행정법 영역에 개혁을 하지 않고 최근에는 비로서 행정법 총론을 일반법으로 제정한 것은 시간낭비이고 국가의 발전을 저해하는 요소였다. **2016년 이후:** 행정일반법이 2016년 7월 1일부터 시행되었으며 현재 시급한 특정 영역의 법률들을 행정일반법에 기반하여 개정하여 더욱 발전된 행정법 각론체계를 구성할 필요가 있다.

현재 몽골행정법의 가장 큰 변화는 2016년 7월1일 이후로 시행된 행정일반법과 2016년 9월 1일부터 시행될 위법행위법을 공포하였다는 것이다. 행정법학 학자로서 위 두가지 법률 중 하나는 긍정적으로 평가하지 않고 있으며, 이에 대한 의견을 나누겠다.

무엇보다도 행정일반법의 필요성 및 새로운 점에 대하여 언급하겠다. 2015년 6월 19일 몽골 국가최고회의에서 행정일반법을 제정하였다. 동법은 11장 107조로 구성되었으며 그 중요성으로 헌법 바로 다음이라고 할 수 정도로 중요한 법률이다.

행정일반법의 내용은 정부와 국민 사이의 법률관계에 최소한의 기준을 제시하는 것이다. 정부에서 개인과 사회 어떠한 영역에서든 상하적인 법률관계에 관하여 행정처분을 내리고, 개인과 협동하게 된다면 행정계약을 체결하고, 반면에 모든 국민을 대상으로 하면 명령을 제정하는 등 행정청 업무의 종류를 규정하였다. 행정일반법의 요지는 행정처분, 행정계약, 명령이라는 각각의 독립된 체계에 있으며, 행정청이 국민을 대상으로 행정행위를 할 때에 합법적이고, 적합한 결과를 목적으로 하는 특정한 단계들로 구성된 상호연관적인 규정의 집합체이다. 어떠한 문제이든 행정청공무원의 자의가 아닌 법률에 따라 행위를 할 법적 근거를 구성하였다.

행정법 학자로서 몽골사회에 행정일반법을 제정할 다음과 필요성이 발생하였다고 평가한다.

- 2004년부터 사용된 행정처분과 관련된 규정을 향후 개선할 필요가 있었다. 예를 들면 행정처분 혹은 명령의 차이점을 명확히 하고, 행정처분의 무효 등 확인 혹은 취소할 요건을 구별하여, 행정처분과 관련된 업무를 규정하는 등 세밀한 규정이 필요하였다.
- 명령에 관한 규정은 정부령으로 규율 되었었는데 이를 법제화하여야 한다.
- 사회의 기본적인 서비스를 제공하고 이행하기 위하여 정부에서 사법상 계약을 체결하여 협력하는 경우가 많이 발생하고 실무상 이권 계약의 사용이 증가하는 추세이기 때문에 행정 계약을 법률로 규정할 필요성이 있다.
- 사회경제적 발전은 세법 혹은 사회복지법 혹은 기간시설건설법 등의 행정법 각론을 개선하여 현대적 법체계를 도입해야 한다.
- 행정청의 업무를 상호연관되게, 특히 특정 행정청의 처분이 다른 행정청의 처분과 모순되지 않도록 개정하여 법률의 통일성을 충족할 필요성이 생겼다.
- 각 영역의 법률의 대부분은 행정청의 권한, 기능 혹은 국민, 법인의 권리 및 의무에 의하여 제한된다. 그러나 정부에서 공권력 행사할 시에 국민과의 관계를 규정한 법률이 없어서 국가공무원의 자의에 의하여 문제를 해결하고, 이념화 및 뇌물수수 등 흠결이 발생하기 때문에 법률로 규정하여야 한다.

행정일반법 제정으로 몽골행정법에 다음과 같은 새로운 규정이 들어서게 되었다.

- 행정청의 행정행위의 일반적 규정을 최초로 법제화하였다. 이로서 법률의 흠결을 보충하였다.
- 행정행위의 당사자로서 국민의 권리를 최초로 규정하였다. 이전에는 행정청이 처분 시에 국민에게 이를 통지하여 실질적으로 국민이 처분행위에 참여하지 않았었다.
- 통지의 원칙을 최초로 규정하였다. 행정청에서 국민의 권리를 침해한 처분을 내리기 이전에 이에 대한 이유를 서면으로 제시할 의무가 있다.
- 행정청에서 통지를 악의적으로 사용할 것을 예방하는 내용의 규정을 최초로 반영하였다.
- 행정처분에 관한 규정을 종합적으로 규정하였다.
- 행정계약에 관한 규정을 최초로 규정하였다. 행정계약과 관련된 분쟁을 법원에서 재판할 수 있게 되었다.
- 명령에 관한 규정을 최초로 규정하였다.
- 전국적인 행정계획을 최초로 법률화하여 거주자, 국민, 행정청, 법인의 권리 및 의무를 정의한 통일된 규범을 최초로 규정하였다.

몽골 행정일반법은 자체적인 특징을 지닌 규정으로 구성되었으며 예를 들면 독일의 행정행위법과 다음과 차이점이 있다.

- 법률의 대상으로는 행정일반법의 명령에 관한 규정, 행정처분의 집행, 구제절차, 손해배상 혹은 위법행위를 한 공무원의 책임과 관련된 사항을 개별적인 장으로 규정하였다면 독일의 동법에는 이러한 규정이 없다.
- 행정일반법에 행정청을 분류하여 규정하였다.
- 행정처분 업무의 당사자라는 개념에 행정청을 포함시키지 않고, 행정청에 관한 개념을 독립적인 장으로 규정하였다.
- 행정처분이라는 개념에 부작위를 포함하였다.
- 행정처분을 취소 시 국민의 신뢰를 보호해야 한다.
- 행정계약의 종류에 따라 분류하여 행정계약의 무효 등 확인 요건을 열거하였다.

행정법 학자로서 행정일반법을 제정함으로써 몽골행정법 발전의 새로운 단계에 들어섰다고 평가한다.

몽골 국가최고회의 2015 년 12 월 04 일 “위법행위법”을 제정하였으며 동법은 2016년 9월 1일부터 시행될 것이다.

위법행위법안의 입법취지에 3) “... 법규범 간의 충돌 및 중복이 발생한 것은 위법행위법을 형법에 부합하게 제정해야 할 중요한 근거가 된다. ... 유효한 행정책임법 혹은 기타 법률관계를 규율한 약 220개의 법률로 규정한 위법행위 및 그에 따른 책임을 정의한 범규범을 분류 및 통합하여 새로운 이념적 내용과 법 제정의 전문기술에 근거한 위법행위법안을 발의한다.” 라고 정의하였다.

환언하면 범죄, 위법행위를 중복하여 규정한 실수가 있었기 때문에 행정 상 모든 위법행위를 하나의 법률에 열거하여 위법행위를 예방할 것을 시도하였다. 그 때문에 위법행위법안 제1조2항2호에 따르면 위법행위를 오직 동법에 의하여 규율 한다고 하였으며, 위법행위법안제조항에 법률 혹은 명령을 위반한 행위 및 부작위를 위법행위라는 개념에 포함되도록 규정하여 동법 각론에 각 영역의 약 230개의 법률에 규정된 책임져야 하는 행위 및 부작위를 동법의 각 조항이 아닌 문장으로 기계적으로 통합하였다.

3) <http://www.parliament.mn/law/project/369/category/1>

행정법 학자로서 위법행위법을 다음과 같은 근거로 인정할 수 없다.

위법행위 혹은 그와 관련된 규정은 행정법에 해당되었던 것을 형법에 포함시켜 원리적 변화로서 형법⁴⁾ 제1조1항에 위법행위법은 형법에 속한다고 직접적으로 규정하였으며, 법집행법⁵⁾으로 위법행위를 수사하여 해결하는 업무에 대하여 규정하였다. 동법의 규정으로 다음과 같은 변화가 생겼다.

- 위법행위 수사 시 행정청의 기능에 따른 관할권 지정 (법집행법 제6조2항3호 및 5호), 수사업무와 관련하여 제기한 청구서를 재결 (법집행법 제6조6항2호 및 3호), 수사의 감시 (법집행법 제6조9항) 등에 검사가 참여하도록 규정하였다.
- 또한 청구서를 재결하는 업무에 형사소송법 제 14조에 규정한 절차를 사용 하도록 법집행법 제6조6항4호에 규정하였다.
- 행정공무원의 위법한 업무에 관하여 청구서를 행정청의 장에게 제기한 후, 검사에게(법집행법 제6조2항2호), 이후로 상급 검사에게 제기한다 (법집행법 제6조9항3호)고 규정하였다.
- 국민은 행정위법행위에 부과한 책임을 인정할 수 없는 경우에 법집행법 제10조1항1호에 따라 검사에게 청구서를 제기할 수 있으며, 그 재결에 불복 시 법집행법 제10조1항4호에 근거하여 법원에 소를 제기하도록 규정하였다. 위법행위 수사 시 형사소송법을 적용하도록 법집행법 제11조1항4호에 규정하였다.

동법의 개정으로 국민에게 다음과 같은 문제점이 발생하였다.

- 위법행위를 수사하여 처리할 요구를 기간 내에 행하지 않으면 벌금을 부과하게 행정청이 요구할 수 없게 되었다. 행정청의 경우 벌금의 부과보다는 전문적인 원조와 협조를 기본적인 기능으로 한다. 반면에 형법상 각 범죄마다 적합한 형벌을 부과하는 원리를 따른다. 이에 대하여 위법행위법 제1조3항2호에 각 위법행위마다 책임을 부과한다고 규정하였다.
- 행정청의 감시 외에도 검사의 감시가 추가된다. 사법전문기관들의 부담이 늘게 된다는 것이다.
- 위법행위를 형사법원에서 재판하는 경우 국민들의 법적 지위가 바뀌게 된다. 위법행위를 행정법원에서 재판하는 경우 국민은 원고, 행정청은 피고가 되는 한편 형사법원에서 재판하는 경우 국민이 범죄인, 행정청 및 검사가 고소인이 되어 국민의 법적 지위가 악화된다.

4) 형법은 2016년 9월 1일부터 시행될 것이다.

5) 법집행법은 2016년 9월 1일부터 시행될 것이다.

결론을 내리자면 위법행위법을 제정함으로써 생산 및 서비스 영역에 생업을 운영하는 국민과 법인의 법적 지위가 더욱 악화되어 사업가들이 사법기관의 압박에 정상적인 영업이 힘들어진다.

또한 위법행위법은 헌법 제 5조3항⁶⁾ 혹은 제16조13항⁷⁾에 위법하다. 국민의 권리 및 자유를 법률에 규정한 특정한 근거 없이 침해할 수 없다. 헌법기본원리인 “법치주의”를 위반하였다. 국민에게 벌을 부과하여 권리, 자유를 침해할 시 정확히 어떠한 행위 및 부작용에 벌을 부과하는 것이 자세하게 규정할 것이 헌법 동조항에 의하여 요구된다. 그러나 위법행위법에 “**명령을 준수하지 않은 경우에 벌금을 부과한다**”⁸⁾ 라는 조항은 각 영역의 법률마다 존재한다. 몽골에 약 800개의 명령이 등록되어 있으며 이들은 평균적으로 각각 30개 이상의 조항으로 구성된다. 그러나 위법행위법으로 각 조항을 위반할 때마다 벌금을 부과하도록 규정한 것은 정확히 어떤 행위를 위반한 것인지 명확하지 않다.

가장 중요한 것은 동법으로 규율 하려는 몽골사회의 법률관계의 특성에 위법행위법이 부합한지에 주목해야 한다는 것이다. 건설, 도로교통, 통신, 교육, 의료 영역의 법률은 기술 및 과학 기술의 발전에 따라 지속적으로 변화되며, 이에 대하여 국민에게 공고하여 법을 위반하는 것으로부터 예방하는 업무를 국가가 거의 하지 않고 있고, 새로운 법률이 몽골에 입지를 굳혀 국민이 이를 인식하여 준수할 때까지 원하든 원하지 않든 시간이 걸린다. 이렇기 때문에 행정청에서 각 영역의 법률을 위반하는 행위에 대하여 벌금을 부과하는 것보다는 행정청의 전문적인 원조 및 협력하는 것이 더욱 효율적일 것이다. 이후의 행정법의 발전동향은 행정청의 전문적인 감사는 국가기관 특히, 검찰청이 아닌 비정부기관의 전문가들에 의하여 행하는 것이다.

행정법 학자로서 향후 몽골에서 유의해야 하는지에 대한 의견을 제시하겠다.

무엇보다도 위법행위법 혹은 법집행법을 무효화해야 한다고 생각한다. 이들 법률은 현재의 법률규정을 하향시키는 위헌적이고, 현대 몽골의 사회관계에 적합하지 않다.

학자로서 위법행위 수사업무, 행정처벌에 관한 법률의 규정을 개선할 필요가 있다는 것에 동의한다. 이 때 행정일반법, 국가감사법에 부합 행정책임법 상 절차 즉 재결규칙을 개선해야 한다. 그러나 행정책임법 각론 즉, 특정한 위법행위들을 열거한 것을 삭제하여야 한다. 특정한 책임 및 처벌의 부과는 각 영역의 법률 혹은 명령에 반영하여 규정하는 것이 합리적이고 사용

6) 헌법 제5조3항. 소유권을 오직 **법률에 근거하여** 제한할 수 있다.

7) 헌법 제16조13항. 구속받지 않고 자유로운 권리가 있다. **법률이 정한 절차와 근거에 의하지 아니하고는** 자의적으로 수색, 체포, 구금, 박해, 자유를 침해하지 않는다.

8) 예를 들어 위법행위법 제10조 19항 8호에 법률을 전국적으로 통일적으로 준수할 요건을 구성하고, 법률의 이행을 위하여 법률에 부합하게 제정한 **명령을 위반할 경우** 개인은 100단위에 해당하는 투그рук, 법인은 1000 단위에 해당하는 투그рук의 **벌금을 부과한다**.

하기에 간편하다.

행정일반법과 관련하여 다음과 같은 사항을 유념하여야 한다.

민법 혹은 형법 총론과 같이 행정일반법의 “행정청”, “행정행위업무”, “행정처분”, “행정계약”, “명령” 이라는 기본적인 개념을 행정법의 각론이 되는 각 영역의 법률에 공통적으로 사용한다. 당연히 몇몇 영역의 특정 상 해당 영역의 법률에 추가적으로 규정할 수 있다. 예를 들면 세법 상 행정처분에 관한 규정은 사회복지법 상 행정처분에 관한 규정과 다른 것은 당연하다. 환언하면 행정일반법의 규정이 각 영역의 법률을 거쳐서 더 세밀하게 정의된다는 것이다. 각 영역의 특징에 부합한 규정을 제정함으로써 법령의 기속력이 더욱 강화될 뿐만 아니라 기타 법률과 상호연관적으로 통일될 수 있다.

학자로서 첫째: 기반시설 건설을 위한 국가 및 사인 간의 협력에 관한 법적 환경을, 둘째로: 세법을, 셋째로: 사회복지법을 현대적인 수준으로 발전시켜야 한다고 본다. 이들은 각각 다수의 법률, 명령으로 구성된 큰 규모의 법 영역으로 모두 행정법 각론에 해당된다.

세법의 경우 용어부터 세무직공무원의 업무, 처분 등에 관하여 종합적으로 법 개혁이 필요하다. 세법은 조세일반법 혹은 세금의 분류된 법률, 이들을 시행할 명령들로 구성되는 행정법의 중요한 법 영역이다. 그렇기 때문에 행정법의 단일한 체계의 한 부분일 뿐만 아니라 세법의 특징을 지닌 세법 영역의 독립적인 법체계이다. 더욱이 행정법 총론의 “행정처분”, “행정행위” 등의 규정은 조세일반법에 세법의 특징을 반영하여 세밀하게 규정된다는 것이다. 이로써 법률의 기속력이 강화하여 법률 간의 충돌 및 모순이 없는 통일된 법체계가 마련될 수 있다.

Session 3

Олон улсын салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага 국제법 분야의 개혁과 과제

**ЭЦЭГ ЭХ БОЛОН ГЭР БҮЛИЙН АЛЬ НЭГ ГИШҮҮН
ХҮҮХДИЙГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР
ХИЛИЙН ЧАНД РУУ АВЧ ЯВАХ ТОХИОЛДОЛД
ХҮҮХДИЙГ ОРШИН СУУГАА УЛСАД НЬ ШУУРХАЙ
БУЦААН АВЧРАХТАЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ЭРХ
ЗҮЙН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ БНСУ
-ын Хууль зүйн яамны санаачилгаар
국제적 아동탈취의 민사적 측면에 관한 협약
- 대한민국 법무부의 역할을 중심으로**

Илтгэгч: Прокурор Су Жонсу (Солонгосын ХЗЯ)

발표: 소정수 검사(한국 법무부)

Хэлэлцүүлэгч: Доктор Ц.Мандах (Монголын ШЕЗ-ийн ШСМСХ-ийн захирал)

토론: Ts.Mandakh 박사(몽골법원평의회 의장)



**ЭЦЭГ ЭХ БОЛОН ГЭР БҮЛИЙН АЛЬ НЭГ ГИШҮҮН ХҮҮХДИЙГ
ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР ХИЛИЙН ЧАНД РУУ АВЧ
ЯВАХ ТОХИОЛДОЛД ХҮҮХДИЙГ ОРШИН СУУГАА УЛСАД НЬ
ШУУРХАЙ БУЦААН АВЧРАХТАЙ ХОЛБООТОЙ
ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ
БНСУ-ын Хууль зүйн яамны санаачилгаар**

БНСУ-ын Хууль зүйн яам

Олон Улсын эрх зүйн

харилцааны хэлтэс

Прокурор Су Жон Сү

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

1

Гарчиг

- I. Агуулга
 1. Оршил
 2. Өнөөгийн байдал
 3. Конвенцийн гол агуулга
 4. Конвенцтэй холбогдуулан баталсан хуулийн танилцуулга
- II. Конвенцийн үндсэн зохицуулалт
 1. Конвенц батлах болсон шалтгаан
 2. Конвенциар зохицуулах зохицуулалт
- III. Конвенцийн асуудалд Солонгос Улсын төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг
 1. Бусад Улсаас БНСУ-руу эцэг эхийн зөвшөөрөлгүй хүүхэд авч ирсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх
 2. БНСУ-аас бусад Улс руу эцэг эхийн зөвшөөрөлгүй хүүхэд авч явсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх
- IV. Жишээ
- V. Дүгнэлт

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

2

I. Ойлголт

1. Оршил

Улс хоорондын иргэдийн шилжилт хөдөлгөөн чөлөөтэй болж байгаатай холбоотойгоор олон улсын гэр бүлийн эрх зүйн асуудал нь

→ Нэг талаас эцэг эхийн хоорондын харилцаанаас үүсэж байгаа олон улсын хүүхдийн эрхийн асуудлыг дурьдъя.

2. Конвенцийн өнөөгийн байдал

- Convention of the Civil Aspects of International Child Abduction
- 1980 оны НссН (Гаагийн Олон Улсын шүүх)-с батлав.
- '16. 7. 95 Улс нэгдэн орж, Ази тивийн 6 Улс(Солонгос, Япон, Хонконг, Макао, Шри-Ланка, Сингапур, Филиппин)
- Нэгдэн орох зөвшөөрөл авж байж 2 улсын хооронд харилцаа үүснэ. (Солонгос Улсыг 31 Улс нэгдэн орохыг зөвшөөрсөний дагуу Солонгос Улс уг конвенцид нэгдэн орсон.)
- Одоогийн байдлаар 21 улс уг конвенцид нэгдэн орох хүсэлт ирүүлсэн. Үүнээс 17 Улс нь нэгдэн орж, 4 Улс нь шүүхэд хэлэлцэгдэж байна

I. Ойлголт

3. Конвенцийн гол агуулга

- (Зорилго) аль нэг оролцогч улсад эцэг эхийн зөвшөөрөлгүй авч ирсэн хүүхдийг шуурхай буцаан явуулах болон тухайн улсын хуулийн дагуу хүүхдээ асран хамгаалах эрх, хүүхэдтэйгээ уулзах эрхийг бусад улс оронд ч мөн адил мөрдүүлэхээр хуульчилсан.
- (Агуулга) Конвенцийн үйлчлэх хүрээ (16 нас хүрээгүй хүүхэд болон конвенцид нэгдэн орсон улсад байнга оршин суугаа хүүхэд), олон улсын хүрээн дэх төрийн байгууллагын тусламж, шүүхийн байгууллага нь өөрийн улсад орж ирсэн хүүхдийг буцаах шийдвэр (олон улсын хууль тогтоомж, холбогдох шийдвэр, гүйцэтгэх шийдвэр, хүүхдийг буцаахаас татгалзах шалтгаан, хэрэглэгдэх хэл зэрэг)

4. Хэрэгжих хууль тогтоомж

- 『Гаагийн Олон улсын хүүхдийн эрхийн конвенцийг хэрэгжүүлэх тухай хууль』 (*12. 12. Батлав, '13. 3. дагаж мөрдөв)
- Конвенцийг дотоодод хэрэгжүүлэхийн тулд төрийн байгууллагыг хууль зүйн ямаар тогтоох
- Хүүхдийг буцаахтай холбоотой журам бэлдэх, төрийн байгууллагын хувьд хүүхэд буцаахыг дэмжих тухай бүрэн эрхийг хууль зүйн яамд олгох (Бусад төрийн байгууллагууд хамтран ажиллах үүрэгтэй)

II. Конвенцийн үндсэн зохицуулалт

1. Хэрэг үүсэх (Конвенц хэрэгжих явцын асуудал)

- ✓ 16 нас хүрээгүй хүүхэд
- ✓ Оршин суугаа улсаас өөр улс руу авч явсан
- ✓ Хоёр Улсын хооронд конвенц байгаа эсэх
- ✓ Хүүхдийг зөвшөөрөлгүй авч явснаас болж эцэг эхийн хүүхэд асран хамгаалах эрх болон хүүхэдтэйгээ уулзах эрх зөрчигдсөн эсэх



2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea


5

II. Конвенцийн үндсэн зохицуулалт

2. 사건 처리 절차

2. Маргаан

ШИЙДВЭРЛЭХ ЯРЦ



2016-07-27

III. Конвенцийн асуудалд Солонгос Улсын төрийн байгууллагын үүрэг

1. Хүүхдийг өөр нэгэн улсаас эцэг эхийн зөвшөөрөлгүй Солонгост Улсад авч ирсэн тохиолдолд (Incoming)

<Жишээ>



- Хүүхдийн хууль ёсоор оршин суугаа улсын төрийн байгууллагаас хүүхэд буцаан авах хүсэлт болон нотлох баримтыг гаргуулж авна
- Конвенц үйлчлэх эсэхийг шалгана
- Хүүхдийн байгаа газрыг олж тогтооно
- Сайн дураар буцаах мэдэгдэл
- Дахин эцэг эхийн зөвшөөрөлгүй хүүхдийг авч явах асуудал үүсэхээс сэргийлж урьдчилан хамгаалах арга хэмжээ авах
- Солонгос улсын шүүхэд өөрийн биеэр гомдол гаргах мөн асран хамгаалагчаар дамжуулан гомдол гаргаж болох нөхцөлийг бүрдүүлэх
- Хүүхдийг буцаах шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх болон хүүхдийг эх орон руу нь буцаахад нь туслах

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

7

III. Конвенцийн асуудалд Солонгос Улсын төрийн байгууллагын үүрэг

2. Хүүхдийг Солонгос Улсаас өөр нэгэн улс руу эцэг эхийн зөвшөөрөлгүй авч явсан тохиолдолд (Outgoing)

<Жишээ>



- Конвенц үйлчлэх боломжтой эсэхийг шалгах
- Ирсэн улсад хүүхдийг буцаахад шаардлагатай зүйлсийг шалгах
- Ирсэн улсын төрийн байгууллагатай байнгын харилцаа холбоотой байх
- Шаардлагатай хүсэлт, нотлох баримтыг гаргаж өгөх
- БНСУ-ын эрх зүйн тогтолцооны талаар тайлбар, албан ёсны шалгалт, хууль зүйн ойлголт олгох

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

8

IV. Бодит жишээ

Жишээ 1

- <Жишээ>



Гэр бүлийн харилцаа муудаж нөхрийн зөвшөөрөлгүйгээр эхнэр нь хүүхдээ дагуулан Австрали явсаны дараа холбоо барихаа больсон

- Конвенц үйлчлэх боломжтой нөхцөл байна гэж харж байна.
- Солонгос улсын хуулиар эцэг эх хүүхдээ асран хамгаалах эрхээ эрх тэгш эдлэх ёстой бөгөөд эхнэр нөхрийн аль нэг нь хүүхдийн амьдрах газрыг тогтоох нь хууль бус явдал юм.
- Австралийн төрийн байгууллагад шаардлагатай баримт бичгийг бүртгүүлж урьдчилсан арга хэмжээ авхуулахыг хүсэх
- Урьдчилсан арга хэмжээ нь хэрэгжиж байгаа бол хилээр гарахыг хориглосон байх бөгөөд шүүхэд хүүхдийг буцаах тухай маргаан үргэлжилнэ.


2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

9

IV. Бодит жишээ

Жишээ 2



✓ Гэр бүлийн харилцаа муудаж эхнэрийн зөвшөөрөлгүйгээр нөхөр нь хүүхдийг Солонгос руу авч явсны дараа Солонгост гэр бүл цуцлуулах нэхэмжлэл гаргасан.

- Эхнэр Японы төрийн холбоо барьж хүүхдийнхээ Солонгост орж ирсэнийг шалгуулна
- Хүүхдийн амьдарч буй газрыг олж тогтоосны дараа хүүхэд аавынхаа асрамжинд байгааг шалгуулна
- Шүүхэд асран хамгаалах эрхтэй холбоотойгоор гэр бүл цуцлуулах нэхэмжлэлээсээ татгалзахыг нөхрөөс хүснэ
- Эхнэр Солонгосын шүүхэд хүүхдийг Япон руу буцаалгахаар гомдол гаргахад нь туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн танилцуулах болон мэдээлэлээр хангана
- Хүүхдийг буцаах шийдвэр гарсаны дараа хүүхдийг Япон руу буцаахаар гадаад хэргийн яамтай зөвшилцөн яаралтай паспорт гаргуулах

- Хүүхэд Японд аюулгүй хүрч ирнэ.

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

10

V. ДҮГНЭЛТ

- Конвенцид нэгдэн орох мөн хэрэгжих хууль тогтоомжийн биелэлтэнд хүүхдийн эрхийг хамгаалах дээр үндэслэн бэлдэх
- Олон соёлт гэр бүлийн хувьд хүүхдийг эцэг эхийн аль нэгний зөвшөөрөлгүй авч явах асуудлаас гадна Солонгос Улсын иргэдийн гэр бүлийн харилцаанд гадаад руу хүүхдээ зөвшөөрөлгүй авч явах нь эцэг эхийн эдлэх эрхээ хэтрүүлж байгаа тул хязгаарлалт хэрэгтэй.
- Конвенцийн тухай агуулгыг HCCH-ийн албан ёсны цахим хуудсанд оруулсан болно. (www.hcch.net)



Баярлалаа.

Thank you



국제적 아동탈취의 민사적 측면에 관한 협약 - 대한민국 법무부의 역할을 중심으로

대한민국 법무부 국제법무과
검사 소정수

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

1

목 차

- I. 개요
 1. 배경
 2. 현황
 3. 협약의 주요 내용
 4. 이행법률 소개
- II. 국제아동탈취사건의 일반적인 처리 절차
 1. 협약의 대상 사건
 2. 협약에 따른 처리 절차
- III. 국제아동탈취사건에서 한국 중앙당국의 역할
 1. 다른 나라에서 대한민국으로 탈취된 사안
 2. 대한민국에서 다른 나라로 탈취된 사안
- IV. 구체적 사례
- V. 결론

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

2

I. 개요

1. 배경

국가 간 사람의 이동이 자유로워짐에 따라 국제가족법상의 문제 발생
→ 한쪽 부모에 의해 이루어지는 국제아동탈취문제 대두

2. 협약 현황

- Convention of the Civil Aspects of International Child Abduction
- 1980년 Hcch(헤이그국제사법회의)에서 제정
- '16. 7. 기준 95개국 가입, 아시아 6개국(한국, 일본, 홍콩, 마카오, 스리랑카, 싱가포르, 필리핀)
- 가입수락이 있어야 양국간 발효(현재 31개국이 한국 가입 수락)
- 현재까지 21건 지원신청, 17건 완결, 4건 법원에 계속 중

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

3

I. 개요

3. 협약의 주요 내용

- (목적) 위법하게 어느 체약국에 유치된 아동의 신속한 반환 확보, 어느 체약국의 법에 따른 양육권 및 면접교섭권이 다른 체약국에서 존중되도록 보장
- (내용) 협약의 적용범위(16세 미만 아동, 체약국에 상거소 존재), 중앙당국간의 국제적 공조, 사법당국에 의한 탈취아동의 반환명령(준거법, 관할, 집행, 아동반환거부사유, 언어 등)

4. 이행법률 소개

- 『헤이그 국제아동탈취협약 이행에 관한 법률』('12. 12. 제정, '13. 3. 시행)
- 협약의 국내적 이행을 위한 중앙당국을 법무부로 지정
- 아동반환 지원 절차 마련, 중앙당국으로서 아동반환 지원을 위하여 법무부에 포괄적 권한 부여(타 국가기관의 협조 의무)

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

4

II. 국제아동탈취사건의 일반적인 처리 절차

1. 사건의 발생(협약적용대상사건)

- ✓ 16세 미만 아동
- ✓ 상거소가 있던 나라에서 다른 국가로 탈취
- ✓ 두 나라 사이에 협약이 발효되어 있을 것
- ✓ 탈취로 인하여 부모 등의 양육권 또는 면접교섭권이 침해되었을 것




2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

5

II. 국제아동탈취사건의 일반적인 처리 절차

2. 사건 처리 절차




2016-07-27

III. 국제아동탈취사건에서 한국 중앙당국의 역할

1. 아동이 다른 나라에서 한국으로 탈취된 경우(Incoming)

• <사례>



- 상거소국의 중앙당국에서 아동반환 신청서 및 증거 전달 받음
- 협약이 적용되는지 판단
- 아동 소재 파악
- 자발적 반환 권고
- 재탈취 방지로 잠정적 보호조치
- 한국 법원에 직접 소를 제기하거나 양육자가 소를 제기할 수 있도록 지원
- 아동반환 결정의 집행 지원, 아동의 출국절차 지원

2016-07-27


Ministry of Justice, Republic of Korea

7

III. 국제아동탈취사건에서 한국 중앙당국의 역할

2. 아동이 한국에서 다른 나라로 탈취된 경우(Outgoing)

• <사례>



- 협약 적용 가능한지 파악
- 탈취국에서 아동반환을 위해 필요한 절차 확인
- 탈취국 중앙당국과 지속적으로 연락 교환
- 필요한 신청서, 증거서류 준비하여 제출
- 대한민국 법제도에 대한 설명 및 공식적 확인, 법률적 의견 제공

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

8

IV. 구체적 사례

사례1

• <사례>



✓ 부부생활 악화되자 남편의 동의 없이 자를 데리고 호주로 간 뒤 연락 두절

- 협약 적용 가능한 사안이라고 판단
- 한국에서는 부모가 공동으로 양육권을 행사하여야 하므로 부부 중 한명이 일방적으로 자녀의 거소를 지정함은 불법
- 호주 중앙당국에 필요한 서류 접수 및 잠정조치 취해줄 것을 신청
- 현재 잠정조치는 인용되어 출국이 금지된 상황이며 법원에 아동반환사건 계속 중

2016-07-27


Ministry of Justice, Republic of Korea

9

IV. 구체적 사례

사례2

• <사례>



✓ 부부생활 악화되자 부인의 동의 없이 자를 데리고 한국으로 입국한 뒤 한국에서 이혼소송 제기

- 일본 중앙당국에서 연락을 받고 아동의 국내입국사실 확인
- 아동 소재 파악 후 아동이 남편의 지배 하에 있음을 확인
- 법원에 이혼소송 및 양육권 관련 소송 중단 요청
- 부인이 한국법원에 아동반환의 소재기를 돕고 변호사 소개 및 정보 제공
- 아동반환 결정 후 아동의 출국을 위해 외교부 협의 아래 긴급여권 발급
- 아동이 무사히 일본으로 귀국

2016-07-27

Ministry of Justice, Republic of Korea

10

V. 결 론

- 협약 가입 및 이행법률의 시행으로 아동 인권의 보호 기반 마련
- 국제결혼에서의 아동탈취문제 뿐만 아니라 내국인 간의 결혼에서 국외로 아동을 탈취하여 친권 남용에 대한 제재를 회피하는 관행 억제
- 협약의 자세한 내용은 HCCH 공식 홈페이지 참조(www.hcch.net)



감사합니다

Thank you

Монгол улсын гадаад худалдааны эрх зүйн
зохицуулалтын онцлог, цаашдын хөгжлийн чиг
хандлага
Монгол улсын гадаад худалдааны эрх зүйн
зохицуулалтын онцлог, цаашдын хөгжлийн чиг
хандлага
Монгол улсын гадаад худалдааны эрх зүйн
зохицуулалтын онцлог, цаашдын хөгжлийн чиг
хандлага
Монгол улсын гадаад худалдааны эрх зүйн
зохицуулалтын онцлог, цаашдын хөгжлийн чиг
хандлага

Илтгэгч: Ахлах багш М.Уянга (МУИС ХЗС)

Баллаа: М. Uyanga профессор (Монгол улсын улсын)

Хэлэлцүүлэгч: Доктор И Санму (Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэн)

Толон: Исанмо профессор (Хангук улсын улсын)

Монгол улсын гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтын онцлог, цаашдын хөгжлийн чиг хандлага

Илтгэгч: ХЗС-ийн ахлах багш М.Уянга

2016 оны 7 дугаар сарын 23 Улаанбаатар хот

Түлхүүр үг:

Гадаад худалдаа, Дэлхийн худалдааны байгууллага, гадаад худалдааны харилцаа, гадаад худалдааны бодлого, тарифын зохицуулалт, тарифын бус зохицуулалт, дотоодын зах зээлийг хамгаалах, Монгол улсын гадаад худалдааны эрх зүй, Гаалийн эрх зүй

Товч агуулга:

Монгол улсын гадаад худалдааны эрх зүйн зохицуулалт нь бусад орныхоос өвөрмөц байдлаараа ялгаатай юм. Социалист худалдааны эрх зүйн зохицуулалтаас зах зээлийн эдийн засагт тулгуурласан гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтыг 1990-д оноос хойш маш богино хугацаанд бий болгох нь амаргүй байлаа. Монгол улсын гадаад худалдааны бодлого 1990-д оноос хойш хэрхэн хөгжиж ирсэн болон эрх зүйн зохицуулалтын онцлог, хөгжлийн чиг хандлагийг энэхүү илтгэлд товч танилцуулах болно. Мөн Монгол улсын гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтын дутагдалтай та болон цаашид анхаарах асуудлыг хөндөнө. Монгол улс нь 1990-д оноос эхлэн илүү гадаад худалдааг чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлж ирсэн бол 2000 оноос хойш үндэсний үйлдвэрийг дэмжих бодлого болон гадаад худалдааг хязгаарлах хандлагатайгаар эрх зүйн зохицуулалтыг хийж ирсэн юм. Энэ нөхцөлд гадаад худалдааны эрх зүй нь хэр оновчтой байгаа, олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрхэн нийцэж байгаа талаар зарим нэг саналыг дэвшүүлсэн байгаа.

1. Танилцуулга

Өнгөрсөн зууны 1980-аад оны төгсгөл гэхэд манай орны гадаад эдийн засгийн харилцаа социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдсэн тогтолцоо буюу Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (цаашид

ЭЗХТЗ гэх)-ийн хүрээнд явагдаж байсан юм. ЗХУ, Зүүн Европын орнууд, Монгол, Вьетнам, Куб зэрэг орнуудыг нэгтгэж байсан тус зөвлөлийн хүрээнд гишүүн улсуудын хоорондын худалдааг 5 жилийн төлөвлөгөөний үндсэн дээр, төрийн тусгай журмууд, тооцооны аргыг ашиглан зохицуулдаг байжээ¹⁾. Эдгээр улсад өмч зөвхөн улсын болон нийгмийн гэсэн хоёр хэлбэрээр зөвшөөрөгдсөн байсантай уялдаатайгаар гадаад худалдаа төрийн бүрэн эрх мэдэлд бүрэн төвлөрч, хувийн хэвшлийнх гэсэн ойлголт төдийлөн байгаагүй юм. Ингэхдээ ЭЗХТЗ нь гадаад худалдаа, тооцоонд зөвхөн тусгай валют болох шилжих рублийг ашиглаж, бараа, бүтээгдэхүүний үнийг төвлөрсөн байдлаар төрөөс зохицуулдаг байсан юм²⁾.

Монгол Улсын гадаад худалдааны дийлэнх нь тус Зөвлөлөөр дамждаг байсан тул манай улс дэлхийн зах зээлд бүрэн ороогүй, бүх худалдааг зөвхөн төрийн байгууллагууд монопольт эрхээр хатуу тогтоосон үнээр хийж³⁾, хувийн хэвшил гадаад худалдааг эрхлэх бололцоогүй байлаа⁴⁾.

Гэвч 1991 онд социалист гэгдэж байсан улс орнууд бараг бүгд эдийн засгийн зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэнтэй уялдаатайгаар ЭЗХТЗ татан буугдаж, Монголын ард түмний өмнө улс орныхоо хөгжлийн асуудлыг, түүний дотор гадаад, дотоод худалдаагаа хөгжүүлэх, дэлхийн зах зээлд хэрхэн нэгдэн орох өөрийн гэсэн арга замыг сонгон олох зайлшгүй шаардлага тулгарсан билээ. Хууль тогтоогчид өмч гэдэг нь үндсэндээ ард түмний өмч гэсэн ойлголтыг бий болгосон гэжээ⁵⁾.

Үндсэн хуулиар өмчийн эрхийг хамгаалсан нь зах зээлийн эдийн засгийн элементийн үндсэн хэсэг болох хувийн өмчийн институтыг Монгол улсад хүлээн зөвшөөрсний илэрхийлэл болсон юм.

1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн⁶⁾ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс

1) Галсандорж Д., Гомбожав Д., Монголын гадаад худалдаа, 90, Уб хот, 2012 он, 45-50 дахь тал

2) Мөн тэнд

3) Монголын эдийн засаг, нийгэм 1991 онд, Монгол Улсын Статистикийн газарв Ингэхдээ, зах зээлийн орнууд болох Англитай дөнгөж 3.5 сая доллар, Япон улстай 9.4 сая долларын худалдаа хийсэн байна. (С.Чулуун, Монголын худалдаа, эдийн засгийн товчоон, 2009 он)

4) Жишээ нь, 1985 онд Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 1784 сая ам доллар байхад, түүнийхээ дийлэнх (83%) буюу 1482 сая ам долларын худалдааг ЗХУ-тай хийж, 34 сая долларын худалдааг Польш, 33 сая долларын худалдааг Румын, 27 сая долларын худалдааг Унгар, 60 сая долларын худалдааг Чехословак зэрэг социалист орнуудтай хийсэн байна

5)

6) Төрийн мэдээлэл, Уб хот, 1992 он, Дугаар 1

дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна“ гэж зааснаар эдийн засгийн салбарын нэг гол бүрэлдэхүүн хэсэг болох гадаад худалдааг улс төр, эдийн засаг, нийгмийн шинэ нөхцөл байдалтай нягтаар уялдуулан хөгжүүлэх төрийн бодлого, үйл ажиллагааны эрх зүйн үндэс тавигдсан юм.

Энэ үеэс эхлэн Монгол улс гадаад худалдааныхаа салбарт зах зээлийн харилцааг эрхэмлэх бодлогыг хэрэгжүүлж, үүнийгээ холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулж ирсэн байна. Ингэхдээ гол анхаарлаа дэлхийн зах зээлд хэрхэн нэвтрэх, шинээр үүсч байсан хувийн хэвшил, улсын өмчийн үйлдвэрүүд гадаад худалдаанд ямар хэлбэр, арга замаар оролцох, энэ салбарт өөрийн гэсэн төрийн бодлоготой болох, түүндээ үндэслэн гадаад худалдааны хуучин тогтолцоог хэрхэн шинэчлэх, эрх зүйн орчныг ямар зохицуулалттайгаар бий болгох зэрэг асуудалд төвлөрүүлсэн байна⁷⁾.

Юуны өмнө, гадаад худалдааны гол зарчмын хувьд 1992 онд олон хэлбэрийн өмчийг хүлээн зөвшөөрсөн тухай Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн дагуу төрийн болон хувийн өмчийн аж ахуйн нэгж болон хувь этгээдийн аль аль нь Монгол улсын хуульд заасан хүрээнд бусад улсад бараа, бүтээгдэхүүн экспортлох, гадаадаас тэдгээрийг импортлон оруулж ирэх өргөн бололцоотой болгосон байна. Өөрөөр хэлвэл, энэ нь дээр дурдсан гадаад худалдааны төрийн монополийг бүрмөсөн халсан хэрэг юм. Ийнхүү, гадаад худалдааг чөлөөтэй болгосон нь энэ салбарт шинэ бодлого хэрэгжүүлж эхэлсэнийг гэрчилсэн анхны хамгийн том зарчмын алхам байлаа. Нөгөө талаасаа Монгол улс нь зах зээлийн эдийн засгийн гадаад худалдааны зохицуулалт хийж байсан туршлагагүй байсан тул цоо шинэ эрх зүйн тогтолцоог бий болгох нь амаргүй байлаа. Иймд энэхүү илтгэлийн дараах хэсгүүдэд Монгол улс нь 1990-д оноос эхэлсэн эрх зүйн шинэчлэлийн үед гадаад худалдааны бодлого, эрх зүйн үндсээ хэрхэн тогтоож ирсэн, гадаад худалдааны хязгаарлалтын ямар аргууд ямар үндэслэлээр тогтоож байсныг танилцуулья.

7) Энэ талаар Сэсээр Г. Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал, Улаанбаатар хот, 2000 он, 188 дахь тал

2. Гадаад худалдааны бодлогын үндэс ба зохицуулалтын хагжлийн чиг хандлага

1992 онд шинэ Үндсэн хуулийг баталсны дараа гадаад худалдааг дэмжих, ялангуяа манай улсын хувьд экспортыг нэмэгдүүлэхэд чөлөөт худалдааны үзэл баримтлалыг үндэслэл болгон, улмаар ДХБ-д гишүүнээр элсэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн байна. Энэ хүрээнд Монгол улсын дотоодын хууль тогтоомжийг ДХБ-ын гэрээ, бусад МУ-ын олон улсын гэрээ, дэлхий даяар баримтлаж байсан олон улсын худалдааны нийтлэг шаардлагад нийцүүлэн өөрчлөх чухал алхамууд хийгдсэн байдаг.

ДХБ-д элсэхтэйгээ холбогдуулан Монгол Улс 1996 онд Гаалийн тухай хууль, Гаалийн тарифын тухай хууль, Зарим бараа бүтээгдэхүүний экспортын тухай хууль, улмаар 1998 онд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг тус тус батлаж, импортын лицензийн тоог 4000-аас 300 болтол нь цөөрүүлж, гадаад худалдааг нээлттэй болгох талаар тууштай бодлого хэрэгжүүлж эхэлсэн байна⁸⁾. ДХБ-д элссэний дараахан гэхэд Монгол Улсын гадаад худалдааны эргэлт нэмэгдэж социализмын үеийн гадаад худалдааны эргэлтээс 3 дахин их болсон байдаг.

Монгол Улсын гадаад худалдаа ийнхүү харьцангуй богино хугацаанд үсрэнгүй өсөж, улс орны хөгжлийн томоохон хүчин зүйл болж, дэлхийн зах зээл, Монголын эдийн засгийг холбох чухал гүүр болсон байна.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойших 25 гаруй жилд манай улсын гадаад худалдааны эрх зүйн зохицуулалт мөн өөрчлөгдөж, олон улсын зээлд нэвтрэх эрх зүйн орчин үндсэндээ бүрэлдэн, чөлөөт худалдааны сонгодог горим, зарчмыг баримталсан тогтолцоонд шилжих, дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээгээ бүрэн хангах боломж улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь дэлхийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага, чөлөөт худалдааны нийтлэг зарчимд тулгуурласан харилцан ашигтай гадаад, дотоод худалдааг өөрийн орны онцлогт тохируулан хөгжүүлэх бодлогыг Монгол Улс тууштай баримталж байгаагийн үр дүн юм.

Нөгөө талаасаа манай улс ДХБ-ын гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг амлалтынхаа хүрээнд дотоодын зах зээлээ гаалийн тарифын болон тарифын бус бусад зохицуулалтаар,

8) НҮБХХ, Гадаад худалдаа ба хүний хөгжил, 2008

түүний дотор эрүүл ахуйн болон техникийн гэсэн шаардлагаар л хамгаалах болсон байна. Аливаа улс ДХБ-д гишүүнээр элссэнээр аль болох худалдааг чөлөөлөх бодлого хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг боловч үүнийхээ зэрэгцээ, дотоодын зах зээл, үндэсний үйлдвэрлэлээ гадаад худалдааны сөрөг үр дагавараас хамгаалах эрхтэй байдаг. Энэ нь бүр дундад зууны үеэс дэлхийн ихэнх улс орнууд үндэсний үйлдвэрлэгчээ дэмжих зорилгоор хэрэгжүүлж байсан гадаад худалдааны протекционизмын үзэл баримтлал уламжлагдан хадгалагдаж үлдсэн юм⁹⁾.

Монгол Улс 1990-д оноос хойших улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөө эрхзүйн тогтолцооны шинэчлэлээр эхэлсэн нь зөв зүйтэй алхам байсан бөгөөд тодорхой үр дүн авчирсан юм. Үүний дотор, олон жилийн турш хаалттай байсан гадаад худалдааны салбарт зарчмын өөрчлөлт оруулах, дэлхийн нийтийн хөгжлийн хандлагыг дагаж илүү нээлттэй болгохыг эрхэмлэх, энэ салбарт олон улсын худалдааны нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахин биелүүлэх, бүх улстай тэгш эрхтэйгээр худалдаа хийх бололцоог олгосон эрх зүйн орчныг цоо шинээр бий болгох хэрэгтэй болсон юм.

Монгол Улсын Их Хурал 1994 онд Монгол улсын гадаад бодлогын анхны үзэл баримтлалыг баталж, үүндээ эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх зорилтыг тусгасан байна. 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалын эдийн засгийн гадаад харилцааны бодлого гэсэн 3 дугаар хэсэгт Монгол Улсын гадаад эдийн засгийн хөгжүүлэхэд баримтлах үндсэн чиглэл, язгуур эрх ашгийг заасан байв. Ингэхдээ үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, бусад улсаас хараат бус байх, аль нэг улсын шахалт дарамтаас чухал байхыг эрхэмлэнэ гэжээ.

Цаашлаад 1991 онд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, 1994 онд Азийн хөгжлийн банк, 1997 онд ДАБ-д гишүүнээр элсэн явдал нь манай улсын гадаад худалдааны хөгжил, эрх зүйн зохицуулалтын хувьд шинэ үеийн эхлэлийг тавьсан юм.

1990-ээд оноос хойш гадаад худалдааны хөгжлийн чиг хандлага нь дотоодын зах зээлийн хэрэгцээ, түүний бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хангах, импортыг дэмжих бодлогыг түлхүү баримтлах явдал байжээ. Энэхүү бодлогодоо тулгуурлан эрх зүйн зохицуулалт нь чөлөөт худалдааг дэмжих талаасаа хийгдэж байсан гэж дүгнэж болохоор байдаг бөгөөд энэ нь мөн ДХБ-д гишүүнээр элсэх шийдвэрийн урьдчилсан нөхцөл болсон байна.

9) Энэ талаар S.Lester and B.Mercurio., World trade law, Text, materials and commentary., Oxford and Portland Oregon., 2008, pp. pp.20-43

Үүнтэй холбоотойгоор Аж ахуйн нэгжийн татварын тухай хууль (1992), Банкны тухай хууль (1996), Татварын ерөнхий хууль (1993), Онцгой албан татварын тухай хууль (1993), Экспортын гаалийн татварын тухай хууль (1996), Гадаад худалдааны арбитрын тухай хууль (1995), Тэмдэгтийн хураамжийн тухай хууль (1993) болон Патентийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

2000-д оноос хойш эдийн засгийн өсөлт тогтвортой болж, үндэсний нөөц баялаг нэмэгдэн, тодорхой салбаруудад үндэсний үйлдвэрлэл, эрчимтэй хөгжиж эхэлсэнтэй уялдан гадаад худалдааны бодлогын чиг хандлагад өөрчлөлт орж, дотоодын зах зээл, үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах зайлшгүй шаардлага бий болж, Засгийн газраас энэ талын зарим нэг арга хэмжээг авч эхэлсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны бодлогыг оновчтой болгох замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, импортын зохицуулалтыг зохистой болгох, экспортыг нэмэгдүүлэх, улмаар гадаад худалдааны тэнцлийн алдагдлыг бууруулах зэрэг том зорилтуудыг олон улсын худалдаанд оролцсоноор манай улсад бий болсон давуу талаа бүрэн дүүрэн ашиглах замаар л хэрэгжүүлэх бололцоотой юм гэж манай зарим судлаач тэмдэглэсэн байдаг¹⁰).

Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт гадны импортыг нэмэгдүүлэх гэхээсээ илүүтэйгээр экспортыг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын зах зээлийг хамгаалах асуудлуудыг түлхүү тусгагдаж эхэлсэн байна. Энэ нь 2000-аад оны сүүлчээс Монгол улсын гадаад худалдааны бодлого нь тодорхой чиг хандлагатайгаар өөрчлөгдөж 1990-д оны эхэн үеийн зөвхөн чөлөөт худалдааг дэмжих агуулгаасаа бага зэргээр холдон үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн байдалтай болж, үүнтэй холбоотой төлөвлөгөөг боловсруулж эхэлсэн юм.

Гэхдээ Монгол улсад гадаад худалдааны харилцааг тусгайлан зохицуулаагүй бөгөөд илүү бусад хуулиар тухайлбал, 2002 оны Монгол Улсын Иргэний хууль¹¹), 2008 онд Гаалийн тухай хууль¹²), 2008 оны Гаалийн татвар, гаалийн тарифын тухай хууль¹³), 1996 оны Зарим

10) Д. Галсадорж, Д.Гомбожав, Монголын гадаад худалдаа 90, УБ хот 2012 он, 115 дахь тал

11) Төрийн мэдээлэл, Дугаар 7, УБ хот, 2002 он

бараа бүтээгдэхүүний экспортын татварын тухай хууль, 2015 оны Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2015 оны Чөлөөт бүсийн тухай хууль болон бусад хуулиар гадаад худалдааны харилцаанд хамаарах нэлээдгүй тооны харилцааг зохицуулсан байдаг. Гэхдээ эдгээрээр голчлон гадаад худалдааны зарим асуудал, тухайлбал бараа бүтээгдэхүүний импорт экспорт, тэдгээрт ногдуулах тарифын тогтолцоо, гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн хэрэгслийг зохицуулж байгаа юм. Тухайлбал, Гаалийн татвар болон тарифын хуулиар импортын бараа бүтээгдэхүүнийг Монгол улсын хилээр нэвтрэн орох, Монгол улсын хилээр экспортлох журам, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар Монгол улсын үйлчилгээний зах зээлд гадаадын үйлчилгээ үзүүлэгч нэвтрэн орох ерөнхий журам, Татварын хуулиар Гадаадын худалдаа эрхлэгч, хөрөнгө оруулагчдын төлөх татвар, татвараас хөнгөлөх, чөлөөлөх үндэслэлийг, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулиар үндсэндээ зохицуулсан байна.

Анх 1991 онд Улсын Бага хурлаар Гаалийн тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулиар Гаалийн хяналт шалгалт, гаалийн албан татвар, хураамж, гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат агуулах, Монгол улсын гаалийн байгууллагын эрх хэмжээг зааж өгсөн байв.

2000 оноос хойш хөнгөн үйлдвэр, үйлчилгээ, уул уурхайн салбарт гадаад болон дотоодын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж 2012 он хүртэл эдийн засаг тогтвортой өссөн юм¹⁴⁾. Нөгөө талаасаа Монгол Улсын дэд бүтэц сайн хөгжөөгүй, өргөн хэрэглээний бараа төдийгүй түүхий эд нийлүүлэлтэд гадаадын импорт давамгайлсаар байсан бөгөөд экспортын хувьд ч түүхий эд нийлүүлэх байдал зонхилж гадаад улсын буюу БНХАУ-ын зах зээлээс хамааралтай байдал хадгалагдсаар ирсэн юм.

2008-аас 2012 онд Монголын эдийн засгийн өсөлт үргэлжилж, дотоодын аж үйлдвэрийг хөгжүүлэх¹⁵⁾ зорилгыг үе үеийн Засгийн газрууд тавьсан тул, дотоодын зах зээлийг хамгаалж дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлого зонхилж эхэлсэн. 2008 оноос хойш Монгол улсын гадаад худалдааны бодлогод хэд хэдэн тодотгол хийгдэж тус улс нь гадаад худалдааг хөгжүүлэхийн зэрэгцээ үндэсний үйлдвэрлэл, экспортыг дэмжих, гадаадын импортоос хэт хамааралтай байхыг халахыг илүүтэйгээр эрмэлзэх болжээ.

12) Төрийн мэдээлэл, Дугаар, У6 хот, 2002 он

13) Төрийн мэдээлэл, Дугаар 23, У6 хот, 2008 он

14) Энэ талаар Д.Галсандож, Д.Гомбожав, Монголын гадаад худалдаа 90, У6 хот, 2012 он, 72-75 дахь тал

15) Монгол Улсын үйлдвэржүүлэлтийн бодлого, Засгийн газар, 2009 он.

Нөгөө талаас энэ асуудлыг өмнө үйлчилж байсан Гаалийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, Татварын багц хуулиуд, Хөрөнгө оруулалтын хуулиар хэвээр л зохицуулсаар байв. Гадаад худалдааны бодлогыг илүү Засгийн газар болон УИХ-аас баталсан бодлогын эрх зүйн баримт бичгээр зохицуулсаар ирсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал 2011 онд шинэчлэгдэн батлагдсан¹⁶⁾ бөгөөд түүнд улсын эдийн засгийн аюулгүй байдлыг чухалчилсан байна. 2011 оны Монгол улсын Их хурлын 10 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан уг үзэл баримтлалын “Эдийн засгийн гадаад харилцааны бодлого” гэсэн 3 дахь хэсэгт Гадаад эдийн засгийн харилцааг хэрэгжүүлэхэд Монгол улсын баримтлах үндсэн зарчим, зорилгыг заасан байв. Үүний дотор гадаад эдийн засгийн харилцааг хөгжүүлэхдээ үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахыг эрхэмлэнэ гэж заасан байна.

Ингэхдээ “Гадаад улс орнуудтай эдийн засгийн харилцаа хөгжүүлэх, хамтран ажиллахдаа эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх, аль нэг орноос хэт хараат байдалд орохоос сэрэмжлэхийн хамт олон улсын аж ахуйн харилцааны зарчим, хэм хэмжээг баримтлан эрх тэгш, харилцан ашигтай байх, хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, улс төрийн болон бусад даралт шахалтад автахгүй байх нөхцөл бүрдүүлэх бодлого явуулна” гэсэн байдаг. Мөн энэ үзэл баримтлалын 20.1-д “1/ эдийн засгийн гадаад харилцааны үйл ажиллагааг улс орны эдийн засгийн чадавхи, экспортын чиглэлийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх, эдийн засгийн дэд бүтцийг бүрэлдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглүүлэх болно”¹⁷⁾ гэжээ.

Эдгээрээс харахад манай улс нь гадаад харилцааны бодлогодоо чөлөөт худалдааны нэлээд асуудлыг тодорхой болгосон байна. Үүнд, гадаад худалдааг чөлөөлөхдөө өөрийн үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах. Үүний тулд, нэгдүгээрт, харилцан ашигтай гадаад худалдааг эрхлэх, хоёрдугаарт, гадны хэт их импортоос хамаарахгүй байх, гуравдугаарт, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Эдгээрийн дотроос гадаад худалдааны хэмжээ нэмэгдэх болсноор түүний эрх зүйн

16) Монгол улсын Их хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан

17) мөн тэнд

зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, ялангуяа, дотоодын зах зээлийг хамгаалах эрх зүйн хэм хэмжээг бий болгох шаардлага улам бүр нэмэгдсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

3. Монгол улсын гадаад худалдааг хязгаарлах ба дотоодын зах зээлийг хамгаалах талаар авч буй арга хэмжээ, практик

Бараа, бүтээгдэхүүний импортын тарифын хязгаарлалт

Монгол Улсын барааны экспорт болон импортын үйл ажиллагааг зохицуулж буй гол хууль нь Гаалийн тухай болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болох тухай өмнө өгүүлсэн. Эдгээр хууль анх 1996 онд батлагдсан бөгөөд 2008 онд шинэчлэгдэн өмнөх хууль нь хүчингүй болсон байна. Ингэхдээ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд гадаад худалдааг хязгаарлах, гадны импортын шудрага бус өрсөлдөөнөөс дотоодын зах зээлийг хамгаалахтай буюу гадаад худалдааны хязгаарлалттай холбогдол бүхий зарим нэг зүйл, заалтыг тусгасан байдаг. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Гаалийн тухай хуулийн холбогддох заалтуудын хамт импортын барааны хувьд Монгол улсын импортын тарифын бодлогын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж байгаа юм. Уг хууль нь гаалийн тарифыг ногдуулах зарчмыг тогтоож, түүний төрөл, ногдуулах, хураах, төлбөр авах, хийх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг болно.

Монгол улс ДХБ-д нэгдэн орох тухай Протоколын дагуу импортын гаалийн татварын тарифын хэмжээ болон үйлчилгээний салбараар авах үүрэг амлалтыг тохирсон юм. Энэхүү тохиролцооны дагуу импортын гаалийн татварын ерөнхий түвшин 20 хувь байх, зарим бараанд, тухайлбал амьд мал, тэжээвэр шувуу, төрөл бүрийн самар, хиймэл утас, модон материал, мэдээлэл боловсруулах машин зэрэг барааны тарифыг 0-10 хувиар тогтоосон юм. Харин дотоодын үйлдвэрээ дэмжих, зах зээлээ хамгаалах үүднээс оёмол, сүлжмэл бараа, нэхий савхин эдлэл, хивс зэрэг барааны импортын барааны тарифыг 30 хувиар тогтоосон юм¹⁸⁾.

“Гаалийн тариф, гаалийн татварын тухай Монгол улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 1

18) Сэсээр Г.Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал, Уб хот, 2000 он

дүгээр хэсэгт: “Монгол Улсад экспортын болон импортын барааны гаалийн тарифыг хэрэглэх бөгөөд гаалийн тарифыг тогтоохдоо барааны код, нэр төрлийг Уялдуулсан системийн дагуу заана” гэж тэмдэглэсэн байна¹⁹⁾.

Гаалийн татварын хувь хэмжээ, ер нь импортын барааны татварыг зөвхөн хуулиар тогтоодог, энэ нь төрийн эрх мэдлийн чухал арга хэрэгсэл бөгөөд үүний зэрэгцээ уг татварын хувь хэмжээ нь тогтмол өөрчлөгдөж байдаг уян хатан шинж чанартай байдгаараа онцлог зүйл юм. Жишээлбэл, энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт заасны дагуу УИХ экспортын барааны гаалийн тариф болон импортын барааны нэн тааламжтай тарифыг шинэчлэн тогтоож болдог. Ер нь энэ хуулиар гаалийн тарифыг хэрхэн ногдуулах, гаалийн татвар тогтоох хэлбэр, гаалийн үнийг тодорхойлох суурь зарчмыг тогтоосон байдаг бөгөөд үүний дагуу Монгол Улс өнөөгийн байдлаар дэлхийн олон улсад нэн тааламжтай тарифын дагуу бараа импортлох эрхийг олгосон байдаг юм²⁰⁾

Уг хуульд заасны дагуу импортын тарифын хэмжээг тогтоох эрх нь хууль тогтоох засаглалын дээд байгууллагад буюу УИХ-д хадгалагдаж байгаа бөгөөд энэ нь өмнө нь үйлчилж байсан 1996 оны Гаалийн тарифын тухай хуулийн зохицуулалтаас ихээхэн ялгаатай зүйл юм. 1996 оны Гаалийн тарифын хуулинд түүний 4.7-д заасны дагуу Засгийн газар нь УИХ-аас олгогдсон эрх хэмжээний хүрээнд гаалийн тарифыг өөрчлөх эрхтэй байсан юм. Ингэхдээ энэ эрх хэмжээ нь Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, амлалтаар бас хязгаарлагддаг байсан болно.

2008 онд шинэчлэн батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн онцог зохицуулалт нь түүний 4 дүгээр зүйл юм. Энэ зүйлд заасны дагуу УИХ нь экспортын бараа, бүтээгдхүүний гаалийн тариф болон импортын бараанд нэн тааламжтай импортын тарифыг тогтоох эрхтэй болсон байна. Энэ талаар дээр мөн дурьдсан бөгөөд гол онцлог нь энэхүү нэн тааламжтай тарифыг Монгол улсын нэгдэн орсон ТХЕХ-ийн гишүүн орнууд, олон улсын гэрээний дагуу хөнгөлөлттэй тариф хэрэглэхээр харилцан тохиролцсон бусад улс, түүнчлэн нэн тааламжтай тариф хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн зарим нэг орны хувьд хэрэглэх болно гэж заасан явдал юм. Өөрөөр хэлвэл, зөвхөн Монгол Улстай адил ТХЕХ-д нэгдэн орсон орон,

19) Төрийн мэдээлэл. Дугаар № 23. УБ хот., 2008 он.

20) Монгол улсын Засгийн газрын тогтоол, Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2009 оны 4 дугаар сарын 1, Дугаар 93

эсвэл энэ хэлэлцээрийн хүрээнд харилцан тохиролцсон улсын хувьд л нэн тааламжтай тарифыг ногдуулах болно гэдгийг баталгаажуулсан байна. Үүнийг мөн эдгээр орныг багтаасан жагсаалтанд ороогүй орны хувьд илүү өндөр импортын татвар ногдуулж болно гэж ойлгож болох юм.

Гаалийн тариф, гаалийн татварын хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан УИХ 1999 оноос хойш гаалийн татварын, түүний дотор гол нь импортын татварын хувь хэмжээг хэд хэдэн удаа шинэчлэн тогтоосон байдаг. Энэ асуудлаар батлагдсан тогтоолуудын дагуу ихэнх бараанд 5 хувийн импортын татвар ногдуулсаныг хэвээр үлдээж байсан боловч зарим хүнс, хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүнд улирлын шинж чанартай, тухайлбал 8 сарын 1-нээс 4 сарын 1 хүртэл хугацаанд ногоонд, гурилд 15 хувийн татвар ногдуулж байсан байдаг²¹⁾. Мөн зарим төрлийн бараанд “0” хувийн импортын татвар ногдуулахаар тогтоож байсан юм²²⁾.

Түүнчлэн 2000 оноос хойш зарим барааг импортын татвараас чөлөөлж байсан юм. Тухайлбал, Монгол Улс нэгдэн орсон олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөр болон ийм төрлийн гэрээний дагуу оруулж ирсэн бараа, тоног төхөөрөмж, мөн “Мянганы зам”-ыг барих зорилгоор импортлож байсан хүнд оврын машин механизм, нүүрс болон эрчим хүчний төслийн тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлж байсан байна²³⁾.

Эдгээрийн зэрэгцээ тухайн цаг үеийн гэсэн шаардлагаар зарим нэг бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх асуудлыг УИХ-аар хэлэлцэх явдал цөөнгүй гардаг байна.

Монгол Улс нь 1993 оны 1 дүгээр сард “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын Конвенци”-²⁴⁾д нэгдэн орсон юм. Монгол Улсын гаалийн тарифын тухай хууль, тогтоомжид заасны дагуу импортын тарифыг ердийн болон нэн тааламжтай гэж ангилдаг. Нэн тааламжтай тарифын хэмжээ нь ердийн тарифаас 2 дахин бага байдаг юм. Нэн тааламжтай тариф тогтоох улсын жагсаалтыг хэрхэн гаргах журмыг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасан байдаг болно.

Монгол Улс нь ТХЕХ-ийн²⁵⁾ 3 дугаар зүйлийн дагуу гадаад худалдаандаа үндэсний

21) Импортын барааны гаалийн татварын хувь хэмжээ тогтоох тухай УИХ-ын Тогтоол, Дугаар 27, 1999 он.

22) Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг багтаах тухай Монгол улсын Их Хурлын тогтоол, Дугаар 5, УБ хот, 1998 он, 2006 онд нэмэлт өөрчлөлт оруулсан

23) Гаалийн тариф, татварын тухай хуулийн 38.1.5, 38.1.14 дүгээр зүйл

24) Гаалийн холбогдолтой олон улсын конвенцийн эмхтгэл, УБ хот, 2003 он

дэглэмийн зарчмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдгийг тэмдэглэх хэрэгтэй юм. Энэ зарчмын хамгийн гол агуулга нь тухайн зах зээлд гадаадын болон дотоодын худалдаа эрхлэгчид адил тэгш эрх эдлэх нөхцлийг бүрдүүлэх асуудал юм. Өөрөөр хэлбэл, гадаад улсаас импортлон оруулж буй бараа, бүтээгдэхүүн болон үндэсний хэмжээнд үйлдвэрлэсэн барааны хувьд дотоодын зах зээлд нэвтрэн ороод ирсэн нөхцөлд борлуулалт, хэрэглээний ижил дэглэм тогтоогдсон байх гэсэн утгатай юм. Энэхүү зарчмыг мөн гадаадын болон дотоодын үйлчилгээний худалдаа, үндэсний барааны тэмдэг, зохиогчийн эрх, патентийн хувьд ч баримтлах ёстой болно.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай мөн Онцгой албан татварын тухай хуульд онцгой албан татварын талаарх зохицуулалт тусгагдсан байдаг. Онцгой албан татварыг ихэнх оронд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй болон тансаг хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, мөрийтэй тоглоомтой холбоотой зүйлсэд ногдуулдаг байна. Монгол Улсын Онцгой албан татварын тухай хуульд заасны дагуу энэ төрлийн татварыг Монгол Улсад үйлдвэрлэн дотоодын зах зээлд борлуулж байгаа болон импортын бараа, бүтээгдэхүүнд аль алинд нь ногдуулж болох юм. Ингэхдээ энэ албан татварыг Монгол Улсад тоо ширхэгээс, эсвэл барааны үнийн хувиар тооцон тогтоодог болно. Харин манай улсын хууль, тогтоомжоор экспортын бараанд онцгой албан татвар ногдуулдаггүй байна. 2006 онд Онцгой албан татварын тухай хууль шинэчлэн батлагдсан байдаг.

Ингэхдээ өмнө үйлчилж байсан Онцгой албан татварын тухай хуулиас ялгаатай нь шинэчилсэн хуулиар дотоодын болон импортын барааны хувьд ижил татвар ногдуулах болсон байна. Тухайлбал өмнөх хуулиар дотоодын согтууруулах ундаанд хувиар тооцож 85 хувийн онцгой албан татвар ногдуулдаг байсан бол импортоор оруулж ирсэн согтууруулах ундаанд литр тус бүрт 7 ам.долларын татвар ногдуулдаг байсан байна²⁵).

Гадаад худалдаа эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага бараа, бүтээгдэхүүн импортоор оруулах болон экспортод гаргах үедээ гаальд тодорхой хэмжээний албан татвар, хураамж төлдөг. Эдгээр албан татвар, хураамжын хэмжээ нь гаалийн үнэ, тоо хэмжээ, татварын төрөл, хэлбэр, тарифын хувь хэмжээ зэргээс хамаарч өөр өөр байдаг болно.

25) Уругвайн хэлэлцүүлгийн үр дүн, баримт бичгийн эмхтгэл, Уб хот, 2000 он, Төрийн мэдээлэл, Тусгай дугаар, Боть 7, 2007 он

26) 2006 оны Онцгой албан татварын тухай хууль

Бараа, бүтээгдэхүүний импортын тарифын бус хязгаарлалт

Монгол улс нь ДХБ-д элсэн орохдоо импорт болон экспортыг хязгаарласан арга хэмжээ, эсвэл лицензийн гэх мэт бусад шаардлагыг хэрэглэхдээ ДХБ-ын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэх үүргийг хүлээсэн байдаг²⁷⁾. Мөн Засгийн газар ДХБ-ын гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хэм, хэмжээний дагуу тодорхойлоогүй тарифын бус аливаа арга хэмжээ, түүний дотор элдэв хориг, квот тогтоох, янз бүрийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авахыг шаардахгүй байх үүрэг хүлээсэн болно. ТХЕХ-ийн 11 дүгээр зүйлийн дагуу импорт болон экспортыг хязгаарлах хууль ёсны арга хэрэгсэл нь зөвхөн татвар болон хураамж байна гэж тогтоосон байдаг²⁸⁾. Үүний зэрэгцээ энэ хэлэлцээрийн 18 дугаар зүйлд иргэдийнх нь амьжиргааны түвшин ихээхэн доогуур, эсвэл хөгжлийнхөө эхэн шатандаа байгаа орон өөрийн эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх нөхцлийг хангах зорилгоор дотоодын зах зээлээ хамгаалах болон импортыг хязгаарлах бусад арга хэмжээ авч болно гэж заасан байдаг юм.

ДХБ-ын гэрээнд заасны дагуу импортын болон экспортын зарим, бараа бүтээгдэхүүний хувьд тэдгээрийн үйлдвэрлэх эрх буюу тусгай зөвшөөрөл авахыг шаардсан заалтуудыг үндэснийхээ хууль, тогтоомжид нэлээд хэмжээгээр тусгасан байдаг. Энэ нь тус улсад хүн, амьтны эрүүл мэнд, ургамлын ургах, олшрох нөхцөл хийгээд эцсийн дүндээ хүний аюулгүй байдал, байгаль орчноо хамгаалах зорилгод манай улс ихээхэн анхаардаг болохын нэг илэрхийлэл юм. Жишээлбэл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу нэлээд олон үйл ажиллагааг явуулахын тулд тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг болно²⁹⁾.

Монгол улсын нутаг дэвсгэрт оруулахыг хориглосон бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоолоор баталсан байдаг бөгөөд үүнд бүх төрлийн этилийн спирт, мансууруулах бодисыг багтаасан байдаг юм³⁰⁾. 2002 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн Засгийн газрын тогтоолоор “Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодолсон барааны жагсаалт”, “Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын

27) ДХБ дахь Монгол улс, Албан ёсны баримт бичгийн эмхтгэл, Засвар өөрчлөлт оруулсан хоёр дахь хэвлэл, УБ х от, 2003 он

28) Уругвайн хэлэлцүүлгийн үр дүн, баримт бичгийн эмхтгэл, УБ хот, 2000 он

29) Төрийн мэдээлэл, Дугаар 6, УБ хот, 2001 он

30) Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай Монгол улсын Их Хурлын тогтоол, Дугаар 5, УБ хот, 1998 он, 2006 онд нэмэлт өөрчлөлт оруулсан

лиценз олгох журам” зэргийг 219 тоот тогтоолоор³¹⁾ баталсан байдаг бөгөөд ингэхдээ өмнө үйлчилж байсан 2001 оны 54 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон байна. Уг тогтоолоор энэ зохицуулалтанд хамрагдсан бараа, бүтээгдхүүнийг гаргах, оруулах гэж хоёр ангилсан бөгөөд лицензтэй оруулах, гаргах бараа, бүтээгдхүүнд онцгой хортой химийн бодис, зайлшгүй хяналтанд байх эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай эд эрхтэн, донорын цус, бичил биетний өсгөвөр, тэсрэх бодис, буу, зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл, техник, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл, мөн мал, ховор амьтан, эвэр, ураны буюу төмрийн хүдэр ба баяжмал, хүний эрхтэн, тэсрэх бодис, буу зэвсэг, урлагийн бүтээл, цуглуулгын зүйлс ба эртний үнэт ховор эд хэрэглэл зэрэг нэлээдгүй тооны зүйлсийг хамруулсан байдаг болно.

Бараа, бүтээгдэхүүний татаас. ДХБ-ын гэрээ хэлэлцээрийн дагуу, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 3 дугаар зүйлд зааснаар экспортонд гаргадаг бүтээгдэхүүнд татаас өгөхийг хориглосон байдаг.

1990-ээд оноос хойш буюу зах зээлээ нээлттэй болгосон үеэс аль болохоор гадаадын хөрөнгө оруулагчыг татах бодлогыг Монгол Улс хэрэгжүүлж эхэлсэн байна. Ингэхдээ гадаадын хөрөнгө оруулагчыг татах нэг гол арга хэрэгсэл нь татварын хөнгөлөлттэй дэглэм тогтоох явдал байсан юм. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулагчын дүрмийн санд оруулсан тоног төхөөрөмж нь гаалийн албан татвараас, хэрэв тэд экспортын чиглэлтэй үйл ажиллагаа эрхэлбэл тодорхой хугацаанд орлогын албан татвараас 50-100 хувь хүртэл чөлөөлөгдөж ирсэн байна³²⁾. Энэ нь экспортын татаасын арга хэрэглэж байгаа гэсэн үг юм.

Экспортын татварын зохицуулалт. Монгол улсад хэд хэдэн бараанд экспортын татвар ногдуулдаг. Зарим бараанд ногдуулах экспортын татварын хэмжээг тогтоох тухай хууль анх 1996 онд³³⁾ батлагдсан бөгөөд түүний дагуу малын түүхий эд, ноолуур болон мод, модон эдлэлд экспортын татвар ногдуулдаг болсон байна. Мансууруулах бодис болон химийн зүйл агуулж буй бүтээгдэхүүнийг экспортлохыг хориглосон байдаг. Түүнчлэн Монгол Улсад НҮБ-ын эдийн засгийн санкцийн арга хэмжээг хэрэгжүүлдэггүй, буу зэвсэг, тэсрэх бодис болон зарим эмийн бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнд экспортын лиценз авахыг шаарддаггүй болон сайн дураараа экспортоос татгалзах тухай гэрээг аливаа нэгэн улстай

31)

32) Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 1992 он, 7.6-р зүйл

33) Төрийн мэдээлэл, Дугаар ..., УБ хот, 1996 он

байгуулаагүй юм. Мөн экспортын барааны хувьд үнийн зохицуулалт тогтоогоогүй байгаа болно.

Манай оронд экспортын бараанд тавигдах стандарт болон техникийн шаардлагын талаар 2003 онд батлагдсан Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байлдыг хангах хууль тус тус үйлчилдэг. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв нь Засгийн газрын тохируулагч агентлаг бөгөөд хэмжил зүй, стандартчилалыг зохицуулах, удирдан зохион байгуулах үндсэн үүрэг хүлээдэг. Мөн энэ нь үндэсний стандартыг тогтоож, үндэсний болон гадаадын бүтээгдэхүүний стандартын тэмдэг олгодог байгуулага юм. Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв нь ДХБ-ын Техникийн саадын тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг манай улсад зохион байгуулж байгаа бөгөөд мөн Олон улсын стандартын байгууллагын гишүүн болно.

Монгол улс нь БНХАУ-тай Стандартчилал болон сертификатын талаар засгийн газар хоорондын хамтран ажиллах тухай гэрээг 1994 онд, ОХУ-тай бараа бүтээгдэхүүний импорт, экспортын чанарыг хангах талаар хамтран ажиллах тухай гэрээг 1996 онд тус тус байгуулсан байдаг.

Үйлчилгээний худалдааны импорт, экспортын эрх зүйн зохицуулалт. Бараа, бүтээгдэхүүний импорт, экспорттой адилаар үйлчилгээний худалдаа нь өнөө үед олон улсын худалдааны нэг үндсэн төрөл болж чадсан төдийгүй эргэлтийн хэмжээ, тухайн улсад үзүүлж буй эдийн засгийн үр нөлөөгөөр барааны худалдааны ач холбогдлоос илүү болоод байна. Өнөөдөр дэлхийн хамгийн 500 амжилттай компанийн дийлэнх хэсгийг үйлчилгээний салбарт ажиллаж байна³⁴).

Монгол улсад 1990-д оноос хойш гадаад худалдааны нээлттэй бодлогыг хэрэгжүүлэхдээ олон улсын барааны эргэлтийг чөлөөлөхийн зэрэгцээ олон улсын үйлчилгээний худалдааг чөлөөлөх бодлогыг мөн баримталж эхэлсэн юм.

Үйлчилгээний худалдааны нь өнөө үед Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн томоохон хэсэг болон өргөжиж байгаа бөгөөд энэ худалдааны зах зээл нь бараа, бүтээгдэхүүний худалдааны зах зээлээс илүүтэйгээр гадаадын өрсөлдөгчдийн хувьд хаалттай байж ирсэн байна.

34) Fortunes 500

Өнөөдөр Монгол улсад гадаад улсын үйлчилгээний худалдаатай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн баримт бичиг нь банкны үйл ажиллагааг зохицуулж буй багц хууль, татварын багц хууль болон гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хууль, тогтоомж, түүнчлэн бусад тодорхой салбарын үйлчилгээг зохицуулж буй хуулиуд юм. Эдгээрийн дотроос гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт тусгайлан авч үзэх ёстой анхаарал татсан асуудал болно.

1993 онд анх Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар хөрөнгө оруулалтын таатай эрх зүйн орчинг бүрдүүлэх, хөрөнгө оруулагч нарт үндэсний дэглэм олгох буюу Монгол улсын зах зээлд нэвтрэн орох, үндэсний үйлдвэрлэгч, нийлүүлэгчтэй тэгш эрх эдлэх талаар Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосон юм.

1990-д оны эхэн үед Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалтыг аль болох нэмэгдүүлэх бодлого баримтлаж байсан бол 2000-д оноос хойш иргэний нийгмийн хөдөлгөөн болон бусад эдийн засгийн үндэслэлээр гадаадын хөрөнгө оруулалтын бодлогод зарим нэгэн өөрчлөлтүүд орж эхэлсэн юм. Гадаадын хөрөнгө оруулагч нь манай улсад хуулиар хориглоогүй салбарт хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсөн байсан бөгөөд энэ нь чөлөөт худалдааны бодлогыг хэрэгжүүлж байсны илрэл байсан юм.

Гадаадын хөрөнгө оруулалт тогтвортойгоор нэмэгдэж байсан 2000-д оны сүүлээр уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтад төрөөс нэмэлт хяналт тогтоох, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор зарчмын шинжтэй хоёр хууль батлагдаж байсан юм. Жишээ нь 2012 онд батлагдсан “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтад зохицуулалт хийх тухай хууль”³⁵⁾ нь Гадаадын хөрөнгө оруулалтын салбарт зарчмын өөрчлөлтийг бий болгож, үндсэндээ гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол улсын зах зээлд нэвтрэх орох журамд хязгаарлалт бий болгосон юм. Тухайн хөрөнгө оруулалтыг хязгаарласан хуулиар уул уурхай, банк, санхүүгийн үйлчилгээ, харилцааны холбооны салбар дахь хөрөнгө оруулалтыг хязгаарлаж тус хуулийн 6.1 дүгээр зүйлд “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болох компанийн

35) Төрийн мэдээлэл, дугаар 41, Уб хот, 2013 он

хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувийг олж авах эрхтэй болох хэлцэл, тус зүйлийн 6.1.2-т гүйцэтгэх удирдлагын байгууллагыг дангаараа, хамтын гүйцэтгэх удирдах бүрэлдэхүүний олонхыг томилох болон төлөөлөх удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний олонхыг аливаа нөхцөлгүйгээр сонгох эрхтэй болох хэлцэл, 6.1.3-т удирдлагын шийдвэрт хориг тавих боломжтой зэрэг хэлцэлд төрөөс зөвшөөрөл авахыг заасан юм. Уг хууль батлагдсанаар уул уурхай, банк, харилцаа холбооны салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийхэд төрөөс хяналт тогтоох бодлого хэрэгжүүлсэн бөгөөд хуулийг хэрэгжүүлэх журам удаан хугацаанд батлагдаагүй байснаас болж дээрх салбарын гадаадын хөрөнгө оруулалт удааширч, цаашид 2014 оны байдлаар Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалт огцом буурсан юм³⁶⁾.

Хүн ам цөөтэй буюу 3 сая орчим хүн амтай бага зах зээлтэй манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдын хамгийн ихээр сонирхож байсан салбар нь экспортод чиглэсэн уул уурхайн салбар, үйлчилгээний салбарууд байсан юм. Хамгийн ихээр сонирхож байсан салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг шууд хязгаарласан бодлого хэрэгжүүлж, улмаар хууль тогтоомжийн зохицуулалт дутмаг байдлаас болж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг манай улсад байгуулах, шинээр хөрөнгө оруулалт хийх, хувьцаа шилжүүлэхтэй холбоотой хэлцэл хийх, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажил хүндрэлтэй байсан улмаас өнөөдрийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалт манай улсад эрс багассан байна.

Мөн түүнчлэн 2009 онд урт нэртэй хууль гэсэн нэрээр алдаршсан Гол мөрний урсац бүрэлдэх эх усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхийг газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль ³⁷⁾батлагдсан нь мөн энэ салбар дахь хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалтын эрхтэй холбоотогоор нэлээд олон асуудлыг үүсгэсэн юм. Өөрөөр хэлбэл үндэсний хөдөлгөөн, зарим төрийн бус байгууллагууд гадаадын хөрөнгө оруулагчид, нэн ялангуяа уул уурхайн салбарт явуулж буй байгаль орчинд хөнөөлтэй үйл ажиллагаа явуулсны төлөө байгаль орчныг хамгаалах, уул уурхайн үйл ажиллагааг явуулах холбогдох лицензийг цуцлахыг удаа дараа шаардаж, жагсаал, олон нийтийн цуглаан хийж байсан юм. Тус хууль батлагдсанаар гол мөрний эх, ойн сан бүхий

36) Монголын үндэсний статистикийн хорооны тайлан, 2015 он

37) Төрийн мэдээлэл, Дугаар 28, Уб хот, 2009 он

газарт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг зогсоох ажлыг эхлүүлж байсан түүхтэй. Энэ нөхцөлд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн лицензийг хурааж авахад төрөөс нөхөн төлбөр олгох асуудал тавигдсан билээ. Нөхөн төлбөрийн дүнгийн хэмжээн дээр Гадаадын хөрөнгө оруулагч болон төрийн эрх баригчид тохиролцоонд хүрч чадаагүй учраас уг хууль нь өнөөдөр хүртэл хэрэгжиж чадаагүй юм.

2013 оноос Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдалд зарим өөрчлөлт орж, инфляц нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбогдуулан гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлсэн юм. Улмаар 2013 оны 10 сард Хөрөнгө оруулалтын хууль³⁸⁾ шинээр батлагдаж, 2012 онд батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтад зохицуулалт хийх тухай хууль” хүчин төгөлдөр болсон юм. 2012 оны хуулиар хөрөнгө оруулалтыг хязгаарлах талаар зохицуулалтыг дутагдалтай байдлыг арилгах, хэтэрхий олон шат дараалалтай зөвшөөрлийг багасгах болон хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх зорилгоор тус хууль батлагдсан байсан гэж дүгнэж болох юм.

Тус шинээр батлагдсан хөрөнгө оруулалтын тухай хуульд ихэнх салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зах зээлд нэвтрэх орох нөхцлийг чөлөөлсөн боловч уул уурхай, банк санхүү, харилцаа холбооны салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийхэд төрөөс зөвшөөрөл авахыг шаардсан байна. Тухайлбал Хөрөнгө оруулалтын хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар уул уурхай, банк санхүү хэвлэл мэдээлэл харилцаа холбооны салбарт Монгол улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна гэсэн байна. Хөрөнгө оруулалтын тухай шинэ хуулиар төрийн өмчит гадаад хуулийн этгээд хөрөнгө оруулалт Монгол улсад хийж байгаа бол зөвшөөрөл авахаар заасан байгаа нь өмнөх 2012 оны Стратегийн салбарт хөрөнгө оруулалт хийх тухай хуульд заасны дагуу бүх гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 33 хувиас дээш бол зөвшөөрөл авах ёстой байсан гэсэн заалтаас ялгаатай зохицуулагджээ.

Үүнийг хууль тогтоомжоор өмнөх зохицуулалтын алдааг залруулах хөрөнгө оруулалтыг

38) Төрийн мэдээлэл, Дугаар 41, Уб хот, 2013 он

нарийн судалгаа, үндэслэлгүйгээр гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байдлыг дахиж давуулахгүй байх талаар хийсэн алхам гэж үзэж болохоор байгаа юм. Нөгөө талаасаа аливаа улс нь дотоодын зах зээлийн аль нэг салбараа гадаадын өрсөлдөгчдөөс хамгаалах нь бас тодорхой үндэслэлтэй байж болох юм. Өөрөөр хэлбэл өөрийн улсын стратегийн гэх объектыг хамгаалах шаардлага үүсч болох бөгөөд энэ тухайн улсын гадаад бодлогын үзэл баримтлалд зааснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын асуудал байж болно. Энэ нөхцөлд харин ямар салбараа гадаадын хөрөнгө оруулагчдаас хамгаалах, алийг нь чөлөөлөх, ийнхүү хамгаалж чөлөөлөх бодлогоо хэрэгжүүлэхдээ ямар хүрээнд хэрэгжүүлэхээ сайтар судлах ёстой байдгийг дээрх жишээ харуулсан юм.

Манай улсын хувьд хэдийгээр 1990-ээд оноос хойш импортын бараа, бүтээгдэхүүнд хөнгөлөлт үзүүлэх бодлогыг голчлон хэрэгжүүлж байсан ч дотоодын зах зээлийг хамгаалахад чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ бас авч, хуульчилсан болох нь судалгаанаас харагддаг юм. Энэ хандлага нь цаашид ч нэмэгдэх шинжтэй байна. Бараа, бүтээгдэхүүний импортын хувьд ийм хандлага 2000 оноос эхлэн илэрч байсан бол үйлчилгээний худалдааны импортын хувьд ийм байдал 2010 оноос хойш ажиглагдаж эхлээд байна.

Маш өндөр өрсөлдөөнтэй хуулийн үйлчилгээний салбарт хуулиар нэмэлт зохицуулалт хийх болсон нь шууд харахад Үйлчилгээний худалдааны хэлэлцээрийн 3 дугаар зүйлийг зөрчөөгүй боловч үндсэндээ хуулиар “тодорхой шалтгаанаар” магадгүй нийтийн дэг журам тогтоох гэсэн шалтгаанаар дотоодын зах зээлийг хамгаалах шууд бус зохицуулалт хийгдсэн гэж үзэж болохоор байгаа юм. Бусад оронд иймэрхүү хамгаалалт байдаг нь ойлгомжтой бөгөөд энэ жишээ нь шүүмжлэх талаасаа биш Монгол Улсад дотоодын зах зээлийг салбарыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хэрхэн авч байгааг л харуулж байгаа болно.

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа үйлчилгээ авах тухай хуульд³⁹⁾ мөн дотоодын үйлдвэрийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт агуулагдсан байдаг. Тухайлбал энэ хуулийн 10 дугаар зүйлийн нэмэлт 1-д “Чанар , стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг шалгаруулахыг хориглоно. Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг Засгийн газар батална” гэж заасан байна. Мөн энэ хуулийн “тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулах” гэсэн 9 дүгээр зүйлд

39) Төрийн мэдээлэл, Дугаар 48, Уб хот, 2005 он

өндөр үнийн дүнтэй аж үйлчилгээний тендерт гадаадын иргэнийг оролцохыг хориглож үл болно гэсэн байгаа юм. 10 дугаар зүйлд Монгол Улсаас гарал үүсэлтэй бараа, Монгол улсын иргэн, хуулийн этгээдэд тендерт давуу эрх олгоно гэж заасан байна.

Монгол Улсын холбогдох зарим хуульд зааснаар үйлчилгээний худалдааны салбарт үндэсний бүтээгдэхүүнд илүү давуу эрх олгосон байдаг. Түүнчлэн Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг уул уурхай, харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, банк санхүүгийн салбарт хязгаарласан байдаг болно. Үйлчилгээний худалдааны салбар нь аливаа улсад гадаадын өрсөлдөгчдийн хувьд илүү хаалттай байдаг бөгөөд бараа, бүтээгдэхүүний худалдаанаас ялгаатай нь Үйлчилгээний худалдааны хэлэлцээрт заасны дагуу аливаа улс энэ салбарт тодорхой үндэслэлээр нэн тааламжтай дэглэм болон үндэсний дэглэмийн хувьд ялгаатай нөхцөл тогтоохыг зөвшөөрдөг явдал юм. Ийм ч учраас манай улсад Үйлчилгээний худалдааны хэлэлцээрт заасны дагуу гадаадын иргэн, хуулийн этгээдэд тухайн үйлчилгээний салбар тус бүрээр нь зах зээлд нэвтрэн орох болон үндэсний үйлчилгээ үзүүлж буй этгээдтэй адил тэгш эрхтэй байх эсэх талаар тусгайлсан хүснэгтээр тодорхойлж үүрэг хүлээлгэж байгаа.

몽골 국제 무역법의 법적 조정의 특징과 발전 경향

발표자: 몽골국립대 법대 엠. 오양가

2016년 7월 23일 울란바타르 시

키워드:

국제 무역, WTO(세계무역기구), 통상관계, 무역 정책, 관세율 조정, 비관세 장벽, 국내시장 보호, 몽골국의 국제 무역법, 관세법

요약:

몽골국의 국제 무역의 법적 조정은 다른 국가들과는 다른 독특한 차이점이 있다. 사회주의 무역의 법적 조정을 시장경제를 근간으로 하는 국제 무역의 법적 조정으로 1990년 이후 단기간 내에 새로 만들기로 쉽지 않았다. 몽골국의 국제 무역 정책이 1990년 이후 어떻게 발전해왔는지와 법적 조정의 특징과 경향을 이러한 발표를 통하여 간략히 소개한다. 또한 몽골국의 국제 무역법의 미흡한 면과 추후 중점을 두어야 할 과제들에 대해 다루려 한다. 몽골국은 1990년도부터 시작해 국제무역개방정책을 펼쳐 왔다면, 2000년도 부터는 국가산업 육성정책과 국제 무역 조정지향의 법적 조정을 제정하였다. 이러한 상황에서 국제 무역법의 적합성과 국제협약에 따른 의무의 이행에 관해 몇가지 주제들을 다뤄보고자 한다.

1. 소개

1980년 말 우리나라의 국제경제관계는 사회주의동맹이라는 국가들간의 경제협력연합체제인 경제공조회에 포함되어 있었다. 소련, 동유럽 국가들, 몽골, 베트남, 쿠바 등의 국가들로 구성된 이 공조회 회원국들 간의 무역을 5개년 계획에 근거해 국가의 별칙들과 산정 방법들을 이용하여 조정하였다.¹⁾ 이 국가들은 재산을 오직 국유 아니면 사회소유의 형태로만 인정하였기에 국제 무역은 국가가 독점되었고, 개인주의적 개념은 사실상 존재하지 않았다. 경제공조회는 국제 무역, 회계에 특별외환 곧 전환 루블을 통용해 물품, 생산품의 가격을 기준으로 삼아 국가에서 통제하였다.²⁾

1) 데. 갈사더르찌, 데, 김버자브, 몽골 국제 무역, 90, 울란바타르 시, 2012, 45-50쪽

2) 또한 거기에

몽골국 국제 무역의 대부분은 해당 공조회를 거쳤음으로 우리나라는 세계시장에 완전히 들어 갈 수 없었고, 모든 무역을 국가기관에서 독점하여 책정한 가격을 따라야 했으며³⁾, 사사로운 국제 무역은 불가하였다.⁴⁾

그러나 1991년에 사회주의였던 국가들이 모두 시장경제체제로 전환하기 시작함에 따라 경제 공조회가 해산되고, 몽골국민들에겐 국가발전의 문제들과 국내외 무역을 개발하고 세계시장에 참여할 고유의 방법을 강구해야 할 요구가 발생했다. 입법자들은 재산은 근본적으로 국민의 재산이다 라는 개념을 발생시켰다고 말한다.⁵⁾

몽골국이 헌법으로 소유권을 보장한 것은 시장경제요소의 근본이되는 사유재산체계의 수용의 표현이 되었다.

1992년 제정된 신헌법⁶⁾ 제 5조 1항에서 “몽골은 보편적 세계 경제정세와 국가적 특수상황을 고려하여 다양한 소유 형태에 기초한 경제를 추구한다. 국가는 국민경제의 안정과 모든 형태의 경제발전 그리고 국민의 사회적 발전을 보장하기 위하여 국가경제를 조정한다.” 라고 명시함으로써 경제분야의 중요한 한 축인 국제무역을 정치, 경제, 사회의 새로운 상황과 면밀히 연관지어 개발하는 국가정책, 사업에 법률적 근거를 마련하였다.

이 시기부터 몽골국은 국제 무역 분야에서 시장경제중시정책을 시행하였고, 이를 관련 법령으로 제정하여 왔다. 이 정책은 세계 시장에 어떻게 합류할 것인지, 새롭게 나타난 개별 무역, 국영 공장들이 국제 무역에 어떠한 형태와 방법으로 합류할 것인지, 이 분야에서 자기만의 고유한 정치적 정책을 가지고 이를 기저로 국제무역 구 시스템을 어떻게 새롭게 할 것인지, 법환경을 어떠한 조정 시스템을 가지고 조성할 것인지 등의 문제들에 그 주안점을 두었다⁷⁾.

우선, 국제 무역의 주요 원칙에 있어서, 1992년에 여러 종류의 소유재산을 인정하는 내용의 헌법 제5조에 따라 국가나 개인 소유의 사업체나 개인은 누구나 몽골국 법이 명시한 범위안에서 다른 국가에 물품, 생산품을 수출, 외국에서 수입해 들여올 수 있다. 다시 말하면, 이는 위에 언급한 국제 무역의 국가 독점을 완전히 배제한 것이다. 이렇게 국제 무역을 개방한 것은 이 분야에서 새로운 정책을 펼치기 시작했음을 보여주는 가장 큰 원칙의 첫 걸음이었다. 다른

3) 몽골의 경제, 사회 1991년, 몽골국 통계청, 이런때에 시장국가들인 영국과 350만불, 일본국과 950만불의 거래를 하였다. (출처: 이스, 몽골의 거래, 경제 약서Товчоон, 2009)

4) 예를 들어, 1985년에 몽골국의 국제 무역의 총 순환액은 17억 8400만불이었으나 그 대부분(83%) 곧 14억 8200만불의 거래를 소련과, 3400만불은 폴란드와, 3300만불은 루마니아와, 2700만불은 헝가리와, 6000만불은 체코슬로바키아 등 사회주의 국가들과 하였다.

5)

6) 국가 정보지, 울란바토르 시, 1992, 1호

7) 이에 대해서 세세르 게. 세계무역기구법의 일부 문제, 울란바타르시, 2000년, 188쪽

면에서는 몽골국은 시장경제에서의 국제 무역 조정을 해본 경험이 전무하기에 완전히 새로운 법체계를 세우는 것은 쉽지 않았다. 이에 이 연구보고서의 다음 부분에서 몽골국이 1990년부터 시작하여 법 개혁시 국제 무역정책과 법의 기저를 어떻게 제정해 왔는지, 국제 무역을 어떠한 방법들과 어떠한 근거로 제한해 왔는지를 소개하고자 한다.

2. 국제 무역 정책 기조와 조정 발전 방향

1992년 새 헌법 제정 이후, 국제 무역 육성, 특히 우리나라의 경우에는 수출 증대에 있어 자유무역주의를 기반으로 삼고, WTO (세계무역기구)의 회원국으로 가입하려는 준비를 시작하였다. 몽골국 국내 법률을 WTO 계약, 기타 몽골국 국제 계약, 국제 무역 세계 표준에 맞춰 수정하는 중요한 걸음을 내디뎠다.

WTO 가입과 관련하여 몽골국은 1996년에 관세법, 관세율법, 일부 품목 수출법, 점차적으로 1998년에 역진세법을 각각 제정하고, 수입 허가서류를 4000 개에서 300개로 축소하고, 국제 무역을 개방하는 방향으로 지속적으로 정책을 시행해 나가기 시작하였다.⁸⁾ WTO 가입 이후에는 몽골국 국제무역 수지가 늘어나 사회주의 체제하에서의 국제 무역 수지보다 3배 증가하였다.

몽골국의 국제무역은 이와 같이 비교적 단기간에 급격히 성장하여, 국가 발전의 큰 원동력이 되었고, 세계 시장과 몽골 경제를 잇는 중요한 가교가 되었다.

시장경제 체제로 전환한지 25여년이 지난 우리 나라의 국제 무역 법적 조정 또한 변화되었고, 국제 시장에 진출할 법환경의 기초가 다져졌으며, 자유무역의 모범 규칙과 원칙을 고수하는 체제로 전환하여 국내시장 수요를 충족할 공급력이 점점 증가하고 있다. 이는 세계 발전의 최근 경향과 자유 무역 통용 원칙에 기반을 두고 상호간 이익을 지향하는 국내외 무역을 자국의 특성에 맞게 발전시켜나가는 함을 몽골국이 지속적으로 고수해 온 결과이다⁹⁾.

몽골국은 1990년 이후 정치, 사회, 경제 변화를 법체계 개혁으로부터 시작한 것은 제대로 된 행보였고, 또한 분명한 결과를 가져왔다. 이를 위해 수년간 폐쇄되어 온 국제 무역 분야의 원칙에 수정을 가하고, 세계 공동 개발의 경향에 발맞춰 개방을 더욱 추구하며, 세계가 인정한 국제 무역의 기준을 준수하며, 다른 모든 국가들과 평등하게 무역할 수 있도록 법환경을 완전

8) 국제연합개발계획(UNDP), 국제무역과 인간개발, 2008.

9) 이 것에 대하여 S.Lester and B.Mercurio., S.Lester and B.Mercurio, World trade law, Text, materials and commentary, Oxford and Portland Oregon, 2008, pp. 20-43.

히 새롭게 조성할 필요가 있다.

몽골 국회는 1994년 몽골국 국제 무역 정책의 첫 기초를 확정하고, 이 것에 경제적 통상 관계를 확대 심화한다는 목적을 반영하였다. 1994년의 대외 정책 기초의 경제적 통상정책 이라는 제3조에 몽골국의 국제 경제 발전에 부합하는 기본 방향과 근본법칙을 명기하였다. 이 때에 국민경제의 안전과 불평등이나 일방적 압력을 행사하지 않는 것을 중요시 한다고 했다.

더 나아가 1991년에 국제통화기금 (IMF), 세계은행, 1994년에는 아시아 개발은행, 1997년에는 WTO의 회원국으로 가입한 일은 우리나라의 국제 무역 개발과 법적 조정에 있어서 새로운 시대의 초석을 놓는 것이었다.

1990년대 이후 국제무역 개발방향은 내수 공급과 수입 육성 정책을 우선시 하였다. 이러한 정책을 근간으로 법적 조정은 자유무역을 육성하는 면에서 적용되었다고 볼 수 있으며, 이것은 또한 WTO 회원국 가입을 위한 전제조건이기도 하였다.

이와 관련하여 산업체세에 관한 법(1992), 은행에 관한 법(1996), 조세일반법(1993), 특별조세에 관한 법(1993), 수출관세에 관한 법(1996), 국제무역 중재에 관한 법(1995), 인증세에 관한 법(1993)과 특허에 관한 법을 개정하였다.

2000년 이후, 안정된 경제 성장, 국가 자원의 증가, 몇몇 분야에서의 국영산업의 비약적 발전의 시작과 함께 국제무역 경향의 변화와 국내 시장과 국영산업 보호라는 절실한 요구가 발생하게 되어 정부에서도 이를 위한 조치를 강구하기 시작하였다.

몽골 정부에서 주창한 수출유망 산업 육성 개발과 외국인 직접투자 증대를 골자로 하는 국제 무역 정책을 적절히 적용함으로써 안정적 경제 성장을 꾀하고, 수입 규정을 적절하게 조절하고, 수출을 늘리고, 점차적으로 국제 무역 균형의 손실을 줄이는 등의 큰 목표들을 국제 무역에 참가함으로써 우리나라가 가진 장점을 충분히 사용하는 방향으로 적용해 나갈 수 있다고 국내 일부 학자들은 말하고 있다¹⁰⁾

이렇기 때문에 최근 수년간 몽골국 대외 정책 기초와 정부업무 수행계획안에 외부 수입증대보다 수출 육성, 국영산업 육성, 국내시장 보호라는 사안들을 대거 반영하기 시작했다. 이는 2000년대 후반부터 몽골국 국제 무역 정책이 분명한 방향성을 가지고 변화되었고, 1990년 초의 자유 무역만을 육성하던 내용에서 조금은 거리가 있으며, 국영 산업 육성을 지향하게 되었고, 이와 관련된 계획을 다듬기 시작했다.

그러나 몽골국에서는 통상관계를 구별하여 조정하지 않았고, 이 보다는 다른 법으로 예를 들

10) 데. 갈사더러찌, 데.검버자브, 몽골 무역 90, 울란바타르시 2012년, 115쪽

면, 2002년도 몽골 민법¹¹⁾, 2008년 관세에 관한 법¹²⁾, 2008년 관세, 관세율에 관한 법¹³⁾, 1996년 일부 품목 수출관세에 관한 법, 2015년 역진세에 관한 법, 2015년 자유구역에 관한 법과 기타 법으로 통상관계를 포함하는 상당 양의 관계를 조정하였다. 그러나 이러한 중요한 국제 무역의 몇 문제, 예를 들면 물품의 수출입시 부과하는 관세율 체계와 국제 무역 정책을 적용하는 법도구를 조정하고 있다. 예를 들면, 관세와 관세율법으로 수입품의 몽골 국경으로의 통관과 몽골 국경을 통한 수출 규정을, 외국인 투자에 관한 법으로 몽골국의 서비스 시장으로의 외국인 서비스 시행자의 통관 일반 규정을, 조세법으로 국제 무역가와 투자자를 위한 세금 과 세금 감면의 근거를, 국유나 지방자치단체 소유 재산으로 상품화나 서비스화에 관한법으로 근본적으로 조정하였다.

처음 1991년에 국가소회의를 통해 통관에 관한 법을 재정하였고, 이 법으로 통관 감사 조사, 관세, 수수료, 면세구역, 통관 창고, 몽골 세관의 권한을 명기하였다.

2000년 이후 경공업, 서비스, 광산업 분야에서 국내외 직접 투자가 증가되어 2012년까지 경제가 안정적으로 성장하였다¹⁴⁾. 다른 면에서 몽골국은 기반시설이 잘 마련되어 있지 않았고, 생필품 정도에만 원료가 조달되었으며 주로 해외 수입이 과도했다. 수출의 경우에도 원자재 채로 내다파는 것이 지배적이었고, 이웃 나라인 중국의 시장에 종속되는 상황이 계속되어 왔다.

2008년부터 2012년까지 몽골 경제는 성장을 계속하였고, 매 정부마다 국내 산업 개발¹⁵⁾을 그 목적으로 삼았기에 국내 시장 보호와 국내 산업 육성 정책이 지배하기 시작하였다. 2008년 이후 몽골 국제무역 정책의 몇 부분을 다듬어 국가가 국제 무역을 개발함과 동시에 국영 산업과 수출을 육성하고 해외 수입에 대한 지나친 의존도를 낮추기 위해 더욱 애쓰게 되었다.

다른 면에서는 이 문제를 이전에 시행되던 통관 업무 조정법과 일련의 조세관련법들, 그리고 투자법으로 여전히 조정해 오고있다. 국제 무역 정책을 정부나 국회에서 제정한 정책의 법 문서로 조정해 왔음을 언급하는 것은 타당하다.

예를 들면, 몽골국의 대외 정책 기조는 2011년에 개혁 확정되었으며¹⁶⁾, 경제의 안전성을 중요시하였다. 2011년 몽골 국회 결정 부칙 제10조로 제정한 당 기조의 제3부 “경제의 대외 관계 정책”에 국제 경제 관계를 적용함에 몽골국이 고수하는 기본 원칙과 목적을 명기하였다. 이 안에는 국제 경제 관계 발전시 국가 경제의 안전성 보장을 지향한다 라고 명기하였다.

11) 국가 정보지, 7호, 울란바타르 시, 2002년

12) 국가 정보지, 울란바타르 시, 2002년

13) 국가 정보지, 23호, 울란바타르 시, 2008년

14) 이에 대하여 데.갈사더러찌, 데.검버잡. 몽골 국제 무역 90, 울란바타르 시, 2012년, 72-75쪽

15) 몽골국 산업화 정책, 정부, 2009년.

16) 몽골국회 2011년 제10호 결의안으로 확정됨.

“외국들과 경제 관계를 발전시키고 협력할 때, 경제의 안전성에 부정적 영향을 미치거나 한 국가가 지나치게 종속적 상태에 놓이지 않도록 경제함과 동시에 국제통상 원칙과 기준을 고수하는 평등, 상호이익 추구, 성실한 의무 이행, 정치적 및 기타 압박에 놓이지 않는 상황을 제공한다”는 골자의 정책을 시행한다.” 라고 했다. 또한 이러한 기초의 20.1에서는 “1/ 경제 국제 통상업무는 해당 국가의 경제 능력과 수출 자원을 성장 증대시키고, 경제 인프라 구성과 수입 대체품 생산 개발을 지향한다”¹⁷⁾라고 했다.

이런 것들을 볼 때, 우리나라는 국제 무역 정책이 자유무역이 갖는 상당한 문제들을 명확히 하였다. 여기에, 국제 무역을 개방할 때 자국 경제의 안전성을 보장한다. 이를 위해, 첫째로는, 상호이익을 추구하는 무역을 하며, 둘째로는, 해외 수입에 지나치게 의존하지 않고, 셋째로는, 수입 대체품 생산을 개발한다 라는 목표들을 제안하였다.

이것들 중에서 국제무역의 양이 증가됨으로써 그에 해당하는 법적 조정을 더욱 개발하고, 특히 국내 시장 보호의 법적 기준을 세워야 한다는 요구가 점점 더 증가하고 있음을 언급하는 것은 타당하다.

3. 몽골국 국제 무역 제한과 국내 시장 보호 조치, 실제

물건, 생산품의 수입 관세의 제한

몽골 제품의 수출과 수입의 업무를 조정하는 주요 법은 통관과 관세율, 관세에 관한 법이라고 앞서 말한바 있다. 이러한 법은 처음 1996년 제정되었고 2008년 개정되어 이전 법은 효력을 상실했다. 이런 과정에서 관세율과 관세에 관한 법에 국제 무역을 제한, 외부 수입의 불공정 경쟁으로부터 국내 시장을 보호하기 위해 국제 무역 제한 한다는 관련 조항을 반영하였다. 관세율과 관세에 관한 법은 몽골 헌법, 통관에 관한 법과 연관된 조항들과 함께 수입품의 경우 몽골국 수입 관세 정책 법규정을 구성하고 있다. 이 법은 관세율 부과 원칙을 정하고, 그 종류, 부과, 징수, 대금 지불, 실행 업무 관련 관계를 조정하게 된다.

몽골국은 WTO 가입에 관한 의정서에 따라 수입 관세 요금의 크기와 서비스 분야에서 받을 의무조약에 합의했다. 이 합의에 따라 수입 관세의 일반적인 수준은 20%이며, 일부 품목, 예를 들면, 생축, 애완새, 땅콩류, 모조전화기, 목재류, 정보 재생기 등의 물품에 대한 관세율을 1-10%로 정하였다. 그러나 국내산업 육성과 국내시장 보호차원에서 봉제, 편물, 가죽제품, 양

17) 또한 거기에

탄자 등의 수입관세를 30%로 정하였다¹⁸⁾.

관세율과 관세에 관하여 몽골법 제4조 1항에 “몽골국에서는 수출입품의 관세율을 사용하며, 관세율을 정함에 있어 물품의 코드, 종류를 연결시스템에 따라 지시한다.”라고 명시되어 있다¹⁹⁾.

관세의 크기와 일반 수입관세를 법으로만 정한다. 이는 국가권한의 중요한 실행 도구임과 동시에 해당 품목의 관세의 크기가 일정하게 변한다는 융통성이 그 특징이다. 예를 들면, 이 법의 제4조 3항에 명시된 바에 의하여 국회가 수출품의 관세율과 수입품의 최혜국 대우관세를 개정하여 정할 수 있다. 대개 이 법으로 관세율 부과 방식, 관세 책정 유형, 관세를 규정하는 기본 원칙을 정하였고, 이에 따라 몽골국은 현재의 상태로 세계 여러 나라에서 최혜국 대우 관세로 물품을 수입할 권리를 부여받았다²⁰⁾.

이 법이 정하는 바에 의하여, 수입관세 결정권은 법을 제정하는 최고의 통치기구인 국회에서 그대로 가지고 있으며, 이는 이전에 적용되던 1996년 관세율에 관한 법의 규정과 상당한 차이가 있다. 1996년 관세율 법 제4조7항에 명시된 대로, 정부는 국회에서 부여한 권한 내에서 관세율을 변경할 권한이 있었다. 이를 시행함에 있어 이 권한은 몽골국이 가입한 국제계약, 협약으로 부여된 의무와 약속에 제한 받는다.

2008년 개정된 관세율과 관세에 관한 법의 특징인 조정은 제4조에 있다. 이 4조가 정하는 바에 의하여 국회는 수출품의 관세율과 수입품의 최혜국 대우 관세를 정할 권한을 가지게 되었다. 이 점에서 나오며 또한 이미 언급한 주요 특징은 이러한 최혜국 대우 관세를 몽골이 가입한 ‘관세 및 무역에 관한 일반 협정(GATT)’의 회원국들과 국제 계약에 따라 감면된 관세를 적용하기로 상호 합의한 다른 나라들, 이처럼 최혜국 대우 관세율을 사용하는 것이 타당하다고 여겨지는 나라의 경우에 이렇게 사용할 수 있다고 명시하였다. 다시 말하자면, 단지 몽골국과 같이 GATT 회원국 또는 이 협정으로 상호 합의한 나라들의 경우에만 최혜국 대우 관세율을 부과한다는 것을 확정하였다. 이를 또한 이들 국가 목록에 들지 못한 국가의 경우에는 더 높은 수입관세가 부과된다고 이해할 수 있다.

관세율과 관세법이 개정됨과 관련하여 국회는 1999년 이후 관세 중에서 주로 수입관세의 크기를 여러번 개정한바 있다. 이 문제로 제정된 법령에 따라 대부분의 물품에 수입관세 5%를 부과하던 것을 그대로 유지하고 있으나, 일부 식품과 농산물과 제품에 대해서는 계절의 특수성

18) 게. 세세르, 세계 무역기구 법적 원칙 문제, 울란바타르 시, 2000년

19) 국가 정보지, 제23호, 울란바타르 시, 2008년

20) 몽골 정부 결정, 법 적용 원칙과 방법에 대하여, 2008년 4월1일, 제93호

을 고려하여 부과한다. 예를 들면, 8월1일부터 4월1일까지에는 야채와 밀가루에 15%를 부과한다²¹⁾. 또한 어떤 종류의 물품에는 수입세를 “0”% 부과하기로 정하기도 하였다²²⁾.

이처럼 2000년 이후 일부 품목의 수입관세를 면제하였다. 예를 들면, 몽골국이 회원으로 가입한 국제 협력 계획(UNDP)이나 이러한 부류의 계약에 따라 들여온 물품과 장비 또는 “천의 길”을 건설하기위해 수입해오는 사업자들에게는 대형차와 석탄과 장비들 수입관세를 면제해 주었다²³⁾.

이와 함께 시기적 요구에 의해 수입해야하는 몇 물품에 대한 감면 문제를 국회에서 논의하는 경우가 꽤 발생하고 있다.

몽골국은 1993년 1월에 “품목을 명확히하고, 코드화 하는 연결 시스템에 관한 국제 협정”²⁴⁾에 가입하였다. 몽골국 관세율에 관한 법, 법령이 정한바에 의하여 수입관세율을 일반과 최혜국 대우 두가지로 구분한다. 최혜국 대우 관세율의 크기는 일반 관세율의 1/2 수준이다. 최혜국 대우 관세율을 정하는 국정세율표를 어떻게 작성할 것인지 그 규칙이 관세율, 관세에 관한 법에 명기되어 있다.

몽골국은 GATT²⁵⁾의 제 3조에 따라 국제 무역시 국가 체계 원칙을 적용하는 의무를 이행하겠다고 표명해야 한다. 이 원칙의 가장 중요한 내용은 국내외 거래를 하는 사람들은 누구에게 시장에서 평등 거래를 보장하는 환경을 조성한다는 것이다. 다시 말하면, 외국에서 수입해 들여오는 물품과 자국 생산품의 경우 국내 시장 유통시 판매, 소비의 동일한 체계가 정해져 있어야 한다는 의미이다. 또한 이러한 원칙은 국내외 서비스 산업, 국산품 표기, 저작권, 특허의 경우에도 준수되어야 한다.

관세율, 관세에 관한 그리고 특별관세에 관한 법에 특별관세에 대한 조정이 반영되어 있다. 대부분의 국가에서는 특별관세를 인체 건강과 환경에 유해 우려가 있는 물품, 사치품에 부과한다. 그리고 국가는 세계경제정세와 국가적 특수상황을 고려하여 다양한 소유의 형태에 기초한 경제를 추구한다. 국가는 모든 형태의 공,사유개념을 인정하며 법률이 정한 바에 의하여 소유자의 권리를 보호한다. 품, 도박 관련 물품에 부과한다. 몽골국 특별관세에 관한 법이 정하는 바에 의하여, 이러한 종류의 세금을 국내 시장에서 판매되는 국산품과 수입품 모두에게 부과할

21) 수입품 관세율의 경우 정도 책정에 관한 국회 법령, 제27호, 1999년

22) 국경 통관 금지, 관세율 이외의 기타 제한받는 품목 목록 책정에 대한 몽골 국회 법령, 제5조, 울란바타르 시, 1998년, 2006년 추가개정

23) 관세율, 관세에 관한 법 38.1.5, 38.1.14

24) 관세 관련 국제 협정집, 울란바타르 시, 2003년

25) 우르콰이라운드 결과, 문서집, 울란바타르 시, 2000년, 국가 정보지, 특집호 제7호, 2007년

수 있다. 부과할 시, 이 특별관세를 몽골국에서는 물품의 수량, 또는 가격을 비율로 계산하여 정한다. 그러나 우리나라의 법, 법령으로는 수출품에 특별관세를 부과하고 있지 않다. 2006년 특별관세에 관한 법이 개정되었다.

이전 특별관세에 관한 법과의 차이는 개정된 법으로 국산품과 수출품에 있어서 동일한 세금을 부과하게 되었다. 예를 들면, 이전 법으로 국산 주류에 특별세 85%를 적용하였다면, 수입 주류에 대해서는 리터당 특별세 7\$를 적용하였다²⁶⁾.

국제 무역을 하는 개인과 사업체와 기관은 물품 수출입시 세관에 일정량의 관세과 대금을 지불한다. 이러한 관세와 대금의 크기는 통관비, 수량, 관세 종류, 형태, 관세율의 크기 등을 고려하여 서로 다르게 정해진다.

물건, 생산품 수입의 비관세 제한

몽골국은 WTO에 가입할 때, 수출입 제한 조치, 또는 허가증 등 별도의 것을 요구할 경우, WTO의 계약 및 조약을 따른다는 의무를 가졌다²⁷⁾. 또한 정부는 WTO의 계약 및 조약에서 정한 기준에 따라, 명시되지 않은 어떠한 조치나 금지, 한도를 정하거나, 다양한 허가, 특별 허가를 요구해서는 안된다는 의무를 가진다. GATT 11조에 따라 수출입을 제한하는 법적 조치는 단지 관세와 대금으로 제한 한다고 정하였다²⁸⁾. 이와 병행하여 이 협정의 제 18조에, 국민 생활 수준 이하 또는 발전 초기 단계에 있는 국가가 자국의 경제 개발 정책, 계획 적용을 유지해 나갈 목적으로 국내 시장을 보호하기위해 수입 제한 조치를 취할 수 있다고 명기하였다.

WTO의 계약이 정하는 바에 의하여, 일부 수출입 물품의 경우 물품의 제조권인 별도의 허가를 요구하는 조항을 자국법, 법령에 상당한 양으로 반영하였다. 이는 해당 국가에서 인간과 동물의 건강, 식물의 성장과 최종 단계에까지 인체의 안전, 자연환경 보호의 목적에 우리나라가 큰 관심을 갖게 됨의 한 표현이다. 예를 들면, 사업체의 별도 허가에 관한 몽골국법 제15조가 정하는 바에 의하여 상당량의 사업 업무를 운영해 나가기 위해서는 별도의 허가를 받아야만 한다²⁹⁾.

몽골 영토내 반입 금지 물품을 국회 1998년 제5 법령으로 지정하였고, 이에 모든 종류의 에틸 알코올, 주류가 포함되었다³⁰⁾. 2002년 10월 25일 정부 법령으로 “허가증을 받아 통관시키

26) 2006년 특별세에 관한 법

27) WTO 몽골국, 공적문서집, 개정 제2판, 울란바타르 시, 2003년

28) 우르콰이 라운드의 결과, 문서집, 울란바타르시 2000년

29) 국가 정보지, 제6호, 울란바타르 시, 2001년

는 코드화된 물품 목록”, “국가 감독하 통관가능 물품의 수출입 허가증 발급 규칙”등을 219호 법령으로³¹⁾ 지정하였고, 이때 이전 2001년 제 54호 법령을 폐지하였다. 이 법령으로 이러한 조정에 해당되는 물품을 반입, 반출 두 종류로 분류했으며 허가증을 받아 반출, 반입해야 하는 물품에 특히 독성 화학 물질, 의사 지시하의 치료, 예방 목적의 장기, 기증 혈액, 항균 미생물, 폭발물질, 총탄류, 총기류, 무기류, 기술, 기술의 부품, 장비, 가축, 희귀 동물, 벌, 우라늄 철광 석과 농축, 인체 장기, 예술품, 수집품과 고대 희귀 고가품 등 적지않은 물품이 포함되어 있다.

물품 보조금. WTO의 계약, 협약에 따라, 보조금과 상쇄 조치에 관한 협약 제 3조가 정하는 바에 의하여 수출품 보조금 지급을 금지하고 있다.

1990년도 이후 시장이 개방될 때, 몽골국이 외국인 투자 유치 정책을 최대한 적용하기 시작하였다. 이때 외국인 투자자들을 유치하는 주된 방법은 세금 감면제도를 마련하는 것이었다. 예를 들면, 외국인 투자자들의 법정 기금에 들여놓은 장비는 관세에서 만약 그들이 수출 목적의 사업을 하고 있으면 일정 기간동안 소득세에서 50-100%까지 경감해 주어왔다³²⁾. 이는 수출 장려 조치를 사용했다는 의미이다.

수출관세 조정. 몽골국에는 일부 물품에 수출관세를 부과한다. 일부 품목에 부과되는 수출관세의 크기 책정에 관한 법은 1996년³³⁾ 처음으로 제정되었으며, 이에 의거하여 가축과 캐쉬미어, 목재와 목제품에 수출관세를 부과하게 되었다. 주류와 화학물질을 포함한 제품들을 수출 금지하였다. 이처럼 몽골국은 UN의 경제제재 조치를 적용하지 않고, 총기류, 폭발위험물, 일부 의약품 이외의 제품에 수출 허가증을 요구하고 자원 수출 거부에 관한 계약을 일부 국가와 체결하였다. 또한 수출품의 경우에 가격 조정을 정하지 않았다.

우리나라에 수출품에 적용하는 표준과 기술요구에 관하여 2003년 제정된 표준화, 적정평가에 관한 법, 계량공용법을 각각 적용된다. 표준화, 계량 국립센터는 정부 산하기관이며, 계량, 표준화를 조정, 지도 기획하는 기본 의무를 진다. 또한 이것은 국가표준을 정하고, 국산품과 외제품의 표준 인증마크를 부여하는 기관이다. 표준 계량 국립센터는 WTO의 기술적 방해에 관한 협약 적용 업무를 우리나라에서 기획하고 있으며 또한 국제표준기구의 회원국이 된다.

몽골국은 중국과 표준화와 라이선스에 대하여 정부간의 협력에 관한 계약을 1994년에, 러시아와는 물품의 수출입의 질을 충족시키는 면에서 협력에 관한 계약을 1996년에 각각 체결하였다.

30) 국경 통관 금지, 관세율 이외로 제한받는 물품 목록 지정에 관한 몽골 국회 법령, 제5조, 울란바타르시, 1998년, 2006년 추가개정됨

31)

32) 산업체 소득세에 관한 법, 1992년, 7.6항

33) 국가 정보지, 울란바타르 시, 1996년

서비스 산업의 수출입 법적 조정. 물품의 수입 수출과 마찬가지로 서비스 산업은 현재 국제 무역 기본의 하나가 되었을 뿐만아니라, 시장 유통량은 해당 국가에 미치는 경제적 영향면에서 물품교역의 중요성보다 더 중요해지고있다. 오늘날 세계에서 가장 성공한 500대 기업의 대부분이 서비스 분야에 있다³⁴⁾.

몽골국에서 1990년 이후 국제 무역 개방 정책이 시행될 때, 국제적 물품 유통을 개방함과 동시에 국제 서비스 산업 개방 정책을 또한 적용하기 시작하였다.

서비스 산업은 이전 몽골의 경제 발전에 큰 부분으로 확대되고있으며, 이 산업 시장은 물품 거래 시장보다 외국인 경쟁자들에게는 더욱 폐쇄적이었다.

오늘날 몽골국에서 외국의 서비스 산업과 연관된 사업을 조정하는 법적문서는 은행 업무 조정 패키지법, 세금 패키지법과 외국인 투자 조정법과 법령, 이처럼 다른 분야의 사업을 조정하는 법들이다. 이러한 것들 중에서 외국인 투자 조정은 별도로 고려해야하는 관심을 끄는 문제이다.

1993년에 처음으로 외국인 투자에 관한 법을 제정하여 투자에 용이한 법적인환경을 조성, 투자자들에게 몽골국 시장에 참여, 자국 생산 공급자들과 동등한 자격 부여에 대하여 WTO에서 허가한 의무 적용을 지향한 법적 조정을 만들었다.

1990년대 초 몽골국은 될수 있는대로 외국인 투자 증대 정책을 고수했다면, 2000년대 이후로는 국가의 사회변동과 기타 경제의 근간으로 외국인 투자 정책에 일부 개정을 시작하였다. 외국인 투자자는 우리나라에서 법으로 금지하지 않는 분야에서 투자하도록 허가받았었고 이는 자유무역 정책을 적용한 표현이었다.

외국인 투자는 안정적으로 증가하였고, 2000년 말 광산업 분야의 투자에 국가에서 추가 감독을 정하고, 환경보호를 지향하는 조치를 증가시킬 목적으로 원칙을 제시하는 두개의 법을 제정하였다. 예로, 2012년에 제정된 “전략 분야에서 사업하는 산업체에게 외국인 투자 조정에 관한 법”³⁵⁾은 외국인 투자 분야에 원칙적인 변화를 주었고, 근본적으로 외국인 투자를 몽골국 시장에 유통하는 규칙에 제한을 만들었다. 투자 제한 법으로 광산, 은행, 금융 서비스, 통신 분야에서 투자를 제한하고, 이 법의 6.1조에 “전략사업 시행 사업체인 회사 지분의 1/3, 그 이상의 비율을 얻을 수 있는 권한을 갖도록 하는 법률행위, 제 6.1.2조에는 집행지도기구가 독자적으로나 협력집행지도구성원의 대다수를 임명하고, 그리고 대표이사회의 구성원의 대다수를 어떠한 조건없이 선출하는 권리를 부여하는 법률행위, 6.1.3에는 지도부의 결정을 견제할 수 있

34) Fortunes 500.

35) 국가 정보지, 제41호, 울란바타르 시, 2013년

는 등의 법률행위에 국가로부터 허가를 받아야 함을 명시하였다. 이 법이 제정됨으로 광산, 은행, 통신 분야에서 외국인 투자와 국가 감독 정책이 적용되었고, 법을 적용하는 규칙이 장기간 제정되지 못함으로 상기 분야의 외국인 투자가 지연되었고, 더 나아가 2014년 상황으로는 몽골국에서의 외국인 투자가 급감하였다³⁶⁾.

3백만 정도의 인구가 적어 시장도 적은 우리나라의 경우 외국인 투자자들이 가장 관심을 갖는 분야는 수출지향 광산업 분야, 서비스 분야이었다. 가장 관심을 갖은 분야에서 외국인 투자를 직접 제한한 정책을 적용하였고, 점점 법적 조정의 미흡으로 외국인 투자가 들어간 사업체를 우리나라에 세우고, 새롭게 투자하고, 주식이전 관련 법률행위와 해당 기관에 등록하는 일이 어렵고 복잡해서 지금은 외국인 투자가 아주 감소한 상태이다.

게다가 2009년 긴 이름 법으로 유명한 ‘강하수 근원이 시작되는 수원지를 보호하지 않는, 삼림지역에서의 광물 조사, 채굴 금지에 관한 법’³⁷⁾이 제정된 것은 또한 이 분야에 있는 투자, 외국인 투자의 권리와 연관되어 상당히 많은 문제를 발생시켰다. 다시 말하면, 국가 기관, 일부 비정부 기관은 외국인 투자자들과 특별히 광산업 분야에서 운영하는 자연환경에 유해한 사업을 시행한 것에 대해 자연 환경 보호, 광산개발 사업 관련 허가 파기를 순차적으로 요구하며 시위를 벌였다. 이 법이 제정됨으로 수원지와 삼림에서의 광산 사업을 중단시키는 일들을 시작한 역사가 있다. 이 상황에서 내외국민의 투자가 이뤄진 광산업 분야의 사업체의 허가를 거둬들일때 국가에서 보상하는 문제가 대두되었다. 보상금 문제에 더해 외국인 투자자와 국가 공무원들이 합의에 이르지 못하여서 이 법은 오늘까지 적용되지 못하고 있다.

2013년부터 몽골국 경제상황이 일부 변하고, 인플레이션이 증가하며, 외국인 투자가 감소됨과 관련하여 외국인 투자를 증대할 목적으로 외국인 투자에 관한 법을 추가 개정하는 일을 시작하였다. 나아가 2013년 10월 투자법³⁸⁾이 새롭게 제정되어, 2012년에 제정된 전략사업 시행사업자에게 외국인 투자 조정에 관한 법”이 유효하게 되었다. 2012년의 법으로 정한 투자 제한에 대한 조정의 취약점을 보완하고, 지나치게 많은 절차를 거쳐야 하는 허가 절차를 간소화하고 투자가 용이한 환경을 조성하고자 이 법이 제정되었다고 결론지을 수 있겠다.

새롭게 제정된 이 투자에 관한 법에, 대부분의 분야에서는 외국인 투자를 시장에 유입시켜야 하는 한다는 조건을 해제하였으나, 광산, 금융, 통신 분야에서만은 외국인 투자와 국가의 허가를 받도록 요구하였다. 예를 들어, 투자법 21조1항에 명시된 광산, 금융, 정보통신 분야에서는

36) 몽골 국가 통계청 보고서, 2015년

37) 국가 정보지, 제28호, 울란바타르시 2009년

38) 국가 정보지, 제41호, 울란바타르시 2013년

몽골 법인 총 지분의 33% 이상을 외국의 국유법인이 점유할 경우, 국가 행정기관에서 허가를 받아야 한다는 것이다. 투자에 관한 신법으로, 외국의 국유법인이 몽골국에 투자하고 있다면, 허가를 받아야 한다고 명시한 점은 이전 2012년의 전략사업 분야 투자에 관한 법에 명시한 것에 의하여 모든 외국인 투자의 규모가 33% 이상이 될 경우 허가를 받아야 한다는 조항과는 다르게 조정되어진 것이다.

이것을 법령으로 정하여 투자에 대한 이전 조정의 실수를 교정한 것은 자세한 연구와 근거 없이 외국인 투자를 제한했던 것을 번복하지 않게하기 위한 행보라고 볼 수 있다. 다른 면에서 한 국가가 자국내 시장의 어떠한 분야를 외국인 경쟁자들로부터 보호하는 것은 어느정도 납득할 만한 일이다. 다시 말하면, 자국의 전략사업품목을 보호할 필요가 생길 수 있으며, 국가의 대외정책 기조에 이것을 명시하는 것은 이것이 국가 경제 안전성의 문제이기 때문이다. 이 상황에서 어떤 분야를 외국인 투자자들로부터 보호할지, 또 어떤 것을 개방할지, 이러한 보호 개방 정책을 적용함에 있어서 어떤 범위안에서 적용할지를 면밀히 연구해야만 함을 위의 예가 잘 보여주고 있다.

우리나라의 경우, 1990년도 이후 수입품의 관세 감면제도를 중점적으로 적용하면서도 또한 국내 시장을 보호하고자 조치를 취하며 법제화 한 것은 조사에서 알 수 있다. 이런 경향은 차후에도 증가할 추세이다. 물품 수입에 있어서의 이러한 경향은 2000년부터 시작하여 나타났다면, 서비스 산업의 수입에 있어서는 이런 상황이 2010년 이후에 나타나기 시작했다.

높은 경쟁력을 가지는 법률서비스 분야에 법으로 추가 조정을 하게 된것은 직접적으로는서비스 산업 협정 제3조를 위반하였으나, 근본적으로는 법으로 “분명한 명분을 가지고” 아마도 공공의 질서 확립이라는 명분으로 국내 시장을 보호하는 간접 조정을 했다고 볼수 있겠다. 다른 국가에도 이러한 보호장치가 있다는 것은 이해할 만하며, 이 예는 비판적 입장에서 볼 것이 아니라 몽골국에서 국내 시장 보호 조치를 어떻게 취하고 있는지를 보여주는 것이다.

국가나 지방자치단체의 소유 재산으로 물건 서비스 만드는 것에 관한 법³⁹⁾ 또한 국내 산업 보호지향한 법적 조정이 포함된 것이다. 예를 들면, 이 법의 10조의 추가 1항에 “품질, 표준을 갖춘 물건을 국내생산으로 공급할수 있는 경우, 외국 물건 공급자들이 입찰에 참여하는 것을 금지한다. 국내생산에서 구입하는 물건들의 목록을 정부에서 지정한다.” 라고 명기하였다. 또한 이 법의 “외국인의 입찰 참여”라는 9조에 고비용의 서비스 입찰에 외국인 참여를 금지하지 못한다고 했다. 10조에 몽골국 국산품, 몽골국민과 법인에게 입찰에서 우선권을 제공한다고 명

39) 국가 정보지, 제48호, 울란바타르시 2005년

기했다.

몽골국과 관련된 일부 법에 명시함으로 서비스 사업 분야에서 국산품에 우선권을 부여한다. 이처럼 몽골국에서 외국인 투자를 광산, 통신, 출판 정보, 금융 분야에 제한한다. 서비스 사업 분야는 어떤 국가에서든 외국인 경쟁자들의 경우 폐쇄적이며, 물품 거래와는 다른 것은 서비스 사업 협정에 명시한 것에 따라 어떠한 국가도 이 분야에서 일정한 근거를 가지고 최적의 체계와 국가적 체계의 경우 다른 조건을 정하기를 허락하고 있다. 이렇기에 우리나라에서 서비스 사업 협정에서 명시한 대로 외국인, 법인에게 해단 서비스 분야마다 시장에 들어갈때마다 국가 서비스 제공하는 사람과 평등한지 여부를 별도의 표로 분명히 할 의미를 가진다.

Session 4

**Хууль эрх зүйн шинэчлэл ба нийгмийн
хөгжлийн зорилт
법제개혁과 사회발전의 과제**

Монгол улсын эрх зүйн шинэтгэл: шүүхийн
шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал
몽골의 법제개혁: 사법개혁의 실행, 성과와 과제

Илтгэгч: Доктор Э.Батбаяр (Монголын ХЗҮХ-ийн захирал)

발표: E.Batbayar 박사(몽골법제연구원장)

Хэлэлцүүлэгч: Су Жонсу прокурор (Солонгосын хууль зүйн яам)

토론: 소정수 검사(한국 법무부)

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ: ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ЦААШДЫН АСУУДАЛ

2016.07.15.

Улаанбаатар хот

Илтгэгч:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, доктор Э.Батбаяр

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бодлогын судлаач Ж.Алтансүх

1990 оноос хойшхи Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөгжлийн асуудлыг шинэ үндсэн хууль батлагдах хүртэл үе /1990-1992/, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдах хүртэл үе /1992-1998/, өнөө үе /1998 оноос хойш/ хэмээн үечлэн авч үздэг. Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгон тогтвортой хөгжүүлэх асуудлын хүрээнд 1998 онд “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталжээ.¹⁾

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт эрх зүйн шинэтгэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх 7 үндсэн чиглэл²⁾-ийн нийт 56 зорилтот арга хэмжээг төлөвлөсөн. Эрх зүйн шинэтгэлийн зорилго нь тус улсад хүмүүнлэг, иргэний

1) “Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан.

2) Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх; Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах; Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх; Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох; Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх гэсэн 7 үндсэн чиглэлтэй.

ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэхэд оршино гэж тус хөтөлбөрт заав.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээний хууль тогтоомжийн шинэтгэлийн үйл явцыг авч үзвэл, Монгол Улсын Их Хурлаас хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг тодорхой хугацаатайгаар төлөвлөн зохион байгуулах үүднээс “Үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2001 оны 44, 2005 оны 26, 2009 оны 38 дугаар тогтоолыг тус тус үргэлжлүүлэн баталж хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байв. Хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барьсан боловч улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан батлах шаардлагагүй гэсэн шийдвэр гарсан юм. 2012 оноос хойш, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого³⁾, Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр зэрэг баримт бичгийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн бодлого, зорилт, арга хэмжээ, хууль тогтоомжийн шинэтгэл хэрэгжиж ирсэн.

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр 1998 онд батлагдсанаас хойш 18 жил өнгөрчээ. 2008 он хүртэл Эрх зүйн шинэтгэлийн Хөтөлбөр, түүнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар өмнө нь тусгайлсан судалгаа, үнэлгээ өгөх ажил хийгдэж байгаагүй. Хөтөлбөрт тусгагдсан хуулиуд батлагдан гарч буй эсэхийг хянаж, эдгээр хуулийн жагсаалтыг шинэчлэх асуудлыг голлон анхаарч иржээ. Иймээс хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иж бүрэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгайлан явуулах шаардлагыг харгалзан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 36 дугаар тушаалаар “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын удирдамж”, “Хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын ерөнхий график”-ийг баталж, Хууль зүй дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 42 тоот

3) “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого батлах тухай” УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсон.

тушаалаар Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсэг, 8 дэд хэсгийг байгуулан ажиллуулж⁴⁾ тус хөтөлбөрийн 2008 он хүртэлх хэрэгжилтийн талаар тайлан гаргасан байдаг.

Энэхүү илтгэлээр 2008 оноос хойшхи эрх зүйн шинэтгэлийн үр дүнг судалж буй “Эрх зүйн шинэтгэл: Хүрсэн үр дүн /2008-2016/, цаашдын зорилт, чиглэл” судалгааны тухай товч танилцуулж, энэхүү судалгааны хүрээнд хийгдсэн “Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал” сэдэвт дэд хэсгийн судалгааны үр дүнг түүвэрлэн авч үзье.

“Эрх зүйн шинэтгэл: Хүрсэн үр дүн /2008–2016/, цаашдын зорилт, чиглэл” судалгааны тухай

Хууль зүйн үндэсний хүрээлэн ХЗЯ-аас ирүүлсэн судалгааны захиалгад тусгасан асуудлууд⁵⁾-ыг судалж эрх зүйн шинэтгэлийн стратегийн баримт бичиг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх хүрээнд “Эрх зүйн шинэтгэл: Хүрсэн үр дүн /2008-2016/, цаашдын зорилт, чиглэл” сэдвээр судалгаа гүйцэтгэж⁶⁾, тайлан боловсруулах шатанд ажиллаж байна.

Судалгааны “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 оноос хойшхи хэрэгжилт, хүрсэн үр дүн, цаашдын чиглэл” хэсэгт тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үйл явц, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлүүдийн хэрэгжилт болон хөтөлбөрийн Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх; Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах ; Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх; Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох; Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх гэсэн 7 үндсэн чиглэлд дэвшүүлсэн 56 зорилтот арга арга хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид эрх зүйн шинэтгэлийн чиглэлээр

4) Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан, ХЗҮХ, 2008, Уб., 6 дахь тал

5) Хууль зүйн яамны 2016 оны 4/487 дугаартай албан бичгээр судалгаа хийх хэрэгцээ, шаардлагатай хэмээн тодорхойлж ирүүлсэн асуудлуудыг судалгаанд хамруулсан.

6) Энэхүү судалгааг ГОУХАН/GIZ/-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл” –ийн дэмжлэгтэйгээр мэргэжилтэн, судлаач, олон нийтийн оролцоог хангах хандлага баримтлан гүйцэтгэж байна.

анхаарах асуудлыг түүвэрлэхэд төвлөрсөн болно.

ХЗЯ-ны захиалга болон судалгааны багийн зүгээс тухайлан судлах нь зүйтэй хэмээн үзсэн саналын дагуу “Эрүүгийн эрх зүйн шинэчлэл, үр дүн, цаашдын зорилт, чиглэл”, “Захиргааны эрх зүйн шинэчлэл, үр дүн, цаашдын зорилт, чиглэл” “Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал”, “Эдийн засгийн хүрээний эрх зүйн шинэтгэл, цаашдын чиг хандлага” сэдвүүдээр дэлгэрүүлэн судалж сэдэв бүрээр тусгай тайлан боловсруулав. Эдийн засгийн хүрээний эрх зүйн шинэтгэлийн үр дүн, цаашдын зорилт, чиглэлийг тандах хүрээнд бизнес, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчны өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагын талаар “Ойлт” судалгааны төвтэй хамтран асуулга боловсруулж иргэд, аж ахуйн нэгжээс судалгаа авч, үр дүнг тусгалаа.

Судалгааны үр дүнд, 1998 онд батлагдсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр анх дэвшүүлсэн зорилтдоо ерөнхийдөө хүрсэн хэмээн дүгнэв. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд 2008 онд хийсэн үнэлгээний тайлангийн “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр үндсэндээ хэрэгжиж, эрх зүйн шинэтгэлийн зорилт хууль тогтоомжийн төвшинд биелэгдсэн байна... Харин хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаарх нийгмийн ухамсарыг бүрдүүлэх зорилт зохих хэмжээнд хангагдсангүй” гэсэн дүгнэлт өнөөгийн нөхцөлд мөн хүчинтэй хэвээр байна.

Нэрт эрдэмтэн Б. Чимидийн бүтээл⁷⁾-д эрх зүйн шинэтгэлийн тусагдахууны талаар баримтлах ёстой 5 үндсэн чиглэл буюу эрх зүйн шинэтгэл зөвхөн хууль тогтоомжийг шинэтгэх бус хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх, хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх, хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх, нийгэмд эрх зүйн ухамсар төлөвшүүлэх чиглэлүүдийг хамтад нь авч үзэх талаар дурдаж ач холбогдлыг тайлбарласан байдаг.

Эрх зүйн шинэтгэлийн 5 тусагдахуунаар баримжаалан доктор, профессор Н.Лүндэндорж⁸⁾, доктор Б.Гүнбилэг⁹⁾ нарын эрдэмтэд эрх зүйн шинэтгэлийн үр дүнд дүгнэлт хийсэн байв.

7) Б. Чимид, Тер, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр. Уб. 2008., 15-16 дахь тал

8) “Монголын эрх зүйн шинэтгэл – 8 жил” Илтгэл болон зөвлөмжүүдийн эмхтгэл.Уб., 2003 он, 463-478 дахь тал

9) Б.Гүнбилэг. Монгол Улсын нэн шинэ үеийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага.“Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд”эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Уб., 2011 он, 36-37 дахь тал

Энэхүү судалгаагаар, 2008 оноос хойшхи эрх зүйн шинэтгэлийн үр дүнг дээрх 5 тусагдахуунаар мөн дүгнэж байгаа. Илтгэлийн хугацаанаас хамаарч хууль тогтоомжийн шинэтгэлийн үр дүнг товч дүгнэж үзье.

Тоон үзүүлэлтээс харахад хууль тогтоомжийн шинэтгэл эрчимтэй хийгдсэн байна. Тухайлбал, 2012-2016 оны хооронд Улсын Их Хурал 1254 хууль баталж, үүнээс бие даасан хуулийн тоо 135, нэмэлт өөрчлөлт оруулах тухай 957, хууль хүчингүй болсонд тооцох тухай 104, гэрээ соёрхон баталсан тухай хууль 58 байна. Мөн хугацаанд УИХ-ын 405 тогтоол батлагджээ.

Хууль зүйн яамнаас 2012-2016 оны хооронд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн албаны тухай, Тахарын албаны тухай хууль Прокурорын байгууллагын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Өршөөл үзүүлэх тухай хууль, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль гэсэн нийт 20 хуулийг боловсруулан УИХ-аар батлуулсан. Эдгээр хуулиудыг дагаад олон хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайлбал Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийг дагаад 200 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт орно. Мөн төсөл боловсруулаад УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулиуд ч байна.

2012-2016 оны эхний 6 сарын байдлаар Хууль зүйн яамнаас боловсруулж УИХ-аар батлагдсан хуулиудын төслийн танилцуулга, үзэл баримтлалыг судалж үзэхэд хууль тогтоомжийн төслийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, олон нийтээр хэлэлцүүлж санал авах замаар төслийг боловсронгуй болгох ажил нэлээд хийгдэж хэвшил болох хандлага ажиглагдав.

Шинээр батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль¹⁰⁾ нь хууль тогтоомжийн шинэтгэл

10) 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан. 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

төдийгүй эрх зүйн шинэтгэлийн бусад асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх том үр дүн гэдгийг онцлон тэмдэглэх ёстой. Энэ хуулиар хууль санаачлагчид хуулийн төсөл боловсруулахын өмнө тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтын төлөв байдал, хууль хэрэгжүүлэгчдийн өмнө практикт тулгамдсан асуудлууд, мөн иргэдийн өргөдөл, гомдол мэдээлэлд хөндөгдсөн асуудлуудад үнэлгээ, дүгнэлт хийж хууль шинээр гаргах хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлохын зэрэгцээ тухайн хууль батлагдсанаар үүсэх үр дагаврын судалгааг заавал хийсэн байх, түүндээ үндэслэсэн шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бодитой тооцоолсон байх үүрэг хариуцлагыг хуульчлан зааж хуулийн төслийн чанар, үр нөлөө, үндэслэлийг сайжруулах сайн талтай бөгөөд хуулийн төслийг боловсруулахад эрх зүй, эдийн засаг, санхүүгийн болон байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн магадлан шалгалт хийх эрх зүйн үндсийг шинээр тавьж байгаагаараа онцлогтой. Энэ хууль батлагдсанаар хууль боловсруулах явцад олон нийтийн оролцоог улам өргөтгөх, хууль хэрэгжүүлэгчдийн болон ашиг сонирхлын бүлгүүдийн саналыг харгалзан тусгах, хууль боловсруулах ажиллагаанд баримтлах аргачлалыг нэгдсэн бодлогоор тогтоож мөрдүүлэх, хуулийн техник, нэр томьёо, хэл найруулгыг сайжруулах, хуульд хэрэглэсэн нэр томьёо нь олон салаа утгагүй нэг мөр тогтвортой хэрэгжих нөхцөл, механизмын үндэс суурийг тавилаа гэж үзэж байна. Уг хуулийн дагуу хуулийн төслийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах тогтолцоог бий болгож, Хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” гэсэн 6 аргачлалын хүрээнд хууль тогтоомжийг шинэтгэх ажлын стандарт, чанар улам сайжрах төлөвтэй. Гэхдээ уг хуулийг мөрдөх, хэрэгжүүлэх явцад шаардагдах хүний нөөц, төсөв санхүүжилтийг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Эрх зүйн шинэтгэлийн стратегийн баримт бичгийг боловсруулах”-аар тусгасан боловч өнөөгийн байдлаар хэрэгжээгүй байна. Гэвч энэ арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан эрх зүйн шинэтгэлийн хүрсэн үр дүн ба цаашид

гүнзгийрүүлэх хэрэгцээ, шаардлага, хүрээ, зорилт, чиглэлийн талаар асуудал хөндсөн олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, хэлэлцүүлэг болон холбогдох бусад ажлын үр дүнг тоймлон судалгааны “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгцээ, шаардлага, цаашдын зорилт, чиглэл” хэсэгт тусгав.

Түүнчлэн тус судалгаагаар эрх зүйн шинэтгэлийн бодлогын талаарх олон улсын чиг хандлагыг тандан, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд болон Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал/2016-2030/-ыг харьцуулан судалж, эрх зүйн шинэтгэлд хамаарах зорилт, зорилгыг тодорхойлж, Монгол Улсын өнөөгийн байдлыг харгалзан эрх зүйн шинэтгэлийн цаашдын бодлого, чиглэлийн талаар санал, зөвлөмж боловсруулж бодлогын баримт бичиг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Судалгааны сэдвийн цар хүрээ өргөн бөгөөд ажлын нэгдсэн тайлан эцэслэн гараагүй байгаа тул тус судалгааны томоохон хэсэг болох “Шүүхийн шинэтгэл, хүрсэн үр дүн, цаашдын асуудал” дэд хэсгийн үр дүнг илтгэе.

Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал

Шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах нь хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг тогтоох үндэс суурь билээ. Шүүх бие даасан, шүүгч хараат бус байх нь иргэний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг бодитой хамгаалах хүчирхэг механизм, шүүх эрх мэдлийн эрх зүйн баталгаа мөн. Тийм учраас бие даасан, хараат бус шүүхийг тогтоох нь эрх зүйт төрийн нэг гол зорилт, шалгуур болдог.¹¹⁾ Монгол Улс 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Үндсэн хуулийн зарчим, агуулгад нийцүүлж шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг эрх зүйт төрийн үзэл баримтлалд нийцүүлж төлөвшүүлэх талаар шинэтгэл хийсэн.

Уг шинэтгэлээр хийгдсэн ажлуудыг он дарааллын хувьд дараах мөчлөгт хамааруулан түүхчлэн шинжлэн судлав. Үүнд: 1/ 1993 - 2002 он; 2/2002-2012 он; 3/ 2012 онд шүүхийн тухай багц хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойшхи үе гэж авч үзнэ. Ийн судлахдаа 1993-2002, 2002-2012 онуудад хэрэгжүүлсэн шүүхийн шинэтгэлийн үр дүнг товч үнэлж, 2012 онд батлагдсан шүүхийн тухай багц хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойш хийгдсэн шинэтгэлийг дэлгэрэнгүй судаллаа.

11) Кристофер Осаке Харьцуулсан эрх зүйн судлал: ерөнхий ба тусгай анги. Бүдүүвч, Орчуулсан Ж.Нямдорж, Л. Намхай, Л.Ундрах, /УБ, 2005/, 54.

“Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр” нь “Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”; Монгол Улсын Их хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; мөн Монгол Улсын Их хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”; Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т тодорхойлсон зорилтуудад нийцүүлэн батлагдсан шүүх эрх мэдлийн шинэтгэлийн стратегийн гол баримт бичгүүдийн нэг юм.

Дээр дурдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 39 дүгээр захирамжаар батлагдсан “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэл”, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2014-2020 онд шүүхийн хөгжлийн стратегийг тодорхойлсон 5 дэд хөтөлбөрийг 2014 онд баталсан. Уг хөтөлбөрт а/ Шүүхийн шинэ менежмент хөтөлбөр; б/ Шүүхийн хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр; в/ Шүүгч, ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр; г/ Шүүхийн хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр; д/ Шүүх ба олон нийт гэсэн хөтөлбөрүүд батлагдсан.

Дээрх хөтөлбөрт заагдсан шалгуур үзүүлэлтэд тулгуурлан шүүхийн шинэтгэлийг 1/ Шүүхийн тогтолцоо; 2/ Шүүхийн бие даасан байдал; 3/ Шүүгчийн хараат бус байдал; 4/ Шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалт; 5/ Шүүхийн ил тод, нээлттэй байдал; 6/ Шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллага гэсэн дэд хэсгүүдэд хуваан авч судалсан ба судалгааны дүгнэлт, санал хэсгийг тоймлон¹²⁾ энэхүү илтгэлээр хүргэе.

1. Шүүхийн тогтолцооны тухайд

Шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдал нэмэгдэх нь тухайн улсын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхийн сацуу авлига, хээл хахуулийн гэмт хэрэг буурах нэг хүчин зүйл болдог.¹³⁾ Судлаачдын үзэж байгаагаар шүүхийн тогтолцоо сул, шүүхийн үйлчилгээ иргэдэд хүртээмжгүй, чанаргүй бол нэг хүнд ногдох дотоодын нийт

12) Судалгааны дүгнэлт, санал гаргасан үндэслэл, иш татсан эх сурвалжийн мэдээллийг энэхүү илтгэлд дурдаагүй тул судалгааны үндсэн тайлангаас үзнэ үү.

13) Wittrup, Jesper. “Budgeting in the Era of Judicial Independence.” International Journal for Court Administration, April 2010. http://www.iaca.ws/files/Jesper_Wittrup4-2010.pdf.

бүтээгдэхүүний хэмжээ болон хөрөнгө оруулалтыг 10 хүртэл хувиар бууруулдаг байна.¹⁴⁾ Ийм учраас дэлхийн улс орнууд хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангаж ажиллах бие даасан шүүх эрх мэдлийг төлөвшүүлэх, институтын хувьд чадавхийг нь бэхжүүлэх талаар анхаарч шүүхийн улс төр, эдийн засаг, хууль зүйн баталгааг хангаж ажиллаж ирсэн.

Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлтийн нэг болох шүүхийн тогтолцооны өөрчлөлтөд дүн шинжилгээ хийхэд шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр буюу шүүхийг дагнан байгуулснаар шүүгч илүү мэргэшэх, энэ нь шийдвэрийн чанарт нөлөөлөн улмаар ажлын ачаалал буурах эерэг үзүүлэлттэй судалгааны дүн гарсан боловч хууль санаачлагчийн зүгээс шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдлийг гаргахдаа хууль тогтоомжийн онолын буюу суурь судалгаа хангалттай хийгээгүй, түүнчлэн хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг хийгээгүйгээс болж шинэтгэлийн томоохон ажлуудын нэг болох дагнасан шүүхийн тогтолцооны хэрэгжилтэд хүндрэл учирсан болох нь тогтоогдсон. Иймд аливаа шинэтгэлийн ажлыг эхлүүлэхдээ судалгаатай хандах, онолын болон хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг ул суурьтай хийж хэвших шаардлагатай гэж үзэж байна. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүхийн тогтолцоонд “тойргийн” зарчим нэвтрүүлснээр буюу шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан байгуулснаар шүүхийн харилцан адилгүй ачааллыг бууруулах, шүүх, шүүгчийг мэргэшүүлэх, мэргэшсэн шүүгчээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрх зүйн үндэс бүрдэх ач холбогдолтой. Иймд цаашид шүүхийн дагнасан тогтолцооноос ухрахгүй байх, одоогийн хүрсэн амжилтаа ахиулж, цаашид шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан мэргэшүүлэх асуудлыг аль болох хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай;
- Шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан дээр дурдсан хүндрэл бэрхшээлүүдийг цаашид давтахгүйн үүднээс хууль тогтоогчоос хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа судалгаатай хандах буюу онолын суурь болон хавсарга судалгааг хийх, түүнчлэн хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг ул суурьтай хийж хэвших шаардлагатай.

14) 2012 онд УИХ-д өргөн баригдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох бусад хуулийн төслийн танилцуулга. www.parliament.mn.

2. Шүүхийн бие даасан байдлын тухайд

Шүүхийн бие даасан байдлыг хувь хүний болон институцийн талаас нь авч үздэг.¹⁵⁾ Шүүхийн /институцийн/ бие даасан байдлыг хангах гэдэг нь хоёр үндсэн утгыг илэрхийлдэг. Үүнд нэг талаас шүүх эрх мэдлийг төрийн бусад эрх мэдэл болох хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс харьцангуй бие даалгах¹⁶⁾, нөгөө талаас шүүх эрх мэдлийг шүүх бүр бие даан [тусгаар] хэрэгжүүлэх агуулга багтдаг.¹⁷⁾ Үүнийг энгийнээр илэрхийлвэл шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахад шүүхийг гаднаас буюу төрийн эрх мэдлийн бусад субъектээс хамгаалах, нөгөө талаар шүүхийг шүүхийн өөрийн удирдлага, захиргаанаас хамгаалах гэж ойлгож болох юм. Энэ талаар Доктор Г.Совд “шүүхийн бие даасан байдал гэж шүүхийн Үндсэн хуулийн статусыг хангахыг..., ...”¹⁸⁾ хэлнэ гэж товчхон тодорхойлжээ.¹⁹⁾

Монгол Улсын шүүхийн шинэтгэлээр дэвшүүлсэн томоохон зоритуудын нэг бол шүүхийг бие даан үйл ажиллагаагаа явуулах хэмжээний төсвөөр хангах, шүүхийн эдийн засгийн баталгааг сайжруулах зорилт байсан. 2012 оноос хойш хийгдсэн шүүхийн шинэтгэлээр шүүхийн бие даасан байдал тэр дундаа шүүхийн эдийн засгийн баталгаа сайжирсан талаар судалгааны дүн гарчээ. Энэ нь шүүхийн бие даасан байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлийг байгуулсан, мөн шүүхийн тухай багц хуулиудад шүүхийн эдийн засгийн баталгааг хангах талаарх зохицуулалтууд өмнөх хуулиудтай харьцуулахад харьцангуй сайн тусгагдаж, хуульчлагдсан зэрэгтэй холбоотой.

Судалгаагаар шүүхийн эдийн засгийн баталгаа хангагдах эрх зүйн зохицуулалт сайжирсан

15) Vicki C. Jackson, “Judicial Independence: Structure, Context, Attitude,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr /Springer Science & Business Media, 2012/, 22–23.

16) О.Мөнхсайхан нар, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, /УБ: Нээлттэй нийгэм форум, 2015 он/, 28.

17) Б.Чимид, “Шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд”, илтгэл, /“Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурал, УБ, 2001 он/, 56.

18) Г.Совд, “Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд”, Монголын төр, эрх зүй, Дугаар 02, /УБ, 1997/, 1.

19) Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”; 47.3-т “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна”; 48.2-т “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”; 48.3-т “Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана”; 49.3-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана” гэх зэргээр шүүхийн бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтоож өгчээ.

гэж гарсан боловч хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс шүүхийн төсвийг бууруулах ёстой гэсэн хандлага хэвээр байна. Тухайлбал, шүүхийн эдийн засгийн баталгааны гол амин сүнс болсон заалтууд болох ШТХ-ийн 28.5-д “шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийн хэмжээнээс бууруулахыг хориглоно”, ШЭЗБТХ-ийн 23.5-д заасан “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй” гэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгосон нь шинэтгэлээр хийж хэрэгжүүлсэн ажлаасаа ухарсан алхам болжээ.

Эдгээр заалтуудыг хүчингүй болгосон нь шүүхийн төсвийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс бууруулах замаар шүүхийн төсвөөр дамжуулан шүүхийн хараат бус байдалд халдах эрсдлийг бий болгож болзошгүй. Иймд дээрх заалтуудыг сэргээн хуульчлах, мөн шүүхийн төсвийн хэмжээг улсын нэгдсэн төсөвт эзлэх хувийн доод хэмжээг хуульчлах, “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх” хөтөлбөрт тусгасан шүүхийн төсвийн хэмжээ улсын нэгдсэн төсвийн 1.5 хувьд хүргэх зорилтыг хангаж ажиллахад анхаарах шаардлагатай.

ШЗТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1 болон ШТХ-ийн 28.5 дахь хэсэгт байгаа “Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэх” гэсэн заалт нь Үндсэн хууль болон холбогдох хуулиудтай зөрчил үүсгэж болзошгүй байдалд анхаарч, шүүхийн төсвийг үндэслэлгүйгээр бууруулах байдлаас сэргийлэх хуулийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай. /Энэ талаар хууль тогтоомжийг хэрхэн өөрчлөх боломжтой талаар бодлогын хувилбар дэвшүүлснийг судалгааны “Шүүхийн бие даасан байдал” хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү/ Түүнчлэн, шүүх хэвийн үйл ажиллагаагаа явуулах зохих байраар хангагдаагүй, шүүхийн байранд шүүхээс бусад байгууллагууд /прокурорын байгууллага/ хамт байршиж байгаа явдалд анхаарал хандуулж Монгол Улсын ШТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтад заагдсан “Шүүх өөрийн байртай байна” гэсэн заалтыг мөрдөх хүрээнд шүүхийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийг хангалттай хэмжээгээр батлах шаардлагатай. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүхийн төсвийн хэмжээний улсын нэгдсэн төсөвт эзлэх хувийн доод хэмжээг нэг хувиас дээш хэмжээтэй болгож хуульчлах;
- ШЗТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1 болон ШТХ-ийн 28.5 дахь хэсэгт “Ерөнхий зөвлөл бүх

шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэх” гэсэн заалт нь холбогдох хуулиудтай зөрчил үүсгэж болзошгүй байдалд анхаарч шүүхийн төсвийн хэмжээг үндэслэлгүйгээр бууруулахаас сэргийлэх зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах;

- ШТХ-ийн 28.5-д “шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийн хэмжээнээс бууруулахыг хориглоно”, ШЭЗБТХ-ийн 23.5-д заасан “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй” гэсэн заалтуудыг хүчингүй болгосныг сэргээн хуульчлах;
- Шүүхийн ерөнхий зөвлөлд хэт өргөн эрх хэмжээ олгогдсонтой холбогдуулан ШЕЗ-ийн гишүүний ёс зүйн дүрмийг батлах, нөгөө талаар шүүхийн захиргааны зарим чиг үүргийг хороодоор дамжуулан хэрэгжүүлэх талаар судлах.

3. Шүүгчийн хараат бус байдлын тухайд

Шүүгч гэдэг бол хэргийн оролцогчид түүнд хамааралтай, сонирхолтой этгээдүүдийн олон эрх ашгийн уулзвар, огтлолцол, зөрчилдөөнтэй асуудлаар хамгийн дээд эрх ашиг буюу хуулийн дагуу шийдвэр гаргах үүрэгтэй онцгой субъект. Шүүгч шударгаар ажиллаж, хуулийн дагуу шийдвэр гаргахын тулд бусад эрх мэдэлтэй, хөрөнгөтэй хүмүүсээс хамгаалагдсан байх ёстой. Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын нэг гол тулгуур зарчим бол шүүх биеэ даасан байхын зэрэгцээгээр шүүгч хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах чадварыг хангах явдал. Энэ талаар Доктор Н.Лүндэндорж “... шүүх бие даасан байвал гадны аливаа хууль бус нөлөө шүүгч рүү чиглэх юм. Харин шүүх бие даасан бус байвал хууль бус нөлөө шүүгч рүү бус, тэдний үйл ажиллагаанд хяналт тавьдаг институц рүү чиглэдэг²⁰⁾ хэмээн дүгнэсэн байдаг.

Монгол Улсын шүүхийн шинэтгэлээр хийгдсэн томоохон өөрчлөлтүүдийн нэг бол ШЭЗБТХ-ийн 22 дугаар зүйлд заасны дагуу “нөлөөллийн мэдүүлэг” хөтлөх болсон явдал. Энэ нь шүүгчийн хараат бус байдлыг хангахад тодорхой ахиц дэвшил бий болгосон бөгөөд нөлөөллийн мэдүүлгийн ач холбогдлыг цаашид сурталчлан таниулах, хуулийн хүрээнд хөтөлж явуулах нь шүүгчийн хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн

20) Н.Лүндэндорж нар, Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь Бодлогын тойм судалгаа, /УБ: Нээлттэй нийгэм форум, 2010/, 39.

ШЭЗБТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь шүүгч эдийн засгийн хувьд хараат бусаар ажиллаж, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байна” гэж заасны дагуу шүүгчийн цалинг шат дараатай нэмэгдүүлсэн нь шүүгчийн хараат бус байдлыг хангахад ахиц дэвшил гарчээ. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүгчийн цалинг тогтоохдоо хууль тогтоогч бодит тооцоо, судалгаанд тулгуурлаж тогтоох, шүүгчийн цалинг инфляцийн түвшинтэй уялдуулж тогтоох зэрэг асуудлыг анхаарах шаардлагатай;
- ШЭЗБТХ-ийн 23.5-д "Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй" гэсэн заалтыг хүчингүй болгосныг сэргээн хуульчлах шаардлагатай;
- Шүүгчийн хариуцлагын тогтолцоог сайжруулах үүднээс шүүгчийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын асуудлыг Шүүхийн ёс зүйн хороо болон Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хороо шийдвэрлэдэг чиг үүргийн давхардлыг арилгах, шүүгчийн мэргэжлийн ёс зүйн алдааг нэг байгууллага буюу Шүүхийн ёс зүйн хороо шийдвэрлэх талаар хууль зүйн давхардлыг арилгах.

4. Шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалтын тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3-т “шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана” гэж тусгажээ. Энэ байгууллага 1993-2012 он хүртэл УДШ болон Хууль зүйн яамны дэргэд хавсарга байдлаар орон тооны гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байсан нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад үр нөлөө муу байв. Иймд 2012 онд батлагдсан Шүүхийн багц хуулиудын хүрээнд Үндсэн хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагыг байгуулсан явдал шүүхийн эрх зүйн шинэтгэлд чухал ач холбогдолтой болсон. Энэ байгууллага байгуулагдсанаар шүүхийн шинэтгэлийг дагнан хэрэгжүүлэх олон арга хэмжээ авч байгаагийн дотор шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалт чухал байр суурийг эзэлнэ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээг өргөтгөснөөр шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаа шинэ шатанд гарсан. Үүнд: 1/ 2012 оны Шүүхийн тухай хуулиар

Шүүхийн мэргэшлийн хороог шинэчилэн байгуулсан. 2/ 2012 оноос өмнөх үетэй харьцуулахад шүүхийн хүний нөөц нэмэгдсэн 3/ Шүүгчид нэр дэвшигчийн бүрэлдэхүүнийг өргөтгөсөн буюу шүүхийн захиргааны ажилтнуудаас бусад өөр өөр төрлийн ажил эрхэлж байсан туршлагатай хүмүүс анхан шатны шүүхэд нэр дэвшиж шүүгчээр томилогдсон. 4/ шүүгчийн сонгон шалгаруулалт, шалгалтын талаарх мэдээлэл илүү ил тод болсон. Шүүгчийн сул орон тоонд шалгаруулалт зарласан зар, шалгалтын болон ярилцлагын хуваарийг ШЕЗ-ийн цахим хуудсанд тухай бүр мэдээлдэг болсон зэрэг дэвшилттэй зүйлүүд бий болсон.

Шүүхийн тухай багц хуулийг баталснаар шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаанд дээр дурдсан дэвшилттэй зүйлүүд гарч байгаа боловч судлаачид шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн томилгоо шударга явагдахгүй байгаа талаар шүүмжлэлтэй хандсаар байна. Тухайлбал, шүүгчийн сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигч шүүгчээр сонгогдож чадахгүй байгаа мөн шүүхийн тогтолцоог өөрчлөн байгуулсантай холбогдуулан зарим шүүгчийг буцаан томилоогүй явдал гарсан талаар судлаачид шүүмжлэлтэй хандаж байна. Түүнчлэн шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагааны журам тодорхой бус, шүүгчийн нэр дэвшигчийн талаарх дүгнэлт хэлбэр төдий явагддаг зэрэг асуудлууд гарч байна.

Иймд Шүүгчийн хараат бус байдлын баталгааны нэг үндсэн шалгуур үзүүлэлт болох шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн томилгоогоор дамжуулан Монгол Улсын Ерөнхийлөгч болон Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус байдалд халдаж болзошгүй байгаа байдалд анхаарал хандуулж шүүгчийн хараат бус байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүгчийн сонгон шалгаруулах чиг үүргийг ШЕЗ-өөс тусдаа бие даасан Мэргэшлийн хороо хэрэгжүүлэх;
- Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулалтыг явуулахдаа Шүүхийн мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн хүмүүсээс нэр дэвшүүлэхдээ шалгалтын онооны эрэмбийг гол шалгуур үзүүлэлт болгон авч үзэх, Мэргэшлийн хорооноос хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилох;
- Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагааг хийхдээ шүүгчид

нэр дэвшигчийг ямар үндэслэлээр Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн болох мөн нэр дэвшигчийг шүүгчээр томилуулахгүй болсон бол үндэслэлээ бичиж, тодорхой тайлбар хийх талаар хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох;

- Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор шүүгчдийг томилохдоо шүүгчийг дахин томилохоос татгалзах, шүүгчийг өөрчлөн зохион байгуулагдсан шүүхэд нь бус өөр шүүхэд, мөн дээд шатны шүүхийн шүүгчийг доод шатны шүүхийн шүүгчээр шилжүүлэн томилсон зэрэг ажиллагаанд ямар үндэслэлээр, яагаад буцаан томилохгүй байгаа үндэслэлээ тайлбарлах, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай;
- Шүүхийн хүний нөөцийн бодлогыг сайжруулах үүднээс шүүгч бэлтгэх сургалтын тогтолцоог сайжруулах, энэ үүднээс шүүгч бэлтгэх дагнасан сургалттай сургууль нээх боломжийг судлах, түүнчлэн шүүгчийг бүх насаар нь томилохоос өмнө “туршилтын хугацааны шүүгч”-ээр 3-5 жилийн хугацаагаар ажиллуулсны дараа шүүгчийг бүх насаар нь томилох зэрэг гадаад орнуудын туршлагыг судлах шаардлагатай.

5. Шүүхийн ил тод, нээлттэй байдлын тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин дөрөвдүгээр зүйлд “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ” гэж заасан ба 2002 оны Шүүхийн тухай хуульд шүүх хуралдааныг нээлттэй явуулна гэж тусгажээ.²¹⁾ Энэ нь шүүх хуралдаан хориглосноос бусад тохиолдолд нээлттэй явагдах, шүүхийн шийдвэр нээлттэй байх гэсэн утгыг илэрхийлж байна.

“Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь дэвшилттэй алхам болжээ. Иймд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг цаашид гүнзгийрүүлэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, судалгааны эргэлтэнд оруулах нь хууль зүйн шинжлэх ухааны цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэрийн ил тод байдалд анхаарч хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой шийдвэрийн нууцлал, ялангуяа гэр бүлийн хүрээний маргаан зэрэг хувь

21) Шүүхийн тухай хууль (2002)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1

хүний нууцтай холбоотой шийдвэрүүдийг олон нийтэд нээлттэй, ил тод байрлуулах нь зохистой эсэхэд анхаарах;

- Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ тогтмол хийж, судалгааны эргэлтэнд оруулахад анхаарах шаардлагатай.

6. Шүүх эрх мэдлийн хүрээний бусад /оролцогч/ байгууллагын тухайд

Монгол Улсын Үндсэн хуулийн “Шүүх эрх мэдэл” гэсэн Дөрөвдүгээр бүлэгт шүүх, прокурорын байгууллагын тогтолцоо, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн бүрэн эрх, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн зохион байгуулалт, бүрэн эрхийн асуудлыг хуульчилжээ. Мөн шүүх хэвийн үйл ажиллагаа явуулахад туслах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй Цагдаагийн байгууллага, Өмгөөллийн байгууллага, Тахар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг байгууллагуудын эрх зүйн үндсийг холбогдох хуулиар зохицуулсан.

Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхэлснээс хойш буюу шүүхийн тухай багц хуулиуд батлагдсантай холбогдуулан шүүх эрх мэдлийн хүрээний байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр олон ажлууд хийгдсэний дотор Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлсэн нь шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон ажлуудын нэг болжээ. Шүүхийг тойргийн тогтолцоогоор шинэчлэн зохион байгуулахтай уялдуулан прокурор, цагдаа, мөрдөх албаны зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэх, эдгээр байгууллагуудын болон хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээний ажлын ачаалал нэмэгдсэн зэрэг хүндрэл бэрхшээлүүд гарч байна.

Мөн шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллагуудын эдийн засгийн баталгаа хангагдахгүй байгаа байдалд анхаарч эдгээр байгууллагуудад шаардлагатай хэмжээний төсвийг батлах шаардлагатай. Иймд эдгээр байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, мөн дээрх байгууллагуудын эдийн засгийн баталгаа, цалин хангамжийг шүүгчийн цалинг нэмэгдүүлсэнтэй дүйцүүлэх хэмжээгээр сайжруулахад анхаарах хэрэгтэй. Үүнтэй уялдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шүүх, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулахад анхаарах;
- Шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллагуудын эдийн засаг, нийгмийн баталгааг

хангах, эдгээр байгууллагуудын ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулахад анхаарах;

- Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, түүнчлэн улс төрөөс хамаарахгүйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Ийнхүү тус илтгэлд Эрх зүйн шинэтгэл: Хүрсэн үр дүн /2008-2016/, цаашдын зорилт, чиглэл” судалгааны талаар товч танилцуулж, тус судалгааны “Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, цаашдын асуудал” дэд хэсгийн дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг жишээ болгон авч үзлээ. 1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг албан ёсоор хаагаагүй ч бидний судалгаа цаашид эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан гаргах ажилд нэмэлт мэдээлэл болно хэмээн найдахын зэрэгцээ эрх зүйн шинэтгэлийн бодлогод харгалзан үзэж болох үндэслэлүүдийг гаргахыг зорьсон болно.

Эрх зүйн шинэтгэл нь өргөн хүрээтэй цогц асуудал тул бодлогын баримт бичгээр дамжиж хийгдэх ёстой бөгөөд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх үндсэн зорилго, зорилт, арга хэмжээ, баримтлах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлтийг үнэлэх/хэмжих шалгуур үзүүлэлтийг цогцоор нь тусгасан байвал зохих талаар тус судалгаанд зөвлөмж болгосон. Бодлогын баримт бичигт эрх зүйн шинэтгэлийн тусагдахуун болох хууль тогтоомжийг шинэтгэх, хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх, хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх, хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх, нийгэмд эрх зүйн ухамсар төлөвшүүлэх чиглэлүүдийг хамтад нь хамруулах байдлаар хэрэгжүүлэх арга хэмжээг зорилтот чиглэл бүрээр төлөвлөн боловсруулах нь зүйтэй. Ингэхдээ 1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, түүний хэрэгжилт, гарсан үр дүн, үр нөлөөг сургамж болгон харгалзах хэрэгтэй. Зарим томоохон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тооцож тухайн баримт бичигт дэвшүүлсэн зорилтот арга хэмжээ хэрэгжсэн эсэхийг эцэслэн үнэлгээ хийж бодлогын залгамж холбоонд оруулдаггүй байдал судалгаа хийх явцад ажиглагдав. Аливаа бодлогын баримт бичгийг боловсруулахдаа судалгаанд суурилож, өмнө батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн үр дүнг заавал

харгалзах ёстой. Ингэхгүй тохиолдолд бодлогын залгамж чанар алдагдах, ололт амжилтаас ухрах, алдаан дээрээ суралцах боломжгүй байдал үүсэх магадлалтай. Түүнчлэн эрх зүйн шинэтгэлийн чиглэл, зорилт, арга хэмжээг тодорхойлохдоо эрдэмтэн судлаач, мэргэжилтэн, иргэд, олон нийтийн оролцоог хангах, тэдгээрийн санал, зөвлөмжийг тусгах, хэлэлцэж зөвлөлдөх арга ажиллагаа нэн чухал болохыг онцолж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

몽골의 법제개혁: 사법개혁의 실행, 성과와 과제

울란바타르 시

2016.07.15.

발표자:

국립법제연구원 원장, 박사 에. 바트бая르

국립법제연구원 정책지도연구원 베. 옹호 아마글랑

국립법제연구원 정책연구원 제. 알투스호

1990년 이후 몽골국의 법제개혁 발전 문제를 신헌법 제정까지의 시대(1990-1992), 법제개혁 프로젝트 확정까지의 시대(1992-1998), 현대시대(1998년 이후)로 구분한다. 헌법으로 공포한 원칙, 사상들에 따라 국가의 모든 각급 기관, 공무원들의 실행 가이드라인을 명확히 하고, 정치, 사회, 경제의 발전과 발전을 지원하는 법률적 근거와 최적화된 환경을 조성할 목적으로 법령을 정비하여 안정적으로 발전시키는 과제의 범주에서 1998년 “몽골국 법제개혁 프로젝트”, “몽골국 법령의 2000년도까지의 정비 가이드라인”, “몽골국 법제개혁 프로젝트의 실행 조치계획”을 정하였다.¹⁾

법제개혁 프로젝트에는 법제개혁의 목적, 원칙, 방법론의 근거를 명확히 하고 이를 시행할 7가지 기본방향²⁾의 총 56개 목표에 조치를 집중시켰다. 법제개혁의 목적은 해당 국가에 인본주의적 민주주의 사회를 구축 발전시켜 나갈 목적을 실현하고자 헌법에서 공포한 원칙, 사상에 따라 국가의 모든 각급 기관 및 공무원들이 실행할 프로젝트의 기본방향을 명확히 하고 정치, 사회, 경제의 발전과 진보를 지원할 법적 근거와 최적의 환경 조성에 그 목적이 있다고 해당 프로젝트에 명시하였다.

법제개혁 범주 내에서의 법령개혁의 절차를 살펴보면, 몽골 국회에서 법령정비 업무를 일정 기간 동안에 기획하는 차원에서 “기본방향 제정에 관한” 국회 2001년 44호, 2005년 26호, 2009년 38호 규칙을 각 각 연속적으로 제정하고, 실행에 대한 감사를 진행해왔다. 법령을 2016년까지 정비할 기본방향안을 정비하여 국회에 상정하였으나, 정치적 상황으로 인해 제정

1) “프로젝트, 가이드라인, 계획 확정에 관한” 국회의 1998년 18호 규칙.

2) 몽골국의 독립을 보장하는 법적 근거를 실효성 있게 함; 시장관계법의 근거의 정비; 인권, 자유와 이를 보호하는 법적 보장; 국가기관의 법적근거 정비; 법제개혁 환경조성; 법전문인력 교육 및 양성 정비; 국제법 규정에 대한 몽골국의 참여 확대; 라는 7대 방향성이 있다.

불필요 라는 결정이 내려졌다. 2012년 이후로, 몽골정부의 사업프로젝트와 몽골국 천년개발목표에 근거한 국가발전통합정책³⁾, 사법권개혁심화 프로젝트 등 문서상에서의 법제개혁의 정책, 목표, 조치, 법령개혁은 실행되어왔다.

법제개혁 프로젝트가 1998년 제정된 후로부터 18년이라는 세월이 흘렀다. 2008년도까지는 법제개혁 프로젝트와 그 조치의 실행, 성과에 대한 사전 특별연구, 평가가 되고 있지 않았다. 프로젝트에 반영된 법률들의 제정여부를 감사하여, 이러한 법률 리스트를 개혁하는 것을 과제의 중점으로 두어왔다. 이러한 이유에서 프로젝트 실행에 대한 포괄적 감사, 연구, 평가에 대한 필요성을 고려해 법무부와 내무부 장관의 2007년 36호 시행령으로 “법제개혁 프로젝트 감사, 연구, 평가 업무 지도”, “감사, 연구, 평가 업무 총체적 도표”를 제정하여, 법무부와 내무부 서기관의 2007년 3월 12일 42호 시행령으로 프로젝트의 실행에 대한 감사, 연구, 평가 부분과, 8개 소제목으로 나누어 구성하여⁴⁾ 해당 프로젝트의 2008년까지 수행한 연구에 대한 보고서를 제출하였다.

이 발표를 통해 2008년 이후의 법제개혁의 성과에 대한 연구인 “법제개혁: 거둔 성과(2008-2016), 앞으로의 목표, 방향” 연구에 관해 간략히 소개하고, 이러한 연구의 범주 내에서 실행한 “사법개혁의 실행, 성과, 과제” 라는 주제에서 소주제의 연구 성과를 엮어서 다뤘다.

“법제개혁: 거둔 성과(2008-2016), 목표, 방향” 연구에 관하여

국립법제연구원은 법무부의 연구 의뢰에 반영된 문제⁵⁾들을 연구하여 법제개혁전략문서 정비 업무를 지원하고자 하는 범주에서 “법제개혁: 거둔 성과(2008-2016), 목표, 방향” 이라는 주제로 연구를 진행하였고⁶⁾, 현재 보고서 정비 단계에 있다.

연구의 “법제개혁 2008년 이후 실행, 성과, 방향” 부분에서 해당 프로젝트의 실행절차, 법률 정비기본방향의 실행과 프로젝트의 몽골국 주권보장의 법적근거를 마련; 경제관계의 법적근거 정비; 인권, 자유의 법적보장; 국가기관의 법적근거 정비; 법제개혁환경 조성; 법전문인력 양성 및 교육체계정비; 국제법규정에서의 몽골국의 참여 확대라는 7대 기본방향 제안 및 56개의 목표실행에 대한 분석과 향후 법제개혁이 집중해야 할 과제들을 접목하는데 그 중점을 두었다.

3) “몽골국의 지속개발기조 - 2030 제정에 관한” 국회의 2016년 02월 05일 19호 법률로 “몽골국천년개발목표에 근거한 국가발전통합정책 제정에 관한” 국회의 2008년 12호 법률을 무효화 하였다.

4) 몽골국 법제개혁 프로젝트 감사, 연구, 평가 보고서, 국립법제연구원, 2008, 울란바타르 시, 8쪽

5) 법무부의 2016년 4/487호 공문으로 연구의 필요성을 명확히 하여, 송달된 문제들을 연구에 포함시켰다.

6) 이러한 연구는 독일국제협력 원조기관(GIZ)의 “경제안정발전 법제환경 확정안”의 지원으로 전문가, 연구원, 다수의 참여를 독려하며 수행하고 있다.

법무부의 의뢰와 연구팀 측에서 분류를 통한 연구방법이 적합하다는 의견에 따라 “형법의 법제개혁, 성과, 목표, 방향”, “행정법의 법제개혁, 성과, 목표, 방향”, “사법개혁의 실행, 성과, 과제”, “경제분야의 법제개혁, 경향” 이라는 주제로 면밀히 연구하여 주제별 보고서를 작성하였다. 경제분야의 법제개혁의 성과, 향후 목표와 방향성을 미리 엿볼수 있는 비즈니스, 중소기업 운영 법환경의 현주소, 향후 정비의 필요성에 대하여 “어일트” 연구소와 협력해 국민, 산업체 대상으로 설문조사를 시행하여 그 성과를 반영하였다.

연구 결과, 1998년 제정된 법제개혁프로젝트에서 제안한 초기목표에 어느 정도 도달하였다. 법제개혁프로젝트 실행에 대한 2008년 한 평가보고서에서 “법제개혁프로젝트는 근본적으로 실행되었고, 법제개혁목표는 법률수준에서 실현되었다.... 그러나 법준수 원칙을 국가 사업에 정착, 법준수에 대한 사회의식 조성이라는 목표는 충족되지 못했다.” 라는 결론은 지금까지 인정되고 있다..

저명한 학자이신 B. 취미드 박사의 저서⁷⁾에서 법제개혁의 보완점에 대하여 취해야 할 5가지 기본방향으로; 법제개혁은 법률개혁만이 아닌 입법, 행정의 지원, 법해석체계, 방법 개혁, 법전문교육 개혁, 법연구학회 개최, 방법론의 개혁, 사회의 법의식 고취 등을 통합적으로 제시함으로써 그 의의에 대해 설명하였다⁸⁾.

법제개혁의 5가지 보완점을 기준으로 룬텐도르츠 교수, 궁빌렉 박사⁹⁾ 등의 학자들은 법제개혁의 성과에 대한 결론을 내렸다. 이 연구를 통해, 2008년 이후의 법제개혁의 성과를 위의 5가지 보완점으로 결론을 내렸다. 발표기간에 따라 법률개혁의 성과에 대한 간략한 결론을 내려 보고자 한다.

수치 면에서 볼 때 법률개혁은 활발히 이루어졌었다. 예를 들면, 2012-2016 사이에 국회에서 1,254개 법률을 제정하였고, 그것들 중 단일법률의 수가 125개, 개정이 957개, 폐지가 104개, 국제협약 비준이 58개였다. 또한 이 기간 동안 국회에서는 405개 규칙을 제정하였다.

법무부에서 2012-2016년의 기간 동안 법제개혁의 범주내에서의 형법, 분쟁법, 가정폭력방지법, 증인 및 피해자 보호법, 보상무능력피고인 법적지원법, 법률에 관한 법, 행정법, 행정소송법, 법인등기법, 동산 및 무체물재산담보법, 법수호에 관한 법, 형사소송법, 판결집행법, 경찰법, 검찰청법, 자금세탁방지 및 테러자금지원 방지법, 총기법, 사면법, 투명경제 지원법 등 20개 법률을 정비하여 국회에서 제정하였다. 이러한 법들과 함께 다른 여러 법들도 개정하였다.

7) B. 취미드, 국가, 정당, 법제개혁의 복잡한 문제, 제 2편, 울란바타르 시, 2008년, 15-16쪽

8) “몽골의 법제개혁 - 8년” 발표 및 조인 책자, 울란바타르 시, 2003년, 463-478쪽

9) B. 궁빌렉, 몽골국의 새로운 시대의 법발전 경향, “몽골국법발전과제” 소학술회 책자, 울란바타르 시, 2011년, 36-37쪽

예를 들면, 형법과 분쟁법의 제정으로 200여개 법들이 개정되었다. 또한 법안정비 후 국가대 회의의 심의단계에 있는 법들도 있다.

2012-2016년 전반기의 상황의 경우, 법무부에서 정비하고 국회가 제정한 법안의 소개와 그 기초를 연구해 보면 법률안들을 과학적 근거 면에서 다듬고, 대중이 토의하고 의견을 얻는 방식을 통한 법안정비업무가 활발히 진행되어, 정착하려는 경향이 관찰되었다.

새로이 제정된 법률에 관한 법¹⁰⁾은 법률개혁만이 아닌 법제개혁의 또 다른 과제들을 해결할 법적근거를 조성한 큰 성과라는 점을 강조하고 기억해야 한다. 이 법으로 법발의자들은 법안정비 전 해당 관계의 법적근거의 특성, 법실행자들에게는 현실적 직면 문제들, 또한 민원과 정보를 통해 제기된 문제에 대해 평가와 결론을 내려서, 법률을 새로 제정할 필요성을 현실적이고 명확하게 함과 동시에 해당 법이 제정됨으로써 발생될 결과에 대한 연구를 반드시 해야 하고, 그것에 기초하여, 요구되는 자본의 출처를 현실적으로 감안 할 의무와 책임을 법제화하고 명시 하여 법안의 질, 영향력, 근거를 개선한다는 장점이 있고; 법안정비 시 법, 경제, 재정과 환경에 끼칠 영향들을 예측하여 검사 할 법적근거를 새로이 마련한다는 점에서 그 특징이 있다. 이 법이 제정됨으로써 법정비 과정에 국민의 참여를 확대시키고, 법실행자들과 이해집단들의 의견을 고려, 반영하여, 법정비 업무의 가이드라인을 통합된 정책으로 수립하여 준수하고, 법기술, 용어, 교정을 개선하여, 법에 사용된 용어가 중의적이지 않고 일관되게 사용될 수 있는 매커니즘의 기초를 놓았다고 보고 있다. 해당 법에 따라 법안의 과학적 근거에 기초하는 정비체계를 만들고, 법률의 질을 개선하는데 그 목적이 있는 “법률안 정비방법”, “법률 필요성 사전인식 연구방법”, “법률안 효과 평가방법”, “법률실행과 관련된 비용해결방법”, “법률실행에 대한 감사, 검사방법”, “법률실행의 결과에 대한 평가방법” 이라는 6가지 방법의 범주에서 법률개혁업무의 기준과 질을 더욱 개선할 계획이다. 그러나 이 법을 준수하고, 실행하는 과정에서 필요한 인적자원, 예산과 재정을 고려할 필요가 있다.

몽골국 정부의 2012-2016년 사업프로젝트를 실행하는 조치계획에 “법제개혁 전략문서를 정비”하도록 명시했으나 현재 실행되지 않고 있다. 그러나 이러한 조치의 범주에서, 기획한 법제개혁의 성과와 향후 심화 필요성과 요구, 범위, 목표, 방향에 대해 문제를 제기하는 국내외 소학회, 모임, 토의들의 결과와 함께 또 다른 업무의 성과를 중점적으로 연구의 “법제개혁 정책문서의 필요, 요구, 목표, 방향” 부분에 반영하였다.

이와 같이 이 연구로 법제개혁정책에 관한 국제 경향을 관측하고 유엔의 안정개발 목표와

10) 2015년 5월 29일 제정. 2017년 1월 1일부터 시행.

몽골국의 장기안정 개발기조(2016-2030)를 비교연구하고, 법제개혁의 목표와 목적을 명확히 하며, 몽골국의 현재 상황을 고려하고, 법제개혁의 향후 정책과 방향에 대한 의견과 조언을 정비함으로 정책문서 정비업무 지원을 그 목표로 하고 있다.

연구주제의 시간적 범위는 광범위하나 업무의 통일된 보고서가 아직 제출되지 않았으므로, 당 연구의 큰 부분인 “사법개혁, 거둔 성과, 앞으로의 과제”에 대한 소 주제의 결과를 발표한다.

사법개혁의 실행, 성과, 앞으로의 과제

사법권의 독립성 보장은 인권, 자유, 정의를 공고히 하는 기초가 된다. 법원의 독립성과 법관의 자주성은 국민의 권리와 자유의 법익을 실질적으로 보호하는 강력한 매커니즘임과 동시에 사법권의 법적 보증이다. 이렇기 때문에 독립적이고 자주적인 법원의 개원은 법치국가의 중요한 목표이자 기준이 된다.¹¹⁾ 몽골국은 1992년 신헌법 제정 이후 헌법의 원칙, 내용에 부합한 법원을 개원하였고, 법치국가의 기초에 부합한 사법권을 위한 개혁을 단행하였다.

이러한 개혁으로 실행된 업무들을 다음과 같이 연도, 시대별로 분류하여 역사적 관점으로 연구하였다. 1) 1993-2002년 2) 2002-2012년 3) 2012년: 법원에 관한 패키지 법 실행 이후, 즉 3단계로 구분한다. 본 연구에서는 1993-2002, 2002-2012년에 실행한 사법개혁의 성과를 간략히 평가하고, 2012년에 제정된 법원에 관한 패키지 법 실행 시작 이후 실행 된 개혁을 자세히 다뤘다.

“사법권내 개혁 심화프로젝트”는 “대통령의 정책, 사업프로젝트”; 몽골국회 제정 2008년38호 법령으로 “정부의 2008-2012년 사업프로젝트”; 또한 국회 제정 2009년38호 법령으로 “몽골국 법률 2012년도까지의 정비 기본방향”; 몽골국정부 제정 2009년69호 정부령으로 “몽골국의 인권보장 국가프로젝트”에 명시한 목표들에 부합하여 제정한 사법권 개혁전략의 주요 문서들 중 하나이다.

위에서 언급한 프로젝트를 실행할 목적으로 법원평의회장 제정 2010년 11월10일 39호 명령으로 “사법권내 개혁 심화프로젝트의 법원에서의 실행강화 기본방향”, 법원평의회에서 2014-2020년에 사법발전전략을 명확히 한 5개 하위 프로젝트를 2014년에 제정하였다. 이 프로젝트는 a) 법원 신경영 프로젝트 b) 법원 인적자원 능력개발 프로젝트 c) 법관의 사회적보호 프로젝트 d) 법원투자 증기 프로젝트 e) 법원과 대중 이다.

11) 크리스토퍼 오사크웨, 비교법학의 연구: 총칙과 각칙. 개요, 번역: J. 남더르취, L. 남하에, L. 온드라흐, 울란바타르 시, 2005, 54쪽

상기 프로젝트들에서 명시한 기준수치에 근거한 사법개혁을 1) 사법체계; 2) 사법독립; 3) 법관의 자주성; 4) 사법인적자원, 선발; 5) 법원의 투명성; 6) 사법권 산하 기관들 이라는 소제 목으로 구분하여 연구하였고, 연구 결과와 전문적 의견을 수렴한 것을¹²⁾ 이 발표를 통해 전하고자 한다.

1. 사법체계에 대하여

사법권의 독립, 자주성 증가는 해당 국가의 경제성장에 긍정적 영향과 뇌물수수범죄 감소 요인의 하나이다.¹³⁾ 학자들은 사법체계가 부족하여 사법서비스가 국민에게 이르지 못하고, 그 질이 좋지 않을 경우 GNP와 투자가 10퍼센트 정도까지 감소된다고 본다.¹⁴⁾ 이러한 이유로 세계 국가들이 인권, 자유, 정의를 보장하는 독립적 사법권의 성숙, 기관 차원에서는 잠재력 강화에 중점을 두고 법원의 정치적, 경제적, 법적 보증을 지원하여 왔다.

몽골국의 사법개혁의 범주에서 이뤄진 상당한 변화 중 하나인 사법체계의 변화를 분석 했을 때, 사법체계가 변화됨으로써 즉 법원을 심급제로 구분하여 개원함으로써 법관의 전문성, 이는 판결의 질에 영향을 끼치고 더 나아가 업무의 부담을 감소시킨다는 긍정적 연구결과가 나왔으나 법발의자 측에서 사법체계변화 심의 결정을 내릴 때, 법학이론 즉 기초적 연구가 충분히 되지 않았고, 법률의 효과에 대한 연구도 충분치 않음으로 인해 개혁의 큰 사업 중 하나인 심급제의 실행에 미흡함이 있었다는 것이 밝혀졌다. 그러므로 어떠한 개혁을 시작함에 있어서 연구적인 자세를 가지고 법률 효과에 대한 연구 근거를 마련하는 의식의 정착이 필요하다고 본다. 이와 관련하여 다음의 의견을 제시하는 바이다.

- 사법체계에 “구역”의 원칙이 도입됨으로써 즉 법원을 사건의 종류 별로 심급하도록 함으로써 법원의 불균등한 부담을 감소시키고, 법원과 법관을 전문화하여 전문화된 법관을 통해 사건을 판결하는 것에 대한 법적근거를 마련하는데 그 의의가 있다. 그러므로 추후 법원의 심급제에서 후퇴하지 않고, 지금까지 이뤄낸 성과에서 진일보하여 차후에도 사건을 종류별로 심급하여 전문화하는 문제를 발전시키는데 더욱 주력해야 한다.
- 위에서 언급한 사법체계 변화 관련 실수를 다시 반복하지 않고자 하는 목적에서 입법자들이 법률안 정비 시, 연구를 통한 이론적 기초와 추가적 연구 진행이, 법률의 효과에 대한

12) 연구결과, 발의근거, 출처에 대한 정보를 이 발표에 언급하지 않았으므로 연구보고서 참조.

13) Wittrup, Jesper. “Budgeting in the Era of Judicial Independence.” *International Journal for Court Administration*, April 2010. http://www.iaca.ws/files/Jesper_Wittrup4-2010.pdf.

14) 2012년 국가대회회의에 심의된 몽골국법원에 관한 법안과 그와 연관된 기타 법안 소개 www.parliament.mn.

연구 시에는 근거를 마련하는 능력의 함양이 요구된다.

2. 사법권의 독립성에 대하여

사법권의 독립성은 개인의 면과 기관의 면에서 본다. 기관으로서의 법원의 독립성을 보장한다는 것은 두 가지 근본적 의미를 가진다.¹⁵⁾ 하나는 사법권을 국가의 또 다른 권력인 입법권과 행정권에 비해 비교적 독립성을 가진다는 것¹⁶⁾, 다른 하나는 사법권을 각 법원의 독립성을 인정하며 실행한다는 것이다.¹⁷⁾ 이것을 일반적으로 표현하자면, 사법권의 자주성 보장을 법원 외부 즉 국가권력의 다른 주체로부터 보호하고, 다른 면에서는 법원을 법원 자신의 지도부, 행정으로부터 보호한다고 이해해도 된다. 이것에 대해 G. 소브드 박사는 “법원의 독립이란 헌법에서 정한 법원의 지위를 보장하는 것...,”¹⁸⁾을 말한다고 간략히 정의하였다.¹⁹⁾

몽골국의 사법개혁으로 제시한 큰 목표들 중에 하나는 법원이 독립적으로 업무를 수행할 수 있을 정도의 예산을 보장하고, 법원의 경제적 보증을 개선하는 것이었다. 2012년 이후의 사법개혁으로 법원의 독립성, 그 중 법원의 경제적 보증 개선에 대한 연구결과가 나왔다. 이것은 법원의 독립성을 보장할 기본적인 역할을 수행하는 헌법기관인 법원평의회를 개원하고, 법원에 관한 패키지 법에 법원의 경제적 보증, 보장 규정들이 이전의 법들과 비교했을 때 비교적 잘 반영, 법제화 된 것과 연관된다.

연구를 통해 법원의 경제적 보증이 보장되는 법적 규정이 개선되었다고는 하지만, 입법권과 행정권에 비해 사법권의 예산을 감소시키려는 경향은 여전하다. 예를 들면, 법원의 경제적 보증의 정수가 되는 조항들인 법원에 관한 법의 제 28조 5항의 “법원업무의 예산을 전년보다 감축시키는 것을 금한다”, 법원의 경제적보증에 관한 법의 제 23조 5항에서 규정한 “법원의 예산을 책정할 때에 법관의 임금의 구성과 규모를 감축해서는 안된다.” 라는 조항들을 각 각 폐지한 것은 개혁실행에서 일보 후퇴한 것이 되었다.

15) Vicki C. Jackson, “Judicial Independence: Structure, Context, Attitude,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr /Springer Science & Business Media, 2012/, 22-23.

16) O. 몽흐세항 등, 몽골국에서의 법원의 행정형태: 당면한 문제, 해결 방안, 울란바타르 시: 열린사회포럼, 2015년, 28

17) B. 취미드, “사법권에 관한 헌법사상에 관하여”, 발표, “사법권-신세기”국제이론-현실의 소회의, 울란바타르 시, 2001년, 56

18) G. 소브드, “법원, 법관의 자주성 보장”, 몽골국, 법학, 02호, 울란바타르 시, 1997년, 1

19) 헌법 제 47조 1항에 “사법권은 법원에 속한다”, 동조 3항에 “법원을 오직 헌법, 기타 법률로 정한다” 제 48조 2항에 “법원의 조직과 그 활동은 법률로 정한다.” 동조 3항에 “법원은 국가예산의 지원을 받으며, 국가는 경제적으로 법원의 활동을 보장한다.” 제 49조 3항에 “법원 평의회는 법원과 법관의 독립과 신분을 보장한다.” 등으로 법원의 독립성을 보장하는 법적 근거를 규정하였다.

이런 조항들의 폐지는 법원 예산을 입법권과 행정권보다의 감축을 통해 법원 예산으로 법원의 자주성을 침해하는 위험을 초래할 수 밖에 없다. 이렇므로 상기 조항들을 부활시켜 법제화하고 또한 법원예산의 규모를 국가 통합예산에서 확보할 최소치를 법제화하여, “사법권내 개혁 심화” 프로젝트에 반영된 법원예산의 규모를 국가 통합예산의 1.5%에 달한다는 목표를 보장하는데 집중해야 한다.

법원행정법 제 6조 1항 1호와 법원법 제 28조 5항에 있는 “평의회는 각급 법원의 업무와 투자, 예산을 기획하여 국회에 직접 상정한다”는 조항은 헌법 관련 법률간의 충돌을 초래하고, 법원예산을 근거없이 감축하는 행위 발생을 방지하는 법규정을 제정할 필요가 있다. (이에 관한 법률을 어떻게 개정할 수 있는지에 대해 제시한 정책사본을 본 연구의 “법원의 독립성” 부분에서 자세히 볼수 있다.) 법원의 일상 업무 수행에 적합한 건물 부족, 법원건물내 법원 외의 기관들(검찰청)과의 공간공유 라는 현 상황을 고려하여, 몽골국의 법원법 제 29조 1항에서 규정한 “법원은 고유의 건물을 갖는다.” 라는 조항을 준수하기 위해서는 법원예산의 투자예산을 충분한 규모로 책정할 필요가 있다. 이와 관련하여 다음과 같이 의견을 제시하는 바이다.

- 법원예산규모를 국가통합예산의 최소 1% 이상으로 하는 내용의 법제화;
- 법원행정법 제 6조 1항 1호와 법원법 제 28조 5항의 “평의회는 각급 법원의 업무와 투자 예산을 계획하여 국회에 직접 상정한다”는 조항은 헌법 관련 법률간의 충돌을 초래하고, 법원예산을 근거없이 감축하는 행위 발생을 방지하는 법규정을 법률에 반영;
- 법원법 제 28조 5항의 “법원업무예산을 전년 규모보다 감축시키는 것을 금지한다”, 법원경제상황에관한법 제 23조 5항에 규정한 “법원예산책정 시 법관의 임금의 구성과 규모를 감축해서는 안된다.”는 폐지된 조항의 부활
- 법원평의회에 지나친 권한을 부여한 것과 관련하여 법원평의회 의원의 윤리적 지침 규정, 또 법원행정 일부 역할의 위원회로의 위임에 대한 연구

3. 법관의 자주성에 대하여

법관이란 사건 당사자들과, 이와 관련된 이해당사자들 간의 이해의 엇갈림, 합의, 충돌의 문제에서 가장 높은 법의를 곧 법에 따라 판결하는 역할을 수행하는 특별한 주체이다. 법관은 정직하게 업무에 임하고, 법에 따른 판결을 내리기 위해서 어떠한 권력이나 자본으로부터 보호되어야 한다. 사법권 자주성의 중요한 원칙은 법원의 독립과 더

불어 법관의 자주적 업무수행력을 보장하는 것이다. 이에 대해 N. 룬텐도르츠 교수는 “... 법원이 독립적이라면 외부로부터 오는 어떠한 불법적 영향력이 법관에게 직접적으로 향하게 된다. 그러나 법원이 종속적이라면 이러한 불법적 영향력이 법관이 아닌 그들의 업무와 감사기관으로 향한다.”²⁰⁾고 결론을 내렸다.

몽골국의 사법개혁의 큰 변화 중 하나는 법원평의회법 제 22조항에 따라 “영향 선서”를 이끌어 낸 것이다. 이것은 법관의 자주성을 보장하는데 특정한 진일보와 성장을 발생시켰고 영향선서의 의의를 앞으로 널리 알려 소개하고 법적 범위에서 활용하는 것은 법관의 자주성을 보장하는데 큰 관계가 있다. 그와같이 법원평의회법 제 23조 1항에 “법관의 공무원 임금 규모는 법관이 경제적으로 자주적 업무를 수행하며 생활하기에 충분하다.” 라는 규정에 따라 법관의 임금을 단계적으로 인상하는 것은 법관의 자주성을 보장하는데 큰 진보가 되었다. 이와 관련하여 다음과 같은 의견을 제시하는 바이다.

- 법관의 임금책정 시 입법자들은 실제적 계산, 연구를 근거로, 또한 임금을 물가상승분을 고려하여 책정하는 것과 같은 문제에 주목해야 하다.
- 법원평의회법 제 23조 5항의 “법원예산 책정 시 법관의 임금의 구성, 규모를 감축시켜 서는 안된다.” 라는 폐지된 조항을 부활시켜 법제화 할 필요가 있다.
- 법관의 책임체계 개선을 위해 법원윤리와 전문성책임 문제를 법원윤리위원회와 법률가연맹, 전문성자격위원회의등 여러 기관에서가 아닌, 법관의 전문성과 윤리문제를 하나의 기관 곧 법원윤리위원회의 소관으로 단일화하여 중복을 해결한다.

4. 법원 인적자원, 선발에 대하여

몽골 헌법 제 49조 3항에 “법원평의회는 법관의 자주성과 독립성의 보장을 위한 업무를 수행한다.” 라고 규정하였다. 이 기관은 1993-2012년 까지 대법원과 법무부의 보조적 업무를 수행하였는데 법원의 독립적 법관의 자주성을 보장하는데에는 효과가 미미하였다. 이러한 이유로 2012년 제정된 법원 패키지법의 범주에서 헌법에 명시한 기본역할을 수행할 기관을 개설한 것은 사법개혁에 있어서 중요한 의의가 있다. 이 기관이 개설됨으로써 사법개혁을 단계적으로 실행할 여러 조치들을 취하고 있고, 그 중에서 법원의 인적자원, 선발이 중요한 위치를 차지한다.

법원평의회와 권한이 변경됨으로써 법관의 선발작업이 새로운 국면에 접어들었다. 1) 2012년 법원법으로 법원자격위원회를 신설하였다. 2) 2012년 이전에 비하면 법원의 인적자원

20) N. 룬텐도르츠 등, 몽골국 법관의 자주성 강화, 정책검토연구, 울란바타르 시: 열린사회포럼, 2010, 39

이 증가되었다. 3) 법관후보자들의 구성을 확대 즉 법원행정직 이외의 다른 직종에 종사했던 유경험자들을 일심법원의 법관후보 자격을 부여하였다. 4) 법관 선발과 고시에 대한 정보를 더욱 투명화하였다. 몇 되지않는 법관선발공고와 시험과 면접 일정표를 법원평의회의 전자사이트에 각 각 고시하게된 것을 비롯하여 여러 발전을 이루었다.

법원에 관한 패키지법을 제정함으로써 법관선발작업에 있어서 위에서 언급한 성과들을 거뒀으나 학자들은 법관선발과 법관임명이 공정하게 진행되지 않는다며 이 문제에 대해 비판적이다. 예를 들어, 법관선발시험을 통해 최고득점을 취득한 후보자가 법관으로 선발되지 못하고 있고 또한 사법체계를 개혁시키는 것과 관련하여 몇 몇 법관들을 재임명하지 않은 경우가 발생한 것에 대해 학자들은 비판적인 자세를 취하고 있다. 이와 같이 법관선발 업무원칙의 불명확성, 법관 후보자에 대한 형식적 심의 등의 문제들이 제기되고 있다.

이러므로 법관의 자주성 보장의 기본 척도가 되는 법관선발시험 및 법관임명을 통해 몽골국 대통령과 법원평의회가 법관의 자주성이 침해받을 수 있는 상황을 잘 고려하여 법관의 자주성을 보장하는 법규정을 잘 정비해야 한다. 이와 관련하여 다음과 같은 의견을 제시하는 바이다.

- 법관선발시험을 법원평의회에서 독립된 별도의 자격위원회가 수행한다;
- 법원평의회에서 법관선발시험 시행 시, 법원의 자격위원회에서 시행하는 시험에 통과한 인물 중에서 후보자를 추천함에 있어서 시험성적순을 주요 기준으로 하며, 자격위원회에서 최고득점 취득 후보자를 법관으로 임명한다.
- 법원평의회는 법관선발시험을 시행 시 법관들은 후보자를 어떠한 근거로 대통령에게 제정할지 또한 후보자가 법관으로 임명되지 않을 경우 그 근거를 서면 작성하여 명확히 밝히는 것에 대한 법률 규정을 정비한다.
- 대통령은 자신의 권한 내에서 법원의 구조와 조직 변경과 관련하여, 법관 임명시 법관의 재임명 거부, 법관을 교체하여 배당받은 법정이 아닌 다른 법정으로의 발령, 또한 상급법원의 법관을 하급법원의 법관으로 임명 등의 권한 행사에 대한 근거와 복귀명령 보류에 대한 근거를 해명하고 이에 관한 법규정을 구성해야 한다.;
- 법원의 인적자원정책을 개선하는 차원에서 사법연수체계 개선 및 사법연수의 단계적 연수 학교 개설 가능성 연구, 종신직 법관으로 임명하기 전 “법관시보”로 3-5년 정도 일을 수행케 한후 법관을 종신직으로 임명하는 등의 외국의 사례를 연구할 필요가 있다.

5. 사법의 투명성, 개방성에 대하여

몽골헌법 제 54조에 “법률이 별도로 정한 경우를 제외하고, 법원의 소송절차는 일반에 공개한다.”고 규정하였고, 2002년 법원법에 재판의 공개한다고 반영하였다.²¹⁾ 이것은 공개가 금지되는 재판이 아닌 경우에는 공개하고 그 판결도 공개한다는 의미를 나타낸다.

“사법부내 개혁심화 프로젝트”를 실행하는 범주에서 법원의 투명, 개방성을 보장할 프로젝트를 확실히 실행한 것은 진보가 되었다. 이따르 법원의 투명, 개방성을 보장하기 위해 실행중인 방안들을 점차 심화하고 판결분석과 연구순환에 포함시키는 것은 법과학의 향후 발전에 중요한 의의를 가진다. 이와 관련하여 다음과 같은 의견을 제시하는 바이다.

- 판결의 투명성을 감안하여 개인, 기관의 기밀과 관련된 판결의 비밀을 보장하고, 특별히 가정내 다툼 등 개인의 사생활과 관련된 판결들을 대중에 공개의 타당성을 고려한다
- 판결에 대한 정기적 분석, 연구 과정을 거치는 것을 고려한다.

6. 사법권 범주의 기타(참여자) 기관에 대하여

몽골헌법 제 4장 “사법권” 부분에 법원과 검찰청의 체계, 근본적 역할, 업무원칙, 법원평의회, 대법원의 권한, 헌법재판소의 조직, 권한들을 법제화하였다. 또한 법원의 안정적 업무보조 역할을 수행할 경찰청, 변호기관, 법집행기관 등 기관들의 법적근거를 관련 법률로 규정하였다.

사법개혁이 실행된 후, 즉 법원에 관한 패키지 법이 제정된 것과 관련하여 사법권 범주의 기관들의 역할의 균형을 개선하는 방향으로 여러 사업들을 시행하였는데, 그 중 하나가 법원과 법수호기관들의 정보전자단일망을 구축한 것이었고, 이는 사법개혁의 범주에서 큰 프로젝트 중 하나이다. 법원을 구역 단위의 체계로 신설한 것과 관련하여 검찰, 경찰, 수사의 조직과 업무를 개혁하고 이 기관들의 법적 부조와 변호서비스 업무의 부담 가중 등의 어려움이 생기고 있다.

또한 사법권내 타 기관들의 경제적 보증이 보장되지 못하고 있는 상황을 고려하여 이들 기관들에게 적정 수준의 예산편성이 필요하다. 이따르 이들 기관들의 업무 균형을 개선하고, 또한 상기 기관들의 경제적 보증과 임금을 법관임금인상과 같은 규모로 개선하는 것을 고려할 필요가 있다. 이와 관련하여 다음 같은 의견들을 제시하는 바이다.

- 사법개혁 실행과 관련하여 법원, 법수호기관들의 업무균형 개선을 고려한다

21) 법원법 (2002) 제 11조 1항

- 사법권내 타 기관들의 경제, 사회적 보증을 보장, 이 기관직원들의 임금 및 사회적 보증 개선을 고려한다.
- 뇌물방지청 업무의 효과 증대를 위한 조치, 정치와 무관하게 업무를 수행할 수 있는 법적 환경을 정비한다.

이 발표에서는 “법제개혁: 거둔 성과(2008-2016), 향후 목표와 방향성” 연구에 대해 간략히 소개하고, 본 연구의 “사법개혁의 실행, 성과와 과제”라는 부 주제에 대한 결론과 향후 실행 조치에 대한 의견, 조언들의 예를 들어 보았다. 1998년 법제개혁프로젝트를 공식적으로 폐지하지 않는다 하더라도 우리의 연구는 향후 법제개혁정책문서가 새로이 정비, 완성될 때에 추가 정보가 될 것이라는 기대와 함께 법제개혁정책에서 고려해야할 근거들의 제시를 그 목적으로 두었다.

법제개혁은 광범위한 총체적 문제이므로 정책문서를 통해 되어야 하며, 법제개혁의 범위내에서 실행해야 할 기본 목적, 목표, 조치, 원칙, 그것들을 실행할 세부계획, 달성에 대한 평가 및 기준들을 총체적으로 반영하는 것이 적합하다는 것을 이 연구를 통해 조언하였다. 정책문서에 법제개혁의 반영 곧 법률개혁, 입법, 행정의 지원, 법해석체계, 업무개혁, 법전문교육개혁, 법학 학회 조직, 방법론 개혁, 사회의 법의식 고취를 함께 지향하여 실행하는지를 목표로하여 방향성마다 중점을 두어 정비하는 것이 타당하다. 이렇게 할 때 1998년 법제개혁 프로젝트의 실행, 성과, 효과를 교훈 삼아 고려해야한다. 몇 몇 큰 정책문서들의 실행을 결정하여 해당 문서에서 제시한 목표에 이르기 위한 조치 실행여부를 최종적으로 평가해, 정책의 연관성에 포함시키지 않는 상황을 연구 중에 관찰하였다. 어떠한 정책문서를 정비할 때 연구에 근거하여, 이전에 제정된 프로젝트와 계획의 실행을 평가한 결론을 반드시 고려해야 한다. 이러지 않는 경우 정책의 연관성의 질이 떨어져 이뤄낸 성과에서 후퇴하여 실패함으로 경험하지 못하는 상황에 이를 수도 있다. 그와 같이 법제개혁의 방향성, 목표, 조치를 명확히 할 때에 학자, 연구가, 전문가, 국민, 대중의 참여를 보장하여 그들의 의견과 조언을 반영하고 토의하는 과정이 매우 중요하다는 것을 강조하는 바이다.

경청해 주셔서 감사합니다.

Солонгосын нийгмийн хөгжил болон эрх зүйн
ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ
한국사회의 발전과 법제발전

Илтгэгч: **Пак Гуандун доктор** (Солонгосын Хууль зүйн үндэсний хүрээлэн)

발표: **박광동 박사**(한국법제연구원)

Хэлэлцүүлэгч: **Доктор (Sc.D) Ш.Үнэнтөгс** (ХЗЯ-ны ахлах мэргэжилтэн)


토론: **Sh.Vnentugs 박사**(몽골법무부 상급 전문가)



KOREA LAW FORUM
K-LAW FORUM
Солонгос болон Монголын хуулийн тогтолцоон дахь шинэчлэлт, үргэлжлэл болон хэтийн төлөв

Солонгос улсын нийгмийн болон хуулийн ТОГТОЛЦОО ДАХЬ ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦ

Баг ГВАН ДУН доктор
БНСУ-н Хууль зүйн үндэсний хүрээлэн





KLRI KOREA LEGISLATION RESEARCH INSTITUTE

Гарчиг

1. Солонгос улсын эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө
2. Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө болон хуулийн тогтолцоо
3. Улсын эдийн засгийн хөгжил болон хуулийн тогтолцоо дахь сайжруулалт, онцлог



2/25



1. Солонгос улсын эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө

1. Үндэсний эдийн засгийг хөгжүүлэх зорилго - засгийн газрын оролцоо, гадаадын хөрөнгө оруулалт татах болон экспортыг дэмжих, бага цалин хөлс • тариа будааны хямд үнийн бодлогыг голчилно
2. 1962 оны 1 дүгээр шат ~ 1996 оны 7 дугаар шат хүртэлх эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх “Хан мөрний гайхамшиг” хэмээх хурдацтай хөгжил

3/25



2. Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө болон хуулийн тогтолцооны засан сайжруулалт

4/25

1. 1 дүгээр үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө

- 1 дүгээр үе шатны эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө (1962-1966 он)-ы зорилт
Тухайн үеийн Солонгос улсын нийгэм • эдийн засгийн удааширсан эргэлтийг зогсоож бие даасан эдийн засгийг цогцлоох үндэсийг тавих
- Үндсэн зорилт: Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх үндсэн чиглэл нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахилгаан эрчим хүч, чулуун нүүрс зэрэг эрчим хүчээр хангах эх үүсвэрийг өргөтгөх, үндсэн салбар болон нийгмийг дэд бүтцээр хангах, экспорт, импортийг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болох гадаад худалдааг сайжруулах зэрэгт гол анхаарлаа хандуулж, хамгийн бодит элемент болох гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр тэдгээрийг татах
- Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн гол заалт
 - Эдийн засаг: Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих багц хууль, валют үнэт цаасыг тогтвортой барих , тусгайлан нэрлэсэн гадны бүтээгдэхүүнийг худалдахыг хориглох тухай хууль, зээлийн төлбөрийн баталгаатай холбоотой эрх зүйн хэм хэмжээ, удаан хугацааны хөрөнгө оруулалтыг дэмжих тусгай арга хэмжээний хууль, онцгой валютын багц хууль, мөнгөний хүүг хязгаарлах тухай хууль, үнэт цаасны арилжааны тухай хууль, Солонгосын банкны тухай хууль (нэмэлт өөрчлөлт), Татварын хөнгөлөлтийн журмын тухай хууль, Солонгос дахь гадаад валют банкны тухай хууль
 - Эрүүл мэндийг хамгаалах болон нийгмийн халамж: Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль (нэмэлт өөрчлөлт),
 - Эдэлбэр газрыг хөгжүүлэх : Барилгын тухай хууль, хот төлөвлөлтийн тухай хууль, газар эзэмших тухай багц хууль, барилга байгууламж газрын нэгдсэн төлөвлөгөөний тухай хууль

5/25

2. 2 дугаар үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө

- 2 дугаар үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө (1967-1971)
- Байгалийн эрчим хүч нэмэгдүүлэх, нийгмийг дэд бүтцээр хангах, хүнсний хэрэгцээгээ хангах болон амжиргааг хангах, аж үйлдвэрийг дэмжих тухай хууль, шинжлэх ухаан технологийн дэмжих зэрэг гол аж үйлдвэрийг дэмжих
- Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн гол заалт
 - Газар тариалан: Хөдөө аж ахуйн газар бүрдүүлэх тухай, хөдөө аж ахуйн тухай ерөнхий хууль, хөдөө аж ахуй загас агнуурыг байгалийн онц аюултай байдлаас хамгаалах арга хэмжээний тухай хууль, сүү цагаан идээний аж ахуйг дэмжих тухай хууль , тариачид, загасчдын тосгоныг сайжруулах багц хууль, тариалангийн газрын шинэчлэлт, аж үйлдвэрийг зохицуулахтай холбоотой тусгай арга хэмжээний багц хууль, тариалангийн тосгоныг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэн тухай багц хууль
 - Эдийн засаг : Үл хөдлөх эд хөрөнгийн өрсөлдөөнийг хязгаарлахтай холбоотой тусгай арга хэмжээний тухай хууль, хөрөнгийн биржийн тогтвортой байдлын тухай хууль, Солонгосын экспорт, импорт банкны тухай хууль, үнэт цаасны салбар дахь хөрөнгө оруулалтын итгэмжлийн тухай хууль
 - Аж үйлдвэр: Газрын тосны үйлдвэрийн тонтог төхөөрөмжтэй холбоотой тусгай багц хууль, машин техникийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, усан онгоцны үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, электрон барааны үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, газрын тос, химийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, төмрийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
 - Худалдаа болон бусад: Худалдааны хууль , экспортын чөлөөт бүс байгуулах тухай хууль, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрчний эвлэл болон хөдөлмөрийн маргааныг зохицуулахтай холбоотой тусгай багц хууль

6/25

3.3 дугаар үе шатны эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө

- 3 дугаар шатны эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө (1972-1976)
 - Хурдацтай хөгжил болон хүнд аж үйлдвэрийг дэмжих зорилгоор
- Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн гол заалт
 - Эдийн засаг: Үнэт цаас нийлүүлэлтийг хязгаарлахыг багасгах болон ажиллагсадын хувьцааны тогтолцоог сайжруулахыг гол болгосон хөрөнгийн зах зээлийг дэмжих тухай хууль, Хөрөнгө оруулагчийн эдийн засгийн үр нөлөөг сайжруулахын тулд хамтын хөрөнгө менежменттэй холбоотой хууль, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээтэй холбоотой хууль тогтоомж, хувьцаа худалдааны таатай болгох болон цэгцлэхийн тулд Үнэт цаасны арилжааны тухай хууль (нэмэлт өөрчлөлт), үнийн тогтвортой байдал болон улсын арилжаатай холбоотой хууль боловсруулах, нийтийн зориулалтын газар эзэмших болон хохирол нөхөн төлөхтэй холбоотой тусгай хууль, Ойрхи Дорнодын хөгжлийг өргөжүүлэхийг дэмжсэн төлөвлөгөө болон хилийн чанадын бүтээн байгуулалттай холбоотой хууль, хөдөө аж ахуй, загасны аж ахуйн маркетинг болон үнийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж
 - Хөдөлмөр : Хөдөлмөрийн маргаан таслах тухай хууль (нэмэлт өөрчлөлт), хөдөлмөрийн хамтын гэрээний тухай хууль (нэмэлт өөрчлөлт), хөдөлмөрийн стандартын тухай хууль (нэмэлт өөрчлөлт), мэргэжлийн сургалттай холбоотой хууль
 - Архи согтууруулах ундааны татвар: Архи согтууруулах ундааны татварын тухай хууль, зүй бус орлогын албан татвар, гадаадын зээл тусламжийг бууруулж санхүүжилтыг баталгаажуулахын тулд хориглох хууль, нэмэгдсэн өртгийн албан татвар
 - Газар эдлэлийг хөгжүүлэх: Сул газрыг хамгаалах болон ашиглах тухай хууль, улсын газар нутгийг ашиглах менежментийн тухай хууль, хөдөө аж ахуйн эдлэл газрын хөгжлийг өргөжүүлэх тухай хууль, газар дахин төлөвлөлтийн тухай хууль

7/25

4.4 дүгээр үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө

- 4 дүгээр үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө (1977-1981)
 - Хөрөнгө оруулалтын сангийн нийлүүлэлтийг татах, олон улсын төлбөрийн тэнцлийг дэмжиж, аж үйлдвэрийн бүтэцийг сайжруулах, нийгмийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих замаар, технологийн шинэчлэл, үр ашгийг сайжруулах
 - Улсын аж үйлдвэрийг жигдрүүлэхийн тулд экспортыг дэмжиж импортын хяналтыг чангатгаж, экспортыг дэмжихийн тулд импорт, экспортын холбоосууд, экспортын татаас, давуу экспортын санхүүжилт ба албан татварын хувьд давуу байдал олгох зэрэг төрөл бүрийн бодлогыг хэрэгжүүлэх
- Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн гол заалт
 - Эдийн засаг : Гадаадын хөрөнгө оруулалт татан оруулах (нэмэлт өөрчлөлт), татвараас чөлөөлөх журам (нэмэлт өөрчлөлт), аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль (нэмэлт өөрчлөлт), орлогын албан татварын тухай хууль (нэмэлт өөрчлөлт), мөнгөний хүүг хязгаарлах тухай хуулийн хэрэгжилт (нэмэлт өөрчлөлт), хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, монополийн журам болон улсын арилжааны тухай хууль
 - Газар эдлэлийг хөгжүүлэх: Орон сууцны барилгыг дэмжих, орон сууц нэмэгдүүлэх бодлогыг дэмжих тухай хууль, ойн тухай хууль, онцгой бүс нутгийг цогцоор нь хөгжүүлэхтэй холбоотой хууль
 - Аж үйлдвэр : Хөдөө аж ахуйн автоматжуулалтыг дэмжих тухай, нэхмэлийн салбарын шинэчлэлийн дэмжих тухай хууль, борлуулалт үйлдвэрлэлийн шинэчлэлийг дэмжих тухай хууль, борлуулалтын үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль

8/25

5. 5 дугаар үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн ТӨЛӨВЛӨГӨӨ

- 5 дугаар үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө (1982-1986 он)
 - Тогтвортой байдал, үр ашиг, тэнцэл гэх үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн тогтвортой байдлыг үндэслэн иргэдийн амьдралын тогтвортой байдал • өрсөлдөх чадвар • төлбөрийн тэнцлийг сайжруулах, ажил эрхлэлт орлогийг нэмэгдүүлэх, орлогын хаалт болон бүс нутгийн тэнцвэртэй байдлыг үндэслэн иргэдийн амьдралын нөхцөл байдлыг сайжруулах зорилготой
- Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн гол заалт
 - Эдийн засаг : Үнэт цаасны нэрийг худалдаалахтай холбоотой хууль, мөнгөний хүүг хязгаарлахтай холбоотой хуулийн хэрэгжилт (нэмэлт өөрчлөлт), эдийн засгийн гэмт хэрэгт тусгайлан ял хөнгөрүүлэхтэй холбоотой хууль, хөдөө тосгодыг хөгжүүлэхтэй холбоотой багц хууль, эдийн засгийн гадаад харилцаа хамтын ажиллагаа мөнгө хуримтлуулахтай холбоотой хууль, тариачид бүс нутгийн мөнгөн хуримтлалыг хөгжүүлэх тухай хууль
 - Архи согтууруулах ундааны татвар: Архи согтууруулах ундааны татварыг хөнгөлөх тухай тусгай хууль (нэмэлт өөрчлөлт), гаалийн албан татварын тухай хууль (нэмэлт өөрчлөлт)
 - Газар эдлэлийг хөгжүүлэх : Нийслэлийн харьяа газрыг сайжруулах төлөвлөгөөний тухай хууль
 - Аж үйлдвэр : Аж үйлдвэрийг сайжруулах тухай хууль
 - Нийгмийн халамж: Иргэдийн тэтгэвэрийн тухай хууль, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай хууль

9/25

6. 6 дугаар үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн ТӨЛӨВЛӨГӨӨ

- 6 дугаар үе шат эдийн засаг нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөө (1987-1991)
 - Тэргүүн зорилго: Эдийн засаг нийгмийн тогтолцоог шат дараалан хөгжүүлэх, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх болон гадны технологи оруулж ирэх ба бүс нутгийн тэнцвэртэй хөгжил ба иргэдийн амьдралын чанарыг сайжруулах
 - Шинэчлэх зорилго: Засгийн газрын оролцоог багасгахын тулд захиргааны тогтолцоог сайжруулах, орлого хувиарлалтыг сайжруулах • татварыг адил тэгш ногдуулахын тулд татварыг шинэчлэх, улсын нутаг дэвсгэрийн тэнцвэртэй өсөлт, эдийн засгийн либералчлал даяаршил, хотын бага орлоготой гэр бүлүүдийн нийгмийн халамжийн арга хэмжээг сайжруулах зэрэг
- Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн гол заалт
 - Газар эдлэлийг хөгжүүлэх : Газар эзэмших дээд хязгаарыг тогтоох тухай хууль, хөгжлийн ашиг тусыг сэргээн тогтоохтой холбоотой хууль, газрын менежмент болон бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэхтэй холбоотой хууль, илүү газарт ногдуулах татварын тухай хууль, газрын үнийг олон нийтэд мэдэгдэх болон газар зэргийн үнэлгээтэй холбоотой хууль
 - Аж үйлдвэр : Барилгын технологи менежментийн тухай хууль, гадаад худалдааны тухай хууль, аж үйлдвэрийг өөрийн нутагт оруулж ирэх, хөгжүүлэхтэй холбоотой хууль, тариачдыг дэмжих арга хэмжээний тухай хууль, ачаа тээврийн эргэлтийг дэмжих тухай хууль
 - Нийгмийн халамж: Барилгын технологи менежментийн тухай хууль, гадаад худалдааны тухай хууль, аж үйлдвэрийг өөрийн нутагт оруулж ирэх, хөгжүүлэхтэй холбоотой хууль, тариачдыг дэмжих арга хэмжээний тухай хууль, ачаа тээврийн эргэлтийг дэмжих тухай хууль

10/25

7.7 дугаар үе шат эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн ТӨЛӨВЛӨГӨӨ

- 7 дугаар үе шатын эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө (1992-1996)[шинэ эдийн засгийн 5 жилийн төлөвлөгөө (1993-1997)]
 - Зорилт: Санхүү, валют, засаг захиргаа зэрэг салбар тус бүрийн тогтолцоонд шударга өрсөлдөөн болон бие даасан байдлыг хангаж, засгийн газрын оролцоогүй иргэдийн оролцоо санаачлагыг үндэслэн эдийн засгийн өсөлт, агентлаг тус бүрт эдийн засгийн ёс зүй болон мэргэжлийн үзэл санааг сэргээх
 - Хөгжлийн стратеги: Аж үйлдвэрийг бүтцийн өөрчлөлт • технологийн хөгжлийн хурдаар дамжуулан хөгжих боломжийг нэмэгдүүлэх, даяаршлыг өргөжүүлэх • эрчимжүүлэх, хөрөнгийн хамтын ажиллагаа зэргийг нэгтгэн валют олон улсын зах зээлд суурилан өргөжүүлэх, орон сууцны хомсдол • томоохон хотын замын түгжрэлийг багасгах зэрэг нийгмийн баталгааг дэмжих зэргээр дамжуулан иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах
- Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн гол заалт
 - Эдийн засаг : Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны журмыг зөөлрүүлэхтэй холбоотой тусгай арга хэмжээний тухай хууль, нийгмийн дэд бүтэцтэй холбоотой хувийн хэвшлийн хөрөнгийг татан оруулахыг хурдасгахтай холбоотой хууль, үл хөдлөх хөрөнгийн жинхэнэ эзэмшигчийн нэртэй холбоотой хууль, ургачын дээжийн солилцооны тухай хууль, хадагламж эзэмшигчийг хамгаалах тухай хууль
 - Аж үйлдвэр: Газрын тухай хууль, тариачдын татвартай холбоотой хууль боловсруулах, үндэсний тэнцвэртэй хөгжлийн тухай хууль, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг бэхжүүлэх орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой хууль, барилгын салбарын ерөнхий хууль
 - Хөдөлмөр: Ажил эрхлэлтийн бодлоготой холбоотой ерөнхий хууль, ажил эрхлэлтийг хамгаалах тухай хууль, үйлдвэрчний эвлэл болон хөдөлмөр зохицуулах тухай хууль (нэмэлт өөрчлөлт), хөдөлмөрийн стандартын тухай хууль (нэмэлт өөрчлөлт), хөдөлмөрийн комиссын тухай хууль (нэмэлт өөрчлөлт), ажилчдын оролцоо болон хамтын ажиллагааг дэмжих тухай хууль, ажилчдын мэргэжлийн сургалтыг дэмжих тухай хууль, томилолттой байгаа ажилчдыг хамгаалахтай холбоотой хууль, цалингийн зээлийн баталгааны тухай хууль
 - Захиргаа: Захиргааны ерөнхий хууль Захиргааны журмын ерөнхий хууль

11/25



KLRI
KOREA LEGISLATION RESEARCH INSTITUTE

3. Үндэсний эдийн засгийн тогтолцоо болон хуулийн тогтолцоог сайжруулах, онцлог

12/25

1. Онцлог

- Солонгос улс нь 1962 онд 1 дүгээр шатны эдийн засгийн хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөг эхэлж 1996 онд хүртэл нийт 7-н үе шат бүхий Солонгосын эдийн засгийн хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, сүүлийн үед Баг ГБН ХЭ ерөнхийлөгчийн эдийн засгийн шинэчлэлийн 3 жилийн төлөвлөгөөг өрнүүлэх /-ж байна/
- Эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө болон хуулийн тогтолцоо дахь хөгжлийн багц загвар


13/25



2. Солонгос улсын эдийн засгийн хөгжлийн хууль тогтоомж, загвар хууль

- Улсын чиглүүлэх загвар, эдийн засгийн хөгжлийн стратегийн “Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө”
- Эдийн засгийн хурдацтай хөгжилд голчлон үйлчлэх “Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө” болон ард түмний чадвар ба нэгдэл
- Бие даасан эдийн засгийг бэхжүүлэхийн тулд “Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө” болон холбогдох хууль боловсруулах
- Нийгэм эдийн засгийг хөгжингүй болгохын тулд “Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө” болон холбогдох хууль боловсруулах

14/25


Thank you







1. 한국의 경제개발 5개년 계획


1. 국민경제발전 목적- 정부주도, 외자 도입 및 수출, 저임금·저곡가정책 중심
2. 1962년 제1차~1996년 제7차까지의 경제개발계획의 추진으로 '한강의 기적'으로 불리는 고도성장



3/25



2. 경제개발계획과 법제정비



4/25

1. 제1차 경제개발 5개년계획

- 제1차 경제개발 5개년계획(1962-1966년)의 목표

당시 한국의 모든 사회·경제적 악순환을 단절시켜 자립경제를 이룩할 수 있는 토대 조성

- 주요 정책 과제: 성장여건 조성을 위한 기본방향을 농업생산력증대, 전력·석탄 등의 에너지 공급원 확충, 기간산업의 확충과 사회간접자본의 증축, 수출증대를 주축으로 국제수지의 개선 등에 중점을 두고 추진, 가장 혁신적인 요소는 외국자본의 도입을 통한 외국자본의 유치

- 주요 제개정 법률

- 경제: 외자도입촉진법, 통화안정증권법, 특정외래품판매금지법, 차관에 대한 지불보증에 관한 법률, 장기결제방식에 의한 자본 재도입 특별조치법, 긴급통화촉진법, 긴급금융조치법, 이자제한법, 증권거래법, 한국은행법(개정), 조세감면규제법, 한국외환은행법
- 보건 및 복지: 의료보험법, 노동조합법(개정)
- 국토개발: 건축법, 도시계획법, 개간촉진법, 국토건설종합계획법

5/25

2. 제2차 경제개발 5개년계획

- 제2차 경제개발 5개년계획(1967-1971)

- 에너지 자원 확충, 사회간접자본 확충, 식량자급자족과 산림녹화, 공업화추진, 과학기술의 진흥을 중점사업으로 추진

- 주요 제개정 법률

- 농업: 농경지조성법, 농업기본법, 농어업재해대책법, 낙농 진흥법, 농어촌 지붕개량 촉진법, 농지개혁사업 정리에 관한 특별조치법, 농촌근대화 촉진법
- 경제: 부동산 투기억제에 관한 특별조치법, 자본시장육성에 관한 법률, 한국수출입은행법, 증권투자신탁업법
- 공업: 섬유공업 시설에 관한 임시조치법, 기계공업 진흥법, 조선공업 진흥법, 전자공업 진흥법, 석유화학공업 육성법, 철강공업 육성법
- 무역 및 기타: 무역거래법, 수출자유지역 설치법, 외국인 투자기업의 노동조합 및 노동쟁의조정법에 관한 임시특별법

6/25

3. 제3차 경제개발 5개년계획

- 제3차 경제개발 5개년계획(1972-1976)

-고도성장 및 중화학공업화를 목표로 추진

- 주요 제개정 법률

- 경제: 신주발행 제한완화와 종업원지주제 강화를 골자로 한 자본시장 육성법, 도입차관의 경제효과 제고를 위한 공공차관 도입 및 관리에 관한 법, 감정평가에 관한 법률, 주식거래 원활화와 거래질서 개선을 위한 증권거래법(개정), 물가안정 및 공정거래에 관한 법률 제정, 공공용지의 취득 및 손실보상에 관한 특례법, 중동진출촉진방안 및 해외건설 촉진법, 농수산물 유통 및 가격안정에 관한 법률
- 노동: 노동쟁의조정법(개정), 노동조합법(개정), 근로기준법(개정), 직업훈련에 관한 기본법
- 조세: 국세기본법, 부당이득세법, 외국원조 감소로 재원 확보를 위한 방위세법, 부가가치세법
- 국토개발: 농지보호 및 이용법, 국토이용관리법, 농지확대개발촉진법, 도시재개발법

7/25

4. 제4차 경제개발 5개년계획

- 제4차 경제개발 5개년계획(1977-1981)

-투자재원의 자력조달, 국제수지의 균형 도모, 산업구조의 고도화, 사회개발을 통한 형평의 증진, 기술혁신과 능률의 향상

-국내 산업을 육성하기 위해 수출이 장려되고 수입은 강하게 억제되었고, 수출 진흥을 위해 수출입 링크제, 수출보조금, 수출우대금융 및 세제상의 혜택을 주는 각종 정책 실시

- 주요 제개정 법률

- 경제: 외자도입 시행령(개정), 조세감면 규정법(개정), 법인세법(개정), 소득세법(개정), 이자제한법 시행령(개정), 소비자보호법, 독점규제 및 공정거래법
- 국토개발: 주택건설 촉진법, 택지개발촉진법, 산림조합법, 특정지역 종합개발 촉진에 관한 특별조치법
- 산업: 농업기계화촉진법, 석유공업근대화촉진법, 유통산업근대화촉진법

8/25

5. 제5차 경제개발 5개년계획

- 제5차 경제사회발전 5개년계획(1982-1986년)

-안정, 능률 및 균형이라는 이념을 구현하기 위해 경제안정기반의 정착을 통한 국민생활안정·경쟁력 강화·국제수지의 개선, 고용확대와 소득증대, 소득계층 및 지역 간 균형발전을 통한 국민복지증진이 목표

- 주요 제개정 법률

- 경제: 금융실명거래에 관한 법률, 이자제한법 시행령(개정), 특정경제범죄 가중처벌 등에 관한 법률, 농어촌소득개발촉진법, 대외경제협력기금법, 농어촌지역 개발기금법
- 조세 :조세감면특별법(개정), 관세법(개정)
- 국토개발: 수도권정비계획법
- 산업: 공업발전법
- 복지: 국민연금법, 최저임금법

9/25

6. 제6차 경제개발 5개년계획

- 제6차 경제사회발전계획(1987-1991)

-초기 목표: 경제사회의 제도와 질서의 선진화, 산업구조의 개편과 기술입국의 실현 및 지역사회의 균형발전과 국민생활의 질적 향상 등

- 수정 목표: 정부규제 완화를 위한 행정제도의 개선, 소득분배개선·과세공평을 위한 세제개편, 국토의 균형개발, 경제의 개방화와 국제화, 도시 저소득층을 위한 복지대책 향상 등

- 주요 제개정 법률

- 국토개발: 택지소유상한에 관한 법률, 개발이익환수에 관한 법률, 토지관리 및 지역 균형개발 특별회계법, 토지초과이득세법, 지가공시 및 토지 등의 평가에 관한 법률
- 산업: 건설기술관리법, 대외무역법, 산업입지 및 개발에 관한 법률, 농어촌발전 특별 조치법, 화물유통촉진법
- 복지: 건설기술관리법, 대외무역법, 산업입지 및 개발에 관한 법률, 농어촌발전 특별 조치법, 화물유통촉진법

10/25

7. 제7차 경제개발 5개년계획

- 제7차 경제사회발전 5개년 계획(1992-1996)[신경제 5개년계획(1993-1997)]

-목표:재정, 금융, 행정 등 각 분야별 제도의 공정 경쟁과 자율성 보장, 정부 주도가 아닌 국민의 참여와 창의를 통한 경제성장, 각 경제주체의 경제윤리와 직업정신 재정립

- 개발 전략:산업구조조정·기술개발의 촉진 등을 통한 성장잠재력의 강화, 국제화의 확대·심화 및 자본협력 등의 강화를 통한 국제시장기반의 확충, 주택난·대도시 교통난 완화 및 사회보장증진 등을 통한 국민생활여건의 개선 등

- 주요 제개정 법률

- 경제: 기업 활동 규제완화에 관한 특별 조치법, 사회간접자본시설에 대한 민간자본유치촉진법, 부동산 실권리자 명의등기에 관한 법률, 선물거래법, 예금자보호법
- 산업: 농지법, 농어촌특별세법 제정, 국가균형발전 특별법, 지역균형개발 지방중소기업육성에 관한 법률, 건설산업기본법
- 노동: 고용정책기본법, 고용보험법, 노동조합 및 노동관계조정법(개정), 근로기준법(개정), 노동위원회법(개정), 근로자 참여 및 협력증진법, 근로자 직업훈련촉진법, 파견근로자 보호 등에 관한 법, 임금채권보장법
- 행정: 행정규제 기본법

11/25



KLRI
KOREA LEGISLATION RESEARCH INSTITUTE

3. 국가경제발전과 법제의 정비와 특징

12/25

1. 특징

- 한국은 1962년 1차 경제개발 5개년 계획을 시작으로 1996년에 이르기까지 총 7차에 걸쳐 한국 경제개발 5개년 계획을 시행하였고, 최근에는 박근혜 정부의 경제혁신 3개년 계획을 추진
- 경제발전 계획 및 법제의 패키지형 발전모형

13/25

2. 한국의 경제개발법제정비와 입법모형

- 국가주도형 경제개발전략의 '경제개발계획'
- 고도 경제성장의 요인으로 작용한 '경제개발계획'과 국민적 역량과의 결합
- 자립경제 확립을 위한 '경제개발계획'과 관련 법제의 제정
- 경제사회 선진화 구축을 위한 '경제사회발전계획'과 관련 법제의 제정

14/25

Thank you

Session 5

Тусгай илтгэл
특별강연

Хойд Солонгосын хүнийн эрхийн эрх зүйн тогтолцооны тулгамдсан асуудал, дүн шинжилгээ 북한 인권법제의 문제점과 전망

Илтгэгч: Проф. Пак Жонвон (КИС)

발표: 박정원 교수(한국 국민대)

Хэлэлцүүлэгч: МУИС-ХЗС-ийн захирал Ж.Эрдэнэбулган (МУИС-ХЗС)

토론: J.Erdenebulgan(몽골국립대 법대 학장)

БНАСАУ-ын Хүний эрхийн тухай хуулийн асуудал болон хэтийн төлөв

Пак Жон Вон профессор(Күкмин их сургуулийн Хуулийн сургууль)

I . Өмнөх үг

БНАСАУ-ын хүний эрхийн асуудал нь 1990-ээд онд эдийн засгийн байдал хүндэрсэнтэй холбоотой дүрвэгсэдийн тоо өсч, олон улсын байгууллагын сайн дурын ажлаар дамжуулагдан нөхцөл байдал нь гадаад ертөнцөд ил болсон. Ялангуяа НҮБ-ын Хүний эрхийн хороо, Олон улсын өршөөлийн хороо(AI: Amnesty International), Freedom House зэрэг олон улсын байгууллага, хүний эрхийн хөдөлгөөн хийдэг ТББ-ууд БНАСАУ-ыг хоцрогдмол хүний эрхтэй улс гэж зарласан. Барууны нийгэм БНАСАУ-д хандан хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулахыг тогтмол сануулсаар ирсэн. АНУ-ын Гадаад харилцааны яамны хүний эрхийн тухай тайлан болон олон улсын шашны эрх чөлөөний тухай тайлангаас үзвэл, БНАСАУ-ыг хүний эрхийн сул дорой улс хэмээн тодорхойлж, БНАСАУ-ын хүний эрхийн асуудлыг шийдвэрлэхэд олон улс хамтран ажиллах шаардлагатайг онцолсон. Мөн Европын холбоо нь 2001 оны 6 дугаар сар болон 2002 онд БНАСАУ-тай хүний эрхийн талаар яриа хэлэлцээ, семинар зэрэгээр дамжуулан тус улсын хүний эрхийн асуудал онц ноцтой хэмжээнд очсоныг мэдэгдсэн. 2002 онд ЕХ-ны төлөөлөгчид Пёняньд айлчлал хийснийхээ дараагаар БНАСАУ-д олон улсын хүний эрхийн тухай хууль тогтоомж үйлчилдэггүй болохыг тогтоосон.

Энэхүү олон улсын талаас БНАСАУ-ын хүний эрхийн зөрчилийг шүүмжилсэн нь БНАСАУ-ыг олон улсын гэрээ конвенцын дагуу хүний эрхийн тайлан гаргаж өгч байх шалтгаан болсон. БНАСАУ нь 1991 оны 9 дүгээр сард Олон улсын хүний эрхийн А, Б конвенцид нэгдсэнээсээ хойш 1 удаа тайлан гарган өгч, 17 жилийн турш тайлан өгөөгүй байснаа 2000 оны 3 дугаар сард 2 дугаар ээлжит тайлангаа өгч БНАСАУ-ын хүний эрхийн асуудлыг шүүмжилсэн улс орнуудтай тэмцэж эхэлсэн.

НҮБ болон ЕХ нь БНАСАУ-ын хүний эрхийн асуудлыг жил бүр хэлэлцэн батлах саналыг

дэвшүүлж олон улс тус улсад анхаарал хандуулахад хүчин чармайлт гаргасаар ирсэн.

НҮБ-ын Хүний эрхийн хороо нь 2005 онд БНАСАУ-ын хүний эрхийн тухай тогтоол баталж, жил бүр НҮБ-ын нэгдсэн чуулганаар танилцуулж ирсэн. Манай Засгийн газар ч гэсэн идэвхгүй байдлаасаа гарч анх удаагаа санал дэвшүүлсэн улсаар хамтран оролцож, НҮБ-ын БНАСАУ-ын хүний эрхийн тогтоолд дэмжсэн санал өгч эхэлсэн. Тэр дундаа АНУ нь “БНАСАУ-ын Хүний эрхийн тухай хууль”-ийг баталж БНАСАУ-ын хүний эрхийн асуудалд анхаарал хандуулж, бодлогын хэмжээнд БНАСАУ-ын хүний эрхийн асуудлыг авч хэлэлцсэн ба БНАСАУ-д хүний эрхийн тусгай элч төлөөлөгч илгээж үүнийгээ дэлгэрэнгүй болгосон.

БНАСАУ нь 2011 онд Ким Жон Ирийг таалал төгссөнөөс хойш Ким Жон Ун эрх мэдлийг шилжүүлэн авсан хэдий ч тогтооцооны хувьд өөрчлөгдөөгүй юм. Ким Жон Ун өөрийн эрх мэдлээ бэхжүүлэх явцад хүний эрх улам ноцтой зөрчигдсөн гэсэн мэдээлэл байдаг. Тиймээс БНАСАУ-ын хүний эрхийн талаарх өнгөрсөн дүгнэлтэд ахиц гараагүй юм. НҮБ-ын хүний эрхийн тайлан нь одоог хүртэл БНАСАУ-д хүний эрх ноцтой зөрчигдөж байгааг цохон тэмдэглэж, БНАСАУ-ын хүний эрхийн асуудал хариуцагчийг томилж, БНАСАУ-ын хүний эрхийн асуудалд онцгой анхаарч байна.

Ким Жон Унын удирдлага дор цөмийн туршилт зэрэгээс үүдэж тус улсын хүний эрхийн асуудал улам хурцадмал болж байгаа тул уг асуудлын эсрэг хүчтэй арга хэмжээ авсан юм. 2014 оны 2 дугаар сард БНАСАУ-ын хүний эрхийг шалгах хороо(COI) нь тайлангаараа дамжуулан НҮБ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд БНАСАУ-ын хүний эрхийн комисс байгуулах тухай саналаа 2015 онд өгсөн юм. Энэ нь БНАСАУ-д үйлдэгдэж байгаа хүний эрхийн гэмт хэрэгт хариуцлага тооцохын тулд газар дээр нь ажиллах асуудлыг агуулж байсан юм. Үүний дараагаар 2015 оны 6 дугаар сард НҮБ-ын хүний эрхийн комисс Сөүл хотод байгуулагдаж үйл ажиллагаа нь эхэлсэн юм.

Нөгөө талаар 2016 оны 3 дугаар сард, БНСУ-ын Парламентын чуулганаар БНАСАУ-ын хүний эрхийн туай хууль батлагдсан юм. 2005 оны 17 дугаар чуулганаар хууль анх удаа хэлэлцэгдсэнээс хойш 11 жилийн дараа болсон зүйл юм. АНУ нь БНАСАУ-ын хүний эрхийн асуудалд илүү нарийн арга хэмжээ авсан. 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Ерөнхийлөгч Барак Обамагийн гарын үсэг зурсан ‘БНАСАУ-ын эсрэг хориг арга хэмжээ’(HR757)-ний 304 зүйлд үндэслэн БНАСАУ-ын хүний эрхийн хориг арга хэмжээг чангатгасан. Үүний

дараагаар 7 сарын 6-ны өдөр АНУ нь БНАСАУ-ын удирдагч Ким Жон Уныг хүний эрхийг санаатайгаар зөрчсөн гэсэн үндэслэлээр хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан. (Захиргааны шийдвэр13722 дугаар, 13687 зүйл). АНУ-ын Засгийн анх удаагаа БНАСАУ-ын удирдагчийг хориг арга хэмжээний жагсаалтад багтаасан нь энэ юм.

Харж байгаачлан БНАСАУ-ын хүний эрхийн асуудлыг дотоод болон гадаадад хуулиараа зохицуулж өгсөн байгаа юм. Гэсэн хэдий ч БНАСАУ хүний эрхийн зөрчилөө арилгах ямар нэг үйлдэл хийхгүй байна. Бид БНАСАУ-ын хүний эрхийн тухай хуулийг баталж, тус асуудалд нарийн хандаж байгаа ба БНАСАУ дахь хүний эрхийн тухай хууль тогтоомж зэрэгийг судалж үзэх нь зүйтэй юм.

Энд БНАСАУ-ын хүний эрхийн асуудлыг хуулийн тогтолцооны хүрээнд хэлэлцэнэ. БНАСАУ-ын хүний эрхийг хангах хууль зүйн тогтолцооны асуудал, БНАСАУ-ын хэлж байгаа хуулийн үүрэг ролийг ардчилсан нийгэмтэй улстай харьцуулна. Хүний эрхийг хангахтай нягт холбоотой БНАСАУ-ын Үндсэн хууль болон Эрүүгийн хууль, шүүх тогтолцоо болон өмгөөлөгч зэрэгийг харгалзан БНАСАУ-ын тогтолцооны гажуудлыг судална. Мөн БНАСАУ-ын ‘Бидний хүний эрх’-ийн талаар судалж, тогтолцооны хүрээнд БНАСАУ-ын хүний эрхийн асуудлыг сайжруулах талаар дурдана.

II . БНАСАУ-ын хуулийн үндсэн зарчим болон үүрэг: ‘Жүчхэ онолын эрх зүй’-д тулгуурлав

1. БНАСАУ-ын хуулийн үндсэн зарчим болон үүрэг

БНАСАУ нь социалист хуулийг “ажилчин анги төдийгүй нийт хөдөлмөрчдийн ашиг сонирхол, шаардлагад нийцүүлэн тэдгээрийн бие даасан байдлыг хангах шинэчлэлийн хууль” гэж томъёолсон байдаг. Тиймд социалист хуулийн үндсэн зарчим нь социалист тогтолцоо болон пролетарийн дарангуйллыг хуулиар хамгаалсан, удирдагчийнхаа санаачилсан ажилчин ангийн тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд оршдог. Иймээс БНАСАУ-ын тус хууль нь хөдөлмөрчин анги болон нийт иргэдийн санаа бодлыг хуульчилсан гэх ба ямар төвшинд эсвэл ямар нийгмийн давхаргын үйлдлийг хязгаарлаж байгаагас хамаарч хуулийн мөн чанар тогтоогддог гэж тайлбарласан байдаг. Социалист

хууль нь тухайн нийгэмд амьдарч байгаа иргэдийн дагаж мөрддөг хууль гэдэг утгаараа албадлагын шинж чанартай хууль учраас эрх чөлөөт ардчилсан нийгмийн хуулийн мөн чанараас ялгаатай юм.

БНАСАУ социалист хууль нь иргэдийн үйлдэл хөдлөл болон тэдгээртэй холбоотой стандартыг тогтоох үндсэн зарчим болон тогтоосон стандарт шаардлагын хүрээнд хязгаарлах зарчмын шинжийг агуулдаг. Энэ хоёр зарчим нь хууль тогтомжийн тогтолцооны онцлогтой шууд хамааралтай ба түүний үндэс гэж авч үздэг. Мөн БНАСАУ иргэдээ хуульд заасан үйл хөдөлгөөний журамд тулгуурлан хянаж, удирдагчийнхаа философи, намын бодлогыг баталгаажуулдаг байна. Үүнээс гадна улс төрийн өндөр албан тушаалтнуудын эсэргүүцлийг дарах үүрэг гүйцэтгэдгээс гадна эдийн засаг, соёлын салбар дахь ажилчидыг нэгтгэх ч үүрэг гүйцэтгэдэг байна. Энэ хууль нийгмийн давхаргын тэмцэлийн зэвсэгийн хувьд нийгэмд дайсагнасан сэтгэлгээг дарж, иргэдийнхээ философийг шинээр боловсруулах шаардлагатай гэсэн санаа руу эргэн орж байна.

Мөн БНАСАУ нь хуулийн үйлчлэх үр нөлөөг онцолж байдаг. Энэ нь хуулийн зарчим болон үүргийг биелүүлсэнээр үүсэх гадаад нөлөө гэж хэлдэг ба нийгмийн тогтолцоог хамгаалах, хүмүүсийг социалист сэтгэлгээнд төлөвшүүлэх, нийгмийн шинэчлэл, ажилчин ангийн бүтэц зохион байгуулалт нь эдийн засаг, соёлын бүтээн байгуулалтад суурь болдог хэмээн тайлбарладаг.

Энэ мэтчилэн хуулийн зарчим болон үүргийн талаарх БНАСАУ-ын тайлбараас үзвэл, социалист хууль нь тус улсын удирдагч болон дайсагнасан үзэлтэнүүдийн халдлагаас улс болон тогтолцоогоо хамгаалдаг гэсэн санаа юм. БНАСАУ-д мөрдөгдөж байгаа хууль нь тус улсын намын бодлогыг бэхжүүлж, бүх ажилчидын анги удирдагчийнхаа философи болон намын бодлогыг мөрдөхөд зорилго нь оршиж байгаа юм.

2. Эрх чөлөөт ардчилсан улсын хуулийн зарчим болон үүрэгтэй харьцуулсан нь

Социалист хууль нь БНАСАУ-ын бүх хүмүүсүүдийн мөрддөг нийт ажилчин ангийг хамгаалсан учраас зөвхөн дарлан мөлжигчидийн санаа бодлыг тусгасан эрх чөлөөт ардчилсан нийгмийн хуулиас ялгаатай гэж өөрсдөө тайлбарладаг ч, хуулийн үндсэн зарчим

болох хүний эрхийг хангах асуудлаас эхлэн өөр хоорондоо ялгаатай юм. Эрх чөлөөт ардчилсан улсын хуулийн зарчим нь гадна тал, бодит асуудлын хувьд хуулийн биелэлтийн талаар үнэ цэнийг тогтоох стандарт гэж хэлж болно. Иймд, хуулийн зарчим нь хуулийн зорилгыг дэлгэрүүлж, бодит болгохын тулд энэ хоёр нь хоорондоо нягт холбоотой. Хуулийн зарчим нь энгийн нийгмийн амьдралын аюулгүй тайван байдлыг хадгалах, улсын эрх мэдлээс шалтгаалсан хууль бус үйлдлийн талаарх хориг бөгөөд хязгаарлах зарчим, үйлдэлийг хууль ёс эсэхийг дүгнэх зарчим, үйлдлийн үр дүнгийн талаар таамаглах зарчим, шүүхийн маргааныг шийдвэрлэх зарчим зэрэг юм.

Энэхүү зарчимууд нь хуулийн шударга ёсны зарчмыг биелүүлэх болон ёс зүйг хадгалахад чиглэгддэг хууль зүйн аюулгүй байдал гэсэн зорилгод тулгуурлан шийдвэрлэгддэг агуулгатай гэж хэлж болно. Хууль нь нийгмийн түүхэн хөгжилөөс шалтгаалан өөрчлөгдөж ирсэн ба тухайн цаг үеийн нөхцөл байдлаасаа шалтгаалан шинэчлэгдэж ирсэн. Тиймээс капиталист нийгэм дээр суурилсан орчин үеийн хуулийн үндсэн шинж ч гэсэн цаг хугацааны хөгжилөөс үүдэж өөрчлөгдөж өнөөг хүрлээ. Эрх чөлөөт ардчилсан нийгэмтэй улсын хэлдэгчлэн хуулийн оршил болон үнэ цэнэ нь ерөнхийдөө үнэ шударгыг биелүүлэх зарчим гэж ойлгож болно. Хуулийн үндсэн ойлголтыг олон талаар тайлбарладаг ба тэгш эрх гэж томьёо уламжлал болж ирсэн. Өнөө цагт тэгш эрхээс гадна хүний эрхийг дээдлэх гэдэг ойлголт нэмэглэж байгаа юм. Энэ нь хүнлэг ёс(Humanism)-д суурилсан байгалийн жам ёсны хуулийн томьёоноос үзвэл, эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдийн субъектив хандлага, бие даасан шийдвэрийг хязгаарласнаар хүн төрөлхөтөний ёс зүйг дээдэлсэн философиос гарсан хүний эрхийн үндсэн үүргийг гүйцэтгэж байгаа юм. Орчин үеийн хуулийн зарчим нь хэв журам сахиулах болон маргааныг шийдвэрлэх үндсэн зарчимаас гадна хувь хүний эрхийг хамгаалах, эрх чөлөөг хүндэтгэх болон хамгаалахад чиглэгдэж байгаа юм. Иймд орчин үеийн ардчилсан улсын хууль нь улсын эрх мэдлийг хязгаарлах хүчин зүйлийн чиглэлийг тодорхойлж, иргэдийн эдлэх эрх, эрх чөлөөг цогцлоох тогтолцоог бүтээх ба хууль нь хүн төрөлхөтөний үндсэн эдлэх эрхийг хамгаалах зарчимтай юм. Мөн хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалхаас гадна эрх тэгш байдлыг бүрдүүлэх, хариуцлага хүлээх зэрэг зүйлс багтаж байгаа юм.

Үүнтэй харьцуулахад БНАСАУ-ын хууль нь хүний үндсэн эрх ашгийг хамгаалах гэхээсээ илүүтэйгээр улсын эрх ашиг, тогтолцоог хамгаалахад чиглэгдсэн гэж хэлж болно. Тус

улсын хуулиас иргэдийн эрх ашгийг хамгаалах агуулга бүхий зүйл заалтыг олоход бэрхшээлтэй байгаа юм. БНАСАУ-ын хуулийн эрхэм зорилго нь социалист улсын зорилгоор тодорхойлогдож байгаа гэж байгаа боловч нөгөө талаараа социалист нийгэмтэй улсын хуулийн үүрэг даалгавар нь тус улсын удирдлага болон нийгмийн тогтолцоо, шинэчлэл зэрэгийг хамгаалахад оршиж байгаа юм. Энэ нь хууль гэдэг нь улсын удирдагчийнхаа философийг нийгэмдээ түгээн дэлгэрүүлэх нэгэн хэрэгсэл гэсэн санаатай юм. БНАСАУ-ын хуулийн мөн чанарыг аваад үзэхийн бол тус хуулиар дамжуулан хүний эрх хамгаалагдана гэж дүгнэхэд учир дутагдалтай юм.

Энэ нөхцөл байдал нь тус улсад хүний эрх зөрчигдөх тогтолцооны асуудал байгаад шүүмжлэлтэй хандаж байна. БНАСАУ-ын хүний эрхийн өнөөгийн нөхцөл байдал ёул дорой гэж байгаа нь тус улсын хуулийн тогтолцоотой салшгүй холбоотой. Иймд БНАСАУ-ын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, шүүх тогтолцоо нь улсынхаа удирдагч, намын бодлогоо хамгаалх зорилготой тул иргэдийн эрх ашиг хязгаарлагдаж байгаа үндсэн шалтгаан болж байна.

III. БНАСАУ-ын Хүний эрхийн тухай хуулийн өнөөгийн нөхцөл байдал ба асуудал

1. БНАСАУ-ын Үндсэн хуульд тусгагдсан хүний эрхийг хамгаалах тухай асуудал

(1) Иргэний эрхийн үндсэн хэлбэр

БНАСАУ-ын Үндсэн хуулийн 5 дугаар бүлэгт иргэдийн үндсэн эрх болон үүргийн талаар заасан байдаг. Тус улсын үндсэн эрхийн тухай ойлголт нь эрх чөлөөт ардчилсан улсын ижил ойлголтоос өөр онцлогтой юм. БНАСАУ-ын иргэн нь нийгмийн бүхий л салбарт ихээхэн том цар хүрээтэй эрх, үүрэг хүлээх ба тус эрх нь тэгш эрх, биелэгдэх боломжтой, ижил тэгш нөхцөлтэйгээр нийгмийн бүтээн байгуулалтад оролцож, тэнцүү ашиг хүртэхийг хэлж байгаа юм. Нийгмийн хөгжлөөс үүдэж хуулийн хамрах цар хүрээ ч томорч байгаа гэж тэд онцолдог. Гэвч энэ бүгд үнэндээ худал хуурмаг ба тус улсын Үндсэн хуулийн зүйл заалт нь огт хэрэгждэггүй чимэглэл төдий зүйл юм. БНАСАУ нь үндсэн эрхийн хэлбэрийг бүрэн хуульчлагдсан гэж үздэг. Тиймээс улсынхаа зорилгыг пролетари засаглалтай гэж үздэг тус

улсын хувьд Үндсэн хуулийн эрх хангагдана гэж үзэхэд хэцүү юм. Ерөнхийдөө социалист нийгэмтэй улсын Үндсэн хуульд заасан эрх нь пролетари засаглалаас үүдэж, хүлээн зөвшөөрөгддөг ба ард, иргэдийн хэлдэгчлэн “Иргэний эрх” (Bürgerrechte) гэдэг утгаараа хувь хүний филсофид тулгуурласан “Хүн төрөлхтөний эрх”(Menschenrechte)-ийг утгыг агуулдаг эрх чөлөөт ардчилсан улсын Үндсэн хуулиас шинж чанарын хувьд ялгаатай юм. Социалист нийгэмт улсын хүн бүрт олгогдсон үндсэн эрх нь улс орныг бүхэлд нь хамарсан байдлаар хүлээн зөвшөөрөгддөггүй ба түүхийн материалист үзэлд ойрхон буюу материалист зүйлээр хангагддаг гэж үздэг. Тэр талаас нь үзвэл социалист улсын үндсэн эрх нь эрх чөлөө гэхээсээ илүү нийгэм, эдийн засгийн эрхд ач холбогдол өгч байгаа юм.

(2) Хүний эрхийг хангахал тулгарч буй асуудал

1) БНАСАУ-ын Үндсэн хуулийн 63 дугаар зүйлд “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгний төлөө” гэж зүйлчилсэн байдаг. БНАСАУ-д нийтийн, нийгмийн эрх ашиг нь хувь хүний эрх ашигаас түрүүнд тавигдаж, хувь хүний эрх ашигийг нийгмийн эрх ашиг гэж үзэх аж амьдралынхан үндсэн зарчим юм. БНАСАУ-ын Үндсэн хуулийн 81 дүгээр зүйлд “Иргэд нь хамт олон, нийтийг хүндэтгэж, нийгэм ард иргэдийн төлөө бие сэтгэлээ дайчлан ажиллахад хүчээнэ” гэж заасан байдаг. Энэ мэтчилэн БНАСАУ-ын Үндсэн хуулийн үндсэн эрх ашиг нь олон нийтийн эрх ашигд суурилж байгаа ба иргэдийн эрх ашиг үүнээс гадуур тавигдах боломжгүй юм. Энэ нь иргэдийн эрх ашиг нь улсын эрх ашигтай паралел ба хувь хүний эдлэх эрх нь улсын эрх ашиг буюу нийтийн эрх ашигт нийцэж байх ёстой юм. БНАСАУ-д нийтийн эрхийг түрүүнд тависнаар хариуцагч хоорондын үзэл санаа гэхээсээ илүүтэйгээр улсын төлөөх үйл хэрэг нь бодитоор хангагдах боломжтой эрх гэж үздэг байна. Тэр нь зөвхөн улс өөрөө тухайн эрхийг хангана гэж заасан тохиолдолд хангагдах эрх ба хувь хүн улсад нэхэмжлэх гаргах, зарга үүсгэх эрхгүй юм.

БНАСАУ-ын үндсэн эрхийг товч авч үзвэл, хувь хүний эрх ашиг болон нийтийн эрх ашигийн нэгдэл, эрх болон үүргийн тэнцэл, эрх болон үүргийн субъектийн шат ангилал, эрхийг бодитоор хангах арга (материалист нөхцөлөөр хангах), цэргийн эрх гэх мэт нийгмийн хязгаарлалтын хүчин зүйлсийг онцолж байгаа гэдгийг харж болно.

2) Үндсэн эрх болон үүргийн харилцаа

БНАСАУ-д үндсэн эрх болон үүрэг нь хоорондоо паралел бөгөөд нийтийн төлөө үйлчлэх хэрэгтэй. Эрх чөлөөт ардчилсан улсаас ялгаатай юм. Социалист улсад хувь, улс, нийгэм нь өөр хоорондоо ялгаатай харилцаатай биш гэж үздэг учраас энэ гурван зүйлс нь түүхийн ёс журамд тулгуурлан ижил чиглэл рүү явж байгаа бөгөөд улсын эсрэг тэмцэж байгаа хувь хүний хэрэгсэл болох хүний эрх гэдэг нь орших үндэслэлгүй болж байгаа юм.

Үүнд БНАСАУ-ын Үндсэн хуулийн үндсэн эрхийг харахдаа, үргэлж түүнтэй ижил агуулга бүхий үүрэг рүү шилждэг гэдэгийг санаж байх нь зүйтэй. БНАСАУ-ын Үндсэн хууль нь зөвхөн улсаас эдлэх эрхээр үүсэх бодит, материалист эрхийг хангах тухай заасан байгаа юм. Мөн тус хуулийн 64 дүгээр зүйлд “Улс нь бүх иргэддээ ардчилсан эрх болон эрх чөлөө, аз жаргалтай материалист, соёлоор хангана” гэж заасан ба “Иргэдийн эрх болон эрх чөлөө нь социалист тогтолцооны хөгжилийн хамтаар улам өргөжин тэлнэ” хэмээсэн байна. Иймл “Хүний эрх гэдэг нь үүрэг” гэсэн үзэл санаатай нэг зүйл бөгөөд нэгдмэл ойлголт юм.

3) Намын бодлогыг мөрдөх зарчим

БНАСАУ-ын үндсэн эрхийн “Улс болон нийгмийн эрх ашигтай нийцэх” гэдэг нь “Намын бодлогод нийцэх” гэсэн утгыг агуулж байгаа юм. БНАСАУ-ын үндсэн эрхийн цар хүрээ, мөрдөгдөх хэмжээ нь намын эрх ашигт нийцүүлэн хэмжигдэх ба намын төлөвлөгөөнд хамаарна. Эцэст нь намын удирдлага нь үндсэн эрхийн нарийн агуулгыг тогтоохоос гадна хязгаарыг бий болгодог. Тиймээс БНАСАУ нь Шүүх ажиллагааны тухай хуульдаа “Намын улс төрийн бодлогыг хэрэгжүүлж, пролетари засаглалын зэвсэг” гэж заасан(1 дүгээр зүйл), мөн шүүх байгууллага нь Хөдөлмөрийн намын дор ажил үүргээ гүйцэтгэнэ (5 дугаар зүйл) гэх заалтыг намын бодлогынхоо үндсэн хэсэгт байрлуулаад байгаа юм.

БНАСАУ-д үндсэндээ хамгийн хүчтэй мөрдөгддөг зүйл бол “Ким Ир Сенийн хэлж үлдээсэн захиас болон Ким Жон Ирын хэлсэн үг, намын хуулийн бодлого” юм. БНАСАУ-ын удирдагч агсан Ким Ир Сен 「Манай намын хуулийн бодлогыг тогтоох нь」 гэх сэдэвт илтгэл(1958. 4) тавих үеэрээ “Улсын бодлого нь намын бодлого” бөгөөд “Хуулийг ягштал мөрдөх нь намын бодлогыг хэрэгжүүлж байгаа” хэрэг хэмээсэн. Мөн хуулийн байгууллагын ажил үүрэг гүйцэтгэгчийн гол шалгуур нь намын бодлогын талаарх мэдлэг байсан ба пролетари өнцөгөөс хуулийг тайлбарлах шаардлагатайг онцолсон юм. Энэ нь шүүх болон

шүүгч нь намын бодлогыг дагахыг хэлж байгаа бөгөөд БНАСАУ-ын хууль хяналтын байгууллага бие даасан биш гэдгийг харуулж байгаа юм. Үүнтэй холбогдуулан 1992 оны Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “Намын удирдамж”-ын заалтыг шинээр оруулж намын эрх ашиг хамгийн түрүүнд тавигдана гэж Үндсэн хуульдаа тусгаж өгсөн юм.

4) Үндсэн эрхийг хязгаарлах болон материалаар хангах зарчим

БНАСАУ-ын Үндсэн хуульд БНСУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасан “Улсын үндсэн эрхийг хамгаалах үүрэг” мөн БНСУ-ын Үндсэн хуулийн 37 дугаар зүйлийн 2-д заасантай адил зайлшгүй тохиолдолд үндсэн эрхийг хязгаарлах буюу “Үндсэн эрхийг хязгаарлах ерөнхий журам” гэсэн зүйл заалт байхгүй юм. Мөн БНСУ-ын 37 дугаар зүйлийн 2-д заасанчлан үндсэн эрхийг хязгаарлах тохиолдолд мөн чанарт халдаж болохгүй гэсэн үндсэн эрхийг хязгаарлах эрсдэлийг тооцохгүйгээс БНАСАУ-ын Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн талаарх зүйл заалт нь үнэндээ ямар ч үр нөлөөгүй зүйл байх магадлал өндөр юм.

БНАСАУ-ын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд “Материалист соёлтой аж амьдралыг бодитоор хангах” болон “Социалист тогтолцооны тогтвортой хөгжил, эрх, эрх чөлөөний өсөлт” гэж үндсэн эрхийг материалаар хангана гэж мэдэгдсэн нь нэг төрлийн үндсэн эрхийн “Үндсэн хуулийг нөхөх заалт” бөгөөд үндсэн эрхийг хангахтай холбоотой дутагдалыг нөхөж байгаа гэж үзэж болно. Үүнээс гадна пролетари засаглалыг хөгжүүлэх ба социалист нийгмийг бүтээн байгуулах зорилготой гэдэг нь БНАСАУ-ын Үндсэн хуульд заасан ерөнхий зүйл заалтын туслах заалт ба эцэстээ үндсэн эрх нь энэ дутагдалтай зүйл дотор хангагддаг гэсэн санаа юм.

5) Эрхэнд халдах, хамгаалах хэрэгсэлийн дутмаг байдал

БНАСАУ-ын Үндсэн хуульд улсын эрхийг материалаар хангах тухай заасан байдаг ба эрх нь зөрчигдсөн тохиолдолд ямар арга хэмжээ авч болох талаар зүйлчилээгүй байна. Тус улсын Үндсэн хуульд “Үндсэн эрхийг хангахын төлөөх үндсэн эрх” эсвэл “Үндсэн эрхээ хамгаалах нэхэмжлэл” зэрэг заалт байхгүй юм. Энэ нь эрх нь зөрчигдсөн тохиолдолд үүнийгээ хамгаалуулах тогтолцоо бүрдээгүй нь шинж юм. Дээр дурдсанчлан нийтийн эрх ашигт суурилж тэгш эрх эдлэх, улс төрд оролцох эрх, хэвлэл, мэдээлэлд хандах, санаа

бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг олон олон эрхийн талаар БНАСАУ-ын Үндсэн хуульд дурдсан байгаа боловч энэ бүх эрх нь улсынхаа эсрэг эдлэх боломжтой биш бөгөөд эрх нь зөрчигдөж байгаа тохиолдолд үүнийг хамгаалах хууль зүйн тогтолцоо бүрдээгүй байгаа юм. Энгээд харахад тэдний хувьд “эрх” гэдэг ойлголт нь энгийн эрх ашиг гэсэн утгыг агуулж байгаа учраас түүнээс үүдэн гарах нийгмийн эрх ашиг ч гэсэн хамрагдаж байгаа юм. БНАСАУ-ын Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлд иргэн улсдаа хандан өөрийн санал хүсэлтээ хүргүүлэх эрхийн талаар хуульчилсан байдаг. Энэ нь БНСУ-ын иргэн үндсэн эрхээ эдлэх тогтолцоотой ижилхэн зүйл юм. Гэвч БНАСАУ-ын Үндсэн хууль дээрх иргэний үндсэн эрх нь бодит байдал дээрээ хэрэгжидэггүй Робиншүйтайнын “Чимэглэл төдий Үндсэн хууль(semanticische Verfassung) гэж томъёолсотой адил зүйл юм.

6) БНАСАУ-ын 2009 оны шинэчлэгдсэн Үндсэн хууль дээрх хүний эрхийн тухай заалт

Үндсэн хуулийн 2009 оны шинэчлэсэн найрууллагын 8 дугаар зүйлд “Бүгд найрамдах ардчилсан солонгос улсын нийгмийн тогтолцоо нь хөдөлмөрчин иргэд бүх зүйлийн эзэн нь болж байгаа бөгөөд нийгмийн бүхий л зүйл хөдөлмөрчин ард иргэдэд зориулагдсан юм. Улс нь дарангуйлал албан шахалтаас чөлөөлөгдөж улс, нийгмийн эзэн нь болсон ажилчин, тариачин, цэрэг, бүх иргэдийн эрх ашгийг хүндэтгэж, хүний эрхийг дээдлэн хамгаална” гэж шинэ заалтыг нэмсэн.

Энэ нь БНАСАУ-ын Үндсэн хуулийн үндсэн эрхийн заалттай холбогдуулан түүний нэр томъёо агуулга нь ихээхэн чухал утгыг агуулж байгаа юм. Олон улс БНАСАУ-ын хүний эрхийн асуудалд анхаарал хандуулаад байгаа энэ цаг үед тус улс Үндсэн хуулийн хүний эрхийг дээдлэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан нь гадаад, дотоодын анхаарлаас шалтгаалж тодорхой хэмжээгээр боловсронгуй болгох арга хэмжээ авсан гэж хэлж болно.

2. БНАСАУ-ын Эрүүгийн хуульд хүний эрхийг хангах асуудал

БНАСАУ-ын 1974 оны Эрүүгийн хууль нь улс төрийн шинж чанартай гэсэн шүүмжлэлээс салахын тулд 1989 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Эрүүгийн хуулиа шинэчилсэн юм. Түүнээс хойш тус хуулийн хэсэг заалтыг 1995, 1999 онуудад өөрчилсөн юм. БНАСАУ-ын Эрүүгийн хууль нь иделоги шинж чанарыг агуулсан “Шинэчлэлийн эсрэг гэмт хэрэг”-ийг “Улсын эсрэг гэмт хэрэг” гэж үгийг өөрчилж, хүний ёс зүйд нийцэхгүй байна гэсэн шүүмжлэлийг

аваад байсан буюу хуулийг шилжүүлэн хэрэглэх тогтолцоогоо хязгаарлах гэх мэт сайжруулах хандлагатай байсан. Үүнээс хойш БНАСАУ 2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Ардын их хурлынхаа 432 дугаар тогтоолоор Эрүүгийн хуулиа дахин өөрчилсөн. 2004 оны шинэчилсэн Эрүүгийн хуулиар зүйл заалт нь 161 байснаас 303 зүйл заалттай болж нэмэгдсэн ба хуулийг шилжүүлэх ашиглах заалтыг устгаж, зөвхөн хуулиар гэм буруутайг тогтооно гэсэн шинжийг агуулж, эдийн засагт эрүүгийн хуулийн зарчмыг харуулсан гэж хэлж болно.

БНАСАУ 2007 онд Эрүүгийн хуульдаа ялыг нэмэгдүүлэх хэд хэдэн заалт нэмж, улсынхаа тогтолцоог хамгаалах хэрэгсэлээ чангатгасан. Үүгээр дамжуулан иргэдийнхээ хяналт, шахалтыг нэмэгдүүлсэн гэдгийг мэдэж болно. Эцэст нь хуулийн өөрчлөлт нь нийгмийн тогтолцоогоо хадгалахад чиглэгдэж байна. Өнгөрсөн хугацаанд БНАСАУ Эрүүгийн хуулийнхаа өөрчлөлтийг ихээхэн нууцалдаг байсан юм.

Мөн бусад нэмэлт заалт ч гэсэн батлагдсанаасаа хойш 2 жилийн дараа буюу 2009 онд бидэнд ил болсон. БНАСАУ Эрүүгийн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь анхаарал татам ховор зүйл бөгөөд энгийн гэмт хэргийн ялыг хүндрүүлэх утгыг агуулж байгаа юм. Энэ нь нийгмийнхээ дэг журмыг хэвийн хадгалах гэсэн үйлдэл юм. БНАСАУ-ын улс төрийн онцлогоос нь авч үзвэл, эрүүгийн хуулиа чангатгаж байгаа нь иргэдийн үйлдлийг хянаж, тогтолцоогоо хадгалах гэсэн оролдлого ба тус улсын эрүүгийн хуулийн заалтад анализ хийх нь БНАСАУ-ын бодит байдлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Мөн 2009 онд Үндсэн хуулиа шинэчлэснээсээ хойш Эрүүгийн хуулиа ч гэсэн шинэчлэн найруулсан. Тус шинэчлэлдээ аж ахуйн өөрчлөлт болон ялыг хүндрүүлэх заалтыг нэмсэн. Дараагаар нь 2012 оны 5 дугаар сарын 14-ны өдөр Эрүүгийн хуульдаа дахин өөрчлөлт оруулсан. 2009 оны хуультай харьцуулахад 290 зүйл заалт болгон бууруулж, зам тээврийн осол гаргаад зугтсан бол ялыг хүндрүүлэх, хууль бусаар валют олох, үл хөдлөх хөрөнгийн ёс журмыг зөрчсөн, бичиг баримт арилжаалах гэмт хэрэг зэргийг устгасан. Энэ нь БНАСАУ-ын эдийн засгийн байдлыг тусгасан гэж хэлж болно.

Дараагаар нь БНАСАУ-ын Эрүүгийн хуульд(2012он)заасан хүний эрхийн асуудлыг үзнэ.

(1) Хууль батлах

Хууль батлах талаас нь авч үзвэл, гэмт хэргийн бүрэлдэхүүн нь тодорхой бус, тэр хэллэг

нь ч хийсвэр ба хууль сахиулагчийн шийдвэрээс шалтгаалж, эрүүгийн ялыг урвуулан ашиглах эрсдэлтэй. Мөн эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бодит хууль хоорондоо холилдож эмх замбраагүй байгаа юм. Үүний талаар 2004 онд шинэчлэгдсэн Эрүүгийн хууль нь гэмт хэргийг хязгаарлах, зорилго нь тодорхой боловч ерөнхийдөө өмнөх Эрүүгийн хуулийнхаа хэлбэрээс өөрчлөгдөөгүй юм.

(2) Гэмт хэргийн онол

Өмнөх Эрүүгийн хуулийн гэмт хэргийн тухай онолоос үзвэл, эрүүгийн ялтай хуулийн заалтыг шилжүүлэн хэрэглэх 10 дугаар зүйл нь Эрүүгийн хуулийн гэмт хэрэг эсэхийг зөвхөн хуулиар тогтоох үндсэн зарчмыг гэмтээх эрсдэлтэй гэж дүгнэгдэж байгаа юм. Тэр нь гэмт хэргийн тухай 9 дүгээр зүйлтэй нэгтгэсэн ба хуулийн аюулгүй байдлыг нурааж байгаа, эрүүгийн хуулийг нийгмийн давхаргын эсэргүүцлийн зэвсэг болох аюултай юм. Гэвч хуулийг шилжүүлэн хэрэглэх зарчим нь 2004 онд устгаж, энэхүү таамагийг няцаах үндэслэл болсон юм.

Мөн өөрийгөө хамгаалах, яаралтай зугтах зэрэг нь нийгмийн эрсдэлээс бусад гэсэн хэсэгт багтаж(15, 16 дугаар зүйл), бусад гэмт хэргийн бүрэлдэхүүнийг няцаахад эрүүгийн ялыг урвуулан ашиглах боломжийг нэмэгдүүлдэг. Мөн гэмт хэрэгтэнийг газар дээр нь илрүүлсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөх ба 14 дүгээр зүйл, төлөвлөх болон бүрэн бус гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ч бүрэн гэмт хэрэг гэж үзэх ба 21 дүгээр зүйл, хамтран гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ижил ял тогтоох 22 дугаар зүйл, эдгээр нь орчин цагийн хуулийн үндсэн зарчмыг зөрчсөн аюултай сэтгэлгээнээс үүдэлтэй гэж хэлж болно.

Мөн нуун далдлах, мэдээлэл хүргээгүй, гэмт хэргийг таслан зогсоогоогүй тухай заалт (24~26 дугаар зүйл), улсын төрийн эсрэг гэмт хэрэг зэргийг хамт тусгаж өгсөн нь ялыг гэмт хэрэгтэн бус ойр дотны хүнд нь тулгах зэргийг хуульчилсан нь тус улсын эрүүгийн хуулийн нөхцөл байдлыг харуулж байна.

(3) Эрүүгийн ялын онол

Эрүүгийн ялын онол талаас нь авч үзвэл, хуулийг эзэрхийллийн хэрэгсэл гэж үзээд эрүүгийн ялын утгыг хувь хүний үндсэн эрхтэй холбох гэхээсээ илүүтэйгээр нийт тогтолцоогоо хадгалахад ашиглаж байна. Ялангуяа ‘Төрийн эсрэг гэмт хэрэг’ийн талаар

цаазаар авах нь түгээмэл бөгөөд(60, 61, 63, 65 дугаар зүйлүүд), ялын хэмжээ ч өндөр байдаг(бүх хөрөнгийг хураах зэрэг). БНАСАУ-ын Эрүүгийн хуулийн анхан шатны үүрэг роль нь улсын удирдагч болон нийгмийн тогтолцоогоо хамгаалах ба иргэд, нийгмийн эрх ашиг нь түүний дараагаар тавигдаж байгаа юм. 1987 онд шинэчлэгдсэн Эрүүгийн хууль болон 1992 онд шинэчлэгдсэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь өмнө нь үйлчилж байсан хуулиасаа утга агуулгын хувьд хүний эрхийг хамгаалсан мэт боловч, бодит байдал дээрээ хэрэгждэггүй гэдгийг тус улсын өнөөгийн хүний эрхийн зөрчил тод харуулж байна. Энэ мэт төрийн эсрэг гэмт хэрэгт өндөр дээд ял оногдуулдаг нь иргэдээ төрийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ ба өөрсдийнхөө нийгмийг тогтолцоог хадгалахад гол анхаарлаа төвлөрүүлж байгаа хэрэг юм. 2004 оны шинэчлэгдсэн Эрүүгийн хуульд төрийн эсрэг гэмт хэргийн тухай заалт нь улс төрийн гэмт хэрэг гэсэн нэрийн доор агуулагдаж байна. Иймд 1987 оны Эрүүгийн хуулийн санаачлагаас үзэхэд өөрчлөлт гараагүй ба 2012 онд шинэчлэгдсэн Эрүүгийн хууль ч мөн адил юм.

3. БНАСАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль дахь хүний эрийн асуу дал

БНАСАУ нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиа шинэчилж(1992. 1. 15) Эрүүгийн үйл ажиллагааны процессын хувьд шинжлэх ухаанд нийцсэн, бие даасан нотлох баримтаар тогтоох (35, 36 дугаар зүйл), хориж, саатуулах зэрэгт хянамгай хандах (11 дүгээр зүйл) зэрэг өмнөх хуультайн харьцуулахад хүний эрхийн асуудалд ахиц гаргасан гэж дүгнэгдсэн. БНАСАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь 1995, 1996, 1997, 1999 онуудад хэсэг өөрчлөлт орсон ба 2004 оны 5 дугаар сарын 6-ны Ардын их хурлын 436 дугаар тогтоолыг шинэчилж, 2012 оны 5 дугаар сарын 14-ны өдөр 2387 дугаар тогтоолоор дахин баталсан. Гэвч шинэчлэгдсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд ч гэсэн хүний эрхийг зөрчих хүчин зүйл оршиж байгаа юм.

(1) Бие мах бодийн эрх чөлөөнд халдах

БНАСАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь мөрдөн байцаагч, нотлох баримт шалгах, цагдан хорих, битүүмжлэх, хураах зэрэг албадан актад зөвшөөрөл авах механизмийг хүлээн зөвшөөрөөгүй байгаа юм. (143, 176 дугаар зүйл).

Харин цагдан хорих тохиолдолд сэжигтэнийг баривчлах, нэгжих тохиолдолд тухайн прокурорын зөвшөөрлөөр гүйцэтгэх (180, 181 дүгээр зүйл) гэмт хэргийг шалгах явцад хүний эрхэд халдах, бие мах бодийн эрх чөлөөнд халдахаас сэргийлсэн тогтолцоо байдаг. Гэвч энэ нь прокурор эрх мэдлийнхээ хүрээнд хязгаарлах боломжгүй, мөрдөн байцаах ажиллагаанд шүүхээс хязгаарлалт тавих зорилгоор зөвшөөрөл авах гэсэн мөн чанарын хувьд ялгаатай учраас бодитоор хүний эрх хангагдана гэж үзэхэд бэрхшээлтэй юм. Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих шүүх тогтолцооны дутагдалтай тал нь БНАСАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль хүний эрхийг хамгаалах гэхээсээ илүүтэйгээр мөрдөн байцаалтын үр дүн, захирах засаглалд нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг гэдгийг харуулж байна.

(2) Шүүх хуралд иргэдийн оролцоо (ил, нууцаар цаазлах)

БНАСАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн процесс нь гэмт хэргээс нийгмийг хамгаалах нь хувь хүний эрхийг хамгаалхаас дээгүүрт тавигддаг ба иргэдэд уг асуудлаар боловсрол олгох бодлого үргэлжилж байна. Тиймээс БНАСАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь гэмт хэрэгтэй шууд холбоогүй энгийн иргэдийг ч төрөл бүрийн хэлбэрээр шүүн таслах ажиллагаанд оролцуулж (ЭБШХ 285 дугаар зүйл) шүүн таслах ажиллагааг шударга явуулах гэхээсээ илүү тус улсын тогтолцоог өмөөрөх улс төрийн ажиллагааны нэг хэсэг болгож байгаа юм. БНАСАУ нь шүүх ажиллагаанд иргэдийн оролцох хүрээг өргөнөөр тогтоож өгсөн. Мөн хуульдаа эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ ард иргэдийн хүч, оюун ухаанд тулгуурлаж(3 дугаар зүйл), шүүх ажиллагаанд иргэдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлүүлэхийн тулд газар дээр нь шүүх хурлыг зарлан хуралдуулах боломжтой ба энэ тохиолдолд ажилчин, ажилчидын төлөөлөгч зэрэг оролцож, гэмт хэрэгтэний талаарх мэдээллийг шууд өгч болно(285 дугаар зүйл). Энэ мэтчилэн гэмт хэрэгт шууд хамааралгүй этгээдийг оролцуулж байгаа нь орчин үеийн бус шүүн таслах ажиллагаа явагдаж байгааг харуулж байна. Энэ нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиараа дамжуулан нийгмийн тогтолцоог хамгаалж, иргэдэд сэрэмж өгч, сэтгэл санааны дарамт, намынхаа бодлогыг тууштай батлан бэхжүүлж буй хэлбэр юм.

(3) Шүүхийн харьяалалын ойлгомжгүй байдал

БНАСАУ нь Нэгдсэн шүүх [Төв шүүх, аймгийн шүүх, иргэний шүүх] багтах ба анхан

шатны шүүхийн талаар тодорхой зүйл байхгүй. Аймгийн шүүх нь шаардлагатай тохиолдолд харьяа хотынхоо Иргэний шүүхэд хамаарах хэргийн шүүх хурлыг зохион байгуулах боломжтой ба (ЭБШТ 127 зүйл), Төв шүүх ч гэсэн шаардлагатай тохиолдолд бусад шүүхэд харьяалагдах анхан шатны шүүхийн үйл ажиллагааг явуулах боломжтой. (129 зүйл) Гурван шүүх хурал бүгд анхан шатны шүүх хурлыг хийх боломжтой. Иймд дээд шатны шүүх нь доод шатны шүүхийнхаа шүүх хэргийг дур мэдэн шүүж, яллагдагчийн эрхэнд халдаж болзошгүй. Энэхүү шүүхийн харьяалалын асуудал нь хүний эрхийн асуудлаас илүү хууль сахиулах байгууллагын бие даасан шийдвэр гаргах аюулыг агуулж байгаа юм.

(4) Төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шийтгэх

